

Боловсролын сайдын
2026 оны 02 дугаар сарын 16 -ны өдрийн
А/16 дугаар тушаалын хавсралт



БАГА БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д “Хүмүүнлэг, оюунлаг, ёс суртахуунтай, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай монгол хүн”, “Дэлхийд өрсөлдөхүйц оюунлаг иргэд бэлтгэх”, “Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэх”, “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлэх”-ээр заасан.

Боловсролын ерөнхий хуульд зааснаар боловсролын зорилго нь “насан туршдаа суралцаж, ажиллах чадамжтай, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэх”, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд заасанчлан “Ерөнхий боловсролын зорилго нь бие даан сурч, амьдрах суурь мэдлэг, чадвартай, ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай суралцагчийг хөгжүүлэх”-д оршиж байна.

Бага боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээ, судалгаа болон сурлагын амжилтын олон улсын үнэлгээ (PISA)-ээр суралцагчдын монгол хэл, математикийн суурь чадвар сул байгаа нь тогтоогдсон. Тухайлбал, 2021 онд хийсэн оношлох үнэлгээгээр хоёрдугаар ангийн суралцагчдын унших чадвар 41.4 хувь, математикийн чадвар 49 хувь, бага боловсролын суралцагчдын монгол хэл, математикийн суурь чадвар 57-оос доош хувь, мэдээлэлтэй ажиллах, асуудал шийдвэрлэх, хамтран суралцах чадамж 55-аас доош хувийн гүйцэтгэлтэй үнэлэгджээ. Мөн 2022 онд хийсэн боловсролын чанарын үнэлгээгээр бага ангийн суралцагчдын асуудал шийдвэрлэх даалгаврын гүйцэтгэл 36.6 хувь, бусдын үзэл бодлыг сонсох, хүндэтгэхтэй холбоотой даалгаврын гүйцэтгэл 26 хувь байна. ПИСА-2022 үнэлгээгээр Монгол Улсын суурь боловсрол эзэмшсэн 15 настай хоёр хүүхэд тутмын нэг нь математикийн болон унших чадварын суурь түвшнээс доогуур үнэлэгдсэн байна. Эдгээр үр дүн нь монгол хүүхдийн эх хэл, бичиг үсэг, математикийн суурь чадамж, бүтээлчээр сэтгэх, шүүн тунгаах, хамтран ажиллах, харилцах, нийгэм, сэтгэл хөдлөлийн ерөнхий чадамжийг бага наснаас нь эхлэн хөгжүүлэх шаардлагатайг илтгэж байна.

Дэлхий дахинд өрнөж буй нийгэм, эдийн засгийн шилжилт, уур амьсгалын өөрчлөлт, технологийн шинэчлэл нь иргэдийн амьдралын хэв маяг, хөдөлмөрийн зах зээлд өргөн хүрээний нөлөө үзүүлж байгаа нь суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар, чадамжийг дахин тодорхойлох, байнга тасралтгүй хөгжих боломж олгох хэрэгцээг бий болгож байна. Технологи ба хиймэл оюун ухаан бүх салбарт

хурдацтай нэвтэрч байгаа нь технологийн чадамжийг нэмэлт бус, харин суурь чадамжийн түвшинд эзэмших, өөр өөр эх сурвалж ба нөөцийг үр дүнтэй ашиглан бие даан суралцах, сурах арга барилтай байх нь мөн суралцагчийн эзэмших суурь чадамж болж байна.

Иймээс Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн зорилт, хуульд заасан боловсролын зорилго болон дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлж, боловсролын бүх түвшинд дараах дүр төрх бүхий Монгол суралцагчийг хөгжүүлэхээр нийгмийн оролцогч талууд 2024 онд “Монголын боловсролын тунхаглал”-д нэгдсэн билээ.

Монгол суралцагчийн дүр төрх:

- Үндэсний соёл, уламжлал, ёс заншлаа өвлөн хөгжүүлдэг “Соёлыг уламжлагч”;
- Ардчилсан, хүмүүнлэг, иргэний нийгмийг цогцлооход хувь нэмрээ оруулдаг “Хүнлэг иргэн”;
- Бие дааж, насан туршдаа суралцдаг “Тасралтгүй суралцагч”;
- Нийгмийн болон гэр бүлийн “Хариуцлагатай гишүүн”;
- Хүн төрөлхтний; соёлыг хүндэтгэдэг, дэлхийн соёлоос суралцдаг “Дэлхийн хүн”.

Энэхүү дүр төрх нь чадамжаар тодорхойлогдох бөгөөд суралцагчийн эзэмших чадамжийг боловсролын түвшин бүрд залгамж холбоотойгоор хөгжүүлэхээр тунхагласан байна.

Улмаар сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 176 дугаар тогтоолоор баталсан бөгөөд тус үзэл баримтлалд “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр нь монгол хэл, сэтгэлгээ, түүх, соёл, өв уламжлал болон дэлхийн өв соёл, үнэт зүйлд суурилах; насан туршийн суралцахуйг дэмжсэн байх; хүмүүнлэг; тэгш хамруулах, ялгаатай хэрэгцээг хүндэтгэх; багшлахуй, суралцахуйн нэгдлийг хангах (заахаас илүү суралцахуйд, өрсөлдөхөөс илүү хамтрахад чиглэсэн, олон хэл, цахим технологи ашиглаж шинэ мэдлэг бүтээх, бодит асуудалд суурилсан утга учиртай суралцахуйг дэмжсэн, суралцахуйн баяр баясал, үнэ цэнийг суралцагчдад мэдрүүлэхүйц багшлахуй, суралцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх); тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санаа, хамтын ажиллагаанд суурилсан байх зарчмыг баримтлахаар тус тус заажээ.

Дээрх үзэл баримтлалд нийцүүлэн бага боловсролын сургалтын хөтөлбөрийг суралцагчийн нас, танин мэдэхүйн онцлогийг харгалзсан, сургуулийн өмнөх боловсролын түвшинтэй залгамж холбоотой байхаар шинэчлэн боловсрууллаа.

Бага боловсролын сургалтын хөтөлбөр нь сургуулийн түвшинд суралцагчийн сурах үйл ажиллагааг дэмжсэн удирдлага, манлайллыг хэрэгжүүлэх, багшид суралцагчийн чадамжийг хөгжүүлэх өдөр тутмын танхимын, танхимын бус сургалт, бие даан суралцах үйл ажиллагааг төлөвлөх, чиглүүлэх, суралцагчид зорилготойгоор сурах, эцэг эх асран хамгаалагчдад хүүхдийнхээ сурах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд баримтлах үндсэн баримт бичиг болно.

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багшийн ном, сурах бичиг, дасгал ажлын дэвтэр нь сургалт, үйл ажиллагааны үндсэн хэрэглэгдэхүүн, салшгүй хэсэг байна.

ХОЁР. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ХҮРЭХ ҮР ДҮН

Бага боловсролын сургалтын хөтөлбөр нь 1-5 дугаар ангийн суралцагчийн эх хэл, бичиг үсэг, математик, компьютерын ухаан ба цахим технологи, байгаль, нийгмийн ухаан, урлаг гоо зүй, гадаад хэлний суурь чадамж, бүтээлчээр сэтгэх, шүүн тунгаах, нийгэм сэтгэл хөдлөлийн ерөнхий чадамж, эрүүл мэнд, бие бялдрын зөв дадал, үндэсний болон дэлхийн өв соёлоос суралцах сурах арга барилыг хөгжүүлэх зорилготой.

Бага боловсролын түвшинд суралцагчийн эзэмших суурь болон ерөнхий чадамжийн хөгжил нь дараах үр дүнд хүрсэн байна.

Хүснэгт 1. Суралцагчийн эзэмших суурь чадамж ба хүрэх үр дүн

Суурь чадамж	Хүрэх үр дүн
Эх хэл, бичиг үсэг	<ul style="list-style-type: none"> - Эх хэлээрээ бичиг үсэгт тайлагдан, уншсан сонссоноо ойлгож тодорхой сэдвээр санаа бодлоо яриа, бичгээр бүтээлчээр илэрхийлж, харилцдаг, сонирхол, хэрэгцээндээ нийцүүлэн унших дадалтай болсон байна. - Шинжлэх ухааны суурь мэдлэг ойлголт, үг хэллэгийг ойлгох, хэрэглэх, хийж гүйцэтгэсэн үр дүнгээ эх хэлээрээ болон бичиг, зураг дүрслэлээр бусдад ойлгомжтой илэрхийлж тайлбарладаг болсон байна.
Математик	<ul style="list-style-type: none"> - Тоо, тоолол, хэмжигдэхүүн, дүрс, биет, өгөгдлийн талаар суурь ойлголтыг мэддэг, түүнийгээ математикийн болон ахуй амьдралын энгийн асуудлыг шийдэхэд хэрэглэдэг болсон байна. - Аливаа асуудлыг математик ухагдахуун, хамаарал, арифметик үйлдэл ашиглан загварчилдаг, шийдвэрлэдэг, танил болон танил бус нөхцөлд хэрэглэдэг, математик сэтгэлгээгээр ханддаг болсон байна.
Шинжлэх ухаан (байгалийн нийгмийн) ухаан ба нийгмийн	<ul style="list-style-type: none"> - Байгаль, нийгмийн танил орчны үзэгдэл, үйл явдлыг сонирхон, хэд хэдэн эх сурвалжаас шинжлэн судалдаг, үр дүнг нь төрөл бүрийн арга хэлбэрээр илэрхийлдэг болсон байна. - Байгаль нийгмийн үндсэн ухагдахууны мэдлэг ойлголтоо өдөр тутмын амьдралд хэрэгжүүлдэг, байгальд ээлтэй, хариуцлагатай ханддаг болсон байна. - Нийгэм, түүхийн үйл явдал болон үндэсний өв соёл, уламжлал (ургийн бичиг, уламжлалт баяр ёслол, хувцас хэрэглэл, бэлгэдэл, цээр зэрэг)-аа ойлгож мэддэг, хүндэтгэлтэй ханддаг, амьдралд хэрэглэдэг болсон байна. - Хүний эрх, ялгаатай байдалд хүндэтгэлтэй ханддаг, дүрэм журмыг мөрддөг болсон байна.
Компьютерын ухаан ба цахим технологи	<ul style="list-style-type: none"> - Цахим орчинд ёс зүйтэй бие даан болон хамтран ажилладаг, харилцдаг, аюулгүй байдлаа хангадаг болсон байна.

	<ul style="list-style-type: none"> - Энгийн алгоритм төлөвлөж, кодчилдог болсон байна. - Цахим технологийн талаар ойлголттой болж, ухаалаг хэрэгслүүд, тэдгээрийг үүрэг, зориулалтын дагуу аюулгүй хэрэглэдэг болсон байна. - Цахим орчноос мэдээлэл ашигладаг, зарим хэрэглээний программ ашиглан боловсруулдаг, өгөгдөл, хиймэл оюуны талаар анхан шатны ойлголт мэдлэгтэй болсон байна.
Англи хэл болон бусад гадаад хэл	<ul style="list-style-type: none"> - Гадаад хэлээр сонсох, ярих, унших, бичих анхан шатны чадвартай, үгийн нөөцтэй, тэр хүрээндээ өөрийгөө илэрхийлдэг болсон байна. - Гадаад хэлээр дамжуулан улс орны соёл, уламжлалаас суралцаж, бусдын ёс заншил, ялгаатай байдалд хүндэтгэлтэй ханддаг болсон байна.
Бие болон сэтгэл зүйн эрүүл мэнд, сайн сайхан байдал	<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэнд, биеийн онцлогт тохирсон идэвхтэй хөдөлгөөн тогтмол хийдэг эрүүл ахуйн зөв дадалтай болсон байна. - Өөрийн болон бусдын сэтгэл хөдлөлийг таньж, ойлгодог, сөрөг сэтгэл хөдлөлөө хянаж, зохицуулдаг болно. - Бусдыг сонсдог, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрдөг, мэдрэмж, санаа бодлоо зохистой илэрхийлдэг, гадуурхалт, дээрэлхийн зан үйл гаргадаггүй байна.

Хүснэгт 2. Суралцагчийн эзэмших ерөнхий чадамж

Ерөнхий чадамж	Хүрэх үр дүн
Бүтээлчээр сэтгэх	<ul style="list-style-type: none"> - Эзэмшсэн мэдлэг, чадвараа танил, танил бус нөхцөлд хэрэглэдэг, асуудлыг шийдэх хувилбар, санаа гаргадаг болсон байна. - Өмнөх туршлагадаа суурилан бүтээл хийх, бүтээлийн зарим нөхцөлийг өөрчлөх замаар шинэ санаа гаргадаг болсон байна. - Бусдын бүтээл, асуудлын шийдэл, үр дүнг өөрийнхтэйгөө харьцуулдаг, сайжруулдаг болсон байна.
Шүүн тунгаах	<ul style="list-style-type: none"> - Асуулт асуудаг, асуудлыг тодорхойлдог болсон байна. - Ялгаатай эх сурвалжийг ашиглан мэдээлэл цуглуулдаг, хэрэгтэй мэдээллээ ялгаж таньдаг, харьцуулдаг, баримт нотолгоотой дүгнэлт тайлбар гаргадаг болсон байна. - Шалтгааныг хайдаг, өөрийн байр суурийг илэрхийлдэг, багшийн тусламжтай шийдвэр гаргадаг болсон байна.
Суралцахууд суралцах	<ul style="list-style-type: none"> - Ахиц дэвшлээ хянадаг, цаашид юу хийхээ төлөвлөдөг болсон байна. - Бие даан болон бусадтай хамтран сурдаг, технологийг аюулгүй, ёс зүйтэй ашиглан сурах арга замыг мэддэг, хэрэглэдэг болсон байна.
Нийгэм, сэтгэл хөдлөлийн хөгжил	<ul style="list-style-type: none"> - Өөрийн таатай, таагүй мэдрэмжээ зохистой илэрхийлдэг болсон байна. Өөрийгөө хянах, сэтгэл хөдлөлөө удирдах энгийн аргыг хэрэглэдэг болсон байна.

	<ul style="list-style-type: none"> - Бусдын сэтгэл хөдлөлийг ойлгож, тэдний оронд өөрийгөө тавьж хүндэтгэлтэй ханддаг болсон байна. - Бусдад туслах, талархах сэтгэлийг эрхэмлэх хандлагатай болсон байна.
Үндэсний болон дэлхийн соёлоос суралцах, өвлөх	<ul style="list-style-type: none"> - Үндэсний соёлын биет болон биет бус өвийн талаар ойлголт мэдлэгтэй, тэдгээрийг ялган таньдаг болсон байна. - Уламжлал, ёс заншлаас суралцдаг, өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэхийг эрмэлздэг болсон байна. - Монгол болон бусад улс, үндэстний соёлын ялгааг ойлгож, тайлбарладаг, бусдын соёлыг хүндэтгэдэг болсон байна. - Хүрээлэн буй орчноо танин мэдэж, хайрлан хамгаалах хандлагатай болсон байна.

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалт, үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Эх хэл, түүх, соёл, өв уламжлалд тулгуурласан байх;
- Гэр бүл, сургууль, байгаль, нийгмийн танил орчны асуудалд суурилсан байх;
- Зохион байгуулалт нь хүүхдийн эрхийг хангасан, тэгш боломжийг бүрдүүлж, хамруулсан байх;
- Хэл, соёлын ялгаатай хэрэгцээнд нийцүүлж, тохируулсан байх;
- Сургалт болон бусад үйл ажиллагаанд суралцагч идэвхтэй оролцох, санаачлах, бүтээлчээр хандахыг дэмжиж, чиглүүлсэн байх;
- Суралцагч бие даан болон хамтран суралцах боломжийг бүрдүүлсэн, тэдний ялгаатай санал бодол, шийдлийг хүлээн зөвшөөрч, тэгш оролцоог дэмжсэн байх;
- Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, олон нийт, иргэдийн оролцоо, хамтын хариуцлагад суурилсан байх;
- Технологийн дэвшлийг ашигласан байх;

- ГУРАВ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА

Бага боловсролын сургалтын хөтөлбөр нь холбогдох хууль болон сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд заасан нийтлэг болон судлагдахууны агуулгаас бүрдэнэ.

Судлагдахууны агуулгыг суралцагчийн эзэмших суурь болон ерөнхий чадамж, сургуулийн өмнөх болон суурь боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгатай уялдуулан, залгамж холбоог харгалзан тодорхойлсон бөгөөд судлагдахууны хөтөлбөр бүрд ай болон дэд айгаар тусгасан. Бага ангид суралцагчийн эх хэл, бичиг үсэг, тоо тоолол, цахим технологи, урлаг, дизайн, гоо зүйн чадвар, үндэсний соёл, өв уламжлалын талаар ойлголт, мэдлэг, дадлыг хөгжүүлэх агуулга, үйл ажиллагаатай. Суралцагчийн эх хэл, бичиг үсэг, цахим технологийн чадамж, үндэсний соёл, өв уламжлалын талаар ойлголт, мэдлэг, дадлыг хөгжүүлэх агуулгыг судлагдахуун бүрийн агуулга, үйл ажиллагаанд заавал тусгаж хэрэгжүүлнэ.

Нийтлэг агуулгыг хүний эрхийн боловсрол, жендэрийн эрх тэгш байдал, иргэний ёс зүй, хувь хүн, гэр бүлийн төлөвшил, амьдрах ухаан, хүн төрөлхтний

нийтлэг үнэт зүйл, тогтвортой хөгжлийн боловсрол, эдийн засаг, санхүүгийн боловсролын мөн гамшгаас хамгаалах, аюулгүй амьдрах ухаан, ажил мэргэжлийн чиг баримжаатай холбоотой чадвар эзэмшүүлэх, эх оронч сэтгэлгээтэй, хүмүүнлэг иргэнийг төлөвшүүлэх чиглэлээр агуулгын багтаамж, гүнзгийрэл, мэдлэг, чадвар, хандлагатай уялдуулж, судлагдахууны сургалтын хөтөлбөр бүрд тусгасан.

Бага боловсролын судлагдахуун бүрийн сургалтын хөтөлбөрт дараах нийтлэг агуулгыг интеграцчилан тусгасан.

Хүснэгт 3. Нийтлэг агуулга

Агуулгын чиглэл	I-II анги	III-V анги
Үндэсний соёл уламжлал, эх оронч сэтгэлгээ	Уламжлалт баяр ёслол, байгаль хамгаалах уламжлал, үндэсний дээл хувцас, хэрэглэл;	Монгол төрийн бэлгэ тэмдэг, тэдгээрийн бэлгэдэл, байгалийн онцлог, байгаль хамгаалах уламжлал, түүхэн хүмүүс, бахархал, үндэсний хувцас хэрэглэл, нүүдэллэх ёс;
Хүний эрхийн боловсрол	Гэр бүл, ангийн орчин дахь оролцоо, дүрэм;	Хийх ёстой болон хийж болохгүй зүйл, дүрэм, хүүхдийн эрх, хүүхдийн эрхийн зөрчил, оролцоо, тэгш байдал;
Жендэрийн эрх тэгш байдал	Хүйсийн ялгаварлалгүй оролцоо, хамтын ажиллагаа;	Хүйсийн ялгаварлалгүй оролцоо, харилцан хүндэтгэлтэй хамтын ажиллагаа;
Иргэний ёс зүй	Монгол хүүхдийн эрхэмлэх зүйл, зөв ба буруу, сайн ба муу үйл, хүндэтгэл, баримтлах ёс уламжлал, эв эе, дүрэм;	Ёс суртахуунтай үйлдэл, шударга байдал, эв эе, эрх үүрэг, дүрэм, хариуцлага;
Эрүүл мэндийн боловсрол	Хооллолт, хөдөлгөөн, амралт, ариун цэвэр, сэтгэл хөдлөл;	Бие махбодын болон сэтгэл зүйн эрүүл мэнд, хооллолт, шим тэжээл, дасгал хөдөлгөөн, амралт, ариун цэвэр, сэтгэл хөдлөл, мэдрэмж;
Хүмүүнлэг иргэн	Ачлал, хүндэтгэл, ач тус;	Бусдыг ачлах, энэрэх сэтгэл, хүндэтгэл, байгальд ээлтэй хандлага, хариуцлага;
Тогтвортой хөгжлийн боловсрол	Байгаль орчин, ус, цахилгааны хэмнэлт, хог хаягдлыг ангилах, ашиглах;	Байгаль орчинд тулгамдсан асуудал, шийдэх арга зам, эерэг шийдэл; Байгаль орчинд ээлтэй амьдрах, аялах
Гамшгаас хамгаалах, аюулгүй амьдрах арга ухаан	Аюултай, аюулгүй зүйл (гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, гал, замын хөдөлгөөн), бусдын тусламж, дэмжлэг;	Аюултай, аюулгүй зүйл (гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, гал, замын хөдөлгөөн), бусдын тусламж, дэмжлэг, урьдчилан сэргийлэх арга зам;
Ажил мэргэжлийн чиг баримжаа	Аав, ээжийн хийдэг ажил хөдөлмөр, талархал;	Мэргэжил, ажил хөдөлмөрийн онцлог, ач холбогдол, талархал, бахархал;
Эдийн засаг, санхүүгийн боловсрол	Хүмүүсийн эрхлэх аж ахуй, мөнгөн дэвсгэрт, худалдаа;	Байгалийн нөөц, үйлдвэрлэл, аж ахуй, хэрэглээ, хуримтлал;

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ агуулгыг орон нутгийн түүх соёл, түүхэн болон байгалийн дурсгалт газар, хэлний онцлогийг харгалзан, суралцахуйн үр дүнтэй нийцүүлэн баяжуулж болно.

Сургалтын хөтөлбөрийн агуулга, суралцахуйн үр дүнгийн тодорхой хэсгийг танхимын бус сургалт, үйл ажиллагаагаар хэрэгжүүлнэ. Тухайлбал, эрүүл мэндийн хоол тэжээлтэй холбоотой агуулгыг үдийн хоолны цагаар хоол тэжээлийн тухай мэдлэгтэй болох, хоолны өмнө гараа, дараа нь шүдээ тогтмол угаадаг болох зэрэг дадалтай болгох байдлаар зохион байгуулна.

ДӨРӨВ. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

Бага боловсролын 1-5 дугаар анги нь суралцагчийн танин мэдэхүйн хөгжлийн хамгийн чухал үе юм. Энэ үеийг бодит үйлдлийн үе шат гэж үздэг бөгөөд хүүхэд юмсыг гараар барьж мэдэрч, танил орчин дахь бодит зүйлс, асуудлаар дамжуулж суралцдаг учир сургалт, үйл ажиллагаанд үе тэнгийнхэн, найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ харилцаж хамтран ажиллах арга зүй хэрэглэх нь тохиромжтой.

Бага боловсролын 1-2 дугаар ангийг “уншиж сурах” үе, 3-5 дугаар ангийг “сурахын тулд унших” үе гэж тодорхойлдог. “Уншиж сурах” үед суралцагч үсгээ таньж, холбон уншиж сурах бөгөөд үг, өгүүлбэр, богино эх; зураг дүрслэл унших, үгийн сангаа баяжуулах, өгүүлбэр зохиох, дэлгэрүүлэх чадвар эзэмшиж, богино эх зохиож эхэлнэ. Энэ үед суралцагчдад хэл заслын зарим арга, техникийг тогтмол хийлгэдэг байх нь эх хэлний суурь чадварын хөгжилд чухал үүрэгтэй.

Бага насны хүүхдийн гар хурууны жижиг булчин, үе бүрэн бэхжээгүй байдаг тул хуулан бичлэгийг их хийлгэх нь зохисгүй. Иймээс бага ангид бичих үйлийн ачааллыг зохистой хэмжээнд төлөвлөж, хүүхдийн бие физиологийн онцлогт нийцүүлэн зохион байгуулна. Суралцагчдыг балын харандаагаар бичихийг дэмжиж, тэдэнд алдаагаа засах, өөрийгөө хянах дадал төлөвшүүлэх боломж олгохын зэрэгцээ хуулан бичлэг, цээж бичгийн хэт ачааллыг бууруулж, суралцах үйл явцыг дэмжих нөхцөлийг бүрдүүлнэ. Түүнчлэн зөв суух нь суралцагчийн биеийн зөв хөгжил, анхаарал төвлөрөл, бичгийн чанарт эерэг нөлөөтэй тул дадал хэвшил болгоход онцгойлон анхаарна.

Харин 3 дугаар ангиас эхлэн “Уншиж сурах” үеэс “сурахын тулд унших” буюу уншиж сурснаа судлагдахууны мэдлэг чадвар эзэмших хэрэгсэл болгон ашиглахад шилждэг учир суралцагчид танин мэдэхүйн ачаалал үүсгэхгүй байхад анхаарна. Энэ үед суралцагчийн ойлгож унших чадвар илүү хөгжиж, уншсан агуулгыг эргэцүүлэн бодох, дүгнэлт хийх, ойлгосноо өөрийн үгээр илэрхийлэх чадвар хөгжинө.

Бага ангид суралцагч талбай, эзлэхүүн зэрэг хийсвэрлэл шаардсан математик ухагдахууныг сурахад бэрхшээлтэй тулгардаг. Иймд бодит юмс, хэрэглэгдэхүүн ашиглан математик ухагдахууны талаар ойлголт, мэдлэгтэй болгоход анхаарна. Суралцагчийг багшийн заавар, удирдамжийн дагуу үйл ажиллагаанд идэвхтэй оролцох нөхцөл бүрдүүлэх, бодит юмс, хэрэглэгдэхүүнийг гараар барьж мэдэрч гүйцэтгэх үйлийг түлхүү оруулах хэрэгтэй. Даалгавар гүйцэтгэхийн өмнө заавар, бодлогын өгүүлбэрийг суралцагчаар уншуулах, ойлгосон зүйлийг нь асууж, ярилцах

алхмуудыг заавал хэрэгжүүлнэ. Хичээл, сургалтын үйл ажиллагааны төгсгөлд өөрийн хийснээ эргэцүүлдэг, бусдынхтай харьцуулдаг, шалгадаг, хамтдаа ярилцдаг байх нь математикийн агуулгыг илүү сайн ойлгоход чухал түлхэц болно.

Суралцагчийн анхаарал төвлөрөх хугацаа багасаж байгаатай холбоотой анхаарал төвлөрлийг нэмэгдүүлэх дасгал, бясалгалын хялбар элемент зэргээс хийлгэж хэвших нь урт хугацаандаа сурах үйл ажиллагаанд чухал нөлөөтэй байна. Мөн суралцагчдын танин мэдэхүйн хөгжлийн онцлог, өмнөх туршлага, бие бялдар, нийгэм сэтгэл хөдлөл, танин мэдэхүйн хөгжлийн онцлогийг харгалзан хамтран суралцах, сонирхон судлах, шинжлэн судлах, тоглоом, орчин, даалгавар, зохиолд суурилсан болон тодорхой, дүрслэл, хийсвэрлэл, асуудал шийдвэрлэх төсөлд суурилсан арга зүйгээс судлагдахууны агуулгатай уялдуулан хэрэгжүүлнэ. Эдгээр арга зүйг ямар үе шат, алхмуудаар дамжуулан хэрэгжүүлэхийг судлагдахуун бүрийн сургалтын хөтөлбөрт тусгасан болно.

Суралцагчийн бүтээлчээр сэтгэх, асуудал шийдвэрлэх, хамтран ажиллах, сурч мэдсэнээ ашиглан асуудал шийдвэрлэх чадамжуудыг хөгжүүлэхэд чиглэсэн төсөлт ажлуудыг төлөвлөж хэрэгжүүлэх, хэлэлцэх, ялгаатай санал гаргах зэргийг тогтмол дэмжиж, чиглүүлж ажиллана. Суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадварын ялгаатай байдлыг харгалзсан даалгавар, дасгалын нээлттэй цахим сан, бусад нөөцийг сургалт, үйл ажиллагаандаа ашиглана.

Дээрх санал болгосон арга зүйг багш сургалт, үйл ажиллагаандаа бүтээлч санаа, орон нутгийн нөөц, эх сурвалжаар баяжуулан ашиглах боломжтой.

ТАВ. СУРГАЛТЫН ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Бага боловсролын сургалтын хөтөлбөрийг танхимын болон танхимаас гадуурх сургалт, бие даах үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх бөгөөд орчин, хэрэглэгдэхүүний тодорхой нөхцөл, шаардлага хангагдсан байхад анхаарна.

Сургалтын материаллаг орчны хувьд эрүүл ахуй, аюулгүй байдлын стандартыг хангасан, танхимын бус сургалт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, багаар болон бие даан суралцах боломжтой, бага насны хүүхэд тоглох, амрах орон зай бүхий тохижилттой анги танхимтай, судалгаа, туршилт, хамтын бүтээл, төсөл хийх лаборатори, өрөөтэй байх шаардлагатай. Орчин нь хөгжлийн онцлог, ялгааг харгалзсан суралцагч саадгүй хөдлөх, суралцах нөхцөлийг хангасан байна. Анги танхимын ширээ, сандал нь хүүхдийн биеийн өсөлтөд нийцсэн, хөнгөн, багийн үйл ажиллагаа зохион байгуулах боломжтой байна.

Түүнчлэн цахим сургалт зохион байгуулах, хиймэл оюун, үүлэн технологи, их өгөгдөл, тоног төхөөрөмжид суурилсан интернэтийн сүлжээ, виртуал орон зай бүхий цахим орчинтой байна.

Сургалтын сэтгэл зүйн орчин нь суралцагчийн эрх, ялгаатай байдлыг хүндэтгэсэн, найрсаг, харилцан хүндэтгэлтэй, хамтын ажиллагааг дэмжсэн уур амьсгалтай, багш–суралцагчийн итгэлцэлтэй, нээлттэй, аюулгүй харилцааг дэмжсэн, бусадтай санал, бодлоо чөлөөтэй солилцох, харилцах, хамтран суралцах

болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, гадуурхалт, дээрэлхлээс ангид, гэр, орон нутаг, бодит амьдралтай холбосон үйл ажиллагаанд оролцох боломж, нөхцөлтэй байна.

Хэрэглэгдэхүүн нь суралцагчид тэгш хүртээмжтэй, хэрэглэх заавар нь ойлгомжтой, хэвлэмэл, цахим болон биет хэлбэрээр байна. Сургуулийн удирдлага хэрэглэгдэхүүний хангалт, хүртээмжтэй байдалд тогтмол үнэлгээ хийж, шаардлагатай хэрэглэгдэхүүнээр хангахын зэрэгцээ сургуулийн нөөцийг ашиглан дахин хэрэглэх боломжтой гарын доорх материалаар сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэж баяжуулан хэрэглэнэ. Цахим агуулга, хэрэглэгдэхүүнийг ашиглах зорилгоор суралцагч бүр, тэр дундаа III-V ангийн суралцагчид ухаалаг хэрэглэгдэхүүнээр бүрэн хангагдсан байх шаардлагатай.

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хэрэглэгдэхүүний жагсаалтыг судлагдахуун бүрээр гаргасны дагуу зайлшгүй шаардлагатай хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг суралцагч бүрд хүртээмжтэй байхаар бэлтгэж, ашиглана. Үүнээс гадна судлагдахууны хөтөлбөрийн суралцахуйн үр дүн бүрийг хэрэгжүүлэх жишиг үйл ажиллагаа болон шаардагдах нөөц эх сурвалжийг (цахим контент, хичээлийн холбоос зэрэг) жагсаалтаар оруулсан бөгөөд багш эрэл хайгуул хийж, бусад багш нарын сайн туршлагыг ашиглах замаар баяжуулан хэрэглэж болно.

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг шаардлагатай хэрэглэгдэхүүнээр бүрэн хангана. Үүнд аудио болон брайл сурах бичиг, сонсох төхөөрөмж, ухаалаг хэрэглэгдэхүүн зэрэг хамаарна.

ЗУРГАА. ҮНЭЛГЭЭНД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Бага боловсролын сургалтын хөтөлбөрийн үр дүнг боловсролын чанарын үнэлгээгээр Боловсролын ерөнхий хуулийн 17.11-д заасан байгууллага холбогдох журмын дагуу үнэлнэ. Боловсролын чанарын үнэлгээ нь суралцагчийн эзэмшсэн суурь болон ерөнхий чадамжийн түвшин, хот, хөдөөгийн суралцагчийн эзэмшсэн чадамжийн түвшний зөрүүг тогтоох, түүнд нөлөөлсөн хүчин зүйлийг илрүүлэх, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах арга замыг тодорхойлоход чиглэнэ.

Судлагдахууны хөтөлбөрийн үр дүнг анги бүрээр үнэлэх ба үнэлгээг сургуульд суурилан зохион байгуулна. Энэхүү үнэлгээ нь явцын, үр дүнгийн гэсэн төрөлтэй байх бөгөөд суралцагчийн эзэмшсэн сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилт дахь мэдлэг, чадварын түвшнийг тодорхойлох, тэдэнд дэмжлэг үзүүлэх, үнэлэлт дүгнэлт өгөхөд чиглэнэ.

- Явцын үнэлгээ нь суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага, төлөвшлийн давуу болон сул талыг илрүүлэх, ахиц, дэвшлийг урамшуулах, сурах үйлийг чиглүүлэх, шаардлагатай дэмжлэг үзүүлэх зорилготой байна.
- Үр дүнгийн үнэлгээ нь суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагад гарсан ахиц дэвшлийг урамшуулах, хүрсэн түвшнийг үнэлэхэд чиглэнэ.

Явцын үнэлгээнд суралцагчийн өөрийн болон үе тэнгийнхний үнэлгээг тооцно. Үнэлгээний даалгавар нь бодит амьдралын энгийн асуудлыг (тухайлбал аяллын

төсөв гаргах, танил орчин дахь асуудлын талаар эх бичих, ургамал, мод тарих, түүнийг ажиглах, шинжлэн судлах, зэрэг) бие даан болон хамтаараа шийдэхэд чиглэсэн байна.

Судлагдахууны хөтөлбөрт үнэлгээний зорилго, шалгуурыг тус тусад нь тодорхойлсон бөгөөд шалгуур нь суралцахуйн үр дүнд тодорхойлсон мэдлэг, чадвар, хандлага, төлөвшилд суурилсан болно.

Үнэлгээнд дараах зарчмыг баримтална:

- Үнэлгээний арга, хэрэгсэл нь тохирцтой, найдвартай, үнэлгээний зорилгод нийцсэн байх;
- Ялгаатай байдлыг харгалзсан, цогц, тэгш хамруулсан байх;
- Уян хатан, тасралтгүй, баталгаатай эх сурвалжид үндэслэсэн байх;
- Үнэлгээг багшлахуйн болон суралцахуйн нэг хэсэг болгох, суралцахуйн үйл явц, ахиц, амжилтыг урамшуулах, дэмжих, үр дүнг хэмжихэд чиглэсэн байх;
- Суралцагчид нөөц боломж, ахиц, амжилтаа олон хэлбэрээр нотлон харуулах боломж олгосон байх;
- Суралцагчид алдаагаа засах боломж олгох, цаг хугацааны хувьд тохиромжтой байх;
- Суралцагч суралцахуйн зорилгодоо хүрэх, ахиц, амжилтаа хянах, үнэлэхэд оролцох тэгш боломжоор хангасан байх;

Бага боловсролын эхлэл шатлалд үнэлгээ нь суралцагчийн чадамжийн ахиц, хөгжлийг урамшуулах, шаардлагатай дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Бага боловсролын төгсгөл шатлалд үнэлгээ нь суралцагчийн чадамжийн ахиц, хөгжлийг тодорхой шалгуурт суурилан үнэлж дүгнэх, сурлагын амжилтыг баримтжуулахад чиглэнэ.

Үнэлгээнд ажиглалт, туршилт, асуулт хариулт, сорил, ярилцлага, бүтээлийн сан, илтгэл, бие даах ажил, жүжигчилсэн тоглолт, үзүүлбэр зэрэг арга хэрэгслийг тухайн үнэлгээний зорилгод нийцүүлэн сонгон хэрэглэнэ. Явцын үнэлгээнд цахим системийг ашиглаж болох бөгөөд энэ нь багшид үнэлгээний үр дүнг богино хугацаанд харж, дүгнэлт өгөх боломжийг олгоно.

ДОЛОО. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТОХИРУУЛГА

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн хөгжлийн онцлог, ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн сургалтын хөтөлбөрийг тохируулан хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийн тохируулгыг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн оролцоотой “Үйл хөдлөл, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал”-д үндэслэн хийж, тэдний хүсэлт, зөвшөөрөлд үндэслэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ. Ингэхдээ тохируулгат хөтөлбөрөөр суралцах суралцагчид шаардлагатай дэмжих үйлчилгээг холбогдох талуудтай хамтран тодорхойлж хэрэгжүүлнэ.

Ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийн хувьд тэдний онцлог, ялгаатай хэрэгцээг харгалзан дараах байдлаар тохируулга хийнэ

- Сургалтын агуулгын тохируулга: Суралцагчдын ялгаатай хэрэгцээ, хөгжлийн онцлогоос шалтгаалан агуулгын багтаамж, гүнзгийрэлд тохируулга хийнэ. Танин мэдэхүйн ачааллыг харгалзан зарим судлагдахууны агуулгыг интеграцчилсан байдлаар суралцах боломжийг олгоно. Агуулгад тохируулга хийхдээ суралцагчийн “ойрын бүсийн хөгжил”-д голлон анхаарахаас гадна дараагийн ангид болон түвшинд суралцахад хамгийн чухал агуулгад төвлөрөх;
- Сургалтын арга зүйн тохируулга: Багаар болон ганцаарчлан дасгал, даалгавар гүйцэтгэх, хугацааг суралцахуйн хурдад тохирсон, ялгаатай байдлаар төлөвлөх (ихэсгэх, багасгах);
- Үнэлгээний тохируулга: Даалгавар гүйцэтгэх үйл явц, хугацааг тохируулах, нэмэлт цаг олгох, асуултад өөрийн арга хэлбэрээр хариулт өгөхийг зөвшөөрөх, хүүхдэд сурч мэдсэнээ харуулах боломжийг олгох;
- Орчин, хэрэглэгдэхүүний тохируулга: Сургалтын хэрэглэгдэхүүн, тараах материал зэргийг хүүхдийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн хүртээмжтэй, сонголттой болгоно.

Үндэстний цөөнх (казах, тува) хүүхдийн хувьд “Хос хэлний боловсрол, сургалтын талаарх баримтлах чиглэл”-д заасны дагуу тохируулга хийнэ.

Тохируулга нь тухайн түвшний сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнг өөрчлөхгүй. Боловсролын ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд тухайн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн тоо, эсвэл түвшнийг тохируулан өөрчилж болно. Өөрчилсөн суралцахуйн үр дүн нь тодорхой, бодитой, хэмжигдэхүйц үр дүн байх ба тухайн хүүхэд бие даан үзүүлж чадах тодорхой мэдлэг, чадвар, төлөвшлийг илэрхийлнэ.

Хөтөлбөрийн тохируулга хийхдээ ялгаатай хэрэгцээтэй суралцагчийг “тусгай” бүлэг гэж үзэлгүйгээр бүх хүүхдүүдтэй ижил тэгш суралцах, хөгжихөд тулгарч буй саадыг арилгах замаар сургалт, үйл ажиллагаанд тэгш оролцох, хөгжих боломжийг олгоход анхаарна. Ингэхдээ дараах үйл ажиллагааг заавал хэрэгжүүлнэ Үүнд:

- суралцагчдын ялгаатай хэрэгцээ, танин мэдэхүйн хөгжлийн онцлогийг таних, тулгарах саадыг тодорхойлох,
- суралцах орчныг хүртээмжтэй, аюулгүй, олон хувилбартай байхаар төлөвлөх,
- суралцагч мэдлэг, ойлголтоо илэрхийлэх боломжоор хангах (жишээ нь: зураг, яриа, хөдөлгөөн, бүтээл, цахимаар хэрэглэгдэхүүн ашиглаж зэрэг),
- суралцагчийн суралцах хэмнэл, ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн суралцахуйн үр дүнг тохируулах, өөрчлөх шаардлагатай.

Ерөнхий боловсролын сургууль нь суралцагчийн авьяас, чадварыг дэмжих нэмэлт сургалтын хөтөлбөрийг боловсруулан холбогдох байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, иргэдтэй хамтран хэрэгжүүлж болно. Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх нэмэлт сургалтын үлгэрчилсэн хөтөлбөрийг Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага боловсруулна.

НАЙМ. БАГА БОЛОВСРОЛЫН СУДЛАГДАХУУНЫ ХӨТӨЛБӨР

Судлагдахууны хөтөлбөр бүрд суралцагчийн эзэмших суурь болон ерөнхий чадамж болон эдгээр чадамжийн хүрээнд суралцах мэдлэг, чадвар, хандлага, төлөвшлийг суралцахуйн үр дүн байдлаар тодорхойлсон. Суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг хөгжүүлэх суралцахуйн суурь онол, арга зүй, үнэлгээг хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн санал болгосон бөгөөд багш энэ онол, арга зүйг илүү баяжуулан, сайжруулж хичээл, сургалтаа зохион байгуулах боломжтой.

Бага боловсролд дараах судлагдахууныг хоёр шатлалаар судална.

Хүснэгт 4. Бага боловсролын шатлал, анги, судлагдахуун

Шатлал	Анги	Судлагдахуун
Эхлэл	I-II анги	Монгол хэл, Математик, Байгаль шинжлэл, Нийгмийн ухаан, Дүрслэх урлаг, дизайн, Хөгжим, Биеийн тамир, Эрүүл мэнд
Төгсгөл	III-V анги	Монгол хэл, Математик, Байгаль шинжлэл, Нийгмийн ухаан, Компьютерын ухаан, Дүрслэх урлаг, дизайн, Хөгжим, Биеийн тамир, Эрүүл мэнд, Англи хэл

Жич: Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн дийлэнх олонх нь үндэстний цөөнх (казах/тува) байх тохиолдолд бага ангийн сургалт үйл ажиллагааг эх хэлээр нь зохион байгуулахаас гадна хос хэлээр зохион байгуулж болно.

МОНГОЛ ХЭЛ

НЭГ. ЗОРИЛГО

1.1. Зорилго:

Монгол хэлний сургалтын хөтөлбөрөөр суралцагчийн сонсох, ярих, унших, бичих суурь чадамж, харилцах, хамтран ажиллах, шүүн тунгаах, бүтээлчээр сэтгэх, монгол хэл, соёлоос суралцах ерөнхий чадамжийг хөгжүүлнэ.

1.2. Хүрэх үр дүн, шатлал

Энэхүү хөтөлбөрийг судалснаар суралцагчид дараах үр дүнд хүрсэн байна.

- Бусдыг сонсож ойлгон, санаа бодлоо бүтээлчээр илэрхийлж харилцдаг болно.
- Унших арга барил эзэмшиж, бие даан унших дадал хэвшилтэй болно.
- Бичих арга барил эзэмшиж, зорилгодоо нийцүүлэн санаа бодлоо уялдаа холбоотой бичиж илэрхийлдэг болно.
- Монгол хэлний зүй, үгийн сангийн анхан шатны мэдлэг эзэмшиж, хэрэглэдэг болно.
- Монгол хэл, соёлоо танин мэдэж, үнэ цэнийг нь ойлгож, суралцдаг болно.

№	Хүрэх үр дүн	Шатлал	
		I-II анги	III-V анги
1	Бусдыг сонсож ойлгон, санаа бодлоо бүтээлчээр илэрхийлж харилцдаг болно.	- Яриаг чих тавин сонсож, гол агуулгыг ойлгодог, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж, хүндэтгэн харилцдаг болно.	- Бусдын санаа бодлыг ойлгон, өөрийн байр суурийг жишээ баримттай илэрхийлдэг болно. - Сонгосон сэдвээр мэдээлэл цуглуулж, тохирох үг хэллэг хэрэглэн уялдаа холбоотой ярьдаг болно.
2	Унших арга барил эзэмшиж, бие даан унших дадал хэвшилтэй болно.	- Эхийг чанга дуугаар түгдрэлгүй уншиж, ойлгосноо тохирох хэлбэр (ярих, бичих, зурах, дүрслэх)-ээр илэрхийлэн, ном уншихын баяр хөөрийг мэдэрч, унших хүсэл сонирхолтой болно.	- Эхээс тодорхой зорилгоор мэдээлэл хайн уншиж, гол санааг ойлгон дүгнэж, уншсанаа амьдралтай холбон илэрхийлж, өргөн хүрээнд бие даан уншдаг болно.
3	Бичих арга барил эзэмшиж, зорилгодоо нийцүүлэн санаа бодлоо уялдаа холбоотой бичиж илэрхийлдэг болно.	- Эргэн тойронд болсон үйл явдал, өөрийн санаа бодол, мэдрэмжийг илэрхийлсэн өгүүлбэр, богино эх бичдэг болно.	- Зорилгодоо нийцүүлэн, догол мөр хоорондын уялдаа холбоог гаргаж, санаа бодол, төсөөллөө бүтээлчээр илэрхийлж, найруулж, зохиож бичдэг болно.
4	Монгол хэлний зүй, үгийн сангийн анхан шатны мэдлэг эзэмшиж, хэрэглэдэг болно.	- Өдөр тутмын харилцааны үгийн сан эзэмшиж, яриа бичигтээ хэрэглэдэг, зөв бүтэцтэй өгүүлбэр зохиож, утгын уялдаатай	- Өдөр тутмын ба нийгмийн харилцааны өргөн хүрээний үг, нутгийн аялгууны үгсийг мэдэж хэрэглэдэг болно. - Үг, өгүүлбэрийн анхан шатны

		дэлгэрүүлж бичдэг болно.	мэдлэг эзэмшиж, яриа бичигтээ хэрэглэдэг болно.
5	Монгол хэл, соёлоо танин мэдэж, үнэ цэнийг нь ойлгож, суралцдаг болно.	- Монгол аман зохиол, сонгодог уран зохиолоос уншиж, ойлгон тогтоож, монгол хэл, соёлын үнэт зүйлээс суралцана.	- Монгол аман зохиол, сонгодог уран зохиол, бүтээлээс уншиж ойлгох, монгол хэл, соёлын үнэ цэнийг таньж, ухаарах чадвартай болно.

ХОЁР. АГУУЛГА

2.1. Бага боловсролын эхлэл шатлал

Агуулгын ай 1. Сонсох-ярих

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Сонсох	1.1а. Өгүүлбэр, богино эхийг анхааралтай сонсож, ойлгосноо илэрхийлнэ. (тоочин ярих, зураг, үйлдлээр харуулах)	2.1а. Сонссон сэдвийн хүрээнд асууж лавлан, хариултын олон хувилбар эрэлхийлдэг болно.
Ярих	1.1б. Өөрийн тухай, гэр бүл, найз нөхөд, дуртай зүйлс зэрэг танил сэдвээр бүтэн өгүүлбэрээр, утгын уялдаатай ярина.	2.1б. Орчиндоо байгаа хүн ба юмс болон өөрийн сонголтын талаар утгын уялдаатай, дэлгэрэнгүй танилцуулна.
Харилцах	1.1в. Бусдыг анхааралтай сонсож ойлгон, ээлж дараагаар ярина.	2.1в. Харилцааны нөхцөл байдалд тохируулан асуулт асуух, хүсэлт гаргах, татгалзах зэргээр өөрийгөө илэрхийлнэ.

Агуулгын ай 2. Унших

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Унших арга барил	<p>1.2а. Үгийн эхэн, дунд, төгсгөлөөс эгшиг, гийгүүлэгч авиаг ялган сонсож, зөв дуудна.</p> <p>1.2б. Дуудлага бичлэг тохирох 1-2 үетэй танил үгсийг сонсоод, үсэглэж болон үелж хэлнэ.</p> <p>1.2в. Цагаан толгойн 35 үсгийг таньж, 1-2 үетэй үгийг бүтэн үгээр, 3 ба түүнээс дээш үетэй үгийг үелэн зөв дуудан уншина.</p>	2.2а. Эх, өгүүлбэрийг уншихдаа цэг тэмдгийг анхаарч, түгдрэлгүй зөв дуудан уншина.

Уншиж ойлгох	<p>1.2г. Хэн, юу, хэзээ, хаана, яав гэсэн асуулт асууж, хариулах замаар эхийн агуулгаас мэдээлэл олно.</p> <p>1.2д. Монгол аман зохиол (зүйр цэцэн үг, оньсого, хэл зүгшрүүлэх үг, ертөнцийн гурав, бэлгэ дэмбэрлийн үг), богино шүлгийг тогтоон, зөв, тод уншина.</p> <p>1.2е. Үлгэр, өгүүллэгийн үйл явдлыг ойлгож дүр, газар орон, цаг хугацааг багтаан хүүрнэн ярина.</p> <p>1.2ж. Мэдээлсэн тайлбарласан богино эх уншиж, юуны тухай өгүүлж байгааг тодорхойлж, агуулгыг давтан ярина.</p> <p>1.2з. Эх, зураг, бүдүүвчээс тодорхой мэдээллийг ялган танина.</p>	<p>2.2б. Хэн, юу, хэзээ, хаана, яав, ямар, хэрхэн, яагаад гэсэн асуулт асууж, хариулах замаар эхийн агуулгаас мэдээлэл олно.</p> <p>2.2в. Монгол аман зохиол (зүйр цэцэн үг, оньсого, хэл зүгшрүүлэх үг, ертөнцийн гурав, зугаа үг, бэлгэ дэмбэрлийн үг), богино шүлгийг ойлгон тогтоож, бусдад ойлгомжтой уншина.</p> <p>2.2г. Үлгэр, ёгт үлгэр, өгүүллэгийн сургамжит санааг ойлгосноо тайлбарлаж, үйл явдлыг дарааллаар нь тоочин ярина.</p> <p>2.2д. Зохиолын дүрд тулгарсан асуудал, түүнийг хэрхэн шийдвэрлэснийг тодорхойлж, тайлбарлана.</p> <p>2.2е. Өгүүллэгийн дүрүүдийн үг, үйлдлийг харьцуулна.</p> <p>2.2ж. Мэдээлсэн, тайлбарласан эхэд юуны тухай өгүүлж байгааг тодорхойлж, эх дэх тодорхой мэдээллийг давтан ярина.</p> <p>2.2з. Эх дэх зураг, бүдүүвчийг тодорхой мэдээллүүдтэй холбож тайлбарлана.</p>
--------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Агуулгын ай 3. Бичих

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Зөв бичих	<p>1.3а. Цагаан толгойн том, жижиг үсэг, үе, үг, өгүүлбэрийг дэгийн дагуу бичнэ.</p> <p>1.3б. Цагаан толгойн эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсгийг ялган танина.</p> <p>1.3в. Өгүүлбэрт цэг, асуултын тэмдэг хэрэглэдэг болно.</p> <p>1.3г. Өгүүлбэр болон хүн, амьтанд оноож өгсөн нэрийг том үсгээр эхлэн бичнэ.</p>	<p>2.3а. Үг, өгүүлбэрийг дэгийн дагуу, зохих хурдтай бичнэ.</p> <p>2.3б. Эр эм үгийг ялган таньж "ы", "ий" залгаврыг зөв залган бичнэ.</p> <p>2.3в. Эгшигт болон заримдаг гийгүүлэгчийг ялган танина.</p> <p>2.3г. Хоёр авиа тэмдэглэсэн н, г үсгийг ялгаж, зөв бичнэ.</p> <p>2.3д. Аймаг, сум, хот, дүүрэг, суурин газрын нэрийг том үсгээр эхлэн бичнэ.</p>

Зохион бичих	<p>1.3д. Өөрийгөө болон гэр бүл, найз нөхөд, дуртай зүйлээ 4-5 өгүүлбэрээр танилцуулж бичнэ.</p> <p>1.3е. Цуврал зургийг ойлгож, үйл явдлын дараалалтай 4-5 өгүүлбэр бүхий богино эх зохиож бичнэ.</p>	<p>2.3е. Орчин тойрныхоо хүн ба юмсын онцлогийг бүтцийн дагуу танилцуулж бичнэ.</p> <p>2.3ж. Өөрт болон орчинд тохиолдсон үйл явдлыг дарааллын дагуу хүүрнэж бичнэ.</p> <p>2.3з. Харилцаж буй хүндээ тохируулан, баярын мэндчилгээ, талархлын зурвасыг бүтцийн дагуу бичнэ.</p> <p>2.3и. Үлгэрийн зургаас дүрийн гадаад төрхийг дүрсэлж бичнэ.</p>
--------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Агуулгын ай 4. Хэл зүй, үгийн санг хэрэглэх

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Хэл зүйн хэрэглээ	1.4а. Хэн/юу, хэнийг/юуг, яах гэсэн асуултад хариулагдах үгээр энгийн өгүүлбэр зохиож бичнэ.	2.4а. Өгүүлбэрийг ямар, хэд хэчнээн, хэзээ, хаана, яаж, яагаад зэрэг асуултад хариулагдах үгээр дэлгэрүүлж бичнэ.
Үгийн сангийн хэрэглээ	1.4б. Өөрийгөө болон орчноо нэрлэсэн, өдөр тутмын энгийн харилцааны үгсийг мэдэж, хэрэглэнэ.	2.4б. Амьдарч буй байгаль, нийгмийн орчинтой холбоотой түгээмэл үгсийг мэдэж, хэрэглэнэ. 2.4в. Өгүүлбэр зохиохдоо шинж заасан эсрэг утгатай үгийг хэрэглэнэ.

Бага боловсролын төгсгөл шатлал

Агуулгын ай 1. Сонсох-ярих

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Сонсох	3.1а. Сонссон тайлбар, зааврын гол санааг ойлгосноо өөрийн үйлдэл, бүтээл (зураг, бүдүүвч зэрэг)-ээр илэрхийлнэ.	4.1а. Дуут, дуу дүрст бичлэг, бусдын яриаг сонсож, гол санааг алдагдуулахгүйгээр бусдад дамжуулна.	5.1а. Хоёр өөр эх сурвалжаас нэг сэдэвтэй мэдээлэл сонсоод, харьцуулж дүгнэнэ.
Ярих	3.1б. Сэдвийн хүрээнд санаа бодлоо жишээ баримтаар баталж тайлбарлана.	4.1б. Сэдэв, асуудлын хүрээнд санаа бодол, сэтгэгдлээ үндэслэлтэй илэрхийлнэ.	5.1б. Сонгосон сэдэв, асуудлын хүрээнд мэдээлэл цуглуулж,

			илтгэл танилцуулна.	бэлтгэн
Харилцах	3.1в. Харилцааны нөхцөлд тохируулан тайлбар өгөх, уучлалт гуйх, талархах зэргээр өөрийгөө илэрхийлнэ.	4.1в. Хэлэлцүүлгийн үед бусдын санаа бодлыг хүндэтгэн сонсож, байр сууриа үндэслэлтэй илэрхийлнэ.	5.1в. Хэлэлцүүлгийн үед тодруулах асуулт асууж, өөрийн байр суурийг, үндэслэлтэй тайлбарлаж илэрхийлнэ.	

Агуулгын ай 2. Унших

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Унших арга барил	3.2а. Эхийг гүйлгэн уншиж, агуулгыг өөрийн үгээр ярьж, асуултад тохирох мэдээллийг хайж уншина.	4.2а. Өөрт хэрэгтэй баримт, мэдээллийг хайж олох зорилгоор эхийг гүйлгэн уншина.	5.2а. Хэд хэдэн эхийг гүйлгэн уншиж, өөрт хэрэгтэй мэдээллийг сонгон нэгтгэнэ.
Уран зохиол уншиж ойлгох	3.2б. Эхээс асуулт асууж, хариулахдаа тохирох жишээ татаж ойлгосноо харуулна. 3.2в. Монгол болон, бусад үндэстний соёлоос гаралтай домог, үлгэр, ёгт үлгэр, өгүүллэгийн гол санаа, сургамж, ёс суртахуун нь тодорхой мэдээллээр хэрхэн илэрснийг тайлбарлана. 3.2г. Зохиолын дүрүүд үйл явдалд хэрхэн оролцож байгааг тайлбарлана. 3.2д. Зохиолын эхлэл, гол, төгсгөл хэсгийг ялгаж, хэсэг тус бүрд юуны тухай өгүүлснийг тайлбарлана.	4.2б. Тодорхой мэдээлэлд үндэслэн эхэд юуны тухай өгүүлснийг таамаглана. 4.2в. Монгол зохиолчдын болон дэлхийн сонгодог зохиол (шүлэг, өгүүллэг)-ыг уншиж, тодорхой мэдээллээс гол санааг тодорхойлж, хураана. 4.2г. Өгүүллэг, жүжгийн дүр, орчин, үйл явдлыг тодорхой мэдээлэл (дүрийн бодол, үг, үйлдэл зэрэг)-д тулгуурлан тайлбарлана. 4.2д. Шүлэг, өгүүллэгийн тухай ярьж бичихдээ бадаг, хэсэг зэрэг нэр томъёог ашиглаж, хэсгүүдийн дараалал, уялдаа холбоог тайлбарлана.	5.2б. Эх юуны тухай өгүүлснийг дүгнэхдээ оновчтой эш татна. 5.2в. Өгүүллэг, жүжгийн дүрүүдийн зөрчил, түүний шийдэл болон тодорхой мэдээллээс гол санааг тодорхойлж, хураана. 5.2г. Өгүүллэг, жүжгийн хэд хэдэн үйл явдал, орчин, дүрийг тодорхой мэдээлэл (дүрүүд хэрхэн харилцаж байгаа зэрэг)-д тулгуурлан харьцуулна. 5.2д. Зохиолын үндсэн төрлийг ялган таньж, жүжиг (тайзны чиглэл, харилцан яриа, тодорхойлолт, орчин, дүрүүд), шүлэг (айзам хэмнэл) зэрэг нэр томъёог ашиглана. 5.2е. Зохиолд хэрэглэсэн үг хэллэг (зүйрлэл, адилтгал

		4.2е. Зохиолоос шууд бус утгатай үгийг олж, утгыг тодорхойлно.	зэрэг дүрслэлийн хэл)-ийн утгыг тодорхойлно. 5.2ж. Төсөөтэй үйл явдал бүхий монгол болон бусад үндэстний уламжлалт үлгэр, домог, өгүүллэг уншиж, харьцуулна.
Уран зохиолын бус эхийг уншиж ойлгох	3.2е. Хэд хэдэн цогцолбор бүхий эхийн сэдвийг тодорхойлно. 3.2ж. Эх дэх зураг, бүдүүвч тодорхой мэдээллүүд гол санааг хэрхэн дэмжиж байгааг тайлбарлана. 3.2з. Зохиогчийн үзэл бодлыг өөрийн үзэл бодолтой харьцуулна.	4.2ж. Эх дэх тодорхой мэдээлэл нь гол санааг хэрхэн дэмжиж байгааг тайлбарлана. 4.2з. Эх болон эхийн хэсгүүдийн үйл явдал, гол санааг ойлгож, он дараалал, шалтгаан үр дагавар, асуудал шийдлээс хэрхэн тусгасныг тодорхойлно. 4.2и. Тодорхой сэдвээр бичих, ярих зорилгоор шууд, дам эх сурвалжаас авсан мэдээллүүдийг нэгтгэн дүгнэнэ.	5.2з. Эхийн хэсгүүд дэх зураг, бүдүүвч, график, тодорхой мэдээлэл зэрэг нь гол санааг хэрхэн дэмжиж байгааг тайлбарлаж, эхийг хураана. 5.2и. Эхийн үйл явдал, гол санаа, мэдээллийн бүтцийг харьцуулан дүгнэнэ. 5.2к. Тодорхой сэдвээр бичих, ярих зорилгоор олон эх сурвалжаас авсан мэдээллүүдийг нэгтгэн дүгнэнэ.

Агуулгын ай 3. Бичих

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Зөв бичих	3.3а. Балархай эгшгийн ялгах үүргийг таньж, зөв бичнэ. 3.3б. Балархай эгшгийн эгшигжүүлэх үүргийг таньж, зөв бичнэ.	4.3а. Балархай эгшгийн зөөлрүүлэх үүргийг таньж, зөв бичнэ. 4.3б. Хатуу, зөөлний тэмдгийн дүрмийг мэдэж, зөв бичнэ.	5.3а. Үйл үг бүтээх "л" залгаврын балархай эгшгийг зөв бичнэ. 5.3б. Дараалан орсон хоёр гийгүүлэгчийг зөв бичнэ.
Зохион бичих	3.3в. Өдөр тутмын үйл ажиллагааны зааврыг алхам дараалал заасан үг хэллэг хэрэглэн бичнэ.	4.3в. Зорилгодоо нийцүүлэн, хувийн захидал бичнэ. 4.3г. Сургуулийн орчны асуудлын талаар санаа бодлоо илэрхийлэхдээ	5.3в. Сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэн, бүтцийн дагуу өдрийн тэмдэглэл бичнэ. 5.3г. Амьдарч буй орчинд тулгамддаг

	<p>3.3г. Өөрт тулгамдсан асуудлын шалтгааныг тайлбарлаж, санаа бодлоо илэрхийлж бичнэ.</p> <p>3.3д. Сэдвийн хүрээнд өдөр тутмын харилцан яриа бичнэ.</p> <p>3.3е. Уншсан зохиолын талаар төрсөн сэтгэгдлээ тайлбарлан бичнэ.</p> <p>3.3ж. Ертөнцийн гурвын хэлбэрийг дуурайн зохиож бичнэ.</p> <p>3.3з. Зохиолын үйл явдлыг үргэлжлүүлэн утгын уялдаатай зохион бичнэ.</p>	<p>баримтаар нотолж уриалан бичнэ.</p> <p>4.3д. Сургуулийн орчинд болсон онцлох үйл явдлын тухай бүтцийн дагуу баримт нотолгоотой мэдээ бичнэ.</p> <p>4.3е. Өөрт төрсөн мэдрэмж сэтгэгдлээ тусган, бүтцийн дагуу номын танилцуулга бичнэ.</p> <p>4.3ж. Шүлгийн хэлбэрийг дуурайн зохиож бичнэ.</p> <p>4.3з. Өгүүллэгийн дүрийн зан төрхийг хувирган бичнэ.</p>	<p>түгээмэл асуудлыг шийдэх арга замыг баримтаар нотлон бичнэ.</p> <p>5.3д. Дүрсэлсэн үг хэллэг хэрэглэн төсөөллөө хүүрнэж бичнэ.</p> <p>5.3е. Зураг, бүдүүвч, график уншиж тайлбар бичнэ.</p> <p>5.3ж. Адил төстэй шинжийг харьцуулан, утга далдлан оньсого зохиож бичнэ.</p> <p>5.3з. Үйл явдлын орчныг өөрчлөн, богино өгүүллэг зохион бичнэ.</p> <p>5.3и. Зохиолд харилцан яриа нэмж бичнэ.</p>
--	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Агуулгын ай 4. Хэл зүй, үгийн санг хэрэглэх

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Хэл зүйн хэрэглээ	3.4а. Жинхэнэ нэрийг асуултаар ялгаж, эх, өгүүлбэрт утгаар нь зөв хэрэглэнэ.	4.4а. Үйл үгийг асуултаар ялгаж, эх, өгүүлбэрт цагийн утгаар зөв хэрэглэнэ.	5.4а. Тэмдэг нэрийг асуултаар ялгаж, өгүүлбэрт утгаар нь зөв хэрэглэнэ.
Үгийн сангийн хэрэглээ	<p>3.4б. Нийгмийн амьдрал болон сэтгэл хөдлөл, мэдрэмж илэрхийлэх үгсийг мэдэж, хэрэглэнэ.</p> <p>3.4в. Ойролцоо утгатай үгийг хэрэглэн, өгүүлбэр зохионо.</p> <p>3.4г. Бие эрхтний нэр орсон өдөр тутам хэрэглэдэг өвөрмөц хэлцийг таньж, утгыг ойлгон, өгүүлбэрт зөв хэрэглэнэ.</p>	<p>4.4б. Өргөн хүрээний харилцаа болон соёл уламжлалын үгсийг мэдэж, хэрэглэнэ.</p> <p>4.4в. Эсрэг ба ойролцоо утгатай үйл үгийг хэрэглэж, өгүүлбэр зохионо.</p> <p>4.4г. Зан чанар, сэтгэл хөдлөл илэрхийлсэн өвөрмөц хэлцийг таньж, утгыг тайлбарлан, ярьж бичихдээ утгаар нь зөв хэрэглэнэ.</p> <p>4.4д. Эх өгүүлбэр дэх танил биш үгийг тайлбар</p>	<p>5.4б. Хийсвэр сэтгэлгээ болон эргэцүүлэл, байр сууриа илэрхийлэх үгсийг мэдэж, хэрэглэнэ.</p> <p>5.4в. Эх, өгүүлбэр зохиохдоо бичлэг ижил, утга өөр үгсийг таньж, хэрэглэнэ.</p> <p>5.4г. Монгол ахуй, зан заншилтай холбоотой өвөрмөц хэлцийн утгыг ойлгож, тайлбарладаг, ярьж бичихдээ утгаар нь зөв хэрэглэнэ.</p> <p>5.4д. Эх, өгүүлбэр дэх танил биш үгийг хэвлэмэл болон цахим</p>

	<p>толиос толгой үсэг, үеэр хайж, утгыг мэднэ.</p> <p>4.4е. Гэр бүл, орон нутгийн хүмүүсийн ярианд бичгийн хэлнээс ялгаатай хэлэгддэг үгсээс (тагш, аяга, өрлөө-өглөө, охин-басган зэрэг) таньж, мэднэ.</p>	<p>толь бичгээс хайж, тохирох тайлбарт үндэслэн үгийн утгыг мэднэ.</p> <p>5.4е. Нутгийн аялгууны үгсийг бичгийн хэлний ижил утгатай үгтэй нь дүйцүүлэн тайлбарлаж, эх хэлний үгийн сангийн баялгаас танин мэднэ.</p>
--	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

ГУРАВ. АРГА ЗҮЙ, ОРЧИН

3.1. Арга зүй

Бага боловсролын монгол хэлний сургалтын хөтөлбөр нь суралцагчдад сонсож, уншсанаа ойлгон ухаарах, санаа бодлоо тодорхой ярьж, бичих суралцахуйн суурь чадварыг эзэмшүүлэхэд чиглэнэ.

Уншиж сурах үйл явц нь төрөлхийн хэл ярианы чадварыг тэмдэг тэмдэглэгээ (код) тайлах, утгыг тайлбарлах чадвар болгон хувиргадаг танин мэдэхүйн нарийн төвөгтэй шилжилт юм. Унших бичих чадвар нь хүний аяндаа сурдаг чадвар биш тодорхой үе шат бүхий зорилготой сургалтын үр дүнд бий болдог бөгөөд бусад хичээлийг судлах, хувь хүний хөгжил болон нийгмийн амьдралд оролцох наад захын нөхцөл болдог суралцахуйн суурь чадвар юм.

Бага боловсрол түвшинд суралцагчдын унших чадварыг хөгжүүлэхдээ дараах дөрвөн түвшнийг сургалтын үйл ажиллагааны алхам бүрд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

I түвшинд суралцагч "Бичиг үсэгт тайлагдах үе" бөгөөд үг, өгүүлбэр, эхийг зөв дуудан унших шууд утгыг ойлгож, эхээс энгийн мэдээлэл олох чадвартай болно. Энэ нь дараагийн бүх түвшний унших суурь болдог. Энэ үед багш суралцагчийн үг, өгүүлбэр, эхийг түгдрэлгүй зөв унших, үгсийн санг баяжуулах, өгүүлбэрийн бүтцийг таниулахад анхаарна.

II түвшинд суралцагч тогтоосон хугацаанд эхийн агуулгыг ерөнхийд нь ойлгож, бүтэц, төрөл зүйлийн баримжаа авах эрэл хайгуул хийнэ. Суралцагч эх, номын нэр, гарчиг, зураг дүрслэл, эхлэл болон төгсгөл зэргээс агуулгыг урьдчилан таамаглаж, мэдээллийн ач холбогдлыг үнэлэх чадвар эзэмшинэ. Энэ түвшинд суралцагчид олон төрлийн эх уншуулж, унших стратегийг үр дүнтэй төлөвлөж хэрэгжүүлэхэд чиглэнэ.

III түвшинд суралцагч эхийн гол санааг ойлгох, шалтгаан үр дагаврыг илрүүлэх зорилгоор эхийг задлан шинжилж нухацтай уншина. Энэ түвшинд суралцагч мэдээлэл хүлээн авахаас гадна эхийн утга, бүтцийн уялдаа холбоог илрүүлэх, зохиогчийн үзэл бодол, байр суурийг эргэцүүлж, өөрийн байр суурийг үндэслэлтэй

илэрхийлдэг болно. Ингэснээр сурагчийн логик сэтгэлгээг хөгжиж, гүн гүнзгий мэдлэг эзэмших нөхцөлийг бүрддэг.

IV түвшин нь уншлагын хамгийн дээд түвшин бөгөөд суралцагч нэг сэдвийн хүрээнд хэд хэдэн эх сурвалж, бүтээлийг харьцуулан шинжилж, тухайн сэдвийн талаар өөрийн гэсэн цогц мэдлэгийг бие даан бүтээнэ. Суралцагч өөр өөр зохиогчийн бүтээлийг зэрэгцүүлэн судалснаар тухайн асуудлыг олон талаас нь харах, ижил болон ялгаатай талыг илрүүлэх, дүгнэлт гаргах чадварыг эзэмшдэг. Энэ түвшин нь сурагчийг бие даасан, шүүн тунгаах сэтгэлгээтэй иргэн болж төлөвшихөд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ нэгдүгээр ангид уншиж, бичих арга барил эзэмшүүлэх үед авианы задлаг нийлэг арга, үсгийн аргыг хослуулан хэрэглэхээс гадна бүтэн үгийн аргыг багш өөрийн арга зүйн туршлага, суралцагчийн хувийн онцлогт тохируулан сонгон ашиглах боломжтой. Анги ахих тусам унших, бичих, ярих сонсох хэлний дөрвөн чадварыг тэнцвэртэй хөгжүүлэх зорилгоор эх зохиолд суурилсан арга зүйг голлон хэрэглэнэ.

Авианы задлаг нийлэг арга нь сонгосон үгээс хэлний авиаг ялган сонсож, зөв хэлж сурахын зэрэгцээ тэдгээрийг кодлон тэмдэглэсэн үсгийг зөв дуудах (унших), үсэг ба үе холбон үг, өгүүлбэр уншиж бичиж сургадаг арга юм. Энэхүү арга нь цагаан толгойн эхэн үед үсэг, үе холбон уншиж эхлэхэд суралцагчаас ихээхэн хичээл зүтгэл шаарддаг хэдий ч холбон унших арга барил эзэмшсэний дараа танил бус ямар ч үгийг тайлж унших чадвар эзэмшүүлэх мөн суралцагчдын танин мэдэхүй, хэл яриа, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлж, эх хэлний анхан шатны мэдлэг олгох, бичгийн хэл эзэмших суурийг тавих зэрэг чадварыг нэгэн зэрэг хөгжүүлдэг давуу талтай.

Авианы задлаг нийлэг аргаар суралцагчдад:

- Эхийг өгүүлбэр, өгүүлбэрийг үг, үгийг үе, үеийг авиагаар задлах;
- Авиаг кодлон тэмдэглэсэн үсгийг нэрлэх, зөв дуудах, утгыг тайлах;
- Үсэг холбон үг, өгүүлбэрийг уншиж, бичих цогц чадвар олгоход чухал ач холбогдолтой.

Хүснэгт 5. Жишиг үйл ажиллагаа

Алхам	Жишиг үйл ажиллагаа
Задлан шинжлэх	<ul style="list-style-type: none"> - Яриа өрнүүлэх: Зургийг ажиглаад эх зохиож ярилцах замаар сурагчдын хэл яриаг хөгжүүлэх, үгийн санг нэмэгдүүлж, өөрийгөө илэрхийлэх, бусдын яриаг сонсож ойлгох чадварыг хөгжүүлэх; - Өгүүлбэр сонгох: Сурагчдын ярианаас шинээр таниулах авиа, үсэгт тохирох үг бүхий өгүүлбэрийг сонгож, бүтцийг бүрдүүвчээр харуулах; - Үг сонгох: Өгүүлбэрээс шинэ авиа, үсэг таниулах үгийг үеэр зааглан хэлж үгийн хаана сонсогдож буйг ажиглуулах, хэлүүлэх; - Шинэ авиа таниулах: Сонгосон үгийг давтан хэлж, шинэ авиа үгийн хаана сонсогдож буйг олуулах, зөв дуудах, үгийн эхэн, дунд, төгсгөлд

	<p>орсон байдлаас хэлж, сонсох;</p> <ul style="list-style-type: none"> - Шинэ үсэг таниулах: Хэлний авиаг тэмдэглэсэн дармал ба бичмэл том, жижиг үсгийг харьцуулан ижил ба ялгааг ярилцах, үсгийн төсөөг шагай, савх, шугам зэргээр бүтээлгэх; - Шинэ үсгийг нүдлүүлэх: Багшийн самбарт бичихийг ажиглаж, үсгийг агаарт дүрслэн бичих, дэвтэртээ дуурайн бичих;
Нэгтгэх	<ul style="list-style-type: none"> - Багшийн чиглүүлгээр дармал үсэг ба битүү, задгай үеийг нүдэлж унших, бичих - Үе холбох, нүдлэн тогтоох замаар үг, өгүүлбэрийг унших, бичих; - Сурах бичгийн эхийг уншиж ойлгох, ярих, асуултад хариулж бичих; - Зураг харж өгүүлбэр, эх зохион бичих;

Үсгийн арга нь үсгийг нэрээр нь зааж, үсгээр үе, үеэр үг, үгээр өгүүлбэр бүтээж уншуулах арга юм. Гадаад үгэнд ордог онцгой дөрөв, я-гийн төрлийн үет үсгийг энэ аргаар таниулна.

Бүтэн үгийн арга нь үгийг авиа, үсэг, үеэр задлахгүйгээр шууд бүтэн үгээр таниулж, уншуулж, бичүүлж сургадаг арга юм. Энэ арга нь олон давтамжтай хэрэглэгддэг үсгийг бүтнээр нь таньж уншихад тохиромжтой бөгөөд танил үгийн хүрээнд унших хурдыг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Унших явцад авианы нэгдлийг заадаггүй учир танил бус үгийг тааж унших, цээжээр бичихдээ алдах зэрэг бэрхшээл үүсэх талтай.

Эх зохиолд суурилсан арга зүй нь уран зохиолын болон уран зохиолын бус эхийг үндсэн хэрэглэгдэхүүн болгон унших, бичих, ярих, сонсох чадварыг зэрэгцүүлэн хөгжүүлдэг онцлогтой. Бага ангид хүүхдэд зориулсан монгол аман зохиол, сонгодог уран зохиол, орчин үеийн уран зохиол болон дэлхийн сонгодог үлгэр, өгүүллэг, бодит түүхүүд, шинжлэх ухаан танин мэдэхүйн төрөл бүрийн эхээр дамжуулан сурагчдын танин мэдэхүй, ёс суртахуун, хүмүүжил, сэтгэлгээ зэрэгт эергээр нөлөөлж, суралцагч бүр санаа бодлоо хуваалцан ярилцах эерэг нээлттэй сургалтын орчныг бүрдүүлэхэд чухал нөлөөтэй. Түүнчлэн суралцагчдын унших сонирхлыг хөгжүүлэх, өөрийгөө илэрхийлэх, ойлгуулах чадварыг дэмжих, уншсан сонссон зүйлийн учир шалтгааныг илрүүлэх, шүүн тунгаах, өөрийн байр сууринаас хандах, бодит амьдралтай холбож ойлгох, ёс суртахууны төлөвшил олгох, асуудлыг олон талаас эргэцүүлэх, шийдлийг нь олох, бусдын санаа бодолд хүндэтгэлтэй хандах, зөв зохистой харилцах зэрэг суралцахуйн олон чадварыг хөгжүүлдгээрээ давуу талтай. Энэхүү арга зүйг тухайн суралцахуйн үр дүнгийн хүрээнд унших, бичих, ярих, сонсох чадварын алиныг нь голлон хөгжүүлэхээс шалтгаалж, дараах байдлаар хэрэгжүүлнэ.

Эх зохиолд суурилан унших чадварыг хөгжүүлэх арга зүй: Бага боловсролын эхлэл шатанд үг, өгүүлбэр зөв уншихын зэрэгцээ утгыг нь ойлгох чадварыг хөгжүүлэх бөгөөд анги ахих тутам уншиж ойлгох, уншсанаа шүүн тунгаахад анхаарна. *Зөв унших нь* сурагч үг, өгүүлбэр, эхийг амьсгал тохируулан үе, үсгийг сольж гээлгүй, бичгийн хэлний дагуу уншихыг; *ойлгож унших нь* утгыг нь ойлгож,

учрыг тайлбарлаж буйг; *шүүн тунгаах гэдэг нь* уншсанаа сайн ойлгож, сайн муу, үнэн худал, зөв бурууг эргэцүүлэн бодож, шалгаж, өөрийнхөөрөө дүгнэж буйг хэлнэ. Эх зохиолд суурилсан арга зүй нь суралцагчдын унших сэдвийн хүрээнд танин мэдэхүйн мэдлэг, ойлголтоо өргөжүүлэх, үгийн нөөцөө нэмэгдүүлэх, уншсанаа ойлгож, амьдралтай холбож, асуудал шийдвэрлэх арга барилыг хөгжүүлнэ.

Хүснэгт 6. Жишиг үйл ажиллагаа

Алхам	Жишиг үйл ажиллагаа
Уншихад бэлдэх (Уншихын өмнө)	<p><i>Эхийн гарчиг, зураг, түлхүүр үгс зэргээс сэдвийг таамаглуулах:</i></p> <ul style="list-style-type: none"> - “Юуны тухай эх байж болох” талаар санал дэвшүүлж, таамаглуулан ярилцах; <p><i>Унших сэдвийн талаар яриа өрнүүлэх:</i></p> <ul style="list-style-type: none"> - Амьдралын туршлага, бодит үйл явдал, өмнө уншсан зүйлтэй холбох;
Уншиж ойлгох	<p><i>Эхийг уншуулах, агуулгыг ойлгуулах:</i></p> <ul style="list-style-type: none"> -Эхийн утгыг бодож чангаар уншуулах, хэсэглэн уншуулах, утгат хэсгээр зогсоц хийн уншуулах, гүйлгэн уншуулах зэргээр тохирох унших арга хэлбэрийг сонгон уншуулах -Уншсан эхийн агуулгыг ойлгосон эсэхээ өөрөөсөө болон бусдаас асуух, ярилцуулах (Юуны тухай уншив?, Гол чухал зүйл нь юу байв?, Ямар ямар үг хэллэг байв?) -Уншихын өмнө юу мэддэг байсан, уншсаны дараа юуг шинээр мэдэж, ойлгосныг бодуулж, дүгнэлт хийлгэх <p><i>Агуулгад задлал хийлгэх:</i></p> <ul style="list-style-type: none"> -Эхийн агуулгыг илүү сайн ойлгохын тулд дахин уншуулах; -Хоёр ба хэд хэдэн санааг холбосон өгүүлбэрийг ойлгох, бусдадаа ойлгосноо хуваалцах боломж олгох; -Эхийн хэсгүүдийг холбож тайлбарлуулах, агуулгыг зураг, график, хүснэгт, бүдүүвчээр илэрхийлүүлэх; <p><i>Унших явцад үгийн нөөцийг нэмэгдүүлэх:</i></p> <ul style="list-style-type: none"> -Шинэ үг, хэллэг дээр зогсоц хийж утгыг тодруулах, тодорхойлох; -Шинэ үг, шинэ санаа оруулах, үгэн тоглоом тоглох; -Сонирхолтой үгийг сонгон хэрэглэх, тайлбар толь бичгээс үгийн утга судлах, утгыг мэдсэн үгээ хэрэглээ болгох
Уншсанаа амьдралтай холбох, хэрэглэх (Уншсаны дараа)	<ul style="list-style-type: none"> - <i>Агуулгыг амьдралтай холбуулж, хэрэглээ болгох:</i> - Уншсан зүйлтэй нь ижил төстэй өөр мэдээлэл хайлгах; - Эхийн утга санааг өөрийн туршлага, бодит байдалтай холбон бодох, өөрийн санаа бодол, байр сууриа илэрхийлэхийг хүсэх; - Эхэд буй асуудлыг шийдвэрлэх олон төрлийн арга зам, шийдэл гаргуулах; - Эхээс суралцсан зүйлээ тусган хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргуулж, мөрдүүлэх

Эхийг уншиж ойлгон дүрүүдийн сайн муу үйлийг тодорхойлох, мэдрэмжийг таньж мэдэх, тэдний оронд өөрийгөө тавьж үзэх зэрэг нь сурагчдын шүүн тунгаах болон өөрийгөө илэрхийлэх, бусдыг ойлгох зэрэг нийгэм сэтгэл хөдлөлийн чадамжид хувь нэмэр оруулна. Уран зохиолын эхийг уншсанаар суралцагчдын уран сэтгэмж, бүтээлч сэтгэлгээ хөгжихийн зэрэгцээ санаа бодлоо оновчтой илэрхийлэх чадвар хөгждөг бол уран зохиолын бус эхүүд уншсанаар аливааг олон талаас эргэцүүлэх, баримт нотолгоонд тулгуурлан шийдвэр гаргах, мэдээллийг үнэн зөвийг үнэлэх зэрэг шүүн тунгаах чадамж хөгждөг.

Хүснэгт 7. Эх зохиолд суурилан бичих чадварыг хөгжүүлэх арга зүй

Алхам	Жишиг үйл ажиллагаа
Бичихийн тулд эхийн бүтэц онцлогийг судлах	<ul style="list-style-type: none"> - Бичих гэж буй төрөл зүйлээр бичигдсэн эхийг уншуулах, эхийн агуулга, бүтэц (эхлэл, гол хэсэг, төгсгөл)-ийн онцлогийг ажиглуулж, ярилцах; - Эхийн төрөл (өгүүллэг, тайлбар, захидал мэдээлэл, мэдээ, шүлэг зэрэг) зорилго, үг хэллэгийн онцлогийг судлуулах; - Нэг сэдэвтэй, өөр төрлөөр бичсэн эхийг харьцуулах, эхийн зорилгыг таамаглуулах, сэдэв, гол санааг тодорхойлуулж хэлэлцэх;
Бичих сэдэв санаагаа олох, төлөвлөх	<ul style="list-style-type: none"> - Ажиглуулах: Эргэн тойрноо сайтар ажиглаж, хүн, юмс, үзэгдэл, орчныг ажиглуулж, тэр тухай бодуулах; - Төсөөлүүлэх: Өөрийн төсөөлөл, бодол санаа, мөрөөдлийг нь ургуулан бодуулах (ид шидтэн, нисдэг машин, зөгнөлт ертөнц, харь гараг г.м); - Яриулах, хэлэлцэх: Багш, найз нөхөд, гэр бүлийнхэнд нь бичих санааг нь яриулах, асуулт асууж, ярилцуулах зэрэг; - Зурах, дүрслэх: Бичих санааг нь зураг, бүдүүвч, дүрсээр илэрхийлүүлэх; - Тэмдэглүүлэх: Хамгийн чухал гэж бодсон үг хэллэг, санааг нь тэмдэглүүлэх;
Төлөвлөгөөний дагуу эхийг, найруулж, зохиож бичих	<ul style="list-style-type: none"> - Эхлэл, гол хэсэг, төгсгөл бичүүлэх: Төлөвлөсний дагуу эхлэл хэсэгтээ тухайн сэдвийг товч танилцуулах, гол хэсэгтээ санаагаа дэлгэрүүлэн бичих, төгсгөл хэсэгтээ дүгнэлт хийх, сэтгэгдлээ илэрхийлэх зэргээр бичүүлэх; - Зохиосон эхийг засуулах: Бичсэн эхийг нь өөрөөр нь уншуулах, ойлгомжгүй эсвэл алдаатай хэсгийг олуулж, хэрхэн засах аргыг тайлбарлаж өгөх; - Бусдад уншиж өгөх, санал авах: Зохиосон эхийг нь бусдад чангаар уншуулах, сонссон хүмүүсийн санал, сэтгэгдлийг хэлүүлэх, саналыг солилцуулах, тодорхой шалгуурын дагуу өөрсдөөр нь болон бусдаар үнэлүүлж, бичсэнийг нь сайжруулж дахин бичүүлэх;

<p>Бичсэний бусадтай хуваалцах, бие даан бичих урам зориг авах</p>	<ul style="list-style-type: none"> - Танил, сонирхдог сэдвээр нь бичүүлэх: Өөрсдийнх нь сонирхсон сэдвийн хүрээнд, хичээлээр үзсэн төрөл хэлбэрээс сонгуулж бичүүлэх; - Багш, эцэг эхийн дэмжлэгийг авах: Суралцагчдын бичсэн эхийг уншиж зөвлөгөө, урам зориг өгөх, бусдад уншуулж, санал сэтгэгдлийг сонсож сайжруулж бичихэд нь туслахыг зөвлөх; - Бичсэн эхийг нь сайшаах, урам зориг өгөх: Бичсэнээ үнэлж, өөртөө итгэх итгэлээ нэмэгдүүлэх, бичсэн эхээрээ үзэсгэлэн гаргах, ангийн болон сургуулийн сонин, ханын булан болон цахим орчинд нийтлэх; - Ном уншуулах: Үгийн баялаг, өгүүлбэрийн бүтэц, зохиомжийн талаар ойлголттой болж, бичих чадвараа хөгжүүлэх;
--------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

3.2. Сургалтын орчин

Сургалтын орчин нь судлагдахууны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад нөлөөлөх гол хүчин зүйл болно. Суралцагчийн хөгжлийн онцлог, хэрэгцээ сонирхолд нийцсэн сургалтын арга хэлбэр, эерэг таатай уур амьсгалтай эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх шаардлагатай. Үүнд:

Эерэг таатай уур амьсгал бүхий харилцаа:

- Багш, сурагчид, сурагч бусдад болон өөртөө урам зориг өгдөг; тууштай, тэвчээртэй байдлыг дэмждэг;
- Хосоор, бүлгээр сонирхолтой, хөгжилтэй, тоглодог, хамтран ажилладаг;
- Өөрийн болон бусдын гаргасан амжилтыг урамшуулдаг;
- Хамтран ажиллаж үр дүнг хуваалцдаг;
- Өөрийгөө болон бусдыг айдасгүй, нээлттэй байхыг дэмждэг;

Эрүүл, аюулгүй, хүртээмжтэй анги танхим:

- Багаар хамтран ажиллах, бүтээлч идэвхтэй оролцоог дэмжих боломжтой;
- Сурагч бүрд хүрэлцэхүйц хэмжээний сургалтын хэрэглэгдэхүүнтэй;
- Сурагчид бие биетэйгээ харилцах, саналаа хуваалцах боломжтой, уян хатан зохион байгуулалттай (орон зай, ширээний зохион байгуулалт, гэрэлтүүлэг);
- Сургалтын техник хэрэгсэл, технологийг ашиглах боломжтой;

Ялгаатай хэрэгцээг харгалзсан орчин:

- Сурагчдын суралцах хэв маягийг (хараа, сонсгол, хөдөлгөөний) харгалзсан зураг, бүдүүвч, өнгө ялгалттай материал, аудио хичээл, ярилцлага, практик туршилт, хөдөлгөөнтэй тоглоом ашиглах боломжтой;
- Хэл, соёлын ялгаатай сурагчдад зориулсан сэдэв, агуулгатай холбогдох төрөл бүрийн эхийн сан, зурагт болон үгийн тайлбар толь бичигтэй;

- Суралцахуйн хоцрогдолтой болон илүү хурдтай сурагчдад зориулсан ялгаатай даалгаврын сантай;

Суралцагч бүрд уншиж бичиж сурч эхлэх цагаас “би чадна” гэсэн мэдрэмжийг төрүүлж, сурах хүсэл сонирхлыг бий болгосон сэтгэл зүйн орчин бүрдүүлэхэд анхаарна.

I-II ангид уншиж сурах үед үсэг таних, зөв унших, энгийн өгүүлбэр бичих зэрэг суурь чадварыг эзэмшүүлэхдээ алдааг засах боломж олгож, ахиц дэвшлийг нь үнэлж урамшуулах нь суралцагчийн өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлж, “чадахгүй” гэсэн мэдрэмжийг даван туулахад дэмжлэг үзүүлнэ. III-V ангид суралцагч уншсан зүйлээ ойлгож, өөрийн үгээр бичиж илэрхийлэх, санаа бодлоо хуваалцах, хамтран бүтээл туурвих замаар оролцоогоо нэмэгдүүлж, ойр орчиндоо өөрийн хувь нэмэр оруулж байгааг мэдэрч эхэлдэг. Иймээс унших, бичих чадварыг суралцагчийн өөрийгөө үнэлэх үнэлэмж, зорилготой суралцах хандлага, хамтын оролцоог хөгжүүлэх үйл явц гэж харж, урамшуулсан, дэмжсэн орчин бүрдүүлэхэд анхаарна.

Монгол хэлний сургалтад ашиглах хэрэглэгдэхүүн нь анги бүрийн суралцахуйн үр дүнд нийцсэн, суралцагчийн монгол хэлээр сэтгэх, унших, бичих, илэрхийлэх, бүтээх чадварыг хөгжүүлэх, эх хэл, өв соёлоо өвлөн, эрхэмлэн дээдэлдэг монгол иргэнийг төлөвшүүлэхэд чиглэсэн агуулгатай байна. Түүнчлэн суралцагчийн нас, хөгжлийн онцлог, хэлний түвшинд тохирсон, илэрхийлэх чадварыг шат дараатайгаар хөгжүүлэхэд чиглэсэн, сонирхолтой, урам өгсөн, бодит хэрэглээтэй уялдсан байна. Монгол хэлний сургалтын хөтөлбөрийн ай бүрээр бага ангид суралцахуйн үр дүнд нийцүүлэн хэрэглэгдэхүүнийг сонгон хэрэглэх ба бага ангид унших чадварыг хөгжүүлэх хүрээнд монгол аман зохиол, сонгодог уран зохиол, орчин үеийн уран зохиол, амьдарч буй орчин, өдөр тутмын амьдралтай холбоотой танин мэдэхүйн болон хэрэглээний уран зохиолын бус эхүүдийг түлхүү унших төдийгүй дэлхийн сонгодог уран зохиолоос суралцагчдын түвшнийг харгалзан сонгон уншуулна.

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

4.1. Үнэлгээний зорилго

Үнэлгээ нь суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, төлөвшлийн давуу болон сул тал, суурь болон ерөнхий чадамжийн ахиц дэвшлийг илрүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг дэмжих, урамшуулах, хөтөлбөрийн хүрэх үр дүнг үнэлж, дүгнэхэд чиглэнэ.

Бага боловсролын эхлэл шатлалд суралцагчийн чадамжийн хөгжил, сонсох-ярих, унших, бичих мэдлэг, чадварын ахиц, гүйцэтгэлийн түвшнийг илрүүлэх, суралцах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн явцын үнэлгээ хийнэ.

Бага боловсролын төгсгөл шатлалд суралцагчийн чадамжийн хөгжил, сонсох-ярих, унших, бичих мэдлэг, чадварын ахиц, гүйцэтгэлийн түвшнийг илрүүлэх, суралцах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн явцын болон үр дүнгийн үнэлгээ хийнэ.

4.2. Үнэлгээний шалгуур

№	Хүрэх үр дүн	Шалгуур
1	Бусдыг сонсож ойлгон, санаа бодлоо бүтээлчээр илэрхийлж харилцдаг болно.	<ul style="list-style-type: none"> - Ярилцсан сэдвийн гол санааг ойлгомжтой, зохион байгуулалттай илэрхийлдэг, тодруулах асуулт тавьдаг. - Бусдыг анхааралтай сонсож, дүгнэлт хийж, өөрийн байр суурийг жишээ баримтаар нотлон тодорхой илэрхийлдэг. - Тодорхой сэдвээр мэдээлэл цуглуулж, гол агуулгыг нэгтгэн дүгнэж, бусдад ойлгомжтой танилцуулдаг.
2	Унших арга барил эзэмшиж, бие даан унших дадал хэвшилтэй болно.	<ul style="list-style-type: none"> - Төрөл бүрийн эхийг чөлөөтэй уншдаг. - Уншсан эхийн гол санааг тодорхой мэдээлэлд үндэслэн тайлбарладаг. - Эхийн санааг өөрийн туршлагатай холбон дүгнэж, байр сууриа илэрхийлдэг. - Уншсанаа яриа, бичиг, зураг, бүдүүвч, дүрслэл зэргээр ойлгомжтой илэрхийлж, хуваалцдаг, бусдын санааг сонсож хүндэтгэдэг. - Зорилгодоо нийцүүлэн ном сонгож, тогтмол уншдаг.
3	Бичих арга барил эзэмшиж, зорилгодоо нийцүүлэн санаа бодлоо уялдаа холбоотой бичиж илэрхийлдэг болно.	<ul style="list-style-type: none"> - Зорилго, сэдэв, асуудлын хүрээнд санаа бодлоо илэрхийлж бичдэг. - Өгүүлбэр, догол мөрүүдийг утгаар нь уялдуулж, тодорхой бүтэцтэй бичдэг. - Жишээ баримт, дүрслэл, тайлбар, өөрийн санаа зэргийг тусгаж бичдэг. - Үзсэн зөв бичгийн дүрмийн хүрээнд алдаагүй бичдэг.
4	Монгол хэлний зүй, үгийн сангийн анхан шатны мэдлэг эзэмшиж, хэрэглэдэг болно.	<ul style="list-style-type: none"> - Өдөр тутмын харилцаа болон нийгмийн харилцаанд өргөн хэрэглэгддэг түгээмэл үг хэллэгийн утга, хэрэглээг ойлгодог, яриа бичигтээ зөв хэрэглэдэг. - Үг, үгийн утга, ижил, эсрэг, ойролцоо утгыг таньж, яриа бичигтээ тохируулан зөв хэрэглэдэг. - Үгийн аймаг, өгүүлбэрийн талаар мэдлэг ойлголтоо хэрэглэн зөв бүтэцтэй өгүүлбэр, эх зохион найруулдаг.
5	Монгол хэл, соёлоо танин мэдэж, үнэ цэнийг нь ойлгож, суралцдаг болно.	<ul style="list-style-type: none"> - Монгол хэл, соёл уламжлал, зан заншил, түүх, ардын аман зохиол болон бичгийн бүтээлүүдийн утга санаа, ач холбогдлыг ойлгож тайлбарладаг. - Монгол хэл, соёлын тухай мэдлэгээ тэлэх, уламжлан хөгжүүлэх эрмэлзэлтэй, хэл соёлын бүтээлч үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог.

МАТЕМАТИК

НЭГ. ЗОРИЛГО

1.1. Зорилго

Суралцагчийн тоолох, тооцоолох, хэмжих, дүрс, биетийг судлах, өгөгдөлтэй ажиллах, тэдгээрийн хамаарал, чанарыг математикийн ба ахуй амьдралын асуудлыг шийдвэрлэхэд хэрэглэх, учирлан үндэслэх суурь чадамж болон шүүн тунгаах, бүтээлчээр сэтгэх, харилцах, бие даан суралцах, хамтран ажиллах ерөнхий чадамжийг хөгжүүлнэ.

1.2. Хүрэх үр дүн, шатлал

Энэхүү хөтөлбөрийг судалснаар суралцагчид математик үйл ажиллагаагаар дамжуулан дараах ерөнхий үр дүнд хүрсэн байна.

- Тоо тоолол, хэмжигдэхүүн, геометр, магадлал, статистикийн суурь мэдлэг, чадвартай болно.
- Математикийн тэмдэг, тэмдэглэгээ болон өгүүлбэртэй бодлогыг уншиж ойлгон бодлого бодох арга дэвшүүлдэг, оновчтой аргыг сонгож хэрэглэдэг, сонгосон аргаа эх хэл болон математик хэл хэрэглэн тайлбарладаг болно.
- Танил болон танил бус нөхцөлд математикийн мэдлэг, чадвараа хэрэглэн асуудал шийдвэрлэдэг, учир шалтгааныг үндэслэлтэй тайлбарладаг болно.
- Ахуй амьдралын асуудалд математик сэтгэлгээгээр хандаж, бие даан болон хамтран бүтээлч шийдэл гаргаж чаддаг болно.

Хүрэх үр дүн	Шатлал	
	I - II анги	III - V анги
Тоо тоолол, хэмжигдэхүүн, геометр, магадлал, статистикийн суурь мэдлэг, чадвартай болно.	<ul style="list-style-type: none"> - Тоо, тооны орон ба арифметикийн үйлдэл, үйлдлийн чанар, гишүүдийн хамаарлыг таних, бичгээр болон цээжээр тооцоолох, зүй тогтол, математик бичвэрийг үнэн болгох тоо, тэмдгийг олох, тоон илэрхийлэл, бодлого зохиох мэдлэг, чадвартай болно. - Дүрсүүдийг таних, өгсөн шинжээр нь ангилах, тэгш хэмтэй дүрс эсэхийг тогтоох, зураг болон хөлөг дээрх юмсын байршлыг тодорхойлох, тоглоомын дүрэм, зааврын дагуу шилжүүлэх мэдлэг, чадвартай болно. 	<ul style="list-style-type: none"> - Бүхэл ба бутархай тоо, процент, харьцаа, пропорцыг таних, арифметикийн үйлдэл, үйлдлийн чанар, гишүүдийн хамаарал, тооны хуваагдах шинжийг хэрэглэх, бичгээр болон цээжээр тооцоолох, зүй тогтол болон тэгшитгэлийн шийд олох, бодлого зохиох мэдлэг, чадвартай болно. - Дүрс, биетийг таних, шинжээр нь ангилах, дүрсийг тэнхлэгийн тэгш хэмээр хувиргах, параллелиар зөөх, эргүүлэх, биетийг дэлгээсээр нь бүтээх, координатын хавтгайд өгсөн цэгийн байршлыг тодорхойлох мэдлэг, чадвартай болно. - Урт, масс, талбай, эзлэхүүн, хугацааг баримжаалах,

	<ul style="list-style-type: none"> - Урт, масс, талбай, эзлэхүүн, хугацааг харьцуулах, стандарт бус болон стандарт нэгжээр хэмжих, хэмжээг тооцоолох мэдлэг, чадвартай болно. - Өгөгдөл цуглуулах, ангилах, бүртгэх, диаграммаар дүрслэх, тайлбарлах, ажиглалт, хялбар туршилтаар сонирхсон үр дүн илрэх боломжтой эсэхийг тогтоох мэдлэг, чадвартай болно. 	<p>тохиромжтой нэгж, хэрэгсэл сонгон хэмжих, нэгжүүдийн хамаарлыг тодорхойлох, хэмжээг тооцоолох мэдлэг, чадвартай болно.</p> <ul style="list-style-type: none"> - Өгөгдөл цуглуулах, диаграмм болон шугаман графикаар дүрслэх, өгөгдлийн дунджуудыг тайлбарлах, үзэгдлийн илрэх боломжийн тоог олох, үзэгдлүүдийг илрэх боломжоор нь эрэмбэлэх, тайлбарлах мэдлэг, чадвартай болно.
<p>Математикийн тэмдэг, тэмдэглэгээ болон өгүүлбэртэй бодлогыг уншиж ойлгон бодлого бодох арга дэвшүүлдэг, оновчтой аргыг сонгож хэрэглэдэг, сонгосон аргаа эх хэл болон математик хэл хэрэглэн тайлбарладаг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Математикийн тэмдэг, тэмдэглэгээг таньж, бичдэг, бодлогын өгүүлбэрийг уншиж ойлгодог болно. - Бодлогыг өөрийн аргаар бодож сэтгэдэг, бодолтоо эх хэл, математик хэл, бичиглэл хэрэглэн тайлбарладаг болно. 	<ul style="list-style-type: none"> - Математикийн тэмдэг, тэмдэглэгээ, бичиглэлийг оновчтой хэрэглэдэг, бодлогын өгүүлбэр, зураг дүрслэл, диаграммыг уншиж ойлгодог, тайлбарладаг болно. - Бодлого бодох олон арга, санаа эрж хайдаг, сонгосон арга, үр дүнгээ эх хэл, математик хэл, бичиглэл хэрэглэн тайлбарладаг болно.
<p>Танил болон танил бус нөхцөлд математикийн мэдлэг, чадвараа хэрэглэн асуудал шийдвэрлэдэг, учир шалтгааныг үндэслэлтэй тайлбарладаг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Математикийн мэдлэг, чадвараа хэрэглэн танил нөхцөл дэх ахуй амьдралын асуудлыг шийдвэрлэдэг, өгүүлбэртэй бодлогын утга санааг ойлгож, шийдлийг тайлбарладаг болно. - Бодлогын хариуг олох, шалгах, бодсон аргаа өөрийн үгээр тайлбарладаг болно. 	<ul style="list-style-type: none"> - Ахуй амьдралын асуудал болон танил бус нөхцөлийг математикаар загварчилж, асуудлын мөн чанарыг ойлгодог болно. - Бодлогын хариу олох, асуудлын шийдэл гаргах оновчтой аргыг сонгон хэрэглэдэг, алдаагүй зөв тооцоолол хийдэг, хэрэглэсэн аргынхаа учир шалтгааныг тайлбарладаг болно. - Бодлогын хариу шалгах, математик үйлдэл, томъёоны учир шалтгааныг тайлбарладаг болно.
<p>Ахуй амьдралын асуудалд математик сэтгэлгээгээр хандаж, бие даан болон хамтран бүтээлч шийдэл</p>	<ul style="list-style-type: none"> - Багшийн өгсөн даалгаврыг бие даан болон хосоор хамтран гүйцэтгэдэг, асуудлыг математикийн мэдлэг, чадвараа хэрэглэн шийдэх хандлагатай болно. 	<ul style="list-style-type: none"> - Багийн ажилд үүрэгтэй оролцож, санаа бодлоо илэрхийлдэг, бусдыг анхааралтай сонсож, бусдад хүндэтгэлтэй ханддаг болно.

гаргаж болно.	чаддаг	- Өдөр тутмын амьдрал дахь математикийн хэрэглээтэй холбоотой жишээг олж хардаг, мэдлэгээ хэрэглэн бүтээлчээр сэтгэх, дүрс, биет ашиглан зурах, бүтээл хийх шинэ санаа гаргадаг болно.	- Математик мэдлэг, чадвараа өдөр тутмын амьдралдаа хэрэглэхийг эрмэлзэж, байгаль орчин, эрүүл мэндэд ээлтэй, хэмнэлттэй хэрэглээг эрхэмлэдэг болно. - Математик мэдлэг, чадвараа биет болон цахим бүтээл хийхэд хэрэглэдэг, шинэ санаа гаргадаг, түүнийгээ тайлбарладаг болно.
---------------	--------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

ХОЁР. АГУУЛГА

2.1. Бага боловсролын эхлэл шатлал

Агуулгын ай 1. Тоо тоолол

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Бүхэл тоо	1.1а. Арав хүртэлх юмсыг тоолох, тоог таних, жиших, дугаарлах, арав дотор нэмэх, хасах; тоон илэрхийллийн утгыг олох, үйлдлийн чанар хэрэглэх, тоог бүтээх, бүтцээр задлах, тайлбарлах, асуудал шийдвэрлэх, өгсөн зурагт тохирох бодлого зохиох мэдлэг, чадвартай болно.	2.1а. Мянга хүртэлх тоо болон үндэсний мөнгөн тэмдэгтийг таних, жиших, хоёр зуу дотор 1, 10-аар нэмэгдүүлэн, хорогдуулан тоолох, аравтаар тоймлох, нэмэх, хасах; үйлдлийн чанар хэрэглэн хялбар арга сонгож тооцоолох, математик бичвэрийг үнэн болгох тоо, тэмдгийг олох, тайлбарлах, асуудал шийдвэрлэх, өгсөн зураг, загварт тохирох бодлого зохиох мэдлэг, чадвартай болно.
	1.1б. Хорь хүртэлх юмсыг тоолох, тоог таних, жиших, үйлдлийн чанар хэрэглэн хорь дотор нэмэх, хасах, математик бичвэрийг үнэн болгох тоо, тэмдгийг олох, тайлбарлах, асуудал шийдвэрлэх, өгсөн зурагт тохирох бодлого зохиох мэдлэг, чадвартай болно.	2.1б. Үржүүлэх, хуваах үйлдлийн утга санааг тайлбарлах, хүрд хэрэглэн үржүүлэх, хуваах, үйлдлийн чанар, гишүүдийн хамаарал, зүй тогтол хэрэглэн үржвэрийн утгыг олох, тайлбарлах, хялбар арга сонгох, цээжээр үржүүлэх, хуваах, математик бичвэрийн мэдэгдэхгүй байгаа гишүүнийг олох, асуудал шийдвэрлэх, шалгах, өгсөн нөхцөлд тохирох тоон илэрхийлэл зохиох, өгсөн зураг, загварт тохирох бодлого зохиох мэдлэг, чадвартай болно.
	1.1в. Зуу хүртэлх юмсыг тоолох, тоо болон үндэсний мөнгөн тэмдэгтийг таних, жиших, зуугийн хүснэгт, тоон шулуун хэрэглэн нэг, арваар нэмэгдүүлэн, хорогдуулан тоолох, дараалуулсан дүрс, тоонуудын зүй тогтлыг олох, аравтыг зуу болгон гүйцээх тоог цээжээр хэлэх мэдлэг, чадвартай болно.	
Бутархай тоо		2.1в. Тууз, хавтан, тоон шулуун хэрэглэн хагас, хагасын хагасыг дүрслэх, $1/2$, $1/4$, $2/4$, $3/4$ энгийн

		бутархайг таних, тэнцүү хуваах үйлдлийг шударгаар хуваарилахтай холбон жишээгээр тайлбарлах мэдлэг, чадвартай болно.
--	--	----------------------------------------------------------------------------------------------------------------------

Агуулгын ай 2. Геометр

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Дүрс, биет	1.2а. Гурвалжин, дөрвөлжин, дугуй дүрсийг таних, зурах; тэгш хэмтэй дүрсийг тэгш хэмтэйгээр нугалах, дүрсээр бүтээл хийх мэдлэг, чадвартай болно.	2.2а. Дүрс (дөрвөн өнцөгт, таван өнцөгт, зургаан өнцөгт)-ийг өнцгийн тоогоор нэрлэх, тэгш өнцөг болон тэгш өнцөгт, квадратыг таних, тэгш хэмтэй дүрсийн тэгш хэмийн тэнхлэгийг зурах, дүрс ба биетээр бүтээл хийх, тайлбарлах мэдлэг, чадвартай болно.
Байршил, хөдөлгөөн	1.2б. Орон зай, байршил, хөдөлгөөнтэй холбоотой үг хэллэг хэрэглэн гэр, сургуулийн орчин дахь юмсын байршлыг тодорхойлох мэдлэг, чадвартай болно.	2.2б. Зураг болон хөлөг дээрх юмсын байршлыг тодорхойлох, заавар, тоглоомын дүрэмд өгсөн чиглэл, зайд шилжүүлэх мэдлэг, чадвартай болно.

Агуулгын ай 3. Хэмжигдэхүүн

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Урт, масс, эзлэхүүн	1.3а. Юмсыг урт, масс, эзлэхүүнээр нь тус тус шууд харьцуулах, хэмжээгээр нь эрэмбэлэх, эрэмбэлснээ тайлбарлах мэдлэг, чадвартай болно. 1.3б. Дүрс болон юмсын уртыг стандарт бус болон стандарт нэгж (см)-ээр хэмжих, уртын хэмжээг сантиметрээр илэрхийлэх мэдлэг, чадвартай болно.	2.3а. Урт, масс, эзлэхүүнийг стандарт нэгж (мм, дм, м, кг, л)-ээр хэмжих, харьцуулах, баримжаалах, хэмжсэнээ тайлбарлах, хэрчим, дүрсийн хүрээний уртыг тооцоолох мэдлэг, чадвартай болно.
Хугацаа	1.3в. Хугацааг стандарт бус болон стандарт нэгж (жил, улирал, сар, долоо хоног, хоног, цаг)-ээр хэмжих, харьцуулах, харьцуулснаа тайлбарлах, үйл	2.3б. Хугацааг хэмжих стандарт нэгж (минут, цаг)-ийг таних, аналогийг цагийг 30 минут, 5 минутын нарийвчлалтай унших, үргэлжлэх хугацааг бүхэл цагаар тооцоолох, дижитал цаг хэрэглэн цагийг 24

	явдлын дарааллыг тогтоох мэдлэг, чадвартай болно.	цагийн горимоор хэлэх мэдлэг, чадвартай болно.
--	---------------------------------------------------	------------------------------------------------

Агуулгын ай 4. Магадлал, статистик

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Өгөгдлийн шинжилгээ	1.4а. Юмсыг нэг шинжээр ангилах, бүртгэх, өгөгдлийг загвар, зурган диаграммаар дүрслэх мэдлэг, чадвартай болно.	2.4а. Өгөгдлийг хоёр шинжээр нь ангилах, зорилгын дагуу өгөгдөл цуглуулж бүртгэх, зурган, баганан диаграммаар дүрслээд тайлбарлах мэдлэг, чадвартай болно.
		2.4б. Туршилтын боломжит үр дүнг таамаглан жагсаах, туршилтаар шалган бүртгэх, бүртгэл болон боломжийн тоог ашиглан үзэгдэл явагдах боломжтой эсэхийг тайлбарлах мэдлэг, чадвартай болно.

2.2. Бага боловсролын төгсгөл шатлал

Агуулгын ай 1. Тоо тоолол

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Бүхэл тоо	3.1а. Зуун мянга хүртэлх тоо болон үндэсний мөнгөн тэмдэгтийг таних, жиших, арван мянга дотор 100, 1000-аар нэмэгдүүлэн, хорогдуулан тоолох, аравт, зуугаар тоймлох, бичгээр болон цээжээр нэмэх, хасах, үйлдлийн чанар, гишүүдийн хамаарал хэрэглэн хялбар арга сонгон тооцоолох, зүй тогтол болон математик бичвэрийг үнэн байлгах тоо, тэмдэг олох, тоон	4.1а. Сая хүртэлх тоог таних, жиших, зуун мянга хүртэлх тоог зуут, мянгатаар нэмэгдүүлэн, хорогдуулан тоолох, зуун мянга хүртэлх тоог зуут, мянгатаар тоймлох, зуун мянга дотор бичгээр болон цээжээр нэмэх, хасах, үйлдлийн чанар, гишүүдийн хамаарал хэрэглэн хялбар арга сонгох, тэгшитгэлийн шийд олох, тоонуудын зүй тогтлыг олж тайлбарлах, асуудал шийдвэрлэх, үр дүнг таамаглаж дүгнэлт гаргах, өгсөн загвар, илэрхийлэлд тохирох бодлого зохиох мэдлэг, мэдлэг, чадвартай болно.	5.1а. Олон оронтой тоог таних, жиших, зуун сая дотор саяар нэмэгдүүлэн, хорогдуулан тоолох, саяар тоймлох, нэмэх, хасах, үйлдлийн чанар, хамаарал хэрэглэн хаалт задлах, хоёр алхамт тэгшитгэлийн шийд олох, тэгшитгэл, зүй тогтол зохиох, учир шалтгааныг тайлбарлах, асуудал шийдвэрлэх, таамаглал дэвшүүлэн дүгнэлт гаргах, өгсөн загвар, тэгшитгэлд тохирох бодлого зохиох мэдлэг, чадвартай болно.

	<p>тэнцэтгэл, тоон тэнцэтгэл биш бичих, зохиох, асуудал шийдвэрлэх, үр дүнг баримжаалж шалгах, өгсөн загварт тохирох бодлого зохиох мэдлэг, чадвартай болно.</p>		<p>5.1б. Зуу хүртэлх монгол тоо, ром тоог унших, бичих, жиших, тооны бичиглэлийг тайлбарлах мэдлэг, чадвартай болно.</p>
	<p>3.1б. Арван мянга дотор 10, 100, 1000-аар үржүүлэх, хуваах, хоёр оронтой тоог нэг оронтой тоогоор үржүүлэх, хоёр, гурван оронтой тоог нэг оронтой тоонд хуваах, тооны 2, 5, 10-т хуваагдах шинж, үйлдлийн чанар, гишүүдийн хамаарал хэрэглэх, хялбар арга сонгох, цээжээр тооцоолох, математик бичвэрийг үнэн байлгах тоо, тэмдэг олох, тоон тэнцэтгэл, тоон тэнцэтгэл биш бичих, зохиох, зүй тогтлыг олж тайлбарлах, асуудал шийдвэрлэх, дүгнэлт гаргах, өгсөн загварт тохирох бодлого зохиох мэдлэг, чадвартай болно.</p>	<p>4.1б. Зуун мянга дотор 10, 100, 1000-аар үржүүлэх, хуваах, нэг, хоёр оронтой тоог нэг, хоёр оронтой тоогоор үржүүлэх, гурван оронтой тоог нэг, хоёр оронтой тоонд хуваах, тооны 50, 100-д хуваагдах шинж, үйлдлийн чанар, гишүүдийн хамаарал тооцоолох, тэгшитгэлийн шийд олох, зүй тогтлыг олж тайлбарлах, асуудал шийдвэрлэх, дүгнэлт гаргах, өгсөн загвар, илэрхийлэлд тохирох бодлого зохиох мэдлэг, чадвартай болно.</p>	<p>5.1в. Зуун сая дотор 10, 100, 1000-аар үржүүлэх, хуваах, хоёр, гурван оронтой тоог нэг, хоёр оронтой тоогоор үржүүлэх, гурван оронтой тоог хоёр, гурван оронтой тоонд хуваах, хоёр оронтой 2 тооны ерөнхий хуваагч, хуваагдагчийг олох, тооны 4-т хуваагдах шинж, үйлдлийн чанар, гишүүдийн хамаарал хэрэглэх, хялбар арга сонгон тооцоолох, хоёр алхамт тэгшитгэлийн шийд олох, тэгшитгэл, зүй тогтол зохиох, учир шалтгааныг тайлбарлах, асуудал шийдвэрлэх, дүгнэлт гаргах, өгсөн загвар, тэгшитгэлд тохирох бодлого зохиох мэдлэг, чадвартай болно.</p>
		<p>4.1в. Сөрөг тоог таних, термометр, тоон шулуун хэрэглэн жиших, тайлбарлах, мэдлэг, чадвараа амьдрал ахуйд хэрэглэх чадвартай болно.</p>	<p>5.1г. Тоон шулуун хэрэглэн сөрөг тоонуудын зөрөөг олох, цаг агаарын мэдээтэй холбон тайлбарлах мэдлэг, чадвараа амьдрал ахуйд хэрэглэх чадвартай болно.</p>

Бутархай тоо	<p>3.1в. 2, 3, 4, 5, 6, 8, 10 хуваарьтай энгийн бутархайг таних, ижил хуваарьтай энгийн бутархайг жиших, нэмэх, хасах, үйлдлийн чанар хэрэглэх, зүй тогтлын мэдэгдэхгүй байгаа гишүүнийг олох, математик бичвэрийг үнэн байлгах тоо, тэмдэг олох, учир шалтгааныг тайлбарлах, тоо хэмжээний хэсгийг олох, асуудал шийдвэрлэх, тайлбарлах мэдлэг, чадвартай болно.</p>	<p>4.1г. Холимог бутархайг таних, дүрслэх, ижил хуваарьтай холимог бутархайг жиших, нэмэх, хасах, үйлдлийн чанар хэрэглэх, тэгшитгэлийн шийд олж, шалгах, зүй тогтлыг олж тайлбарлах, хэсгийн бодлого бодох, асуудал шийдвэрлэх, хэлэлцэх, тайлбарлах мэдлэг, чадвартай болно.</p>	<p>5.1д. Тэнцүү бутархайг таних, хавтангаар дүрслэх, бутархайн үндсэн чанар хэрэглэн нэг нь нөгөөгийнхөө хуваагдагч байх ижил биш хуваарьтай энгийн бутархайнуудыг жиших, нэмэх, хасах, үйлдлийн чанар хэрэглэх, асуудал шийдвэрлэх, хэлэлцэх, тайлбарлах, мэдлэг, чадвартай болно.</p>
	<p>4.1д. Аравтын бутархайг таних, арав хуваарьтай энгийн бутархайг аравтын бутархайгаар илэрхийлэх, жиших, бүхлээр тоймлох, нэмэх, хасах, үйлдлийн чанар, гишүүдийн хамаарлыг хэрэглэх, асуудал шийдвэрлэх, хэлэлцэх, тайлбарлах мэдлэг, чадвартай болно.</p>	<p>5.1е. Зуу, мянга хуваарьтай энгийн бутархайг аравтын бутархайгаар илэрхийлэх, жиших, тоймлох, нэмэх, хасах, үйлдлийн чанар, гишүүдийн хамаарлыг хэрэглэх, хялбар арга сонгон нэмэх, хасах, зүй тогтлыг олж тайлбарлах, тэгшитгэлийн шийд олох, өгсөн нөхцөлд тохирох тэгшитгэл зохиох, асуудал шийдвэрлэх, хэлэлцэх, тайлбарлах мэдлэг, чадвартай болно.</p> <p>5.1ж. Аравтын бутархайг 10, 100, 1000, нэгжээр үржүүлэх, хуваах, үйлдлийн чанар, гишүүдийн хамаарлыг хэрэглэн хялбар арга сонгон тооцоолох, зүй тогтлыг олж тайлбарлах, тэгшитгэлийн шийд</p>	

			олох, өгсөн нөхцөлд тохирох тэгшитгэл зохиох, асуудал шийдвэрлэх, хэлэлцэх, тайлбарлах мэдлэг, чадвартай болно.
			5.1з. Процентог таних, тоо, хэмжээний 2, 4, 5, 10, 20, 100-ны тэнцүү хэсгийг процентоор илэрхийлэх, утгыг тайлбарлах, процентог энгийн бутархай болон аравтын бутархайгаар илэрхийлэх, процент бүхий хялбар асуудлыг шийдвэрлэх мэдлэг, чадвартай болно.
		4.1е. Харьцааг таних, тоо, хэмжээг хэд дахин багасгах, ихэсгэх, өгсөн харьцаагаар хуваах, харьцаа хэрэглэн асуудлыг шийдвэрлэх, хэлэлцэх, тайлбарлах мэдлэг, чадвартай болно.	5.1и. Пропорцын үндсэн чанарыг таних, хэрэглэх, тайлбарлах, пропорцын мэдэгдэхгүй байгаа гишүүнийг олох, пропорц хэрэглэн асуудлыг шийдвэрлэх, хэлэлцэх, тайлбарлах мэдлэг, чадвартай болно.

Агуулгын ай 2. Геометр

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Дүрс, биет	3.2а. Цацраг, шулуун, өнцгийг таних, параллель, перпендикуляр шулууныг тэмдэглэх, зурах, гурвалжныг өнцөг ба талаар ангилах мэдлэг, чадвартай болно.	4.2а. Транспортер хэрэглэн өнцөг хэмжих, өгсөн хэмжээтэй өнцөг зурах, гурвалжин ба дөрвөн өнцөгтийн дотоод өнцгийн нийлбэрийг олох, тайлбарлах, хэрэглэх мэдлэг, чадвартай болно.	5.2а. Олон өнцөгт болон тойрог, дугуйг таних, төв, радиус, диаметр, хөвчийг зурах, дөрвөн өнцөгтийг нэрлэх, ангилах мэдлэг, чадвартай болно.

	3.2б. Куб, параллелепипедийг таних, тэдгээрийн дэлгээсийг гүйцээж зурах, өгсөн дэлгээсээр нь бүтээх мэдлэг, чадвартай болно.	4.2б. Пирамид, призмийг таних, тэдгээрийн дэлгээсийг гүйцээж зурах, өгсөн дэлгээсээр нь бүтээх мэдлэг, чадвартай болно.	5.2б. Цилиндр, конусыг таних, тэдгээрийн дэлгээсийг гүйцээж зурах, өгсөн дэлгээсээр нь бүтээх мэдлэг, чадвартай болно.
Байршил, хөдөлгөөн	3.2в. Цэг, хэрчмийг тэнхлэгийн тэгш хэмээр хувиргах мэдлэг, чадвартай болно.	4.2в. Тэгш өнцөгт гурвалжин болон тэгш өнцөгтийг тэнхлэгийн (налуу) тэгш хэмээр хувиргах, параллелиар зөөх мэдлэг, чадвартай болно.	5.2в. Дүрсийг тэнхлэгийн (налуу) тэгш хэмээр хувиргах, тэгш өнцөгт гурвалжныг аль нэг оройг төв болгон 90 градусын өнцгөөр эргүүлэх; тэгш хэм, параллель зөөлт, эргүүлэлтээр зураг, хээ зурах, бүтээх мэдлэг, чадвартай болно.
	3.2г. Зураг болон хөлөг дээрх юмсын байршлыг тодорхойлох, шилжүүлэх; тоон шулуун дээр өгсөн цэгийн координатыг тодорхойлох, өгсөн чиглэл, зайд шилжүүлэх мэдлэг, чадвартай болно.	4.2г. Координатын хавтгайн I мөч дэх цэгийн координатыг тодорхойлох, өгсөн координаттай цэг тэмдэглэх, өгсөн чиглэл, зайд шилжүүлэх мэдлэг, чадвартай болно.	5.2г. Координатын хавтгайд цэгийн координатыг тодорхойлох, өгсөн координаттай цэг тэмдэглэх, координатын хавтгайн I мөч дэх хэрчмийг өгсөн чиглэл, зайд параллелиар зөөж, хэрчмийн эхлэл болон төгсгөлийн цэгийн координатыг тодорхойлох мэдлэг, чадвартай болно.

Агуулгын ай 3. Хэмжигдэхүүн

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Урт, масс	3.3а. Хэмжих хэрэгсэл ашиглан урт (км), масс (г, ц, т), эзлэхүүн (мл)-ийг хэмжих, харьцуулах, хэмжих хэрэгслийн хуваарийн утгыг тайлбарлах, нэг нэгжийг нөгөөгөөр илэрхийлэх, жиших, ахуй амьдралын эд зүйлсийг хэмжихэд танил нэгжээ ашиглах, тооцоолох	4.3а. Ахуй амьдралын эд зүйлсийн урт, масс, эзлэхүүнийг тохиромжтой нэгж сонгон хэмжих, хэмжээг энгийн, аравтын бутархайгаар илэрхийлэх, тайлбарлах мэдлэг, чадвартай болно.	5.3а. Урт, масс, эзлэхүүнийг илүү нарийвчлалтай хэмжихийн тулд тохиромжтой нэгж эсвэл нэгжийн хослолыг ашиглах, ахуй амьдралын асуудлыг шийдвэрлэх мэдлэг, чадвартай болно. 5.3б. Урт, хугацааг хэмжих Монголын уламжлалт нэгжийг таних, хэрэглэх мэдлэг, чадвартай болно.

	мэдлэг, чадвартай болно.		
Талбай	3.3б. Талбайг стандарт бус болон стандарт нэгж (см.кв)-ээр хэмжих, жиших, квадрат, тэгш өнцөгт, тэдгээрээс үүссэн нийлмэл дүрсийн талбайг олох мэдлэг, чадвартай болно.	4.3б. Палетка хэрэглэн аливаа дүрсийн талбай олох, стандарт нэгж (дм.кв, м.кв)-ээр хэмжих, нэг нэгжийг нөгөөгөөр илэрхийлэх, тайлбарлах, талбайн хэмжээг тооцоолох мэдлэг, чадвартай болно.	5.3в. Талбайг хэмжих тохиромжтой нэгж сонгох, стандарт нэгж (км.кв, а, га)-ээр хэмжих, нэг нэгжийг нөгөөгөөр илэрхийлэх, куб, тэгш өнцөгт параллелепипедийн гадаргуугийн талбайн хэмжээг олох, талбайтай холбоотой ахуй амьдралын асуудлыг шийдвэрлэх мэдлэг, чадвартай болно.
Эзлэхүүн		4.3в. Куб, тэгш өнцөгт параллелепипедийн эзлэхүүнийг түүнд багтсан стандарт нэгж (см.куб)-ийг тоолох замаар хэмжих, жиших, биетийн эзлэхүүн ухагдахууныг таних мэдлэг, чадвартай болно.	5.3г. Куб, тэгш өнцөгт параллелепипедийн эзлэхүүнийг томьёо хэрэглэн олох, тайлбарлах, тохирох нэгж (см.куб, дм.куб, м.куб)-ээр илэрхийлэх мэдлэг, чадвартай болно.
Хугацаа	3.3в. Хугацаа (секунд, минут, цаг)-г хэмжих, харьцуулах, аналогич цаг хэрэглэх, 12, 24 цагийн горимыг ялгах, үргэлжлэх хугацааг тооцоолох, хугацааны нэг нэгжийг нөгөөгөөр илэрхийлэх, жиших, хэрэглэх мэдлэг, чадвартай болно.	4.3г. Хугацааг тохиромжтой нэгж сонгон хэмжих, хуанли хэрэглэх, үргэлжлэх хугацааг тооцоолохтой холбоотой бодлого бодох, зохиох мэдлэг, чадвартай болно.	5.3д. Цагийн хуваарь болон аяллын төлөвлөгөө хэрэглэн үйл ажиллагааг төлөвлөх, үйл явдал болон аяллын үргэлжлэх хугацааг тодорхойлох, хугацаатай холбоотой ахуй амьдралын асуудлыг шийдвэрлэх мэдлэг, чадвартай болно.

Агуулгын ай 4. Магадлал, статистик

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Өгөгдлийн шинжилгэ	3.4а. Өгөгдлийг хоёр шинжээр нь ангилал, Карролл, Эйлер-	4.4а. Өгөгдөл цуглуулж, диаграммын түлхүүр, хуваарийг оновчтой	5.4а. Өгөгдөл шугаман дүрслэх, цуглуулан, графикаар

э	<p>Веннийн диаграммаар дүрслэх мэдлэг, чадвартай болсон байна.</p> <p>Өгөгдөл цуглуулж баганан, цэгэн диаграммаар дүрслэх, тайлбарлах мэдлэг, чадвартай болно.</p>	<p>сонгож дүрслэх, өгсөн шугаман графикийг тайлбарлах мэдлэг, чадвартай болно.</p>	<p>өгөгдлүүдийн хамаарлыг тайлбарлах, өгсөн дугуй диаграммыг тайлбарлах тайлбарлах мэдлэг, чадвартай болно.</p>
		<p>4.4б. Өгөгдлийн моодыг олох, тайлбарлах мэдлэг, чадвартай болно.</p>	<p>5.4б. Өгөгдлийн далайц, арифметик дундаж, медианыг олох, тайлбарлах мэдлэг, чадвартай болно.</p>
Туршилт, боломж	<p>3.4б. Ажиглалт, туршилтаар үзэгдлийг бага, их боломжтой, гарцаагүй болохыг тайлбарлах, хоёр болон нэг олонлогоос хос үүсгэх бүх боломжийн тоог тооцоолж, боломжуудад тулгуурлан таамаглал дэвшүүлэх, түүнийгээ туршилт, тооцооллоор шалган дүгнэлт гаргах мэдлэг, чадвартай болно.</p>	<p>4.4в. Ялгаатай туршилтууд, туршилтын нөхцөл өөрчлөгдөх үед үзэгдлийн боломжуудыг шинжилж жиших, боломжийн тоог олж, үзэгдлийн боломжийг таамаглаад туршилт болон тооцооллоор их, бага, гарцаагүй байхыг тогтоож тайлбарлах, боломжуудыг харьцуулсан үндэслэлтэй шийдвэр гаргах мэдлэг, чадвартай болно.</p>	<p>5.4в. Үзэгдэл илрэх боломжийн тоог олох, үр дүнг ангилж бүртгэх, тэгш боломжтой үзэгдлийг таних, үзэгдлийн боломжийг таамаглаад туршилт болон тооцооллоор шалгаж боломжоор нь эрэмбэлэх, тайлбарлах мэдлэг, чадвартай болно.</p>

ГУРАВ. АРГА ЗҮЙ, ОРЧИН

3.1. Арга зүй

Суралцахуйн онолд суралцагч багшийн өгсөн мэдлэг, мэдээллийг идэвхгүйгээр хүлээн авагч биш, өмнө эзэмшсэн мэдлэг, чадвар, туршлагадаа тулгуурлан мэдлэгийг идэвхтэйгээр бүтээдэг гэж үздэг. Бага боловсролын математикийн хөтөлбөрийг дээрх онолын үзэл баримтлалд суурилан хэрэгжүүлнэ.

Математикийн хөтөлбөрийн зорилго нь суралцагчийн математик сэтгэлгээг хөгжүүлэх, бие даан болон хамтран суралцах чадварыг дэмжих, суралцах сонирхлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн. Иймд математикийн сургалтад асуудал шийдвэрлэх арга зүйг голлон хэрэгжүүлнэ. Энэхүү арга зүй нь суралцагчийн суралцахуйд суралцах, бие даан болон хамтран ажиллах чадамжийг хөгжүүлнэ.

Ахуй амьдралын асуудал шийдэх болон математикийн бодлого бодохын аль алиныг асуудал шийдвэрлэхэд хамааруулдаг. Бага боловсролын түвшинд шийдвэрлэх ахуй амьдралтай холбоотой асуудал нь дараах нийтлэг агуулгыг хамарсан байна. Үүнд: 1. монгол соёл, өв уламжлал (хээ, угалз, тооны нэр, уламжлалт хэмжих нэгж, үндэсний болон хөлөгт тоглоом зэрэг), 2. эдийн засаг, санхүүгийн боловсрол (үндэсний мөнгөн тэмдэгт (төгрөг)-ийг таних, задлах, бүхэлдэх, хэмнэлттэй хэрэглээ, тооцоолол хийх, хадгалах, хуримтлуулахын ач холбогдлыг ойлгох зэрэг), 3. эрүүл мэндийн боловсрол (эрүүл мэндэд ээлтэй дэглэм, хэрэглээтэй холбоотой өгөгдөлтэй ажиллах, тооцоолол хийх, ...), 4. тогтвортой хөгжлийн боловсрол (байгаль орчинд ээлтэй хэрэглээний болон ус, цахилгааныг хэмнэх тооцоолол хийх, ..), 5. иргэний ёс зүй (сайн, муу болон шударга, шударга бус үйлтэй холбоотой өгөгдөл, тоон мэдээлэлтэй ажиллах, суралцагчдад зөв, шударга, сайн үйлийг ухуулан таниулах зэрэг), 6. нийгэм, сэтгэл хөдлөлийн суралцахуй (товлосон цагаасаа хоцрохгүйн тулд хугацаагаа тооцоолох, сэтгэл хөдлөлөө таньж ойлгохын тулд өгөгдөл цуглуулах, бүртгэх, дүрслэх, боломж, эрсдэлийг тооцоолж сэтгэл хөдлөлөө удирдах, математик тооцоолол ашиглан олон сонголтоос оновчтойг сонгох зэрэг)

Математикийн сургалтад асуудал шийдвэрлэх арга зүйг дараах алхмуудын дагуу төлөвлөж хэрэгжүүлнэ.

Асуудал шийдвэрлэх арга зүйн алхмууд

Алхам	Жишиг үйл ажиллагаа
Асуудалтай танилцах	<ul style="list-style-type: none">- Математикийн болон ахуй амьдралтай холбоотой асуудал дэвшүүлэх, асуудлыг сонирхолтойгоор танилцуулах;- Хэрэв багаар ажиллаж буй бол гишүүдийн үүргийг тодорхойлох, төлөвлөх, багаар хэлэлцэх, асуудлаа танилцуулах;

Асуудлыг ойлгох, төлөвлөх	<ul style="list-style-type: none"> - Асуудлын зорилго, нөхцөлийг ойлгосон эсэхийг баталгаажуулах, тодруулж асуух, суралцагчийн санаа, таамаглалыг тандах, асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх аргаа төлөвлөхөд чиглүүлэх; - Өмнөх мэдлэгээ сэргээн санах, багаараа асуудлын жагсаалт гаргах, янз бүрийн эх сурвалжаас мэдээлэл хайх;
Асуудлыг шийдэх	<ul style="list-style-type: none"> - Төлөвлөсөн аргаа хэрэгжүүлэхэд нь суралцагчдыг ажиглах, дэмжих, суралцагчдад асуудлыг өөрийнхөөрөө, өвөрмөц аргаар шийдэх боломж олгох; - Бие даан эсвэл хамтран ажиллах, бие биеэсээ асуулт асуух нөхцөл бүрдүүлэх; - Ахуй амьдралын асуудлыг математикийн загварт шилжүүлэх, математикийн мэдлэг, чадвараа ашиглан шийдэх, шийдлийг ахуй амьдралын нөхцөлд тайлбарлах;
Шийдлийг танилцуулах, эргэцүүлэх	<ul style="list-style-type: none"> - Суралцагч өөрийн болон хамтын шийдлийнхээ талаар бусдадаа танилцуулах (математик хэлээр илэрхийлэх), бусдыг анхааралтай сонсох, өөрийн шийдлийг бусдынхтай харьцуулах, үнэлэх;
Нэгтгэн дүгнэх, үнэлэх	<ul style="list-style-type: none"> - Суралцагч асуудлыг шийдлийг шалгах, адил төстэй асуудалд хэрэглэж сурах, өөр арга шийдэл санал болгох, хамгийн оновчтойг нь сонгох, тэмдэглэх.

Бага ангийн суралцагчийн нас, сэтгэхүйн онцлогийг харгалзан суралцагчид асуудалтай танилцах, шийдвэрлэх аргыг сонгох, өөр өөрийн чадах аргаар шийдвэрлэх, шийдлийг тайлбарлах, нэгтгэн дүгнэх үйлийн дарааллаар хичээл, сургалтын үйл ажиллагаагаа төлөвлөнө. Бага насны суралцагчид ахуй амьдралын бодит юмсыг гараар барьж, нүдээр харж мэдэрч байж математикийн ухагдахууны талаар ойлголт, мэдлэгтэй болдог. Энэ онцлогийг харгалзан сургалтад “ТДХ” аргыг голлон ашиглана. Энэ нь асуудал шийдвэрлэх суралцахуйн арга зүйг дэмжих арга болно.

ТДХ арга

Т нь *тодорхой*, Д нь *дүрслэл*, Х нь *хийсвэр* гэсэн үгийн товчлол бөгөөд ТДХ нь тодорхой (биет, бодит зүйлс), дүрслэл (зураг, дүрслэл, диаграмм), хийсвэр (тоо, тэмдэгт) ойлголтын үе шат хоорондын холбоогоор суралцагчид математик ухагдахуун, ойлголтыг таниулах арга юм. Энэ аргын дагуу эхлээд биет хэрэглэгдэхүүн, бодит юмс ашиглах, тэдгээрийг зураг, дүрслэл, загвараар илэрхийлэх, загвар, дүрслэлд суурилан математик ухагдахууныг ойлгох, бичих, тэмдэглэх гэсэн дарааллаар суралцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үе шат бүр хоорондоо уялдаа холбоотой бөгөөд дараагийнх нь өмнөх шатандаа суурилдаг. Суралцагч “тодорхой” болон “дүрслэл”-ийн шатыг дамжилгүйгээр шууд “хийсвэр” шатанд хүрэхэд бэрхшээлтэй. “Хийсвэр” шатанд математикийн тэмдэг, тэмдэглэгээ, ухагдахууныг таниулдаг. Суралцахуйг үр дүнтэй болгохын тулд суралцагч үе шатуудын хооронд эргэж буцаж, урагшлах хэрэгтэй болдог. Ингэснээр суралцагчид математикийн ухагдахууны мэдлэг, ойлголтыг бататгах, бэхжүүлэх боломж олгоно. Бага боловсролын эхлэл шатлал (I-II анги)-д “Тодорхой” түвшнийг заавал харгалзан

үзэх хэрэгтэй, харин төгсгөл шатлал (III-V)-д агуулгаас хамаарч “Дүрслэл” түвшнээс эхэлж болно.

Мөн өнөөгийн мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил, суралцагчийн дижитал суралцахуйн хэрэгцээ, чадварыг үндэслэн цахим технологи, дижитал платформ хэрэглэн суралцагчийн сонирхлыг татах, бүтээлчээр сэтгэх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэхэд анхаарна.

Математикийн сургалтаар бага ангийн суралцагчийн уншиж ойлгох чадварыг хөгжүүлэхэд өгүүлбэртэй бодлого бодуулах нь чухал нөлөөтэй. Мөн өгүүлбэртэй бодлого нь математикийг ахуй амьдралтай холбох, суралцагчийн хэл яриа, математик сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх чадварыг хөгжүүлэх боломж олгодог. Өгүүлбэртэй бодлогын хам сэдэв нь бодит судалгаа, мэдээлэлд суурилагаас гадна эх дэлхий, эх орон, түүх, соёл уламжлал, технологи зэрэг ахуй амьдралтай уялдаа холбоотой байна.

Суралцагчдад өгүүлбэртэй бодлого бодоход тулгарч буй бэрхшээлийг дараах таван алхмын дагуу тодорхойлж, шаардлагатай дэмжлэг үзүүлнэ.

Өгүүлбэртэй бодлого бодох алхмууд

Алхам	Жишиг үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт
Унших	Бодлогын өгүүлбэрийг унших, шаардлагатай бол дахин унших	Бодлогын өгүүлбэрийг уншиж чадсан уу? Дахин унших хэрэгтэй юу? зэрэг.
Ойлгох	Уншсанаа ойлгох, бодлогын нөхцөлийг ойлгох, өөрийн үгээр тайлбарлах	Бодлогын өгүүлбэрийн утгыг ойлгосон уу? Юу ойлгосон бэ? Юу өгсөн байна вэ? Юу олох ёстой вэ? гэх мэт.
Загварчлах	Бодлогын асуудлыг математикийн загварт хөрвүүлэх, бодох арга, үйлдлийг тодорхойлж, төлөвлөх	Бодлогын нөхцөлийг загвар дүрслэлээр илэрхийлж чадсан уу? Өгсөн ба олох зүйлийн холбоо хамаарлыг илрүүлж чадсан уу? Ямар арга, үйлдэл сонговол тохиромжтой вэ? Ямар алхмын дагуу бодох вэ? Ямар үйлдэл хийх вэ? гэх мэт.
Бодох	Төлөвлөсөн арга, үйлдлээ гүйцэтгэх, тооцоолол хийх	Төлөвлөсний дагуу үйлдлээ гүйцэтгэсэн үү? Сонгосон аргаар үйлдэл, тооцооллоо зөв гүйцэтгэж чадсан уу? зэрэг.

Хариу бичих, шалгах	Хариуг бичих, тэмдэглэх, шалгах	Хариугаа бичсэн үү? Хариундаа нэгж, тэмдэглэгээ бичсэн үү? Тайлбарлаж чадах уу? Хариугаа шалгасан уу? гэх мэт
---------------------	---------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------

3.2. Сургалтын орчин

Сургалтын орчин нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад нөлөөлөх гол хүчин зүйл юм. Суралцагчийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн сургалтын арга, хэлбэрийг сонгон, эерэг таатай уур амьсгал бүхий эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх нь чухал. Үүний зэрэгцээ тоглоом, үйл ажиллагааны дүрэм баримтлах, тэгш оролцоотой байх (хүний эрх), багаар ажиллахад хүйсийн харьцааг анхаарах, тэгш боломж олгох (жендэрийн эрх тэгш байдал), бусдыг ойлгох, нэг нэгэндээ туслах (хүмүүнлэг), үүрэг даалгаврыг хариуцлагатай гүйцэтгэх, шударга байх (иргэний ёс зүй) зэргийг харгалзан хичээл, сургалтын үйл ажиллагааг удирдан чиглүүлнэ. Иймд дараах орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Эерэг таатай уур амьсгал бүхий харилцаа:

- Багш-суралцагч, суралцагч-суралцагч бие биеэ сонсдог, хүндэтгэдэг, урам зориг өгдөг;
- Суралцагч алдахаас айдаггүй, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлдэг;
- Математик тоглоом, сонирхолтой үйл ажиллагаанд оролцох боломж бүрдүүлсэн;
- Харилцах, хамтран ажиллах боломжтой;
- Багш туслагч, зөвлөгч, чиглүүлэгч байж, суралцагчийг өөртөө итгэлтэй, математикт дуртай болоход дэмжлэг болдог;
- Суралцагчийн тууштай байдал, идэвхтэй оролцоог дэмжиж, амжилтыг урамшуулдаг;

Эрүүл, аюулгүй, хүртээмжтэй анги танхим:

- Суралцагчийн сэтгэл санаа, бие махбодын эрүүл мэндийг дэмжсэн;
- Суралцагчийн хөдөлгөөн хийх, бие биетэйгээ харилцах боломжтой, уян хатан зохион байгуулалттай;
- Суралцагчийн бүтээлч үйл ажиллагааг дэмжсэн, хүртээмжтэй, аюулгүй хэрэглэгдэхүүн ашиглах боломжтой;
- Сургалтын интерактив, дижитал хэрэглэгдэхүүн ашиглах боломжтой;

Ялгаатай хэрэгцээг харгалзсан орчин:

- Суралцагчийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрсөн, түүнийг хүндэтгэсэн;
- Суралцагчийн суралцах хэв шинж, ялгаатай хэрэгцээнд тохирсон төрөл бүрийн сургалтын материал, хэрэгслийг бэлтгэх, ашиглах боломжтой;

- Хэл, соёлын ялгаатай суралцагчдад зориулсан сургалтын болон бусад толь бичиг, номтой;
- Суралцахуйн хоцрогдолтой болон илүү хурдтай суралцагчдад зориулсан, сонголт хийх боломж бүхий ялгаатай даалгаврын сантай.

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

4.1. Үнэлгээний зорилго

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, төлөвшлийн давуу болон сул тал, суурь болон ерөнхий чадамжийн ахиц дэвшлийг илрүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг дэмжих, урамшуулах, хөтөлбөрийн хүрэх үр дүнг үнэлж, дүгнэхэд чиглэнэ.

Бага боловсролын эхлэлд суралцагчийн чадамжийн хөгжил, математикийн мэдлэг, чадварын ахиц, гүйцэтгэлийн түвшнийг илрүүлэх, суралцах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн явцын үнэлгээ хийнэ.

Бага боловсролын төгсгөлд суралцагчийн чадамжийн хөгжил, математикийн мэдлэг, чадвар эзэмшилтийн түвшин, ахицыг илрүүлэх, суралцах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн явцын болон үр дүнгийн үнэлгээ хийнэ.

4.2. Үнэлгээний шалгуур

Хүрэх үр дүн	Шалгуур
Тоо тоолол, хэмжигдэхүүн, геометр, магадлал, статистикийн суурь мэдлэг, чадвартай болно.	<ul style="list-style-type: none"> - Бүхэл тоо, бутархай тоо, процент, харьцаа, пропорцын утга санааг ойлгодог, арифметикийн үйлдэл, тооцооллыг бичгээр, цээжээр, ойролцоогоор гүйцэтгэдэг, үйлдлийн чанар, гишүүдийн хамаарал, тооны хуваагдах шинжийг хэрэглэдэг, тэгшитгэл боддог, тоонуудын хамаарал, зүй тогтлыг олдог, тэгшитгэл, бодлого зохиодог. - Урт, масс, талбай, эзлэхүүн, хугацааг баримжаалдаг, тохиромжтой нэгж, хэрэгсэл сонгон хэмждэг, нэгжүүдийн хооронд нь шилжүүлдэг, хэмжээг тооцоолдог, ахуй амьдралын асуудлыг шийдвэрлэхийн тулд тохирох хэмжигдэхүүнийг сонгон ашигладаг. - Хавтгайн дүрс, шулуун, өнцөг, биетүүдийг нэрлэдэг, зурдаг, ангилдаг, шинж чанарыг нь тодорхойлдог, дэлгээсээр биетийг бүтээдэг, дүрсийн хувиргалтыг таньдаг, координатын хавтгай дахь дүрс, цэгийн байршлыг тодорхойлдог, шилжүүлдэг. - Өгөгдөл цуглуулж, диаграмм, шугаман графикаар дүрсэлдэг, өгөгдлийн дунджуудыг олдог, үзэгдлийн илрэх боломжийн тоог олдог, үзэгдлүүдийг илрэх боломжоор нь эрэмбэлдэг, тайлбарладаг.
Математикийн тэмдэг, тэмдэглэгээ болон өгүүлбэртэй бодлогыг уншиж ойлгон бодлого бодох арга	<ul style="list-style-type: none"> - Математикийн тэмдэг, тэмдэглэгээ, бичиглэлийг уншиж ойлгодог, санаагаа эх хэл болон математик хэлээр ойлгомжтой илэрхийлдэг.

<p>дэвшүүлдэг, оновчтой аргыг сонгож хэрэглэдэг, сонгосон аргаа эх хэл болон математик хэл хэрэглэн тайлбарладаг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Математикийн ухагдахуун, зүй тогтлыг нэг хэлбэрээс нөгөөд шилжүүлдэг, асуудалд тохирох хэлбэрийг сонгон оновчтой илэрхийлдэг. - Тооцоолол хийх, бодлого бодохдоо боломжит аргуудаас хамгийн хялбар, дөт аргыг сонгон хэрэглэдэг. - Бодлого бодох, тооцоолол хийх өөрийн арга, санаа гаргадаг, туршдаг, түүнийгээ эх хэл болон математик хэл хэрэглэн бусадтай хуваалцдаг.
<p>Танил болон танил бус нөхцөлд математикийн мэдлэг, чадвараа хэрэглэн асуудал шийдвэрлэдэг, учир шалтгааныг үндэслэлтэй тайлбарладаг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Танил, танил бус нөхцөл байдал, ахуй амьдралын асуудлыг математикаар загварчилж, асуудлын мөн чанарыг ойлгодог. - Асуудлыг шийдвэрлэх оновчтой аргыг сонгон, мэдлэгээ уян хатан хэрэглэж, тооцоолон боддог. - Өөрийн гаргасан шийдвэр, үйлдэл, сонголтыг математикийн зүй тогтол, дүрэм, эсвэл учир шалтгаанд үндэслэн баталгаажуулж, тайлбарладаг. - Асуудлын шийдвэрийг бодит нөхцөл байдалтай харьцуулан, хариу нь бодит байдалд нийцэж байгаа эсэхийг эргэцүүлэн шалгадаг.
<p>Ахуй амьдралын асуудалд математик сэтгэлгээгээр хандаж, бие даан болон хамтран бүтээлч шийдэл гаргаж чаддаг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Математик мэдлэг, чадвараа өдөр тутмын амьдралдаа хэрэглэхийг эрмэлздэг, байгаль орчин, эрүүл мэндэд ээлтэй, хэмнэлттэй хэрэглээг эрхэмлэдэг. - Багийн ажилд үүрэгтэй оролцдог, санаа бодлоо илэрхийлдэг, бусдын ялгаатай байдал, санаа бодлыг хүндэтгэн харилцдаг, ажлын гүйцэтгэлээ эргэцүүлэн дүгнэдэг. - Математикийн мэдлэг, чадвараа хэрэглэн биет болон цахим бүтээл хийх, зураг зурах, дижитал хэрэгслийг бүтээлчээр ашигладаг. - Асуудлыг шийдвэрлэхэд бүтээлчээр ханддаг, математик сэтгэлгээгээ хэрэглэдэг.

БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ

НЭГ. ЗОРИЛГО

1.1. Зорилго

Суралцагчийн хүрээлэн буй орчны юмс үзэгдлийг шинжлэн судлах суурь чадамж болон бүтээлчээр сэтгэх, шүүн тунгаах, суралцахууд суралцах, харилцах, хамтрах ерөнхий чадамжийг хөгжүүлнэ.

1.2. Хүрэх үр дүн, шатлал

Энэхүү хөтөлбөрийг судалснаар суралцагчид дараах ерөнхий үр дүнд хүрсэн байна.

- Байгалийн ухааны үндсэн ухагдахууны талаарх мэдлэг, ойлголттой болно.
- Байгалийн юмс, үзэгдлийг шинжлэн судлах арга барил эзэмшиж, өөрийн судалж, туршсанаа эх хэлээрээ ойлгомжтой илэрхийлэх, тайлбарлах чадвартай болно.
- Байгаль орчноо хайрлан хамгаалах сэтгэлгээ хөгжиж, байгальд ээлтэй, хариуцлагатай ханддаг болно.

№	Хүрэх үр дүн	Шатлал	
		I-II анги	III-V анги
1	Байгалийн ухааны үндсэн ухагдахууны талаарх мэдлэг, ойлголттой болно.	Амьдрал, байгалийн юмс үзэгдлийн шинж чанар, өөрчлөлтийг урьдчилан таамаглаж, туршилтаар нотлон үндсэн ойлголт, нэр томъёог ялган таньдаг болно.	Амьдрал, байгалийн юмс үзэгдлийн шинж чанар, өөрчлөлт, тэдгээрийн холбоо хамаарал, зүй тогтлыг ойлгож учир шалтгааныг харьцуулан тайлбарладаг болно.
2	Байгалийн юмс, үзэгдлийг шинжлэн судлах арга барил эзэмшиж, өөрийн судалж, туршсанаа эх хэлээрээ ойлгомжтой илэрхийлэх, тайлбарлах чадвартай болно.	<p>Байгалийн юмс, үзэгдлийн талаар сонирхсон зүйлээ "хэн?", "юу?", "хаана?", "хэзээ?", "яагаад?", "яаж?" зэрэг асуулт асууж, юу болохыг урьдчилан таамагладаг болно.</p> <p>Багшийн дэмжлэгтэйгээр юуг яаж ажиглах, туршилт ажлын багаж, хэрэгслийг сонгож хэрэглэн гүйцэтгэх алхмыг төлөвлөдөг болно.</p> <p>Ажиглалт, туршилт, хэмжилтийг хийхдээ аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөн, зааврын дагуу гүйцэтгэх, үр дүнг бүртгэх зэргээр ажлын хуудсанд тэмдэглэдэг болно.</p> <p>Ажлын хуудсанд тэмдэглэсэн үр дүнг харьцуулах, ангилах аргаар боловсруулдаг болно.</p> <p>Багшийн дэмжлэгтэйгээр боловсруулсан үр дүнг зурах,</p>	<p>"Яагаад ийм өөрчлөлт гарсан бэ?", "Ямар холбоо, хамааралтай вэ?", "Ямар зүй тогтол ажиглагдсан вэ?" зэргийг баримт нотолгоонд тулгуурлан асуулт асууж, тухайн өөрчлөлтийн шалтгаан, холбоо хамаарал, зүй тогтлын талаар таамаглал дэвшүүлдэг болно.</p> <p>Багш суралцагчдын хамтын оролцоотойгоор ажиглалт болон туршилтад шаардлагатай багаж хэрэгслийг сонгож, хэрхэн ашиглах заавар, гүйцэтгэх алхам, ажлын хуудсыг бэлтгэн төлөвлөдөг болно.</p> <p>Ажиглалт, туршилтыг алхам дарааллаар нягт нямбай гүйцэтгэх, өөрчлөлтийн шалтгаан, холбоо хамаарал, зүй тогтлыг бүртгэж, ажлын хуудсанд тэмдэглэдэг болно.</p>

		ярих, бичих зэргээр илэрхийлж, бусдад танилцуулдаг болно.	Ажлын хуудсанд тэмдэглэсэн үр дүнг харьцуулах, ангилах, нэгтгэх, задлан шинжлэх аргаар боловсруулах, үр дүнг нягталдаг болно. Боловсруулсан үр дүнг зураг, бичвэр, хүснэгт, бүдүүвч, баганан диаграмм, график ашиглан дүгнэлт гаргаж, бусдад тайлбарлан танилцуулдаг болно.
3	Байгаль орчноо хайрлан хамгаалах сэтгэлгээ хөгжиж, байгальд ээлтэй, хариуцлагатай ханддаг болно.	Байгалийн юмс үзэгдлийг шинжлэн судлах хүсэл сонирхолтой, бусдад хамтран ажилладаг болно. Туршилт, дасгал даалгаврыг зааврын дагуу нягт нямбай, аюулгүй гүйцэтгэдэг болно. Байгаль орчноо бохирдуулахгүй байх, хогоо хогийн саванд хийх дадлыг өөрийн үйлдлээр үлгэрлэн харуулдаг болно.	Байгалийн юмс үзэгдлийг шинжлэн судалж, багийн ажилд өөрийн хувь нэмрийг оруулдаг болно. Туршилт, дасгал даалгаврыг гүйцэтгэхдээ аюулгүй байдлыг эрхэмлэдэг болно. Амьд бие, юмсыг хайрлан хамгаалахад хувь нэмрээ оруулж, бусдад нөлөөлдөг болно.

ХОЁР. АГУУЛГА

2.1. Бага боловсролын эхлэл шатлал

Агуулгын ай 1. Амьд бие

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Амьд биеийн онцлог, үндсэн хэрэгцээ	1.1а. Эргэн тойрны амьд бие ба амьгүй биетийг ажиглаж хөдлөх, мэдрэх шинжид үндэслэн ялган танина. 1.1б. Хүний биеийн бүтцийн хэсгүүдийг нэрлэж, бие өсөж том болдгийг жишээгээр нотлон тайлбарлана 1.1в. Хүний мэдрэхүй нь өнгө, хэлбэр, хэмжээ хөдөлгөөн, дуу чимээ, амт, үнэр, халуун, хүйтэн, хатуу, зөөлөн шинжийг мэдэрч ялган таньдаг болохыг туршилтаар нотолно.	2.1а. Тасалгааны ургамлын үндэс, иш, навч зэрэг бүтцийн хэсгүүдийг ялган танина. 2.1б. Ургамалд ус ба гэрэл хэрэгтэй болохыг ажиглалт туршилтаар тодорхойлно.
Амьд биеийн амьдрах орчин	1.1г. Таван хошуу мал, тэжээвэр амьтад, хүнсний ногоо, жимс жимсгэнийг ажиглан, амьдрах орчны онцлог, хэрэглээг тайлбарлана.	2.1в. Олон янзын ургамлын ургах орчин ялгаатай болохыг ажиглаж, тайлбарлана. 2.1г. Монгол орны зарим амьтан, ургамлыг ой, тал хээр, говь цөл, усан орчинд амьдардаг болохыг ангилан

		бүлэглэж, амьдрах орчны ялгаатай байдлыг жишээгээр тайлбарлана.
--	--	-----------------------------------------------------------------

Агуулгын ай 2. Бодис

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Бодис, Материалын шинж	<p>1.2а. Анги танхим, гэрт байгаа биетийг мод, шил, хуванцар, цаас, даавуу, металл, резин зэрэг материалаар хийсэн болохыг ялгаж нэрлэнэ.</p> <p>1.2б. Материалын бат бөх-хэврэг, уян-уян биш шинж чанарыг тодорхойлно.</p>	<p>2.2а. Анги танхим, гэрт байгаа биетийг хийсэн материал болон материалын шинж чанарыг нь үндэслэн ангилна.</p> <p>2.2б. Анги танхим, гэрт байгаа биетийн гэрэл нэвтэрдэг, нэвтэрдэггүй шинж чанарыг туршин тодорхойлно.</p>

Агуулгын ай 3. Хүч ба энерги

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Хүч ба хөдөлгөөн	<p>1.3а. Тайван байгаа биеийг хөдөлгөхийн тулд татах, түлхэх шаардлагатай гэдгийг илрүүлж, хөдлөх чигийг тодорхойлно.</p> <p>1.3б. Соронзод татагддаг-татагддаггүй, усанд хөвдөг-живдэг биеийг ялгана.</p>	<p>2.3а. Биед хүч үйлчлэхэд байрлал, хэлбэр хэмжээ, хурд, хөдөлгөөний чиглэл өөрчлөгдөж байгааг жишээгээр тайлбарлана.</p>
Энерги (дуу авиа, гэрэл)	<p>1.3в. Дуу чимээг үүсгэгчийн байршил, зайнаас хамааруулан чанга сул сонсогдох ялгааг тайлбарлана.</p>	<p>2.3б. Гэрэл үүсгэгчийг ялган таньж, гэрлийн өөрчлөлт нь орчны харагдах байдалд нөлөөлж буй эсэхийг ажиглаж тайлбарлана.</p>

Агуулгын ай 4. Дэлхий

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Орон зай	<p>1.4а. Эргэн тойрны юмсын байрлалыг харьцуулан үндсэн 4 зүгээр ялгаж нэрлэнэ.</p>	<p>2.4а. Сургууль орчмын план зураг болон орчны ажиглалтаар үндсэн ба завсрын зүг чигийг зурж, ялган нэрлэнэ.</p>
Байгаль орчин, үзэгдэл	<p>1.4б. Энгийн туршилт хийж өдөр шөнийн ялгаа (гэрэлтэй харанхуй, дулаан, хүйтэн)-г харьцуулна.</p> <p>1.4в. Дөрвөн улирлаас хамаарч монгол орны байгаль орчинд гарч байгаа өөрчлөлтийг ялгана.</p>	<p>2.4б. Мэдээлэлд тулгуурлан хоног, сар, жилийн ялгааг таньж, саруудыг улирлаар нь ангилна.</p> <p>2.4в. Төрөл бүрийн дүрслэл, загвар, газрын зураг ашиглан гадаргын хэлбэр, усны төрлүүдийг ялган танина.</p>

		2.4г. Тэнгэрийн байдлыг ажиглан цаг агаарын нөхцөлийг дүрс, зургаар илэрхийлнэ.
--	--	---------------------------------------------------------------------------------

2.2. Бага боловсролын төгсгөл шатлал

Агуулгын ай 1. Амьд бие

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Амьд биеийн онцлог, үндсэн хэрэгцээ	<p>3.1а. Амьд биеийг 5 үндсэн шинжид нь үндэслэн амьгүй биетээс ялган таньж, тайлбарлана.</p> <p>3.1б. Амьтан (шавж, аалз)-ы биеийн бүтцийн онцлог шинжийг харьцуулна.</p> <p>3.1в. Ургамал ургахад ус чийг, гэрэл, дулаан, агаар шаардлагатай болохыг туршилтаар нотолно.</p>	<p>4.1а. Хүний биеийн араг ясны бүтцийн хэсгүүдийн үүргийг жишээгээр тайлбарлана.</p> <p>4.1б. Хүн ба амьтны араг ясны төсөөтэй ба ялгаатай шинжийг жишээгээр тайлбарлана.</p> <p>4.1в. Булчин, араг яс, үе холбоос нь хөдөлгөөнд оролцдог болохыг бугалгын хос булчингийн бүтцийн загвараар тайлбарлана.</p>	<p>5.1а. Хүний төрөхийн өмнөх болон төрсний дараах өсөлт, хөгжлийн онцлог шинжийг зурагт тайлбарлана.</p> <p>5.1б. Ургамлыг ишээр үржүүлж, бие гүйцсэн ургамал бий болохыг туршина.</p> <p>5.1в. Цэцэгт ургамлын амьдралын эргэлтийг зурагт тайлбарлаж, бүдүүвч зохионо.</p> <p>5.1г. Амьтан (байцайны эрвээхэй, царцаа)-ы үржил хөгжлийн онцлог, амьдралын эргэлтийг зурагт харьцуулж тайлбарлана.</p>
Амьд биеийн амьдрах орчин	<p>3.1г. Амьд биеийн өсөлт, хөгжилд амьдрах орчны нөхцөл хэрхэн нөлөөлдгийг жишээ, туршилтаар нотолно.</p>	<p>4.1г. Зарим амьтан, ургамлын биеийн бүтцийн онцлог нь амьдрах орчиндоо зохилдсон болохыг жишээгээр тайлбарлана.</p>	<p>5.1д. Амьд биесийн идэш тэжээлийн уялдаа холбоог зураг болон хөдөлгөөнт загвараар илэрхийлнэ.</p>

Агуулгын ай 2. Бодис

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Бодис, Материалын шинж	<p>3.2а. Материалын шинж чанарт үндэслэн биетийн хэрэглээг тодорхойлно.</p> <p>3.2б. Хатуу, шингэн, хийн төлөвийн шинж</p>	<p>4.2а. Хатуу бодисыг усанд уусдаггүйгээр уусдаг нь ангилна.</p>	<p>5.2а. Температур хугацааны хамаарлын муруй, эсвэл хайлах, буцлах цэгийг үндэслэн тухайн бодис өгөгдсөн температурт ямар төлөвт оршихыг нэрлэнэ.</p>

	чанарыг харьцуулан тайлбарлана.		5.2б. Буцлах болон уурших үзэгдлийн ялгааг тайлбарлана.
Бодис, Материалын өөрчлөлт	3.2в. Холимог дахь материалын шинж чанарт үндэслэн тэдгээрийг салгах арга (шигших арга, соронзын арга)-ыг сонгон хэрэглэнэ, холимгийн масс, холимгийг салгасны дараах массын нийлбэр хадгалагдаж байгааг нотолно.	4.2б. Уусдаггүй бодисыг холимгоос нь шүүх аргаар ялгана. 4.2в. Эргэн тойрон дахь төлөвийн шилжилтээс хайлах, хөлдөх, уурших, конденсацын үзэгдлийг таньж, нэрлэж жишээ гаргана.	5.2в. Байгаль дахь усны эргэлт (хатуу, шингэн, хийн төлөвийн шилжилт)-ийг энерги (нарны гэрлийн энерги, агаарын температурын зөрөө)-ийн шилжилтээр учирлан тайлбарлана. 5.2г. Амьдрал ахуйд тохиолдох үзэгдэл (лаа шатах) дэх эргэдэг, үл эргэдэг өөрчлөлтийг ялгаж, тайлбарлана.

Агуулгын ай 3. Хүч ба энерги

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Хүч ба хөдөлгөөн	3.3а. Салхи болон резинийг ашиглан биеийг хөдөлгөж, үйлчлэлийг тайлбарлана.	4.3а. Дэлхийн татах хүч, усны өргөх хүчийг жишээгээр илэрхийлнэ. 4.3б. Дүүжин ашиглан хөдөлгөөний зүй тогтлыг илрүүлнэ.	5.3а. Хөшүүрэг, хялбар механизмын зарчмыг жишээгээр тайлбарлана. 5.3б. Харилцан үйлчлэлийн үр дүнд биед ямар өөрчлөлт орж байгааг тодорхойлно. 5.3в. Бидний эргэн тойрон дахь үзэгдэл, биеэс сонгож түүнийг хөдөлгөөд байгаа шалтгааныг үндэслэж түүний энергийн хэлбэр, хувирлын өөрчлөлтийг жишээгээр тайлбарлана.
Энерги (дуу авиа, гэрэл)	3.3б. Дуу үүсгэгч, хүлээн авагчийг ялган, орчинд дуу тархахыг тайлбарлана.	4.3в. Сүүдэр үүсэх нөхцөл, гэрэл ойх үзэгдлээр гэрлийн шинж чанарыг тодорхойлно.	5.3г. Нар, сар, од, дэлхийн хөдөлгөөн, одны орд, сарны харагдах байрлал болон хэлбэрийн зүй тогтлыг ажиглан үр дагаврыг жишээ гарган тайлбарлана.

Цахилгаан ба соронз	3.3в. Соронз, соронзон шинж чанар, тэдгээрийн харилцан үйлчлэлийг туршилтаар харуулна.	4.3г. Материалын цахилгаан дамжуулах чанарыг ашиглан энгийн цахилгаан хэлхээг угсарч, түүнийг схем зургаар илэрхийлнэ.	
---------------------	----------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------	--

Агуулгын ай 4. Дэлхий

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Орон зай	<p>3.4а. Таних тэмдэг, зүг чигийн тэмдэглэгээ ашиглан план зураг уншина.</p> <p>3.4б. Глобус ба газарзүйн зураг дээр дэлхийн далай, хуурай газар, тивүүдийг ялган нэрлэхдээ таних тэмдэг ашиглана.</p>	<p>4.4а. Таних тэмдэг, зүг чигийн тэмдэглэгээ ашиглан гэр ба сургууль орчмын план зураг зурж танилцуулна.</p> <p>4.4б. Цаасан дээр дүрсэлсэн зай ба юмсын хэмжээг бодит хэмжээтэй харьцуулна.</p> <p>4.4в. Газарзүйн зураг дээрх зайг шугам ашиглан хэмжиж, масштабын дагуу бодит зайг тооцоолно.</p>	<p>5.4а. Голдоч болон зэргэдийг ашиглан газар орны байршлыг зүг чигийн дагуу зөв тодорхойлно.</p>
Байгаль орчин, үзэгдэл	<p>3.4в. Газарзүйн зураг дээр дүрслэгдсэн монгол орны томоохон уул нурууд, гол мөрөн, нуурыг зааж нэрлэнэ.</p> <p>3.4г. Энгийн багажаар агаарын температур, салхины чиг, тунадсыг хэмжиж тэмдэглэнэ.</p>	<p>4.4г. Мэдээлэл зурагт үндэслэн нарны аймгийн гарагуудыг загварчлан танилцуулна.</p> <p>4.4д. Дэлхийн дотоод бүтцийн давхаргуудыг зураг, загвар ашиглан нэрлэж, тус бүрийг ялгаж тайлбарлана.</p>	<p>5.4б. Хоног ба улирал солигдох учрыг дэлхийн хөдөлгөөнтэй холбон тайлбарлана.</p> <p>5.4в. Дэлхийн ус ба хуурай газрын хэмжээг диаграммаар дүрслэх, тооцоо хийх зэргээр харьцуулж тайлбарлана.</p> <p>5.4г. Дэлхийн зарим томоохон уул нуруу, тал, гол мөрөн нуурыг газарзүйн зурагт зааж нэрлэнэ.</p> <p>5.4д. Цаг агаарыг тодорхойлох температур, салхи, тунадас, үүлшилтийг багаж ашиглан хэмжиж график, диаграммаар илэрхийлнэ.</p>

			5.4е. Дэлхийн уур амьсгалын ялгаа үүсэх шалтгааныг нарны тусгал, газарзүйн байрлалтай холбон тайлбарлана.
--	--	--	-----------------------------------------------------------------------------------------------------------

ГУРАВ. АРГА ЗҮЙ, ОРЧИН

3.1. Арга зүй

Бага боловсролын байгаль шинжлэлийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд суралцагч нь мэдээллийг шууд хүлээн авагч бус, харин өөрийн өмнөх мэдлэг, туршлага дээр үндэслэн шинэ мэдлэгээ идэвхтэйгээр өөрөө бүтээдэг гэж үздэг суралцахуйн конструктивизмын онолд тулгуурлана.

Хөтөлбөрийн зорилго нь суралцагчид хүрээлэн буй орчны юмс үзэгдлийг шинжлэн судлах суурь чадамж болон бүтээлчээр сэтгэх, шүүн тунгаах, суралцахуйд суралцах, харилцах, хамтрах ерөнхий чадамжийг хөгжүүлэхэд чиглэсэн. Иймд суралцагч танил орчныхоо туршлагад тулгуурлан асуулт асуух, ажиглах, таамаглах, үйл ажиллагаагаа төлөвлөх, туршилт хийх, туршилтын үр дүнгээс баримт нотолгоонд үндэслэн дүгнэлт гаргах зэрэг үйлийг түлхүү дэмждэг “шинжлэн судлах” арга зүйг голчлон хэрэгжүүлнэ.

Мөн бага ангийн суралцагчийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон тоглонгоо суралцах, тоглоомд суурилсан, газар орчинд суурилсан, даалгаварт суурилсан, асуудал шийдвэрлэх болон төсөлд суурилсан сургалтын арга зүйг нээлттэйгээр хэрэглэж болно.

Шинжлэн судлах арга зүй нь байгалийн юмс, үзэгдлийн талаар таамаглал дэвшүүлэх, эрэл хайгуул хийх боломжийг олгосноор суралцагчийн шинжлэн судлах суурь чадамжийг хөгжүүлнэ. Шинжлэн судлах арга зүйг дараах алхмуудаар хэрэгжүүлнэ.

Шинжлэн судлах арга зүйн алхмууд

Алхам	Жишиг үйл ажиллагаа
Асуулт асуух, асуудал, таамаглал дэвшүүлэх	<ul style="list-style-type: none"> - Суралцагчаар аливаа юмс, үзэгдлийг ажиглуулах - Юу болох талаар тунгаан бодуулах - Суралцагчийн гаргасан тайлбарыг цааш боловсруулж, хөгжүүлэхийн тулд мэдээлэл цуглуулах, ашиглахад чиглэсэн “Хэрхэн”, “Аль нь”, “Ямар” зэрэг асуултуудыг асуух - Таамаглал дэвшүүлэх
Туршилт, үйл ажиллагааг төлөвлөх	<ul style="list-style-type: none"> - Суралцагчийн өмнөх шатанд дэвшүүлсэн асуулт, таамаглалыг шалгахын тулд суралцагчтай хамтран туршилтын зорилгыг тодорхойлох - Ажиглалт, туршилтаар ямар мэдээлэл цуглуулахаа төлөвлөх - Ямар аргаар хийх талаар хамтдаа ярилцах, үйл ажиллагааг төлөвлүүлэх - Туршилт хийх орчин, хэрэглэгдэхүүн болон зарим нөлөөлөх зүйлсийг хянаж, тогтвортой байлгах

Турших, өгөгдөл цуглуулж, задлан шинжлэх	<ul style="list-style-type: none"> - Суралцагчаар туршилтын явцад үр дүнг бүртгэх, цуглуулах, тэмдэглүүлэх - Суралцагчийн ажиглалтад тулгуурлан тэмдэглэл хөтлүүлэх - Юу болсон бэ?, Юу анзаарсан бэ?, Ямар үр дүн гарсан бэ?, Аль мэдээлэл нь илүү чухал вэ? зэрэг асуултуудыг тавих - Цуглуулсан үр дүнг зураг, бичвэр, хүснэгт, диаграмм, графикаар илэрхийлж, үр дүнг боловсруулахад чиглүүлэх
Үр дүнг боловсруулах, нягтлах	<ul style="list-style-type: none"> - Суралцагчид туршилтын дараа “Би юу сурсан бэ?”, “Өөрийн асуултад тодорхой хариулт авч чадсан уу?”, “Хэрвээ үгүй бол яагаад?”, “Өөр тайлбар байж болох уу?”, “Үүнийг ойлгоход ямар мэдээлэл хэрэгтэй вэ?”, “Одоо ямар шинэ асуулт гарч ирж байна вэ?” зэрэг асуултыг тавих - Суралцагчаар учир шалтгааныг олж чадсан эсэхийг эргэцүүлэн бодуулах
Үр дүнг бусдад тайлбарлах	<ul style="list-style-type: none"> - Суралцагч хийсэн ажлаа бусдад ойлгомжтойгоор танилцуулах, бусдын санааг хүндэтгэх, тэгш хүндэтгэлтэй хамтран ажиллахад чиглүүлэх - Суралцагч юуг, ямар аргаар, хэрхэн хийснээ энгийн өгүүлбэр бүхий зураг, бичвэр, хүснэгт, диаграмм, график, аман хэлбэрээр тайлбарлаж илэрхийлэхэд чиглүүлэх

I-V ангийн суралцахуйн үр дүнгийн онцлогт тохируулан харьцуулах, тодорхойлох, турших, хамаарал тодорхойлох зэрэг шинжлэн судлах арга зүйг сонгон хэрэглэж болно.

Тоглонгоо суралцах арга зүй. Бага боловсролын эхлэл шатлал (I-II анги)-д суралцагчийн өөрийн санаачилга, нийгэм орчны харилцах харилцаанд тулгуурлан *тоглох явцдаа* байгалийн юмс, үзэгдлийг сонирхон судлах боломжийг олгоно. Энэ нь хүүхдийн биеийн хөдөлгөөн, нийгмийн харилцаа, төсөөлөн бодох чадвар, бүтээлч байдал, хамтын ажиллагаа, харилцааг хөгжүүлэхэд чиглэнэ. Суралцах үйл явц нь дүрд тоглох, бүтээлчээр тоглох, дүрслэн тоглох, хөдөлгөөнтэй тоглох, төсөөлөн тоглох, барьж байгуулан тоглох зэрэг тоглох хэлбэртэй явагдах бөгөөд суралцагчийн сониуч зан, танин мэдэхүйд чиглэсэн сонирхолтой орчныг бүрдүүлнэ.

Тоглоомд суурилсан арга зүй. Бага боловсролын төгсгөл шатлал (III-V анги)-д суралцагч уламжлалт болон цахим хэлбэрийн *тоглоомын арга хэрэгсэл, хэрэглэгдэхүүнийг* ашиглан зорилготой, дүрэмтэй, сорилт бүхий тоглоомуудыг шат дараалалтайгаар гүйцэтгэж, оноо цуглуулах болон шагнал хүртэх замаар байгалийн юмс, үзэгдлийг судална. Энэ нь суралцагчдын суралцах идэвх оролцоог нэмэгдүүлж, асуудал шийдвэрлэх, шүүн тунгаах, хамтран ажиллах, цахим орчинд ажиллах ур чадваруудыг хөгжүүлэхэд чиглэнэ. Суралцах үйл явц нь ангиллын тоглоом, хөзөр болон карт тоглоом, интерактив самбарын тоглоом, даалгаварт суурилсан уралдаант тоглоом, эвлүүлдэг тоглоом, асуулт хариултын тоглоом, цахим орчинд дасгал даалгавар гүйцэтгэх зэрэг төрөл бүрийн тоглоомын арга хэрэгсэл, хэрэглэгдэхүүнийг ашиглана.

Газар орчинд суурилсан арга зүй. Суралцагч анги танхимын хүрээнээс гарч бодит орчинд асуудал шийдвэрлэх судалгаа хийх, орон нутгийн соёл, байгаль нийгэм, түүхийг таньж мэдэх боломжийг олгох замаар хэрэгжинэ. Мөн эцэг эх асран

хамгаалагчийн дэмжлэгтэйгээр богино хугацаанд хэрэгжүүлэх төсөлд суурилсан арга зүйгээр сургалтыг зохион байгуулж болно.

3.2. Сургалтын орчин

Сургалтын орчин нь сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад нөлөөлөх гол хүчин зүйл болдог. Суралцагчийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн сургалтын арга хэлбэр, зэрэг таатай уур амьсгал бүхий эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх шаардлагатай. Үүнд:

Эерэг таатай уур амьсгал бүхий харилцаа:

- Суралцагчийн аливаа оролдлого, сониуч зан байдлыг “Маш сайн оролцлоо”, “Сонирхолтой асуулт асуулаа”, “Сайн ажиглалаа” зэрэг үгсээр урам зориг өгөх.
- Суралцагчийн туршилт амжилтгүй болсон тохиолдолд шалтгааныг олох, туршилтыг дахин хийхийг дэмжих.
- Суралцагчийн ахиц, гүйцэтгэл бүрийг ажиглаж амжилтыг чи өмнөхөөсөө илүү сайн хийж чадлаа, энэ сэдвийг маш сайн ойлгожээ, бие даан ажиллаж чадсан нь үнэхээр бахархмаар байна зэрэг үгсээр урамшуулах.
- Багаар хамтран туршилт хийх, асуудлыг шийдвэрлэх оролцоог дэмжих, хамтран суралцах орчныг бүрдүүлэх.
- Суралцагчийн хариулт нь буруу байсан ч хариултыг шууд үгүйсгэхээс зайлсхийх, тухайн хариултад хүрэх болсон учир шалтгааныг олох, зөв хариултад дөхөх оновчтой арга замыг эрэлхийлж, алдаа гаргах, туршиж үзэхэд айдасгүй, нээлттэй харилцдаг орчныг бүрдүүлэх.

Эрүүл, аюулгүй, хүртээмжтэй анги танхим:

- Суралцагчийн сонирхлыг өдөөх, бүтээлч үйл ажиллагааг чиглүүлэх байгалийн ухааны буланг анги танхимд байгуулж, идэвхтэй оролцоог дэмжих.
- Суралцагч бүрд хүрэлцэхүйц туршилтын багаж хэрэгсэл, гарын доорх материал зэрэг сургалтын хэрэглэгдэхүүнийг хангаж, тэгш боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийн ажиглалт, туршилт хийх, бие биетэйгээ харилцах, хамтран суралцах боломжтой чөлөөтэй орон зай бүхий зохион байгуулалттай анги танхимыг бүрдүүлэх.
- Интерактив, цахим хэрэглэгдэхүүн ашиглах боломжтой цахим орчныг бүрдүүлж, орчин үеийн техник хэрэгслийг сургалтад нэвтрүүлэх.
- Туршилт, ажиглалтад ашиглах бүх багаж хэрэгслийг зориулалтын тавиур, шүүгээнд байршуулж, суралцагчийн хүрэх боломжгүй, аюулгүй газарт хадгалах, халуун, хурц, хүнд зүйлсийг тусгай тэмдэглэгээтэй саванд хийж, зөвхөн багшийн хяналт дор ашиглах, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, нүдний хамгаалалтын шил, халаад, бээлий зэрэг хамгаалах хэрэгслээр бүрэн хангаж, зөв хэрэглэх, эрүүл мэнд, аюулгүй орчин бүрдүүлэх.

- Аюулгүй ажиллагааны дүрэм болон тэмдэг, тэмдэглээг анги танхимд байршуулах.

Ялгаатай хэрэгцээг харгалзсан орчин:

- Суралцагчийн хараа (аудио хичээл, багшийн яриа, ярилцлага) сонсгол (хөдөлгөөнт дүрс, зурагт үзүүлэн, схем зураг, инфографик) хөдөлгөөн болон хүртэхүй (бодит багаж хэрэгсэл ашиглан ажиглалт хийх, барих, эвлүүлэх, хөдөлгөөнтэй оролцох үйл ажиллагаа) зэрэг суралцах хэв маягийг харгалзан олон төрлийн хэрэглэгдэхүүн ашиглах.
- Хэл, соёлын ялгаатай суралцагчийн өдөр тутмын амьдралтай холбоотой, танил орчинд тулгуурласан жишээг хичээлд оруулах, орон нутгийн байгаль, ахуй, уламжлалтай холбоотой баримт мэдээлэл бүхий сургалтын орчин бүрдүүлэх.
- Хоцрогдолтой суралцагчийн хувьд хялбаршуулсан тайлбартай, алхамчилсан дасгал, даалгавар, энгийн туршилт ажлыг багтаасан санг бүрдүүлэх.

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

4.1. Үнэлгээний зорилго

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, төлөвшлийн давуу болон сул талыг илрүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг дэмжих, ахиц дэвшлийг урамшуулах, хүрсэн түвшнийг үнэлэхэд чиглэнэ.

Бага боловсролын эхлэл шатанд суралцагчийн үнэлгээ нь сурах үйл явц, мэдлэг чадварын ахиц, гүйцэтгэлийг илрүүлэх, суралцах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Бага боловсролын төгсгөл шатанд суралцагчийн эзэмшсэн байгалийн ухааны мэдлэг, шинжлэн судлах чадвар, байгальд ээлтэй, хариуцлагатай хандах давуу болон сул талыг илрүүлэх, амжилт, үр дүнг үнэлж, дүгнэхэд чиглэнэ.

4.2. Үнэлгээний шалгуур

Хүрэх үр дүн	Шалгуур
Байгалийн ухааны үндсэн ухагдахууны талаарх мэдлэг, ойлголттой болно.	<ul style="list-style-type: none"> - Байгалийн ухааны нэр томъёо, тодорхойлолт, ухагдахуун, үг хэллэгийг ялган таньдаг. - Байгалийн юмс үзэгдлийн шинж чанар, өөрчлөлт, тэдгээрийн харилцан хамаарал, байгалийн үзэгдэл зүй тогтлыг ойлгож тайлбарладаг. - Байгалийн ухааны тэмдэг, тэмдэглэгээ, хэмжигдэхүүн, нэгжийг хэрэглэдэг.
Байгалийн юмс, үзэгдлийг шинжлэн судлах арга барил эзэмшиж, өөрийн судалж, туршсанаа	<ul style="list-style-type: none"> - Тодорхой, чиглэлтэй, шинжлэхүйц асуулт гаргадаг. - Өмнөх мэдлэг баримтад суурилсан таамаглал дэвшүүлдэг. - Туршилтад хэрэглэх багаж хэрэгслийг сонгож, аюулгүй хэрэглэдэг

<p>эх хэлээрээ ойлгомжтой илэрхийлэх, тайлбарлах чадвартай болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Туршилт хэмжилтийг гүйцэтгэх төлөвлөгөөг хамтран боловсруулдаг. - Туршилтын хамаарах, үл хамаарах, тогтмол хувьсагчийг тодорхойлдог. - Асуулт, таамаглалыг нотлоход чиглэсэн мэдээлэл цуглуулах аргыг сонгодог. - Юмс, үзэгдлийг ажиглах, турших үйл ажиллагааг заавар аргачлалын дагуу аюулгүй гүйцэтгэдэг. - Ажиглалт болон туршилтын үр дүнг тэмдэглэж, баримт нотолгоо, мэдээллийг цуглуулдаг. - Цуглуулсан үр дүнгээ зураг, хүснэгт, бүдүүвч, диаграмм, график зэрэг тохирох аргаар боловсруулдаг. - Ажиглалт, туршилтын үр дүнг логик дараалалтай шинжилдэг, зөрүү алдааг илрүүлэн нягталдаг. - Туршилтын үр дүнг тодорхой, логик дараалалтай ойлгомжтой хэлбэрээр (зураг, бичвэр, хүснэгт, диаграмм, график, амаар) илэрхийлдэг. - Гаргасан дүгнэлтээ (ангилал, шалтгаан-үр дагавар, зүй тогтол, хамаарал) нотолгоонд тулгуурлан эх хэлээрээ үндэслэлтэй тайлбарладаг.
<p>Байгаль орчноо хайрлан хамгаалах сэтгэлгээ хөгжиж, байгальд ээлтэй, хариуцлагатай ханддаг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Байгалийн юмс, үзэгдлийг шинжлэн судлахдаа идэвхтэй оролцож, асуулт тавьж, өөрийн санаа бодлыг илэрхийлдэг. - Багийн ажилд бусадтай хамтран ажиллаж, санаа бодлоо хуваалцаж, өгсөн даалгаварт өөрийн хувь нэмэр оруулдаг. - Туршилт хийхдээ багшийн зааврыг мөрдөж, аюулгүй байдлыг хангаж, нягт нямбай гүйцэтгэдэг. - Амьд бие, юмсыг хайрлан хамгаалах үйлдэл хийж, байгаль орчныг бохирдуулахгүй байхыг хичээж, бусдад нөлөөлдөг.

НИЙГМИЙН УХААН

НЭГ. ЗОРИЛГО

1.1. Зорилго

Суралцагчийн танил орчныхоо нийгэм, түүхийн үйл явдлын талаарх баримт, эх сурвалжийг ялгах, тайлбарлах, дүн шинжилгээ хийх суурь чадамж, үндэсний болон дэлхийн нийтлэг үнэт зүйл, өв уламжлалаас бие дааж болон хамтран суралцах, харилцах, шүүн тунгаах ерөнхий чадамжийг хөгжүүлнэ.

1.2. Хүрэх үр дүн, шатлал

Энэхүү хөтөлбөрийг судалснаар суралцагчид дараах ерөнхий үр дүнд хүрсэн байна.

- Танил орчны нийгэм, түүхийн үйл явдал, үндэсний уламжлалын талаар цахим болон бусад эх сурвалжаас мэдээлэл цуглуулдаг, харьцуулдаг, нотолгоотой дүгнэлт гаргадаг болно.
- Нийгмийн орчинд (гэр бүл, сургууль, үйлчилгээний газар) баримталдаг дүрэм, уламжлалт зан заншлыг ойлгож мөрддөг болно.
- Бусдын эрх, ялгаатай байдал, санаа бодлыг хүндэтгэдэг, сэтгэл хөдлөлөө таньж, эх хэлээрээ зохистой илэрхийлдэг болно.
- Багийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, эх хэлээрээ мэдээлэл солилцох, хэлэлцэх замаар асуудлыг шийдвэрлэх, хамтын зорилгод хүрэхэд хувь нэмрээ оруулдаг болно.

№	Хүрэх үр дүн	Шатлал	
		I-II анги	III-V анги
1	Танил орчны нийгэм, түүхийн үйл явдал, үндэсний уламжлалын талаар цахим болон бусад эх сурвалжаас мэдээлэл цуглуулдаг, харьцуулдаг, нотолгоотой дүгнэлт гаргадаг болно.	<ul style="list-style-type: none"> - Өөрийн танил орчин (гэр бүл, сургууль, орон нутаг)-ны уламжлал, зан заншил, нийгмийн үйл явдалтай холбоотой мэдээллийг ялгадаг, “Хэн?, Хаана?, Юу?, “Яагаад?” зэрэг асуултад хариулагдах хэсгийг олдог, зураг дүрслэл ашиглан эх хэлээрээ тайлбарладаг болно. - Уламжлалт баяр ёслол, үндэсний дээл хувцсаар жишээлэн бэлгэдлийг тайлбарладаг, бэлгэдэх болон цээрлэх ёсыг мөрддөг болно. 	<ul style="list-style-type: none"> - Танил орчны нийгэм, түүхийн үйл явдал болон үндэсний уламжлал, зан заншилтай холбогдох мэдээллийг хоёроос доошгүй эх сурвалжаас цуглуулдаг, вений диаграмм, хүснэгт зэргийг ашиглан харьцуулдаг, эх сурвалжаас иш татан дүгнэдэг болно. - Түүхийн эх сурвалжаас авсан мэдээллийг шинжилж, өнгөрсөн болон одоо үеийн өөрчлөлт, үргэлжлэлийг харьцуулдаг, үр дүнгээ тайлбарладаг, өөрийн байр суурийг эх хэлээрээ үндэслэлтэй илэрхийлдэг болно. - Монголчуудын биет болон биет бус соёлын өвийг өвлөх, хамгаалах арга замыг дэвшүүлдэг, хэрэгжүүлдэг болно.

2	<p>Нийгмийн орчинд (гэр бүл, сургууль, үйлчилгээний газар) баримталдаг дүрэм, уламжлалт зан заншлыг ойлгож мөрддөг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Сайн ба муу үйлийг жишээгээр тайлбарладаг, сайн үйл хийж хэвшихийг эрмэлздэг болно. - Гэр бүл, сургуулийн орчинд мөрддөг энгийн дүрэм, цээрлэх зүйлсийг таньж нэрлэдэг, бусадтай харилцахдаа мөрддөг болно. 	<ul style="list-style-type: none"> - Өөрийн хийх ёстой ба хийх ёсгүй үйлдлийг ялгаж, үндэслэлтэй тайлбарладаг, бусадтай хэлэлцдэг болно. - Гэр бүл, анги хамт олны гишүүн болохыгоо хүүхдийн эрх, үүрэгтэй холбон тодорхойлдог, дүрэм, зан заншлыг мөрдөх хэрэгтэйг тайлбарладаг, нийгмийн орчинд мөрддөг болно.
3	<p>Бусдын эрх, ялгаатай байдал, санаа бодлыг хүндэтгэдэг, сэтгэл хөдлөлөө таньж, эх хэлээрээ зохистой илэрхийлдэг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Өөрөөсөө ялгаатай хүүхдийг ойлгодог, тусалдаг болно. - Өөрт аюултай болон аюулгүй зүйлсийг ялгаж, хэрэгтэй дэмжлэгээ хүсдэг болно. - Өөрт төрсөн таатай, таагүй мэдрэмжийг ялган таньдаг, зохистой илэрхийлэх аргыг тайлбарладаг болно. 	<ul style="list-style-type: none"> - Хүүхдийн эрх, түүний зөрчлийг ялган таньдаг, урьдчилан сэргийлэх талаар санал дэвшүүлдэг болно. - Өөрийнхөө аюулгүй байдлыг хамгаалах аргыг хэрэглэдэг болно. - Сэтгэл хөдлөл ба биеийн мэдрэмж нь холбоотой болохыг жишээгээр тайлбарладаг, таагүй сэтгэл хөдлөлөө удирдах аргыг хэрэглэдэг болно.
4	<p>Багийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, эх хэлээрээ мэдээлэл солилцох, хэлэлцэх замаар асуудлыг шийдвэрлэх, хамтын зорилгод хүрэхэд хувь нэмрээ оруулдаг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Хамтран ажиллахдаа санал хэлдэг, багийн ажилд хүлээсэн үүргийнхээ дагуу оролцдог болно. - Бусдыг сонсдог, багийн гишүүддээ талархал илэрхийлдэг болно. 	<ul style="list-style-type: none"> - Багийн даалгаврыг биелүүлэхийн тулд цуглуулах мэдээлэл, багийн гишүүдийн ажил үүргийн талаар өөрийн санаа бодлоо илэрхийлдэг болно. - Багийн гишүүд санал зөрсөн үед асуудлыг ярилцаж, хамтын шийдэл гаргадаг болно. - Багийн ажлын үр дүнгийн талаар санал бодлоо илэрхийлдэг, сайжруулах талаар санал дэвшүүлж, хэлэлцдэг болно.

ХОЁР. АГУУЛГА

2.1. Бага боловсролын эхлэл шатлал

Агуулгын ай 1. Бидний эрхэмлэх зүйл

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Би хэн бэ?	1.1а. Өөрийн гэр бүлийнхээ гишүүдийг нэрлэж, тэдний талаар товч танилцуулна.	2.1а. Гэр бүлийн гурван үеийн ургийн модыг бүтээж, үе бүрийн гишүүдээс сонгон танилцуулж тайлбарлана.
	1.1б. Эцэг эх, багш, ахмад настан, найз нөхөдтэйгөө харилцахдаа хүндэтгэлийн үг хэрэглэнэ.	2.1б. Эцэг эх, багш, ахмад настан, найз нөхөдтэйгөө харилцахдаа баримталдаг цээрлэх зүйлсийн талаар мэдээлэл цуглуулж тайлбарлана, харилцаандаа мөрдөнө.
	1.1в. Сайн (туслах) ба муу (худлаа хэлэх) үйлийг жишээгээр тайлбарлана, сайн үйл хийж хэвшихийг эрмэлзэнэ.	2.1в. Сайн үйлийн ач тус, муу үйлийн хор уршгийг зураг дүрслэл, хүснэгтээр харуулж, харьцуулан тайлбарлана, сайн үйлийг хэвшүүлнэ.
	1.1г. Эрдэм сурах болон ажил хөдөлмөр эрхлэхийн ач тусыг энгийн жишээгээр тайлбарлана.	2.1г. Бусдын хийж буй ажил хөдөлмөрийн ач тусыг таньж, тэдэнд талархаж, хүндэтгэлтэй хандана.
Бид хэрхэн аж төрдөг вэ?	1.1д. Цагаан сар, наадмын үеэр мөрддөг зарим ёс заншлыг биеэр үзүүлж танилцуулна.	2.1д. Цагаан сар, наадмын үеэр баримталдаг уламжлалт ёс заншлын талаар мэдээлэл цуглуулж, тайлбарлана, хэрхэн мөрддөгөө харуулна.
	1.1е. Монгол дээлтэй холбоотой зан үйлийг нэрлэж, биеэр хэрэглэж харуулна.	2.1е. Монгол дээл, малгай, бүс зэрэг хувцасны бэлгэдлийг тайлбарлана, хүндэтгэлтэй хандана.
	1.1ж. Монгол гэрт баримтлах дэг ёс, цээрийг нэрлэж, хэвшүүлнэ.	2.1ж. Монгол гэрт баримтлах дэг ёс, бэлгэдэл, цээрийн ёсноос тайлбарлана, хэвшүүлнэ.
	1.1з. Таван хошуу малыг нэрлэж, тэдгээрийн ашиг шим (сүү, мах, цагаан идээ)-ийг тайлбарлана.	2.1з. Таван хошуу малыг ангилж, цагаан идээ боловсруулах үйл явцыг дүрслэн тайлбарлана.
	1.1и. Байгаль хамгаалах уламжлалт ёс заншлыг усаар жишээ аван тайлбарлана, усыг хэмнэх дадалтай болно.	2.1и. Уул, усаа хамгаалах уламжлалт зан үйлээс жишээгээр тайлбарлаж, дагаж мөрдөнө.
Бусдыг хэрхэн ойлгож, хүндэтгэх вэ?	1.1к. Өөрт төрсөн таатай, таагүй мэдрэмжээ таньж, зөв илэрхийлж харуулна.	2.1к. Таатай таагүй мэдрэмжийг ялган таньж, таагүй мэдрэмжийг зохистой шийдэх дасгалуудыг хийж хэвшихийг эрмэлзэнэ.
	1.1л. Гэр болон сургуулийн орчин дахь аюултай болон аюулгүй зүйлсийг ялгаж, жишээгээр тайлбарлана.	2.1л. Гэр болон сургуулийн орчин дахь аюултай болон аюулгүй зүйлсийн учрыг тайлбарлаж, бусдаас тусламж хүсэх аргыг санал болгоно.
		2.1м. Хүмүүсийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, ойлгож буйгаа үйлдлээр харуулна.

2.2. Бага боловсролын төгсгөл шатлал

Агуулгын ай 1. Иргэний боловсрол

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Бидний эрхэмлэх зүйл	3.1а. Гэр бүлийнхээ дөрвөн үеийн ургийн модыг бүтээж, үе бүрийн гишүүдээс сонгон танилцуулж тайлбарлана.	4.1а. Гэр бүлийнхээ таван үеийн ургийн модыг бүтээж, үе бүрийн гишүүдээс сонгон танилцуулж тайлбарлана.	5.1а. Гэр бүлийнхээ дөрвөөс доошгүй үеийн ургийн бичгийн таних тэмдэг, хүснэгт ашиглан танилцуулж тайлбарлана.
	3.1б. Холбогдох эхээс (үлгэр, домог, зүйр үг, бусад эх) эв эеийг эрхэмлэх сургаалыг сонгон судалж, гол санааг хэлэлцэнэ, бусадтай эвсэг, найрсаг, тусархаг харилцаж сурна	4.1б. Монголчуудын зочноо угтах, үдэх, айлд зочлох ёсноос танин мэдэж, тайлбарлана, хэвшүүлнэ.	5.1б. Монголчуудын эрдэм номыг дээдлэх, багшийг хүндэтгэх уламжлалаас жишээгээр танилцуулна, өөрөө дагаж мөрдөхийг эрмэлзэнэ.
Бидний аж төрөх ёс, уламжлал	3.1в. Цагаан идээ боловсруулах үйл явцад хэрэглэдэг уламжлалт хэрэгслийг таньж, тайлбарлана.	4.1в. Уламжлалт хоол хүнс, идээ ундааны төрлийг ялгана, ач холбогдлыг тайлбарлана.	5.1в. Монголчуудын идээ ундааг цаг, улиралд тохируулан хэрэглэж ирсэн уламжлалаас хүний эрүүл мэндтэй холбон тайлбарлана.
	3.1г. Үндэсний дээлийн төрөл, онцлогийг таньж, хэрэглэхийг эрмэлзэнэ.	4.1г. Угсаатны хувцас, хэрэглэл нь ялгаатай болохыг таньж, тайлбарлана.	5.1г. Монгол хувцас, хэрэглэлийн бэлгэдлийн утгыг танилцуулна, хүндэтгэж буйгаа илэрхийлнэ.
	3.1д. Монгол гэр барих, буулгах, гэрт орох, гарах ёс, зан үйлийг таньж, баримталж хэвшихийг эрмэлзэнэ.	4.1д. Мал маллах арга ухаан, байгаль хамгаалах ёс, зан үйлийн уялдаа холбоог тайлбарлана.	5.1д. Байгалиа хамгаалах ёс заншлыг нүүдлийн болон суурин амьдралтай холбон тайлбарлана, өөрийн байр суурийг илэрхийлнэ.
Хариуцлагат ай Монгол хүүхэд	3.1е. Өөрийн болон бусдын таатай, таагүй мэдрэмж, сэтгэл хөдлөлийг таньж, бусдад санаа тавьж сурна.	4.1е. Өөрийн болон бусдын сэтгэл хөдлөлийн илрэлийг таньж, сөрөг сэтгэл хөдлөлийг	5.1е. Сэтгэл хөдлөл (баярлах, гуниглах) болон биеийн мэдрэмж (зүрх хурдан цохилох, хөлрөх,

		зохицуулах аргыг хэрэглэж хэвшинэ.	чичрэх зэрэг) нь хамааралтай болохыг жишээгээр тайлбарлана, сөрөг сэтгэл хөдлөлийг зохицуулах аргыг хэрэглэж хэвшинэ.
	3.1ж. Өөрийн хийх ёстой болон хийх ёсгүй үйлдлүүдийг ялган таньж, яагаад хийх ёстой болон хийх ёсгүй болохыг тайлбарлаж хэлэлцэнэ.	4.1ж. Өөрийгөө сургууль, гэр бүлийн гишүүн болохыг хүүхдийн эрх, үүрэгтэй холбон тодорхойлж, дүрэм журмыг шударгаар мөрдөхийн ач холбогдлыг тайлбарлана.	5.1ж. Сургууль, гэр бүлийн болон цахим орчинд хүүхдийн эрх зөрчигдөж болзошгүй нөхцөлийг илрүүлж, хүүхдийн эрхийн зөрчлөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар санал дэвшүүлж хэлэлцэнэ.
	3.1з. Хувийн эд зүйлс (мөнгө, гар утас, бичиг баримт г.м)-ийг таньж, эрсдэлээс сэргийлэх аргыг тайлбарлана.	4.1з. Мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой ойлголтыг ялган таньж, хувийн цахим мэдээллийг (нэр, хаяг, зураг, нууц үг зэрэг) хамгаалах тохиромжтой аргыг сонгон хэрэглэнэ.	5.1з. Өөрийн хэрэгцээнд тохирсон хуримтлалын төлөвлөгөө боловсруулж, мөнгөө зөв зарцуулах дадлыг өөртөө хэвшүүлнэ.

Агуулгын ай 2. Бидний түүх, соёл

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Өнгөрсөн ба одоо	3.2а. Тоглоом, гэр сууцын өөрчлөлтийг харуулсан бодит хэрэглэгдэхүүн, түүхэн гэрэл зураг зэрэг эх сурвалжийг ашиглан түүхийн өнгөрсөн, одоо үеийг харьцуулна.	4.2а. Түүхэн гэрэл зураг, аман яриа зэрэг эх сурвалжийн мэдээлэл ашиглан өнгөрсөн үеийн хүмүүсийн өдөр тутмын амьдралыг одоо үеийнхтэй харьцуулан тайлбарлана.	5.2а. Өнгөрсөн болон одоо үеийн хүмүүсийн хэрэглэж байсан холбоо, харилцааны хэрэгслийг судлан, тэдгээрийн хөгжлийн ялгаа болон уялдаа холбоог харьцуулан тайлбарлана.
		4.2б. Монгол Улсын болон орон нутгийн түүхэнд гавьяа байгуулсан түүхэн хүмүүсээс сонгон	5.2б. Хүннү гүрэн, Их Монгол улс, Богд хаант Монгол улсын түүхээс иш татаж (газар зүйн байршил,

		намтрыг нь судална, тэдний үйл хэргээр бахархаж буйгаа илэрхийлнэ.	түүхэн он цаг, түүхэн хүмүүс) тайлбарлана.
Монголчуудын соёл, бахархал	3.2б. Орон нутгийн түүхийн дурсгалт зүйлсээс (хадны зураг, хүн чулуу, буган чулуу, хөшөө дурсгал), нэрлэнэ, тэдгээрийг хамгаалах арга замыг тайлбарлана.	4.2в. Монгол Улсын төрийн бэлгэ тэмдэг (төрийн сүлд, туг, далбаа, тамга г.м)-ээс сонгож, түүний өнгө, дүрсийн бэлгэдлийг тайлбарлана, төрийн бэлгэ тэмдгээ хүндэтгэнэ.	5.2в. Музейн үзмэр, орон нутгийн түүхийн дурсгалт газраас сонгон, холбогдох түүхэн үйл явдал, он цагийн мэдээлэлтэй уялдуулан тайлбарлана, тэдгээрийн түүх, соёлын ач холбогдлыг тодорхойлно.
	3.2в. Ардын урлагийн түүхийг домгийн эх сурвалж (Уртын дуу үүсэн домог, Хөхөө Намжилын домог) ашиглан тайлбарлана.	4.2г. Монголын түүхэнд холбогдох бичиг соёлын дурсгал (Монголын нууц товчоо)-аас түүхэн ач холбогдлыг тайлбарлана, бахархана.	5.2г. ЮНЕСКО-д бүртгэлтэй Монголчуудын биет болон биет бус соёлын өвөөс сонгон тэдгээрийг үндэсний бахархал, өв уламжлалаа хадгалахын ач тустай уялдуулан тайлбарлана.

Агуулгын ай 3. Хүмүүсийн нийгэм, газар орон

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Миний нутаг	3.3а. Орон нутгийнхаа байршил, гол мөрөн, нуур, уул нуруудыг газар зүйн зурагт зааж нэрлэнэ, гадаргын онцлогтой холбон тайлбарлана.	4.3а. Орон нутгийнхаа байгалийн нөхцөл (цаг агаар, гадарга, ургамал, амьтан) болон байгалийн нөөц (ус, хөрс, ургамал, амьтан, ашигт малтмал г.м)-ийг газар зүйн зураг, зурагт мэдээлэл ашиглан нэрлэнэ, ач холбогдлыг тодорхойлно.	5.3а. Орон нутгийнхаа байгаль, нийгмийн орчныг судлах хэрэгцээ, ач холбогдлыг зураг, өгөгдөл, баримт мэдээлэлд тулгуурлан тайлбарлаж, өөрийн байр суурийг илэрхийлнэ.

	3.3б. Орон нутгийнхаа хүмүүсийн эрхэлдэг аж ахуй, ажил хөдөлмөрөөс нэрлэнэ, ижил ба ялгаатай шинжийг харьцуулна.	4.3б. Орон нутгийн байгалийн нөхцөл (цаг агаар, газар нутгийн байдал, нөөц баялаг) нь хүмүүсийн эрхлэх аж ахуй, үйлдвэрлэлтэй холбоотой болохыг тайлбарлана.	5.3б. Орон нутгийн хүмүүсийн эрхэлдэг аж ахуй, үйлдвэрлэл нь зам, тээврийн нөхцөл байдалтай хэрхэн уялдаж байгааг жишээгээр тайлбарлаж, дүгнэлт хийнэ.
	3.3в. Орон нутгийн соёл, үйлчилгээний байгууллага (номын сан, музей, эмнэлэг, эмийн сан, дэлгүүр)-ын үйл ажиллагааг танина, ижил ба ялгаатай шинжийг харьцуулна.	4.3в. Орон нутгийн соёл, үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаа нь хүмүүсийн өдөр тутмын амьдралд ач холбогдолтой болохыг тодорхойлно.	5.3в. Орон нутгийн засаг захиргааны байгууллагын үйл ажиллагааг нэрлэнэ, иргэдийн соёл, боловсролыг дэмждэг талаар өөрийн байр суурийг илэрхийлнэ.
Манай дэлхий	3.3г. Газар зүйн зургаас Монгол улстай хил залгаа улсуудыг ялгаж, танилцуулна.	4.3г. Дэлхийн хүмүүс арьс, хэл, соёлын хувьд ялгаатай болохыг зураг, жишээ, мэдээлэл ашиглан харьцуулж, бусдын хэл, соёлыг хүндэтгэнэ.	5.3г. Дэлхийн хүмүүсийн хоол, хувцас, орон сууц зэрэг нь ялгаатай байгаад байгаль орчин, газар зүйн байршил, уламжлал хэрхэн нөлөөлдгийг жишээгээр нотолно.
	3.3д. Орон нутаг тулгарч буй байгаль орчны асуудлаас(усны бохирдол, хог хаягдал, мод огтлолт зэрэг) сонгон, шийдэх арга замыг байгаль хамгаалах уламжлалт ёс заншилтай холбон тайлбарлана.	4.3д. Орон нутгийн байгаль орчинд тулгарч буй асуудлыг сонгон түүний шалтгааныг тодорхойлно, шийдвэрлэх арга замыг байгаль хамгаалах уламжлалт ёс заншилтай холбон тайлбарлана.	5.3д. Орон нутаг болон дэлхий нийтэд тулгарч буй байгаль орчны нийтлэг асуудлыг тодорхойлон, урьдчилан сэргийлэх болон шийдвэрлэх арга замыг санал болгоно.

ГУРАВ. АРГА ЗҮЙ, ОРЧИН

3.1. Арга зүй

Нийгмийн ухааны судлагдахууны хөтөлбөрөөр суралцагчийн чадвар, чадамжийг хөгжүүлэхийн тулд тэдний суралцахуйг Сонирхон судлах болон Туршлагад суурилсан арга зүйгээр чиглүүлэн удирдана. Учир нь ёс зүй, иргэний үнэт зүйл, харилцаа нь зөвхөн нийгэм, хүмүүсийн харилцааны хүрээнд бүрэлддэг, тэдний

хуримтлуулсан туршлага юм. Мөн эдгээр арга зүй нь зөвхөн мэдлэг бус, хандлага (хүндэтгэл, эрмэлзэл, шударга байдал), чадвар (харьцуулах, нэгтгэх, дүгнэх, шийдвэр гаргах)-ыг нэгэн зэрэг хөгжүүлдэг.

Сонирхон судлах болон Туршлагад суурилсан арга зүйн онолын үндэс нь Нийгмийн конструктивизм буюу Хамтын суралцахуйн онол болно. Эдгээр онолыг үндэслэгчид суралцагч мэдлэгийг зөвхөн хүлээн авдаг бус, бусадтай хамтран ярилцаж, судалж, туршлага хуваалцаж бүтээдэг. Тэд нийгмийн орчин, хамтын үйл ажиллагаа, соёлын орчинд суралцдаг гэж үздэг.

Сонирхон судлах арга зүй нь дараах алхмаар хэрэгжинэ.

Алхам	Жишиг үйл ажиллагаа
Асуулт гаргах (гаргуулах)	<ul style="list-style-type: none"> - Энэ зураг дээр хүмүүс юу хийж байна вэ? - Өвөөгөөсөө ямар асуулт асуувал түүний бага насыг мэдэж болох вэ? - Манай сум олон жилийн өмнө ямар байсан гэж бодож байна? - Баримт болон санаа бодлыг ялгахын тулд ямар асуулт асуух вэ? - Хоёр эх сурвалжаас цуглуулсан мэдээллийг хэрхэн харьцуулах вэ?
Мэдээлэл, баримт, өгөгдөл цуглуулах ба бүртгэх	<ul style="list-style-type: none"> - Гэр бүлийнхээ зургаас мэдээлэл хайх; - Ахмад хүмүүстэй (өвөө, эмээ) богино ярилцлага хийх; - Зураг + өгүүлбэрээс мэдээлэл цуглуулах; - Баримт ба санаа бодлыг ялгах; - Түүхэн зураг + эхээс гол мэдээллийг олох, ялгах;
Мэдээлэл, баримт, өгөгдлийг тайлбарлах, үнэлэх, дүгнэх	<ul style="list-style-type: none"> - Юу харагдаж байна вэ? зураг ажиглан тайлбарлах, жишээ нь, зураг дээрх хүмүүс баяртай байна уу, гунигтай байна уу? Яагаад? - Өвөөгийн бага нас өнөөдөртэй хэр адил/өөр болохыг тодорхойлох - Баримт ба санаа бодлыг Т-хүснэгт ашиглан үндэслэлтэй тайлбарлах, - Зурагт үйл явдлын дараалал тогтоох; - Газрын зураг дээрх мэдээллийг унших, тайлбарлах - Эх сурвалжаас авсан мэдээллийн гол агуулга, тухайн эх сурвалжийн ач холбогдол зэргийг тодорхойлох; - Нийгэм, түүхийн үйл явдлын шалтгаан, үр дагаврыг “Энэ үйл явдал яагаад болсон гэж бодож байна? Энэ үйл явдал ямар ач холбогдолтой вэ?” зэрэг асуултаар тодорхойлох; - Хоёр эх сурвалжийн найдвартай байдлыг харьцуулж, дүгнэх;
Олсон үр дүнгээ мэдээлэх, танилцуулах	<ul style="list-style-type: none"> - Богино постер бүтээх, бусдын өмнө танилцуулах; - Хүснэгт ба зураг, зураглал, бүдүүвч зэргийг ашиглан мэдээлэл боловсруулсан үр дүн танилцуулах; - 2–3 минутын танилцуулга бэлтгэх (ишлэлтэй);

	- Бусдын асуултад хариулах, саналыг сонсох;
--	---------------------------------------------

Суралцагчдын гаргасан болон багшийн тавьсан асуултад хариулахын тулд мэдээлэл, баримт, өгөгдөл зэргийг цахим болон бусад эх сурвалжаас цуглуулах бөгөөд багш эдгээрийг цуглуулах арга, хэрэгслийг урьдчилан бэлтгэсэн байхад анхаарна. Цахим эх сурвалжаас цуглуулах үед эцэг, эх, асран хамгаалагчдад мэдэгдэж, тэднийг хүүхдэдээ ямар чиглэлээр дэмжлэг үзүүлэхийг урьдчилан мэдэгдэх нь хүүхдийн цахим орчинд аюулгүй ажиллаж суралцахад тустайг анхаарна.

Туршлагад суурилсан арга зүй нь дараах алхмаар хэрэгжинэ.

Алхам	Жишиг үйл ажиллагаа
Хийж үзэх (Бодит туршлагаа солилцох)	- Өмнөх мэдлэг, туршлагадаа үндэслэн өөрийн биеэр ямар нэг зүйлийг хийж, оролдож үзэх, хийх, оролцох, жишээ нь, дээл мялаахыг дүрд тоглож үзүүлэх, бие биеийнхээ хийж байгааг үзэж ярилцах, дээлээ эвхэж харуулах, хэрхэн эвхэж байгааг ажиглах, ярилцах;
Эргэцүүлэн бодох, хэлэлцэх (Юу, юу болсон бэ?, Хэн, юу, яаж хийсэн бэ?)	- Хийсэн зүйлсээ эргэн санаад, юу ойлгосон, юу болсон талаар ярилцах; жишээ нь, дээл мялааж дүрд тоглохдоо дээлийн урд, хойд хормойг заасан уу? Дээлээ эвхэхдээ ямар дарааллаар, хэрхэн эвхсэн бэ? Эвхээд яаж, хаана тавьсан бэ? Дээлийн захыг хааш нь харуулж тавьсан бэ? зэрэг асуултыг бие биедээ тавьж ярилцах, хэлэлцэх;
Үр дүнг нэгтгэх, ойлгох (Юунаас, юу сурсан бэ?)	- Сурагч хийсэн зүйлээ бодож дүгнэж, утга агуулгыг ойлгох, жишээ нь дээлийн урд, хойд хормой, дотоод энгэр гэж үүнийг нэрлэдэг юм байна, дээлийг ийм дарааллаар эвхдэг юм байна, дээлийн захыг үүд рүү харуулж тавьдаггүй уламжлалтай зэрэг. - Сурагчид юу мэдэж, ойлгосноо бие биедээ танилцуулах, тайлбарлах;
Хэрэгжүүлэх, сайжруулах (Мэдсэн, ойлгосон зүйлээ хаана, хэрхэн ашиглах вэ?)	- Сурсан зүйлээ амьдралд хэрэглэж, шинэ нөхцөлд туршиж үзэх, хэрхэн хийсэн, юу болсон талаар эргэн ярилцах;

I-II ангид гэртээ баримталдаг ёс заншил зарим бэлгэдэх болон цээрлэх ёс зэргийг суралцагч өөрийн биеэр хийж үзэх, үзүүлэх, өмнө хэрхэн баримталдаг байсан талаар ярилцах зэргээр тодорхой үйлийг хийх замаар туршлагад суурилсан арга зүйг хэрэглэнэ. Харин III–V ангийн суралцагч өөрөө туршлагаа ярьж, мэдээлэлд тулгуурлан тайлбарлах, харьцуулах, дүгнэх, бүтээх зэрэг сэтгэхүйн үйлдэл хийх чадвар хөгждөгийг харгалзан энэхүү арга зүйг хэрэглэнэ.

3.2. Сургалтын орчин

Судлагдахууны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг үр дүнтэй, сонирхолтой зохион байгуулах зорилгоор наад зах нь дараах шаардлагыг хангасан орчин бүрдүүлнэ. Үүнд:

Эерэг, урам зоригтой уур амьсгал бүрдүүлнэ.

- Багш, суралцагчид бие биедээ урам зориг өгдөг; тууштай, тэвчээртэй байдлыг дэмждэг;
- Хамтдаа ярилцдаг, тоглонгоо суралцдаг, санаа бодлоо илэрхийлдэг;
- Өөрийн болон бусдын гаргасан амжилтыг урамшуулдаг байх;
- Хамтран ажиллаж үр дүнг хуваалцдаг байх;
- Алдааг айх зүйл биш, суралцах боломж гэж үздэг байх;

Бие даан болон хамтран ажиллах боломжтой анги танхимтай байна.

- Ширээ, сандлын байрлалыг суралцагч бие даан ажиллах болон бүлгийн ажил, тоглоом, хэлэлцүүлэгт тохируулан байрлуулах;
- Суралцагчид хоорондоо чөлөөтэй харилцаж, хамтран ажиллах орон зайтай байх;
- Зураг, цахим хэрэгсэл ашиглах боломжтой байх;

Ялгаатай хэрэгцээнд тохирсон дэмжлэг авах боломж бүрдүүлнэ.

- Суралцагчдын суралцах хэв маягийг (хараа, сонсгол, хөдөлгөөний) харгалзсан зураг, бүдүүвч, өнгө ялгалттай материал, аудио хичээл, ярилцлага, практик туршилт, хөдөлгөөнтэй тоглоом ашиглах боломжтой байх;
- Хэл, соёлын ялгаатай сурагчдад зориулсан сэдэв, агуулгатай холбогдох толь бичигтэй байх;
- Суралцахуйн хоцрогдолтой болон илүү хурдтай суралцагчдад зориулсан ялгаатай даалгаврын сантай байх;

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

4.1. Үнэлгээний зорилго

Суралцагч мэдлэг, чадвар, төлөвшлийг эзэмшсэнээр түүнд бий болсон давуу болон сул талыг илрүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг дэмжих, ахиц дэвшлийг урамшуулах, хүрсэн түвшнийг үнэлэхэд чиглэнэ.

Бага боловсролын эхлэл шатанд суралцагчийн үнэлгээ нь тэдний гүйцэтгэлийн түвшин, чадварын ахицыг илрүүлэх, суралцах үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Бага боловсролын төгсгөл шатанд суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварын давуу болон сул талыг илрүүлэх, суралцахуйн үр дүнг үнэлж, дүгнэхэд чиглэнэ.

4.2. Үнэлгээний шалгуур

	Хүрэх үр дүн	Шалгуур
1.	Танил орчны нийгэм, түүхийн үйл явдал, үндэсний уламжлалын талаар цахим болон бусад эх сурвалжаас мэдээлэл цуглуулдаг, харьцуулдаг, нотолгоотой дүгнэлт гаргадаг болно.	<ul style="list-style-type: none"> - Танил орчны нийгэм, түүхийн үйл явдал болон үндэсний уламжлалтай холбогдолтой хоёроос дээш эх сурвалжийг (зураг, эх, аман түүх) ялгадаг, ижил ба ялгаатай талыг харьцуулдаг, нэгтгэн дүгнэдэг. - Өөрийн дүгнэлт, байр суурийг (жишээ нь: байгаль хамгаалах, ижил болон ялгаатай талыг нэгтгэх, хоёр зүйлийн уялдаа холбоог тодорхойлох г.м) эх сурвалжийн баримт, нотолгоотойгоор илэрхийлдэг.
2.	Нийгмийн орчинд (гэр бүл, сургууль, үйлчилгээний газар) баримталдаг дүрэм, уламжлалт зан заншлыг ойлгож мөрддөг болно.	<ul style="list-style-type: none"> - Тодорхой уламжлал, зан заншил болон (жишээ нь, гэрт баримтлах дэг, цээрлэх ёс, байгальтай харилцах, хамгаалах зан заншил г.м) бэлгэдэл (үндэсний хувцас хэрэглэл, төрийн бэлгэ тэмдэг зэргээр жишээлэн)-ийн утга учрыг тайлбарладаг. - Нийгмийн орчинд (гэр бүл, сургууль, үйлчилгээний газар) дүрэм, зан заншлыг мөрдөж буйгаа харуулдаг.
3.	Бусдын эрх, ялгаатай байдал, санаа бодлыг хүндэтгэдэг, сэтгэл хөдлөлөө таньж, эх хэлээрээ зохистой илэрхийлдэг болно.	<ul style="list-style-type: none"> - Хүүхдийн эрх, үүргийн талаарх мэдлэгээ нийгмийн орчин (гэр бүл, сургууль)-д тулгарсан энгийн нөхцөл байдалтай холбож тайлбарладаг. - Сургууль, гэр бүлийн орчинд хүүхдийн эрх зөрчигдөж болзошгүй нөхцөлийг илрүүлж, түүнээс хамгаалах тодорхой арга замыг санал болгодог, өөрийн эрх, аюулгүй байдлаа хамгаалах арга замыг нэрлэдэг, хэрэглэдэг. - Өөртөө төрсөн болон бусдад илэрч буй сэтгэл хөдлөлийг таньж нэрлэдэг, таагүй мэдрэмж, сэтгэл хөдлөлөө зохицуулах аргыг (дасгал, хөдөлгөөн г.м) амжилттай хэрэглэж буйгаа харуулдаг.
4	Багийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, эх хэлээрээ мэдээлэл солилцох, хэлэлцэх замаар асуудлыг шийдвэрлэх, хамтын зорилгод хүрэхэд хувь нэмрээ оруулдаг болно.	<ul style="list-style-type: none"> - Багийн ажилд өөрийн санал бодлыг илэрхийлдэг, үүргээ бүрэн гүйцэтгэж оролцдог. - Багийн ажил, хэлэлцүүлгийн явцад бусдын ялгаатай байдал болон санаа бодлыг хүндэтгэдэг, үл ойлголцлыг эелдгээр шийдвэрлэж буйгаа үйлдлээр харуулдаг. - Хамтын ажлын үр дүнг үнэлж, дүгнэдэг, юу амжилттай болсон, юуг сайжруулах талаар санал дэвшүүлдэг.

КОМПЬЮТЕРЫН УХААН

НЭГ. ЗОРИЛГО

1.1. Зорилго

Суралцагчийн компьютер, ухаалаг хэрэгслийг зөв, аюулгүй ашиглах, энгийн код бичих, хиймэл оюуны хэрэгслийг зөв хэрэглэх, цахим орчинд өөрийгөө хамгаалах суурь чадамж болон бүтээлчээр сэтгэх, харилцах, хамтран ажиллах, шүүн тунгаах ерөнхий чадварыг хөгжүүлнэ.

1.2. Хүрэх үр дүн, шатлал

Энэхүү хөтөлбөрийг судалснаар суралцагчид дараах ерөнхий үр дүнд хүрсэн байна.

- Гэр болон сургуулийн орчин дахь ухаалаг хэрэгслүүд, компьютерын бүтэц, үүрэг зориулалтыг мэддэг, аюулгүй хэрэглэдэг болно.
- Цахим орчинд хувийн мэдээллээ хамгаалан, эх хэлээрээ зүй зохистой, аюулгүй харилцаж, дэлгэцийн цагаа ухаалгаар удирддаг болно.
- Хэрэглээний программ, аппликейшныг хэрэгцээндээ тохируулан сонгон ашигладаг, сурах үйлдээ бүтээлчээр хэрэглэдэг болно.
- Алгоритмыг алхам алхмаар төлөвлөж, дүрсэлдэг, энгийн код бичдэг, засаж сайжруулдаг болно.
- Өгөгдөл болон хиймэл оюуны үндсэн ойлголттой болж, хиймэл оюуны хэрэгслүүдийг сонгон ашиглахдаа гарсан үр дүнг хянаж, сайжруулдаг болно.

№	Хүрэх үр дүн	Шатлал
		Төгсгөл шат (III-V анги)
1.	Гэр болон сургуулийн орчин дахь ухаалаг хэрэгслүүд, компьютерын бүтэц, үүрэг зориулалтыг мэддэг, аюулгүй хэрэглэдэг болно.	- Ухаалаг хэрэгсэл, компьютерын бүрэлдэхүүн хэсгүүдийн бүтэц, ажиллагааны зарчмыг мэддэг, аюулгүй ашигладаг болно.
2.	Цахим орчинд хувийн мэдээллээ хамгаалан, эх хэлээрээ зүй зохистой, аюулгүй харилцаж, дэлгэцийн цагаа ухаалгаар удирддаг болно.	- Цахим орчинд хувийн болон нууц мэдээллээ хамгаалдаг болно. - Интернэтээс мэдээлэл хайж, хэрэгцээт мэдээллийг ялган таньдаг болно. - Цахим орчинд гарч болох аюул, эрсдэлийг таньж, өөрийгөө болон бусдыг хамгаалдаг болно. - Мэдээлэлд хүндэтгэлтэй ханддаг, цахим орчинд эх хэлээрээ зүй зохистой харилцдаг болно.
3.	Хэрэглээний программ, аппликейшныг хэрэгцээндээ зориулан сонгон ашиглах, сурах үйлдээ бүтээлчээр хэрэглэдэг болно.	- Энгийн бичвэр, хүснэгт, үзүүлэн бэлтгэхэд зориулсан программыг зорилгодоо тохируулан сонгож ашигладаг болно. - Бие даан эсвэл хамтран, сонирхсон сэдвээрээ дижитал медиа хэрэгслүүдийг ашиглан энгийн бүтээл боловсруулдаг болно.
4.	Алгоритмыг алхам алхмаар төлөвлөн, дүрсэлдэг, энгийн	- Алгоритмын шугаман, нөхцөлт болон давталтын төрлүүдийг ялган тодорхойлж, блок кодоор дүрсэлдэг

	код бичдэг, засаж сайжруулдаг болно.	болно. - Өгсөн бодлогыг шийдвэрлэх алхмыг төлөвлөж, кодчилдог болно. - Роботын хөдөлгөөнийг алхамчилж төлөвлөн, блок кодоор дүрслэн ажиллуулдаг болно. - Кодчилох явцдаа алдааг шалгаж, засварладаг болно.
5.	Өгөгдөл болон хиймэл оюуны үндсэн ойлголттой болж, хиймэл оюуны хэрэгслүүдийг сонгон ашиглахдаа гарсан үр дүнг хянаж, сайжруулдаг болно.	- Өгөгдөл болон хиймэл оюун гэж юу болохыг тайлбарладаг болно. - Хиймэл оюун нь өгөгдлөөс хэрхэн сурдаг, ажилладаг, яагаад зөв хэрэглэх хэрэгтэйг тайлбарладаг болно. - Хиймэл оюуны хэрэгслүүдийг сонгон, сурах үйлдээ хариуцлагатай, зөв ашигладаг болно. - Хиймэл оюуны гаргасан үр дүнг нягталж, сайжруулдаг болно. - Шинэ технологийг сонирхон судалж, бүтээлчээр хэрэглэдэг болно.

ХОЁР. АГУУЛГА

2.2. Бага боловсролын төгсгөл шатлал

Агуулгын ай: Компьютерын цагаан толгой

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Дижитал иргэншил	3.1а. Ухаалаг хэрэгсэл, компьютерын үндсэн эд ангиудыг ялган таньж, үүрэг зориулалтыг нь тайлбарладаг болно.	4.1а. Компьютерын оролт, гаралт болон хадгалах, боловсруулах төхөөрөмжүүдийг ялгаж, ажиллагааны зарчмыг тайлбарладаг болно.	5.1а.Компьютер мэдээллийг хэрхэн дүрсэлж, хэмждэг болохыг тайлбарладаг болно.
	3.1б. Ухаалаг хэрэгсэл, компьютерыг удирдаж ажиллуулдаг болно.	4.1б. Файл удирдах системийг ашигладаг болно.	5.1б.Файл, мэдээллийн хэмжээг тооцож, хадгалах төхөөрөмжийг сонгож хэрэглэдэг болно.
	3.1в. Ухаалаг хэрэгсэл, компьютерын эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны дүрмийг хэрэгжүүлдэг болно.	4.1в. Өөрийн цахим хэрэглээ, дэлгэцийн цагаа төлөвлөж, хянадаг болно.	5.1в. Бусдын цахим төхөөрөмжийн хэрэглээг үнэлж, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны дүрмийг зөвлөдөг болно.
Цахим орчин ба аюулгүй байдал	3.1г. Интернет нь хүмүүс болон төхөөрөмжүүдийг хэрхэн холбодог, мэдээлэл дамжуулдгийг энгийн жишээгээр ойлгодог болно.	4.1г. Интернетийг суралцах үйлдээ ашиглахад ямар боломж, хязгаарлалт байдгийг ялган, тайлбарладаг болно.	5.1г. Интернет сүлжээний ашиг тус болон учирч болох эрсдэлийг жишээгээр тайлбарладаг болно.

	3.1д. Интернэтээс түлхүүр үг, зургаар мэдээлэл хайж, хэрэгцээндээ тохирсон мэдээллийг сонгон ашигладаг болно.	4.1д. Зөвшөөрөгдсөн, найдвартай веб сайтаас хэрэгцээтэй мэдээллийг хайж, олж ашигладаг болно.	5.1д. Цахим орчинд мэдээллийг бусадтай зохистой, аюулгүй, хариуцлагатайгаар хуваалцдаг болно.
	3.1е. Цахим орчинд хувийн болон нууц мэдээллээ хамгаалахын ач холбогдлыг жишээгээр тайлбарладаг болно.	4.1е. Цахим орчин дахь зөв ба буруу үйлдлүүдийг ялган таньж, цахим орчинд үлдээсэн ул мөрийн үр дагаврыг тайлбарладаг болно.	5.1е. Цахим орчны халдлагын төрлүүдийг таньж, тэдгээрээс урьдчилан сэргийлэх аргуудыг тайлбарлан, хэрэгжүүлдэг болно.
Дижитал медиа	3.1ж. Дижитал медиа программаар бичвэр, зураг, дүрс, хүснэгт бүхий бүтээл боловсруулах аргыг тайлбарладаг болно.	4.1ж. Дижитал медиа программаар аудио, видео, хөдөлгөөн бүхий бүтээл боловсруулах аргыг тайлбарладаг болно.	5.1ж. Дижитал медиа бүтээлийг төлөвлөн, тохиромжтой технологи сонгох арга замыг тайлбарладаг болно.
	3.1з. Хэрэгцээндээ нийцүүлэн дижитал медиа программаар зураг, бичвэр, хүснэгт бүхий бүтээлийг төлөвлөн боловсруулдаг болно.	4.1з. Хэрэгцээндээ нийцүүлэн дижитал медиа программаар аудио, видео, хөдөлгөөн бүхий бүтээл төлөвлөн боловсруулдаг болно.	5.1з. Дижитал медиа бүтээлийг зохиомжлон боловсруулдаг болно.

Агуулгын ай: Тооцоолох сэтгэлгээ

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Алгоритм кодчиллол	3.2а. Өдөр тутмын энгийн үйлдлийн алгоритмыг төлөвлөж, бичвэр болон блок дүрсээр дүрсэлдэг болно.	4.2а. Өгсөн алгоритм дахь давталт болон нөхцөл шалгах үйлдлийг таньж, жишээгээр тайлбарладаг болно.	5.2а. Өгсөн алгоритм дахь нөхцөл, давталт болон энгийн хувьсагчийг таньж, жишээгээр тайлбарладаг болно.
	3.2б. Өгсөн алгоритмын алхмуудыг шинжлэн алдааг илрүүлж, зөв дараалалд оруулж, сайжруулдаг болно.	4.2б. Өгсөн даалгаврыг гүйцэтгэх давталт болон нөхцөл ашигласан алгоритмыг төлөвлөж, блок кодчиллын орчинд кодчилдог болно.	5.2б. Өгсөн бодлого даалгаврыг шийдвэрлэх нөхцөл, давталт, хувьсагч ашигласан алгоритмыг блок кодчиллоор дүрслэн, туршиж сайжруулдаг болно.
Робот кодчиллол	3.2в. Роботын үндсийг ойлгож, төрөл, үүрэг зориулалтыг жишээгээр тайлбарладаг болно.	4.2в. Роботын төрлүүдийг харьцуулж, ажиллах зарчмыг тайлбарладаг болно.	5.2в. Роботын үйлдлийг кодчилж, удирдах аргыг тайлбарладаг болно.

	3.2г. Роботыг удирдах энгийн код бичдэг, ажиллуулдаг болно.	4.2г. Давталт ба нөхцөлт үйлдлийг хослуулсан робот удирдах алгоритм зохиож, туршиж, алдааг илрүүлэн засдаг болно.	5.2г. Роботын оролтын суурилан үйлдлийг өгөгдөлд төлөвлөж, программчлан удирдаж, алдааг илрүүлэн сайжруулдаг болно.
--	-------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------

Агуулгын ай: Өгөгдөл ба хиймэл оюун

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Өгөгдөл ба хиймэл оюуны үндэс	3.3а. Өгөгдлийг бүлэглэж, хүснэгт, багана хэлбэрээр дүрсэлдэг болно.	4.3а. Өгөгдлийг шинж чанарын дагуу ангилж, өөрийн зорилгод тохируулан тооцоолол хийдэг болно.	5.3а. Өгөгдлийг зорилгодоо нийцүүлэн ангилж, асуудал шийдвэрлэхэд ашигладаг болно.
	3.3б. Хиймэл оюун болон түүний төрлүүдийг энгийн жишээгээр тайлбарладаг болно.	4.3б. Хиймэл оюуны хэрэгслийн хэрэглээ, ач холбогдлыг харьцуулан тайлбарлаж, түүнийг ашиглахад гарч болох эрсдэлийг тодорхойлдог болно.	5.3б. Хиймэл оюуны хэрэгслүүдийн гаргасан үр дүнг сайжруулдаг, сурах үйлдээ ашигладаг болно.
	3.3в. Хиймэл оюун нь өгөгдөлд тулгуурлан хэрхэн суралцдагийг энгийн жишээгээр тайлбарладаг болно.	4.3в. Хиймэл оюун нь өгөгдлийг хэрхэн ялгаж, ангилж, боловсруулдаг болохыг жишээгээр тайлбарладаг болно.	5.3в. Хиймэл оюун хэрхэн өгөгдөлд суурилан ажиллаж, шийдвэр гаргадгийг тайлбарладаг болно.

ГУРАВ. АРГА ЗҮЙ, ОРЧИН

3.1. Арга зүй

Компьютерын ухааны хөтөлбөр нь суралцагчдын технологийг ёс зүйтэй ашиглах, логиктой сэтгэх, бүтээлчээр асуудал шийдвэрлэх, кодчилох, дижитал бүтээл бүтээх зэрэг чадваруудыг хөгжүүлэхэд чиглэж, тэдний аливаа зүйлийг сониучирхан судалж, туршиж, технологийн мэдлэг, ур чадвараа өөрийн туршлагаар бүтээж хөгжүүлэх суралцахуйн конструктивизмын онолд суурилна.

Компьютерын ухааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ тоглоом болон төсөлд суурилсан, асуудал шийдвэрлэх зэрэг суралцагч төвтэй, идэвхтэй аргад суурилан асуудлыг шат дараатайгаар шийдвэрлэх, харилцах, хамтран ажиллах, тооцоолон бодох сэтгэлгээний чадварыг хөгжүүлнэ.

Эдгээр идэвхтэй сургалтын аргуудын үе шат бүрд суралцагчид алдаа, туршлагаасаа суралцаж, өгөгдөлтэй ажиллах, код бичих, робот удирдах, энгийн программчлалын даалгавар гүйцэтгэх замаар компьютерын ухааны суурь ойлголттой болж, тооцоолох сэтгэлгээ, бүтээлчээр асуудал шийдвэрлэх болон цахим орчинд ёс зүйтэй оролцох мэдлэг чадвараа хөгжүүлнэ.

Тухайлбал асуудал шийдвэрлэх арга зүй нь суралцагчдад

- Бодож, төлөвлөж, бие даан сурах;
- Логиктой сэтгэх, шалтгаан хамаарлыг ойлгох;
- Хамтран ажиллах, харилцах;
- Сонирхон судлах, идэвхтэй оролцох;
- Бодит, хэрэгцээтэй мэдлэг эзэмших боломж олгодог.

Алхам	Жишиг үйл ажиллагаа
Асуудлыг ойлгох, тодорхойлох	<ul style="list-style-type: none"> - Асуудалтай танилцах - Асуудлын талаар мэдээлэл, мэдлэгтэй болох - Шийдвэрлэх асуудлыг тодорхойлох
Асуудал шийдвэрлэх арга замыг төлөвлөх	- Дэвшүүлсэн асуудлыг шийдвэрлэх зорилго, зорилтыг тодорхойлж төлөвлөгөө гаргах
Асуудал шийдвэрлэх арга замыг хэрэгжүүлэх(турших)	<ul style="list-style-type: none"> - Асуудал шийдвэрлэхэд шаардлагатай мэдээлэл цуглуулах, боловсруулах, асуудал шийдвэрлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх - Шийдвэрлэсэн үр дүнгийн мэдээллийг шинжлэх, сайжруулах
Үр дүнг танилцуулах, үнэлэх	- Асуудлыг шийдвэрлэсэн үр дүнг танилцуулах, үнэлэх дүгнэх

3.2. Орчин

Сургалтын орчин нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад нөлөөлөх гол хүчин зүйл юм. Сурагчийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн сургалтын арга хэлбэрт тохирсон, эерэг таатай уур амьсгал бүхий эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэхийг чухалчилна. Компьютерын ухааны сургалтын орчин нь суралцагч төвтэй үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн, суралцах таатай уур амьсгал бүрдүүлсэн, эрүүл, аюулгүй байдлыг хангасан, зайлшгүй шаардлагатай хэрэглэгдэхүүн, материалаар хангагдсан байна. Иймээс сургалтын орчныг суралцагчийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, сонирхолд нийцсэн байхаас гадна, сургалтыг олон арга хэлбэрээр зохион байгуулахад тохиромжтой, эерэг таатай уур амьсгал бүхий эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлсэн байна. Үүнд:

1. Эерэг таатай уур амьсгал бүхий харилцаа:

- Урам зориг өгдөг, тууштай, тэвчээртэй байдлыг дэмждэг;
- Сонирхолтой, хөгжилтэй; тоглодог;
- Амжилтыг нь урамшуулдаг;
- Хамтын ажиллагааг дэмждэг;
- Айдасгүй, нээлттэй;

2. Эрүүл, аюулгүй, хүртээмжтэй анги танхим:

- Бүтээлчээр ажиллах, оролцоог дэмжих боломжтой;
- Сурагч бүрд хүрэлцэхүйц хэмжээтэй сургалтын хэрэглэгдэхүүнтэй;
- Сурагчид хөдөлгөөнтэй, бие биетэйгээ харилцах боломжтой, уян хатан зохион байгуулалттай (ширээний зохион байгуулалт, гэрэлтүүлэг хэлбэр);
- Сургалтын техник хэрэгсэл ашиглах боломжтой;

3. Ялгаатай байдлыг дэмжсэн, ялгаатай хэрэгцээг хангасан орчин:

- Сурагчдын суралцах хэв маягийг (хараа, сонсгол, хөдөлгөөний) харгалзсан зураг, бүдүүвч, өнгө ялгалттай материал, аудио хичээл, ярилцлага, практик туршилт, хөдөлгөөнт тоглоом ашиглах боломжтой;
- Хэл, соёлын ялгаатай сурагчдад зориулсан сургалтын болон бусад толь бичигтэй;
- Суралцахуйн хоцрогдолтой болон илүү хурдтай сурагчдад зориулсан ялгаатай даалгаврын сантай байх;

Мөн компьютерын ухааны сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай.

Цахим орчин

Компьютерын ухааны сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай цахим төхөөрөмж, хэрэгсэл бүхий анги танхимд зохион байгуулна. Цахим танхим нь бага ангийн сурагчид ашиглахад тохирсон стандарт ширээ, сандал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байна.

Техник хангамж

Цахим танхим нь өндөр хурдны интернэтэд холбогдсон, хүртээмжтэй тооны зөөврийн цахим төхөөрөмж (таблет, компьютер), ухаалаг самбар (проектор, дэлгэц)-тай байна.

Хэрэглэгдэхүүн:

Компьютерын ухааны сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд суралцахуйн зорилго, үр дүнд нийцсэн, сурагчийн нас сэтгэхүйн онцлогт нийцсэн, бүтээлч сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх, хамтын ажиллагаа, технологийн хэрэглээний чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн олон төрлийн хэрэглэгдэхүүн шаардагдана. Үүнд:

- Бодит болон виртуал блок кодчиллын орчин (нээлттэй эхийн блок кодчиллын программ, мини робот, кодчиллын онлайн симулятор гэх мэт)
- Аудио, видео бичлэг (танилцуулга, даалгаврын зааварчилгаа, технологийн танин мэдэхүйн контент гэх мэт)
- Цахим платформ, интерактив программ (Code.org, Blockly, Scratch, Tinkercad гэх мэт)
- Үзүүлэн, зурагт самбар (алгоритмын дараалал, блок кодчиллын жишээ, дижитал медиа үзүүлэн, мэдээллийн урсгалын схем гэх мэт)
- Тэмдэг тэмдэглэгээ, дүрслэл (компьютерын бүрэлдэхүүн, өгөгдлийн дүрслэл, сүлжээний схем гэх мэт)

- Энгийн хэрэглээний дижитал төхөөрөмжүүд (таблет, суурин компьютер, ухаалаг самбар, хулгана, гар гэх мэт)
- Тоглоомын хэрэгсэл, дүрд тоглох элементүүд (“код тайлагч” дүр, “робот жолооч” тоглоомын элемент гэх мэт)

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

4.1. Үнэлгээний зорилго

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, төлөвшлийн давуу болон сул талыг илрүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг дэмжих, ахиц дэвшлийг урамшуулах, хүрсэн түвшнийг үнэлэхэд чиглэнэ.

4.2. Үнэлгээний зорилт

Хүрэх үр дүн	Шалгуур
Гэр болон сургуулийн орчин дахь ухаалаг хэрэгслүүдийн бүтэц, үүрэг зориулалтыг мэддэг, аюулгүй ашигладаг болно.	<ul style="list-style-type: none"> - Компьютер, таблет, гар утас зэрэг ухаалаг төхөөрөмжүүд ямар үүрэг, зориулалттайг мэддэг. - Гэр ба сургуулийн орчинд ухаалаг төхөөрөмжийг зөв, аюулгүй ашигладаг.
Цахим орчинд хувийн мэдээллээ хамгаалан, эх хэлээрээ зүй зохистой, аюулгүй харилцаж, дэлгэцийн цагаа ухаалгаар удирддаг болно.	<ul style="list-style-type: none"> - Нууц үг үүсгэж, хувийн мэдээллээ хамгаалдаг. - Интернэтээс зөвшөөрөгдсөн эх сурвалжаас эх хэлээрээ мэдээлэл хайж, ашигладаг. - Цахим орчинд соёлтой, хариуцлагатай оролцдог.
Хэрэглээний программ, аппликейшныг хэрэгцээндээ зориулан сонгон ашиглах, сурах үйлдээ бүтээлчээр хэрэглэдэг болно.	<ul style="list-style-type: none"> - Хэрэгцээндээ нийцүүлэн хэрэглээний программ, аппликейшныг сонгон ашигладаг. - Хэрэгцээндээ нийцүүлэн хэрэглээний программ, аппликейшн ашиглан дижитал медиа бүтээл зохиомжлон боловсруулдаг.
Алгоритмыг алхам алхмаар төлөвлөдөг, энгийн код бичдэг, засаж сайжруулдаг болно.	<ul style="list-style-type: none"> - Алгоритм, кодчиллын үндсэн ойлголтыг жишээгээр тайлбарладаг. - Өгсөн даалгавар гүйцэтгэх алгоритмыг төлөвлөж, блок кодоор кодчилдог. - Роботын үйлдлийг кодчилж, туршиж, сайжруулдаг.
Өгөгдөл болон хиймэл оюуны үндсэн ойлголттой болж, хиймэл оюуны хэрэгслүүдийг сонгон ашиглахдаа гарсан үр дүнг хянаж, сайжруулдаг болно.	<ul style="list-style-type: none"> - Өгөгдөл, хиймэл оюуны үндсэн ойлголтыг жишээгээр тайлбарладаг. - Өгөгдлийг бүлэглэж, дүрсэлж, ашигладаг. - Хиймэл оюуны хэрэгслийг аюулгүй, хариуцлагатай хэрэглэдэг.

ДҮРСЛЭХ УРЛАГ, ДИЗАЙН

НЭГ. ЗОРИЛГО

1.1 Зорилго

Суралцагчийн зурах, дүрслэх, урлан бүтээх суурь чадамж болон бүтээлчээр сэтгэх, гоо зүйн мэдрэмж, өөрийгөө илэрхийлэх, үндэсний болон дэлхийн урлагийн бүтээлээс суралцах, шүүн тунгаах, хамтран ажиллах ерөнхий чадамжийг хөгжүүлнэ.

1.2. Хүрэх үр дүн, шатлал

Энэхүү хөтөлбөрийг судалснаар суралцагчид дараах ерөнхий үр дүнд хүрсэн байна.

- Дүрслэх урлаг, дизайны үндсэн элемент, арга зарчмыг ойлгож хэрэглэх, материал, хэрэглэгдэхүүнийг зориулалтын дагуу ашиглах чадвартай болно.
- Өөрийн мэдрэмж, санаагаа зураг, бүтээлээр илэрхийлэхдээ материал, хэрэглэгдэхүүнээ сонгон хийх арга, дарааллыг төлөвлөж бүтээлчээр гүйцэтгэдэг болно.
- Өөрийн мэдлэг туршлагад тулгуурлан хийх бүтээлийн санаа гаргаж, санаагаа бүтээж хөгжүүлдэг болно.
- Үндэсний болон дэлхийн дүрслэх урлагийн бүтээлээс судалж, өөрийн мэдрэмж, санаагаа зураг дүрслэл, эх хэлээрээ ойлгомжтой илэрхийлдэг болно.

№	Хүрэх үр дүн	Шатлал	
		I-II анги	III-V анги
1	Дүрслэх урлаг, дизайны үндсэн элемент, арга зарчмыг ойлгож хэрэглэх, материал, хэрэглэгдэхүүнийг зориулалтын дагуу ашиглах чадвартай болно.	<ul style="list-style-type: none">- Дүрслэх урлагийн үндсэн элемент, зохиомжийн энгийн зарчмыг таньж мэддэг болно.- Материал, хэрэглэгдэхүүнийг таньж сонгох, зориулалтын дагуу хэрэглэдэг болно.	<ul style="list-style-type: none">- Дүрслэх урлаг, дизайны үндсэн элемент, арга зарчмыг ойлгож хэрэглэдэг болно.- Төрөл бүрийн материал, хэрэглэгдэхүүнээс бүтээлийн онцлогт нийцүүлэн сонгож, аюулгүй ажиллагааны дүрэм баримтлан хэрэглэдэг болно.
2	Өөрийн мэдрэмж, санаагаа зураг, бүтээлээр илэрхийлэхдээ материал, хэрэглэгдэхүүнээ сонгон хийх арга, дарааллыг төлөвлөж бүтээлчээр гүйцэтгэдэг болно.	<ul style="list-style-type: none">- Өөрийн мэдрэмж, санаагаа зураг, бүтээлээр илэрхийлэхдээ бусдын дэмжлэгтэйгээр материал, хэрэглэгдэхүүнээ сонгож, хийх арга, дарааллын дагуу цэвэр нямбай хийж гүйцэтгэдэг болно.	<ul style="list-style-type: none">- Өөрийн мэдрэмж, санаагаа илэрхийлэхдээ материал, хэрэглэгдэхүүн, хийх арга, дарааллыг төлөвлөж, цэвэр нямбай, бүтээлчээр гүйцэтгэдэг болно.

3	Өөрийн мэдлэг туршлагад тулгуурлан хийх бүтээлийн санаа гаргаж, санаагаа бүтээж хөгжүүлдэг болно.	- Өөрийн сонирхол, туршлагаас бий болсон санаагаа зураг бүтээлээр илэрхийлдэг болно. - Бусдын санал бодлыг сонсож бүтээлээ сайжруулдаг болно.	- Өөрийн мэдлэг, туршлагадаа тулгуурлан бүтээлийн шинэ санаа шийдэл гаргаж, туршиж хөгжүүлдэг болно. - Бүтээл хийх явцдаа өөртөө шүүмжлэлтэй ханддаг, бусдын санал бодлыг сонсож бүтээлээ сайжруулах, өөрчилж загварчилдаг болно.
4	Үндэсний болон дэлхийн дүрслэх урлагийн бүтээлээс судалж, өөрийн мэдрэмж, санаагаа зураг дүрслэл, эх хэлээрээ ойлгомжтой илэрхийлдэг болно.	- Үндэсний урлагийн бүтээлээс санаа авч өөрийн мэдрэмжээ зураг дүрслэлээр илэрхийлж эх хэлээрээ тайлбарладаг болно.	- Үндэсний болон дэлхийн дүрслэх урлагийн бүтээлээс судалж, өөрийн мэдрэмж, санаагаа зураг дүрслэл, эх хэлээрээ ойлгомжтой илэрхийлдэг болно.

ХОЁР. АГУУЛГА

2.1. Бага боловсролын эхлэл шатлал

Агуулгын ай 1. Дүрслэлийн хэл

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Дүрслэх урлаг, дизайны үндсэн элемент, арга, зарчим	1.1а. Дүрслэх урлагийн үндсэн элементүүд (үндсэн өнгө, цэг толбо, өргөн, нарийн, шулуун, тахир зураас, үндсэн дүрс)-ийг ялган таньж хэрэглэнэ.	2.1а Дүрслэх урлагийн үндсэн элементүүд (үүсмэл өнгө, толбо, долгион, нуман зураас, нийлмэл дүрс (зууван дугуй, таван хошуу, ромбо))-ийг таньж зураг бүтээлд хэрэглэнэ.
	1.1б. Дүрслэх урлаг, дизайны үндсэн арга, зарчим (тэгш хэм, жигд давтамж (нэг элемент), орон зай)-ыг ойлгож хэрэглэнэ.	2.1б. Дүрслэх урлаг, дизайны үндсэн арга, зарчим (тэгш хэм, жигд давтамж, орон зай)-ыг ойлгож зураг бүтээлд хэрэглэнэ.

Агуулгын ай 2. Урлан бүтээхүй

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Материал, хэрэглэгдэхүүн	1.2а. Зургийн хэрэглэгдэхүүн (харандаа, тосон харандаа, бийр, усан будаг)-ийг таньж, зориулалтын дагуу хэрэглэнэ.	2.2а. Зургийн хэрэглэгдэхүүн (харандаа, тосон харандаа, бийр, усан будаг, гуаш)-ийг бүтээлийн онцлогт нийцүүлэн сонгож хэрэглэнэ.
	1.2б. Материал (нимгэн, хатуу цаас, баримлын шавар, байгалийн болон дахин ашиглах материал), багаж, хэрэглэгдэхүүн (хайч, цавуу)-ийг	2.2б. Материал (нимгэн, хатуу цаас, баримлын шавар, байгалийн дахин ашиглах материал), багаж, хэрэглэгдэхүүн (хайч, цавуу)-ийг

	таньж, зориулалтын дагуу хэрэглэнэ.	бүтээлийн онцлогт нийцүүлэн сонгож хэрэглэнэ.
Урлан бүтээх арга ажиллагаа	1.2в. Бодит байдлаас ажиглаж танил зүйлс (<i>ургамал (цэцэг, навч), амьтан, хүн зэрэг</i>)-ийг хялбар (<i>энгийн тойм дүрсээр зэрэг</i>) аргаар зурна.	2.2в. Бодит байдлаас ажиглаж танил зүйлс (<i>мод ургамал, гэрийн тэжээмэл амьтан, төл мал, хүн</i>)-ийг хялбар (<i>хэлбэр, хэмжээг ойролцоо дүрсээр баримжаалж зэрэг</i>) аргаар зохиомжлон зурна.
	1.2г. Үлгэрийн гол дүрийг өөрийн бодол, төсөөллөөр зурахдаа зохиомжийн санаагаа илэрхийлнэ.	2.2г. Үлгэрийн үйл явдлыг өөрийн бодол, төсөөллөөр зурж зохиомжийн санаагаа илэрхийлнэ.
	1.2д. Хөгжмөөс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ (<i>хурдан, удаан зэрэг</i>) зураг дүрслэлээр илэрхийлнэ.	2.2д. Хөгжмөөс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ (<i>хөгжилтэй, ууртай, уйтгартай дүр төрх зэрэг</i>) зураг дүрслэлээр илэрхийлнэ.
	1.2е. Өгөгдсөн сэдвийн хүрээнд өөрийн төсөөлөл, уран сэтгэмжээс бий болсон дүрийг (<i>гол дүр</i>) зохиомжлон зурна.	2.2е. Өгөгдсөн сэдвийн хүрээнд өөрийн төсөөлөл, уран сэтгэмжээс бий болсон дүрүүд (<i>гол ба туслах дүр</i>)-ийг зохиомжлон зурна.
	1.2ж. Үндсэн дүрсүүдийг хайчлан өрж, наах болон цаасыг туузлан хайчилж, холбох аргаар хоёр ба гурван хэмжээст бүтээл хийж сайжруулна.	2.2ж. Үндсэн дүрсүүдийг хайчлан, өрж, наах, цаасыг туузлан хайчилж, хэлбэр үүсгэн холбох, сүлжих зэрэг аргаар хоёр ба гурван хэмжээст бүтээл хийж сайжруулна.
	1.2з. Зурган зааврын дагуу цаасыг 2-3 нугалж бүтээл хийх, өөрийн бодол төсөөллөөр анхны загвараа өөрчилж сайжруулна.	2.2з. Зурган зааврын дагуу цаасыг 3-4 нугалж бүтээл хийх, бүрдэл хэсгийн байршлыг өөрчлөх аргаар анхны загвараа өөрчилнө.
	1.2и. Баримлын шаврыг хавтгайлах, бөөрөнхийлөх, цувих, нааж холбох аргаар танил сэдвээр бүтээл (<i>жимс, ногоо, амьтан зэрэг</i>) хийж сайжруулна.	2.2и. Баримлын шаврыг бөөрөнхийлж хэлбэр үүсгэн дарж наах, ором гаргаж чимэглэх аргаар танил сэдвээр бүтээл хийж санааг тусгаж сайжруулна.
	1.2к. Байгалийн материал (<i>навч зэрэг</i>)-ын хэлбэр, дүрсийг ажиглан сонгож өрөх, наах аргаар бүтээл хийж анхны санаагаа өөрчилж сайжруулна.	2.2к. Байгалийн материал (<i>чулуун зэрэг</i>)-ын хэлбэр, дүрсийг ажиглан сонгож өрөх, баримлаар наах, будаж чимэглэх аргаар бүтээл хийж өөрийн санаагаа тусгаж сайжруулна.
	1.2л. Төрөл бүрийн материалаар бүрдэл хэсэг нэмж, наах, будаж чимэглэх аргаар 2 хэмжээс (<i>наамал</i>) бүтээл хийж өөрийн санаагаа тусгаж сайжруулна.	2.2л. Төрөл бүрийн материалын хэлбэрийг өөрчилж хайчлах, наах, будаж чимэглэх аргаар загварчилж бүтээл хийж өөрийн санаагаа тусгаж сайжруулна.
	1.2м. Техникийн бүтээлийн жишээн дээр хөдөлгөөний чиглэлийг (<i>урагш, хойш, дээш, доош</i>) ойлгож, хөдөлгөөнт бүтээл хийж сайжруулна.	2.2м. Техникийн бүтээлийн жишээн дээр (<i>савлах, өнхрөх</i>) хөдөлгөөнийг ойлгож, хөдөлгөөнт бүтээл хийж өөрийн санаагаа тусгаж сайжруулна.

Агуулгын ай 3. Соёлын үнэт зүйл

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Үндэсний болон дэлхийн дүрслэх урлагийн бүтээл	1.3а. Үндэсний урлагийн бүтээл ширмэл ширдгийн жишээн дээр чагтан хээг таньж нэрлэх, зураг дүрслэлд хэрэглэнэ.	2.3а. Үндэсний урлагийн бүтээлийн жишээн дээр алхан хээг таньж нэрлэх, бэлгэдлийг ойлгож зураг дүрслэлд хэрэглэнэ.
	1.3б. Эртний хадны зургийн дүрслэлээс санаа авч өөрсдийн төсөөллөөр дүрслэх замаар хадны зураг дүрслэлийг таньж нэрлэнэ.	2.3б. Эртний буган хөшөөний дүрслэлээс санаа авч өөрсдийн төсөөллөөр дүрслэх замаар буган чулуун хөшөөний дүрслэлийг таньж нэрлэнэ.

2.2. Бага боловсролын төгсгөл шатлал

Агуулгын ай 1. Дүрслэлийн хэл

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Дүрслэх урлаг, дизайны үндсэн элемент, арга, зарчим	3.1а. Дүрслэх урлаг, дизайны үндсэн элементүүд (гуравдагч үүсмэл өнгө, тод ба бүдэг өнгө, толбо, зураас (шулуун, тахир, долгион, нуман зураасны илэрхийлэл), дүрс (абстракт) ба биет)-ийг таньж зураг бүтээлд хэрэглэнэ.	4.1а. Дүрслэх урлаг, дизайны үндсэн элементүүд (дулаан, хүйтэн өнгө, толбо, биет (куб, параллелепипед))-ийг таньж нэрлэх, зураг бүтээлд сонгож хэрэглэнэ.	5.1а. Дүрслэх урлаг, дизайны үндсэн элементүүд (ойролцоо ба эсрэг өнгө, толбо, биет (конус, цилиндр))-ийг таньж нэрлэх, зураг, бүтээлд сонгож хэрэглэнэ.
	3.1б. Дүрслэх урлаг, дизайны арга, зарчим (тэгш ба тэгш бус хэм, давтамж (өсөх, буурах хэмнэлт)), хэмжээ (зохицол), орон зай (цаана, наана байршлыг давхцуулан зурах аргаар))-ыг ойлгож зураг бүтээлд хэрэглэнэ.	4.1б. Дүрслэх урлаг, дизайны үндсэн арга, зарчим (давтамж (жигд бус хэмнэлт), хэмжээ, харьцаа (эд зүйлийн өөрийн өндөр, өргөн), орон зай (хол, ойр байршлыг өнгийн ялгарлаар дүрслэх))-ыг онцлогийг ойлгож зураг бүтээлд хэрэглэнэ.	5.1б. Дүрслэх урлаг, дизайны үндсэн арга, зарчим (давтамж (цацраг хэлбэрийн 2-3 элемент), хэмжээ, харьцаа (эд зүйлийн хэмжээ хооронд), орон зай (хол, ойр байршлыг 1 цэгийн алслалтаар))-ыг ойлгож сонгож хэрэглэнэ.
	3.1в. Зохиомжийн төрөл (<i>нэг төвт (гол ба туслах дүр)</i>) онцлогийг бүтээлийн жишээн дээр таньж нэрлэх, зураг бүтээлд ойлгож хэрэглэнэ.	4.1в. Зохиомжийн төрөл (<i>задгай зохиомж (гол ба туслах дүр)</i>) онцлогийг бүтээлийн жишээн дээр таньж нэрлэх, зураг бүтээлд ойлгож хэрэглэнэ.	5.1в. Зохиомжийн төрөл (<i>өнцөглөсөн зохиомж (гол ба туслах дүр)</i>) онцлогийг бүтээлийн жишээн дээр таньж нэрлэх, зураг бүтээлд ойлгож хэрэглэнэ.

Агуулгын ай 2. Урлан бүтээхүй

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Материал, хэрэглэгдэх үүн	3.2а. Цаас болон төрөл бүрийн материал (баримлын шавар, байгалийн материал, нэхмэлийн утас, дахин ашиглах материал)-аар бүтээл хийхдээ тохирох багаж, хэрэглэгдэхүүнээ сонгож, аюулгүй ажиллагааны дүрэм баримтлан хэрэглэнэ.	4.2а. Бүтээлийн онцлогт нийцүүлэн төрөл бүрийн материал (нимгэн, зузаан (картон цаас), баримлын шавар, байгалийн материал, товч, шүр, сувс, дахин ашиглах материал), тохирох багаж хэрэглэгдэхүүнийг сонгож, аюулгүй ажиллагааны дүрэм баримтлан хэрэглэнэ.	5.2а. Төрөл бүрийн материал (картон цаас, баримлын шавар, байгалийн материал, оёдлын утас, бөс даавуу, чимэглэл, дахин ашиглах материал)-аар бүтээл хийхдээ тохирох багаж хэрэглэгдэхүүн (гар оёдлын зүү, хайч, хуруувч)-ийг сонгож, зориулалтын дагуу аюулгүй ажиллагааны дүрэм баримтлан хэрэглэнэ.
Урлан бүтээх арга ажиллагаа	3.2б. Бодит байдлаас ажиглаж танил зүйлс (байгалийн юмс буюу уул, гол, үүл, нар, сар, тэнгэр), мал, амьтан, хүний хөдөлгөөн)-ийг хялбар (бүдүүвч) араг зургийн) аргаар зурж зохиомжийн санаагаа хөгжүүлнэ.	4.2б. Бодит байдлаас ажиглаж танил ба танил бус байгалийн юмс, үзэгдэл (улирал), амьтан, хүнийг хялбар (хэлбэр, хэмжээг баримжаалж дүрслэх) аргаар зурж зохиомжийн санаагаа хөгжүүлнэ.	5.2б. Бодит байдлаас ажиглаж танил ба танил бус зүйлс хүрээлэн буй орчин (эд юмс, байшин барилга, байгалийн юмс, үзэгдэл), мал, амьтан болон хүнийг (хэмжээ хоорондын харьцааг баримжаалж дүрслэх) хялбар аргаар зурж зохиомжийн санаагаа хөгжүүлнэ.
	3.2в. Эхийг уншиж өөрийн бодол, төсөөллөө зурахдаа нэг төвт зохиомжийн ойлголтоо илэрхийлнэ.	4.2в. Уран зохиолын эх уншиж өөрийн бодол төсөөллөө зурахдаа задгай зохиомжийн ойлголтоо илэрхийлнэ.	5.2в. Бодит түүхээс сэдэвлэн өөрийн бодол, төсөөллөө зурахдаа өнцөглөсөн зохиомжийн ойлголтоо илэрхийлнэ.
	3.2г. Хөгжмөөс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ (хүчтэй, сул, ширүүн, намуун) зураас, дүрсээр илэрхийлж зурна.	4.2г. Хөгжмөөс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ (дулаан ба хүйтэн) өнгөөр илэрхийлж зурна.	5.2г. Хөгжмөөс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ (ээрэг ба сөрөг) дүр дүрслэлээр илэрхийлж зурна.
	3.2д. Өгөгдсөн сэдвийн хүрээнд өөрийн төсөөлөл, уран	4.2д. Өгөгдсөн сэдвийн хүрээнд өөрийн төсөөлөл, уран	5.2д. Өгөгдсөн сэдвийн хүрээнд өөрийн төсөөлөл, уран

сэтгэмжээс бий болсон дүр, дүрслэлийг (<i>гол ба туслах дүр</i>) нэг төвт зохиомжийн аргаар зурж өөрийн санаагаа хөгжүүлнэ.	сэтгэмжээс бий болсон дүр, дүрслэлүүд, үйл явдлыг задгай зохиомжийн аргаар зурж өөрийн санаагаа хөгжүүлнэ.	сэтгэмжээс бий болсон дүр, дүрслэл, үйл явдлыг цуврал байдлаар зурж өөрийн санаагаа хөгжүүлнэ.
3.2е.Өөрийн бодол төсөөллөөс бий болсон дүр дүрслэлийг зургийн энгийн программ ашиглан илэрхийлж зурна.	4.2е.Өөрийн бодол төсөөллөөр илэрхийлсэн дүр дүрслэлийг дижитал орчинд зурж, зохиомжийг өөрчилж хөгжүүлнэ.	5.2е. Өгөгдсөн сэдвийн хүрээнд өөрийн бодол, төсөөллөө зураг, бичвэр, дүрс, фото зураг ашигласан дижитал бүтээл (коллаж) хийж илэрхийлнэ.
3.2ж. Цаасны нимгэн, зузааныг туршин бүтээлийн онцлогт тохируулан сонгож хайчлах болон нааш, цааш нугалж орон зай үүсгэн холбох аргаар гурван хэмжээст бүтээл хийж загварчилна.	4.2ж. Цаасны ширхгийн чиглэлийн дагуу хуйлж бат бөх чанарыг туршин бүтээлийн онцлогт тохируулан сонгож, туузлан хайчлах, хуйлж хэлбэр үүсгэх аргаар гурван хэмжээст чимэглэлийн бүтээл хийж загварчилна.	5.2ж. Цаасыг дахин ашиглах, боловсруулахтай холбоотой мэдээллийг судалж, шуумлын болон цаас шигтгэх аргаар хоёр ба гурван хэмжээст хэрэгцээт бүтээл хийж загварчилна.
3.2з. Зааврын дагуу цаасыг 5-с дээш нугалж бүтээл хийж бүрдэл хэсгийн тоог нэмэх аргаар загварчилна.	4.2з. Зааврын дагуу цаасыг нугалж ахуйн хэрэгцээт бүтээл хийж хэлбэрийг өөрчлөх, бүрдэл хэсгийн тоог нэмэх аргаар загварчилна.	5.2з. Зааврын дагуу цаасыг нугалж, ахуйн хэрэгцээт бүтээл хийж, хэмжээг өөрчлөх, бүрдэл хэсгийн тоог нэмэх аргаар загварчилна.
3.2и. Баримлаар бүрдэл хэсгүүдийг бэлтгэж савхаар (<i>савх мод, төмөр утас</i>) холбох аргаар хүн, амьтны баримал хийж орчин бүрдүүлж хөгжүүлнэ.	4.2и. Баримлаар өгөгдсөн сэдвийн (<i>үлгэр, хүүхэлдэйн кино</i>) гол дүрийн гадаад байдал, онцлог (ерөнхий хэлбэр, өнгө, хөдөлгөөний хувьд танигдахуйц)-ийг илэрхийлсэн бүтээл хийж өөрийн санаагаа хөгжүүлнэ.	5.2и. Баримлаар өгөгдсөн сэдвийн (<i>үлгэр, хүүхэлдэйн кино</i>) гол дүрийн гадаад байдал, онцлог төрх (ерөнхий хэлбэр, өнгө, хөдөлгөөний хувьд танигдахуйц), үйл явдлыг илэрхийлсэн бүтээл хийж өөрийн санаагаа хөгжүүлнэ.
3.2к. Байгалийн материал (<i>мөчир</i>)-ын хэлбэрийг ажиглаж сонгох, өрж холбох, будаж чимэглэх аргаар хэрэгцээт бүтээл хийж туршиж сайжруулна.	4.2к. Байгалийн материал (<i>боргоцой</i>), баримлын шаврыг хослуулан өрж холбох аргаар гурван хэмжээст бүтээл хийж хөгжүүлнэ.	5.2к. Байгалийн материал (<i>мөчир, боргоцой</i>)-ыг бусад материалтай хослуулан өрж, холбох аргаар хэрэгцээт зүйлс хийж туршиж сайжруулна.
3.2л. Төрөл бүрийн дахин ашиглах материалын хэлбэр,	4.2л. Төрөл бүрийн чимэглэлийн болон дахин ашиглах	5.2л. Даавуу, гар оёдлын багаж хэрэгсэл болон дахин ашиглах

	хэмжээг нь өөрчлөх, өрж холбох, бүрдэл хэсэг нэмж загварчлах аргаар бүтээл хийх сайжруулна.	материалаас сонгон хэлбэр, хэмжээг нь өөрчлөх, бүрдэл хэсэг нэмж загварчлах аргаар хэрэгцээт зүйлс хийж туршиж сайжруулна.	материалаар хийх бүтээлийн санаа гаргаж, ахуйн хэрэглээний зүйлс хийж туршиж сайжруулна.
	3.2м. Энгийн материал (<i>шаар, резин зэрэг</i>)-ыг ашиглан хөдөлгөөн үүсгэх боломжуудыг туршиж, хөдөлгөөнт загвар зохион бүтээнэ.	4.2м. Энгийн материал (<i>пүрш, хүндрүүлэгч ачаа зэрэг</i>)-ын механик зарчмыг судалж, хөдөлгөөн үүсгэх боломжийг туршиж техникийн хөдөлгөөнт загвар зохион бүтээнэ.	5.2м. Хөдөлгөөн үүсгэхэд тохиромжтой материал (<i>шаар, резин, пүрш зэрэг</i>)-ыг сонгон туршиж, хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн техникийн хөдөлгөөнт загвар зохион бүтээнэ.

Агуулгын ай 3. Соёлын үнэт зүйл

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Үндэсний болон дэлхийн дүрслэх урлагийн бүтээл	3.3а. Үндэсний урлагийн бүтээлийн жишээн дээр хээ (алхан), угалзыг (хамар, эвэр) ялган таньж нэрлэх, зураг дүрслэлд дагнаасалж зурах аргыг хэрэглэнэ.	4.3а. Үндэсний тоглоом наадгайн (өрж эвлүүлэх уламжлалт тоглоом) зураг дүрслэлээс санаа авч зураг, бүтээл хийхдээ зохиомжийн ойлголтоо илэрхийлнэ.	5.3а. Үндэсний урлагийн бүтээлээс санаа авч зураг, бүтээл хийхдээ хээ, угалзын хэрэглээ, бэлгэдэл, зохиомжийн ойлголтоо илэрхийлнэ.
	3.3б. Монголын болон дэлхийн хосгүй үнэт уран зургийн бүтээл (Өвгөн хуурч, Мона Лиза)-ээс сонгож хэлэлцэх замаар үнэ цэнийг ойлгож, таньж нэрлэнэ.	4.3б. Монголын болон дэлхийн хосгүй үнэт уран зургийн бүтээл (Ажлын дараа, Мадонна Литта, Пабло Пикассо)-ээс сонгож хэлэлцэх замаар үнэ цэнийг ойлгож, таньж нэрлэнэ.	5.3б. Монголын болон дэлхийн хосгүй үнэт уран зургийн бүтээлээс (Азарганы ноцолдоон, Хамтын хөдөлмөр, Одтой шөнө, Сикстийн эх дагина) сонгож уран бүтээлчтэй холбон хэлэлцэх замаар үнэ цэнийг ойлгож, таньж нэрлэнэ.

ГУРАВ. АРГА ЗҮЙ, ОРЧИН

Арга зүй

Дүрслэх урлаг, дизайн судлагдахууны хөтөлбөр нь ажиглалт-туршлага болон асуудалд суурилсан суралцахуйн арга зүйгээр хэрэгжих ба энэхүү арга зүй нь суралцагч аливааг сонирхох, өөрөө хийж турших, туршлагаа эргэцүүлж, ойлголтоо гүнзгийрүүлэх, шинэ нөхцөлд хувиргах үйл ажиллагаагаар бүтээлчээр сэтгэх, урлан бүтээх чадвараа цэгцтэй хөгжүүлэх боломж олгоно.

Дүрслэх урлаг, дизайн судлагдахууны хөтөлбөрийг дараах алхмаар төлөвлөж хэрэгжүүлнэ.

Алхам	Жишиг үйл ажиллагаа
Ажиглах-асуудал дэвшүүлэх	<p><i>Ажиглах, асуулт асуух, санаагаа илэрхийлэх:</i></p> <ul style="list-style-type: none"> - Байгаль, орчны юмс үзэгдэл, дүрслэх урлагийн бүтээл (зураг, баримал, гэрэл зураг зэрэг)-ийг ажиглах; - “Яагаад?”, “Хэрхэн?”, “Ямар сэтгэгдэл төрж байна?” зэрэг асуултын дагуу ярилцах; - Ажигласан юмсын талаарх (өнгө, хэлбэр, бүтэц зэрэг) мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлэх, бусадтайгаа хуваалцах; - Багш суралцагчийн сэтгэгдэлтэй холбоотой асуулт асуух, асуудал дэвшүүлэх, хийх бүтээлийн санааг тодруулах;
Эрэл хайгуул хийх-турших	<p><i>Материал, хэрэглэгдэхүүн, арга барил, бүтээлийн анхны санаагаа турших, шинэ санаа шийдэл хайх:</i></p> <ul style="list-style-type: none"> - Материал, хэрэглэгдэхүүн, зурах, дүрслэх, урлан бүтээх арга ажиллагаа (зурах, будах, заавар дарааллын дагуу хийж гүйцэтгэх)-г туршиж үзэх; - Материал хэрэглэгдэхүүн, хийх арга ажиллагааг эргэцүүлэх, туршилтай холбоотой өөрийн санаагаа бусадтай хуваалцах; - Хэрвээ би энэ санаагаа илэрхийлэхдээ өөр материал хэрэглэвэл яах бол надад хэрэгтэй материал байхгүй бол яах вэ? зэрэг асуултаар туршилтын явцад санаагаа хөгжүүлэх;
Бүтээх-гүйцэтгэх	<p><i>Өөрийн санааг бүтээл хийж илэрхийлэх, урлан бүтээх ур чадварыг хөгжүүлэх:</i></p> <ul style="list-style-type: none"> - Өөрийн санаагаа илэрхийлэхэд хэрэглэх материал, хэрэглэгдэхүүнээ сонгож хийх арга, дарааллаа төлөвлөх; - Өөрийн санаагаа төлөвлөлтийн дагуу хийх, бүтээх; - Бүтээл хийх явцдаа өмнөх мэдлэг, ойлголт, туршлагадаа тулгуурлан анхны санаагаа сайжруулах, өөрчилж загварчлах шинэ шийдэл гаргах;
Үнэлэх-хөгжүүлэх	<p><i>Бүтээлээ дүгнэх, өөртөө шүүмжлэлтэй хандах, бусдыг сонсож суралцаж бүтээлээ сайжруулах:</i></p> <ul style="list-style-type: none"> - Бүтээлээ танилцуулах, хэлэлцүүлэх; - Өөрийн бүтээлийн талаар санал бодлоо хуваалцах, бусдын бүтээлээс санаа авч сайжруулах санаагаа тэмдэглэх; - Бусдынхаа бүтээлийн талаар эерэг сэтгэгдэл, сайжруулах саналаа хуваалцах; - Өөрийн бүтээлээ сайжруулах санаагаа хэрэгжүүлэх; - Өөрийн ахиц дэвшлээ бүтээлийн сан, зураг, дэвтэртээ тэмдэглэх;

Дүрслэх урлаг, дизайны судлагдахууны хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ тухайн сэдэв, агуулгатай уялдуулж дараах сургалтын аргуудаас сонгож, хослуулан хэрэглэнэ.

1. Бүтээлийн танилцуулга, хэлэлцүүлэг:

- Сурагчдын сонсох, илэрхийлэх, бусдад хүндэтгэлтэй хандах, шүүн тунгаах чадварыг дэмжинэ.

2. Төсөөллийн зураг зурах:

- Төсөөлөл, мэдрэмж, сэтгэл хөдлөлөө дүрслэлээр илэрхийлэх чадварыг хөгжүүлнэ.

3. Хамтын бүтээл хийх:

- Харилцах, хамтран ажиллах, бүтээлч сэтгэлгээг дэмжинэ.

Сургалт, үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулахдаа суралцагчийн оролцоонд тулгуурласан идэвхтэй сургалтын олон арга, хэлбэрийг хэрэглэх нь тэдний хөгжил, төлөвшилд илүү үр дүнтэй. Дүрслэх урлаг, дизайны судлагдахууны хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ, багш дижитал нөөц, хэрэглэгдэхүүн (зургийн программ, аппликейшн, онлайн платформ)-ийг зохистойгоор ашиглан сурагчдын бүтээлч сэтгэлгээ, цахим ур чадварын хөгжлийг дэмжинэ.

3.2 Сургалтын орчин

Сургалтын орчин нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад нөлөөлөх гол хүчин зүйл болдог. Суралцагчийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн сургалтын арга хэлбэр, эерэг таатай уур амьсгал бүхий эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх шаардлагатай.

Эерэг таатай уур амьсгал бүхий харилцаа:

- Эелдэг, найрсаг харилцдаг.
- Сурагчдын онцлогийг хүндэтгэж дэмждэг.
- Алдаанаас суралцахыг зөвшөөрдөг урам зориг өгдөг.
- Бусдыг сонсох, өөрийн санаагаа чөлөөтэй илэрхийлдэг.
- Бүтээлчээр сэтгэх, шинэ санаа гаргаж бусадтай хуваалцах боломжийг дэмждэг.
- Тоглох, амрах, хамтран суралцах боломжийг тэнцвэртэй хангадаг.
- Идэвх, оролцоонд эергээр нөлөөлж сурагчдад суралцах, хөгжих боломжийг дэмждэг.

Эрүүл, аюулгүй, хүртээмжтэй анги танхим:

- Анги танхимын ханаар сурагчдын бүтээл, алдартай уран бүтээлчдийн зураг, өнгөний хүрд (дугуй) бүхий үзүүлэн байрлуулсан байх;
- Байгальд ажиглалт хийх, эргэн тойронд байгаа эд зүйлсийг ажиглан уран бүтээл хийх боломжтой байх;
- Сурагчид хөдөлгөөнтэй, бие биетэйгээ харилцах боломжтой, уян хатан зохион байгуулалттай (ширээний зохион байгуулалт, гэрэлтүүлэг г.м) байх;
- Сурагчдад хүрэлцэхүйц хэмжээтэй зориулалтын сургалтын хэрэглэгдэхүүнтэй байх;

- Сургалтын хэрэглэгдэхүүн, материалуудыг эмх цэгцтэй, хүүхдэд хүрэхээр байрлуулах;
- Сурагчдын бүтээл хатаах, танилцуулах булан байх;
- Анхны тусламжийн булантай байх;
- Сургалтын техник хэрэгсэл болон дижитал нөөц ашиглах боломжтой байх;

Ялгаатай хэрэгцээг харгалзсан орчин:

- Сурагчдын суралцах хэв маягийг (хараа, сонсгол, хөдөлгөөний) харгалзсан зураг, бүдүүвч, өнгө ялгалттай материал, аудио хичээл, ярилцлага, практик туршилт, хөдөлгөөнтэй тоглоом ашиглах боломжтой;
- Хэл, соёлын ялгаатай сурагчдад зориулсан сургалтын болон бусад толь бичигтэй;
- Ялгаатай түвшний сурагчдад зориулсан (хоцрогдолтой болон авьяаслаг) даалгаврын сантай;

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

4.1 Үнэлгээний зорилго

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, төлөвшлийн давуу болон сул талыг илрүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг дэмжих, ахиц дэвшлийг урамшуулах, хүрсэн түвшнийг үнэлэхэд чиглэнэ.

Дүрслэх урлаг, дизайны судлагдахууны хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг суралцагчийн суралцах үйл явц, гүйцэтгэлд төвлөрч үнэлнэ.

Бага боловсролын эхлэл шатанд суралцагчийн үнэлгээ нь өөрийн санаагаа бүтээлээр илэрхийлэхдээ дүрслэлийн үндсэн элемент, арга зарчмыг таньж, ойлгож хэрэглэж буй байдал, материал, хэрэглэгдэхүүнийг зориулалтын дагуу ашиглаж буй эсэх, бусдын санал бодлыг сонсож бүтээлээ сайжруулж буй байдлыг илрүүлэх, суралцах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зэрэгт чиглэнэ.

Бага боловсролын төгсгөл шатанд суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварын давуу болон сул талыг илрүүлэх, суралцахуйн үр дүнг үнэлж, дүгнэхэд чиглэнэ.

4.2 Үнэлгээний шалгуур

Хүрэх үр дүн	Шалгуур
Дүрслэх урлаг, дизайны үндсэн элемент, арга зарчмыг ойлгож хэрэглэх, материал, хэрэглэгдэхүүнийг зориулалтын дагуу ашиглах чадвартай болно.	<i>Дүрслэх урлаг, дизайны суурь мэдлэг:</i> <ul style="list-style-type: none"> - Дүрслэх урлаг, дизайны үндсэн элемент, арга зарчмыг таньж, ойлгож хэрэглэдэг. - Материал, багаж хэрэглэгдэхүүнийг зориулалтын дагуу аюулгүй ажиллагааны дүрмийг баримталж хэрэглэдэг.
Өөрийн санаа, мэдрэмжээ зураг, бүтээлээр илэрхийлэхдээ материал, хэрэглэгдэхүүн хийх арга	<i>Урлан бүтээх үр чадвар:</i> <ul style="list-style-type: none"> - Өөрийн санааг илэрхийлэхэд тохирсон материал, хэрэглэгдэхүүн, арга ажиллагааг

ажиллагааг сонгон төлөвлөж бүтээлчээр гүйцэтгэдэг болно.	бие даан сонгон төлөвлөж, цэвэр нямбай, бүтээлчээр гүйцэтгэдэг.
Өөрийн мэдлэг туршлагадаа тулгуурлан хийх бүтээлийн санаа гаргаж, санаагаа бүтээж хөгжүүлдэг болно.	<p><i>Бүтээлч сэтгэлгээний чадвар:</i></p> <ul style="list-style-type: none"> - Өмнөх мэдлэг, туршлагадаа тулгуурлан бүтээлийн анхны санаа гаргадаг. - Бүтээлийн санаагаа хэрэгжүүлэх явцдаа анхны санаагаа сайжруулах, дизайны шинэ санаа, шийдэл гаргаж хөгжүүлдэг.
Үндэсний болон дэлхийн дүрслэх урлагийн бүтээлээс судалж, өөрийн мэдрэмж, санаагаа зураг дүрслэл, эх хэлээрээ ойлгомжтой илэрхийлдэг болно.	<p><i>Урлагийн мэдлэг, хандлага:</i></p> <ul style="list-style-type: none"> - Үндэсний болон дэлхийн уран зургийн зарим бүтээлийг таньдаг. - Үндэсний болон дэлхийн дүрслэх урлагийн бүтээлээс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ эх хэлээрээ ойлгомжтой тайлбарладаг. - Үндэсний болон дэлхийн дүрслэх урлагийн бүтээлээс санаа авч, санаагаа бүтээлчээр илэрхийлдэг.

ХӨГЖИМ

НЭГ. ЗОРИЛГО

1.1. Зорилго

Суралцагчийн хөгжим сонсох, дуулах, хөгжимдөх, бүжиглэх суурь чадамж болон бүтээлчээр сэтгэх, харилцах, хамтран ажиллах, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, үндэсний болон дэлхийн өв соёлоос суралцах ерөнхий чадамжийг хөгжүүлнэ.

1.2. Хүрэх үр дүн, шатлал

Энэхүү хөтөлбөрийг судалснаар суралцагчид дараах ерөнхий үр дүнд хүрсэн байна.

- Хөгжмийн хэлний үндсэн ухагдахууныг ойлгож хэрэглэдэг болно.
- Үндэсний болон Дэлхийн шилдэг хөгжмийн бүтээлээс сонсох, ардын болон хүүхдийн дуу дуулах, хөгжимдөх, бүжиглэх чадвартай болно.
- Өөрийн болон бусад улс орны соёлын өв, дуу хөгжмөөс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ эх хэлээрээ бүтээлчээр илэрхийлдэг болно.
- Өөрийн болон бусад улс орны дуу, хөгжмөөс бие дааж болон хамтран суралцах чадвар, төлөвшилтэй болно.

№	Хүрэх үр дүн	Шатлал	
		Эхлэл шат /I-II анги/	Төгсгөл шат /III-V анги/
1.	Хөгжмийн хэлний үндсэн ухагдахууныг ойлгож хэрэглэдэг болно.	<ul style="list-style-type: none"> - Хөгжмийн үг хэллэг, тэмдэг тэмдэглэгээг таньж, ойлгодог болно. - Хөгжмийн бүтээлийн дүр, дүрслэл, хурд, хүчийг тодорхойлдог болно. 	<ul style="list-style-type: none"> - Хөгжмийн үг хэллэг, тэмдэг тэмдэглэгээг ойлгож хэрэглэдэг болно. - Хөгжмийн бүтээлийн дүр, дүрслэл, хурд, хүч, утга санааг тодорхой жишээгээр тайлбарладаг болно.
2.	Үндэсний болон Дэлхийн шилдэг хөгжмийн бүтээлээс сонсох, ардын болон хүүхдийн дуу дуулах, хөгжимдөх, бүжиглэх чадвартай болно.	<ul style="list-style-type: none"> - Зохиолын утга санааг мэдэрч, тэмдэг тэмдэглэгээний дагуу дуулж, хөгжимддөг болно. - C1-C2 наймц (октав)-ын цараанд бичигдсэн эгшгүүдийг ноотоор дуулж, хэмнэл зохиодог болно. - Өөрийн сонирхлоор бүтээлийн сонголт хийж, сонсож, дуулж, хөгжимддөг болно. - Хэм хэмжээнд нийцүүлэн өөрийгөө болон бусдыг сонсож дуулж, хөгжимддөг 	<ul style="list-style-type: none"> - Зохиолын утга санаа, дүр дүрслэлийг ойлгож, тэмдэг тэмдэглэгээг зөв илэрхийлэн дуулж, хөгжимддөг болно. - C1-C2 наймц (октав)-ын цараанд дуу, аялгууг ноотоор дуулж, хэмнэл зохиож хөгжимддөг болно. - Өөрийн сонирхлоор бүтээлийн сонголт хийж, сонирхсон хөгжмийн зэмсгээс сонгож хөгжимддөг болно. - Хэм хэмжээнд нийцүүлэн бие даан ноотоор дуулж, хөгжимддөг болно.

		болно.	
3.	Өөрийн болон бусад улс орны соёлын өв, дуу хөгжмөөс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ эх хэлээрээ бүтээлчээр илэрхийлдэг болно.	<ul style="list-style-type: none"> - Байгаль орчны юмс үзэгдэл, мал амьтдын төрх араншин, дүр байдлыг хөдөлгөөн, дуу хоолой, хэмнэл, аялгаар илэрхийлдэг болно. - Хөгжмийн бүтээлд сонсголын ажиглалт хийж, мэдрэмж, сэтгэгдлээ янз бүрийн арга хэлбэрээр илэрхийлдэг болно. 	<ul style="list-style-type: none"> - Байгаль орчны юмс үзэгдлийн онцлог, дүр байдлыг зураг, дүрслэл, бичиглэлээр илэрхийлж, танил бус нөхцөлд хэрэглэдэг болно. - Хөгжмийн бүтээлд сонсголын ажиглалт хийж, төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ бусадтай хуваалцдаг, өдөр тутмын амьдралтай холбон эх хэлээрээ ойлгомжтой тайлбарладаг болно.
4.	Өөрийн болон бусад улс орны дуу, хөгжмөөс бие дааж болон хамтран суралцах чадвар, төлөвшилтэй болно.	<ul style="list-style-type: none"> - Өөрийн болон бусад улс үндэстний соёл, өв уламжлалтай танилцаж, дуулж хөгжимддөг болно. - Өөрийн болон бусад улс үндэстний дуу, хөгжмөөс сонсож, дуулж, хөгжимддөг болно. 	<ul style="list-style-type: none"> - Өөрийн болон бусад улс үндэстний соёл, өв уламжлалтай танилцаад, төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ эх хэлээрээ бүтээлчээр илэрхийлдэг болно. - Өөрийн болон бусад улс үндэстний дуу, хөгжмийн бүтээлийг сонсож дуулж, хөгжимддөг санаа бодлоо эх хэлээрээ илэрхийлж, ярилцдаг болно.

ХОЁР. АГУУЛГА

2.1. Бага боловсролын эхлэл шатлал

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Хөгжмийн хэлийг ойлгох	<p>1.1а. Байгаль, орчны дуу чимээг сонсоод урт богино, чанга сул, давталт өөрчлөлтийг ялган таньдаг болно.</p> <p>1.1б. Дуу, бүжиг, маршийг сонсоод шинж төрхийг ялган таньдаг болно.</p> <p>1.1в. Хөгжмийн бүтээлийг сонсоод төрөл зүйлийг ялган тайлбарладаг болно.</p>	<p>2.1а. Хүний дуу хоолой, амьтдын шинж төрх, дуугаралтын онцлогийг сонсоод ялган таньдаг болно.</p> <p>2.1б Хялбар дуу, дасгалыг сонсоод аялгууны чиглэл хөдөлгөөнийг зурагладаг болно.</p> <p>2.1в. Эгшгийн өндөр нам, чанга сул, хурд хүчний өөрчлөлтийг сонсоод ялган таньдаг болно.</p>

<p>Дуулах, хөгжимдөх, бүжиглэх</p>	<p>1.2а. Хөгжмийн бүтээлийг сонсоод аялгууны шинж төрхөд нийцүүлэн хөдөлгөөнөө /найгах, ганхах, эргэх зэрэг/зохицуулдаг болно.</p> <p>1.2б. Хөгжмийн энгийн зэмсэг, янз бүрийн хэрэгсэл ашиглан дуу авиа үүсгэдэг болно.</p> <p>1.2в. Бүтэн, хагас, дөрөвт, наймт, арван зургаат ноотны уртаашийг ялган таньдаг, энгийн хэмнэлээр хөгжимддөг болно.</p> <p>1.2г. 2/4, 3/4, 4/4 айзамд наймт, дөрөвт, хагас, бүтэн уртааш бүхий хэмнэлийг хөгжмийн энгийн зэмсгээр хөгжимддөг болно.</p> <p>1.2д. Хэм хэмжээнд нийцүүлэн өөрийгөө болон бусдыг сонсож дуулж, хөгжимддөг болно.</p> <p>1.2е. Хөгжмийн энгийн зэмсгээр хүчтэй ба сул хувийг ялган хөгжимддөг болно.</p>	<p>2.2а. Хөгжмийн бүтээлийг сонсоод, аялгууны шинж төрх, өнгө аясыг мэдэрч хөдөлгөөнөөр илэрхийлдэг болно.</p> <p>2.2б. Аялгууны чиглэл хөдөлгөөний дагуу гарын тулгуур дохио ашиглан дуулдаг болно.</p> <p>2.2в. Соль-до2, соль-до1 эгшгүүдийг янз бүрийн хэмнэлд оруулан ноотоор дуулдаг болно.</p> <p>2.2г. 2/4, 3/4, 4/4, 8/3, 8/6 айзамд янз бүрийн эгшгүүдийг хэмнэлжүүлэн ноотоор дуулж, хөгжимддөг болно.</p> <p>2.2д. до1-до2 буюу нэг наймц /октав/-ын хүрээнд бичигдсэн янз бүрийн өндөрлөгтэй эгшгүүдийг ноотоор дуулдаг болно.</p> <p>2.2е. Цэгтэй ноот бүхий дуу, аялгууг ноотоор дуулж, хэмнэлээр хөгжимддөг болно.</p>
<p>Бүтээлчээр илэрхийлэх</p>	<p>1.3а. Дуу авианы өөрчлөлтийг сонсоод янз бүрийн аргаар илэрхийлдэг (зураглал, дуу хоолой, хөдөлгөөн, дүрээр зэрэг..) болно.</p> <p>1.3б. Өгөгдсөн хэмжээнд тодорхой сэдвийн хүрээнд хэмнэлийн зохиомж хийдэг болно.</p> <p>1.3в Дуу, бүжиг, маршийн шинж төрхийг илтгэсэн богино хэмнэл зохиодог болно.</p>	<p>2.3а. Хөгжмийн энгийн зэмсгүүдийн дуу авиа үүсгэх арга замыг туршилтаар тодруулж тэдгээрийн дуугаралтын онцлогийг тодорхойлон ангилдаг болно.</p> <p>2.3б. Наймт, дөрөвт, хагас, бүтэн уртааш болон зогсцын тэмдгүүдийг ашиглан өгөгдсөн хэмд янз бүрийн хувилбарт хэмнэл зохиодог болно.</p> <p>2.3в. Өгөгдсөн хэмд цэгтэй ноот, зогсоц бүхий хэмнэлийг зохиодог болно.</p>

2.2. Бага боловсролын төгсгөл шатлал

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Хөгжмийн хэлийг ойлгох	<p>3.1а. Хөгжмийн бүтээлээс зэмсгийн дуугаралтын онцлогийг сонсож тодорхойлдог болно.</p> <p>3.1б. Жижиг хэлбэрийн хөгжмийн бүтээлийг сонсоод бүрэлдэхүүнийг тодорхойлдог болно.</p> <p>3.1в. Хөгжмийн бүтээлээс айзам хэмжээ, хурд, хүч, аялгууны шинж төрхийг сонсож тодорхойлдог болно.</p>	<p>4.1а. Өөрийн болон бусад улс орны хөгжмийн бүтээлээс сонсоод утга санааг тэмдэг тэмдэглэгээтэй холбон тайлбарладаг болно.</p> <p>4.1б. Уран илэрхийллийн арга, тэмдэг тэмдэглэгээний үүрэг зориулалтыг хөгжмийн бүтээлийн илэрхийлэмжтэй холбон тайлбарладаг болно.</p> <p>4.1в. Хөгжмийн хэлний хэрэглүүрүүдийг (темп, динамик, онцлог ритм, штрих) ялган тэмдэглэдэг болно.</p>	<p>5.1а. Хөгжмийн бүтээлийг сонсоод давталт, ялгарамжийг тодорхойлж чаддаг болно.</p> <p>5.1б. Хөгжмийн бүтээлийг сонсоод энгийн хэлбэрийг ялгаж чаддаг болно. /А, АВ, АВА, АВС/</p> <p>5.1в. Хөгжмийн бүтээлийн хэлбэр, бүтцийг тэмдэглэдэг, ялган тодорхойлдог болно.</p>
Дуулах, хөгжимдөх, бүжиглэх	<p>3.2а. Аялгууны дүр дүрслэлд тохирсон хэрэгсэл /алчуур, дарцаг, .../-ийг сонгож хэм хэмнэлд нийцүүлэн бүжиглэдэг болно.</p> <p>3.2б. Дуу, дасгалын хурд, хүчний өөрчлөлтийг мэдэрч хөдөлгөөнөөр илэрхийлдэг болно.</p> <p>3.2в. Соль-до2, соль-до1 эгшгүүдийг бишгүүр /пианика/-т хөгжимддөг болно.</p> <p>3.2г. Догол (синкоп) хэмнэл бүхий дуу, аялгууг ноотоор дуулж, хөгжимддөг болно.</p> <p>3.2д. Нэг наймцын (с1-с2) цараанд хялбар дуу, аялгууг пианика, бишгүүр хөгжмөөр хөгжимддөг болно.</p>	<p>4.2а. Өөрийн болон бусад улс үндэстний хөгжмийн бүтээлийн аялгууны шинж төрх, өнгө аясын өөрчлөлтийг мэдэрч (дүрээр, хөдөлгөөнөөр, жүжигчилсэн тоглолтоор) илэрхийлдэг болно.</p> <p>4.2б. Аялгууны дүр дүрслэлд нийцүүлэн сэтгэл хөдлөлөө илэрхийлэн бүжиглэдэг болно.</p> <p>4.2в. Солигдмол хэм, хэмжээтэй хүүхдийн дуу, хөгжмийн бүтээлийг дуулж, хөгжимддөг болно.</p> <p>4.2г. Дуу, дасгалыг харилцаа болон хөөцөл хэлбэрээр дуулж, хөгжимддөг болно.</p> <p>4.2д. Утга санааг ойлгож, тэмдэг тэмдэглэгээний дагуу уран</p>	<p>5.2а. Өөрийн болон бусад улс үндэстний хөгжмийн бүтээлийн эгшиглэгээний онцлогийг янз бүрийн арга хэлбэрээр (өнгө будаг, зураглал, жүжигчилсэн тоглолт) илэрхийлдэг болно.</p> <p>5.2б. Хөгжмийн жижиг хэлбэрийн бүтээлээс давталт, ялгарамжийг мэдэрч хөдөлгөөнөөр илэрхийлдэг.</p> <p>5.2в. Ардын болон эстрад, джаз зэрэг янз бүрийн хэв маягт дуулдаг болно.</p> <p>5.2г. Хялбар дуу, дасгалыг 2 ба 3 хоолойд хөгжимддөг болно.</p> <p>5.2д. Хоёр ба гурван хоолойд уран илэрхийлэлтэй дуулдаг болно.</p>

	3.2е. Хялбар дуу аялгууг бие даан хөгжимдөж, ноотоор дуулдаг болно.	илэрхийлэлтэй дуулж, хөгжимддөг болно. 4.2е. Утга санааг уран илэрхийлэлтэйгээр 2 хоолойд хамтран дуулж, хөгжимддөг болно.	5.2е. Ноот бичигт ажиглалт хийж, тэмдэг тэмдэглэгээний үүрэг зориулалтын дагуу дуулж, хөгжимддөг болно.
Бүтээлчээр илэрхийлэх	3.3.а Хөгжмийн зэмсгийн дуу авиа үүсгэх аргад тулгуурлан янз бүрийн хэрэгсэл ашиглан хөгжмийн энгийн зэмсэг бүтээдэг болно. 3.3.б Өөрийн бүтээсэн хөгжмийн энгийн зэмсгээ ашиглан янз бүрийн хэмнэлийн зохиомж хийж хөгжимддөг болно. 3.3.в Өөрийн зохиосон хэмнэлээ (энгийн, догол- синкоп зэрэг....) зураглал болон хөдөлгөөнөөр илэрхийлдэг болно.	4.3а. Хөгжмийн бүтээлийн аялгууны шинж төрх, давталт ялгарамжийн өөрчлөлтийг илэрхийлэн зурагладаг болно. 4.3б. Өгөгдсөн хэмнэл, аялгууг канон болон хөөцөл хэлбэрт хөгжүүлдэг болно. 4.3в. Янз бүрийн дижитал хэрэгсэл, ашиглан хялбар дуу аялгуу зохиомжилдог.	5.3а. Тодорхой сэдэв, дүрд тохирох хөгжмийн зохиолын сонголт хийж, дижитал хэрэгслээр баяжуулдаг болно. 5.3б. Өөрийн сайн мэдэх дуу, аялгууг янз бүрийн хэрэгсэл ашиглан баяжуулан зохиомжилдог болно. 5.3в. Өөрийн болон бусад улс үндэстний хөгжмийн бүтээлээс төрсөн сэтгэгдэл, мэдрэмжээ янз бүрийн аргаар зохиомжилдог болно.

ГУРАВ. АРГА ЗҮЙ, ОРЧИН

3.1. Арга зүй

Бага боловсролын хөгжмийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд суралцагч нь мэдээллийг шууд хүлээн авагч бус, харин өөрийн өмнөх мэдлэг, туршлага дээр үндэслэн шинэ мэдлэгээ идэвхтэйгээр өөрөө бүтээдэг гэж үздэг суралцахуйн конструктивизмын онолд тулгуурлана.

Хөгжмийн боловсрол нь хүүхдийн танин мэдэхүй, сэтгэл хөдлөл, нийгмийн цогц хөгжлийн нэн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хүний дотоод, гадаад ертөнцийн гоо сайхныг мэдрүүлэх, урлаг (*бүжиг, жүжиг, хөгжим, дүрслэх болон медиа урлаг*) - аар дамжуулан мэдрэмж, санаа, туршлагаа илэрхийлэх, дэлхийн болон үндэсний соёлын онцлог, ялгаа, үнэ цэнийг ойлгох, хөгжүүлэх, өвлөн тээх, хуваалцах, дамжуулах боломжийг суралцагчдад олгодог нийгэм болон соёлын ач холбогдолтой.

Суралцагчийн туршлагад тулгуурлан хөгжмийн мэдрэмж, уран сэтгэмжийг нэмэгдүүлэх, бусдыг сонсох, бие даан болон бусадтай хамтрах, хамт олны дунд биеэ авч явах, өөрийгөө илэрхийлэх зэрэг чадвараа бүтээлчээр хөгжүүлэхэд зохиолд суурилсан арга зүйг тохиромжтой гэж үзсэн.

Зохиолд суурилсан арга зүй нь хөгжмийн зохиолоор дамжуулан өмнөх туршлагаасаа суралцан шинэ ур чадвараа хөгжүүлэх, мэдрэмж, санаа бодол, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, сэтгэн бодох, үнэлэх чадварыг хөгжүүлэхэд чиглэдэг.

Хөгжмийн сургалт, үйл ажиллагаанд зохиолд суурилсан арга зүйг дараах алхмаар төлөвлөж, зохион байгуулна.

Алхам	Жишиг үйл ажиллагаа
Зохиолоо сонгох, төлөвлөх	<ul style="list-style-type: none"> - Сонсох хөгжмийн жагсаалт гаргах, янз бүрийн эх сурвалжаас мэдээлэл хайх; - Суралцагчдын сонирхол, хэрэгцээ, онцлогт тохирсон үйл явдал, агуулгатай; номын сан, цахим орчноос дэлгэрүүлэн үзэх, унших, сонсох боломжтой байхаар сонгох; - Багаар ажиллуулах тохиолдолд гишүүдийн үүргийг тодорхойлох, танилцуулах;
Сонсож ойлгох	<ul style="list-style-type: none"> - Бие даан эсвэл хамтран ажиллах, бие биеэсээ асуулт асуух, хариулах нөхцөлийг бүрдүүлэх; - Хөгжмийн зохиолыг сонсоод хэмнэл, өнгө аяс, хурд, хүч, аялгууны шинж төрхийг мэдэрч тодорхойлох, эргэцүүлэх; - Хөгжмөөс хамгийн чухал гэж бодсон хэсгийг тэмдэглэх;
Идэвхтэй оролцох, хэлэлцэх	<ul style="list-style-type: none"> - Тухайн уран бүтээлийн гол санаа, үг хэллэг, дүр, үйл явдал, сэдвийн талаар хосоор, бүлгээр хэлэлцэх; - Гол дүрүүд болон үйл явдлуудыг хөгжмийн элементүүдтэй холбуулж санаа бодлыг нь сонсох, бусадтай хуваалцах; - Суралцагчдыг ажиглах, дэмжих, өөрийнхөөрөө, нээлттэй ярих боломж олгох; - Өөрийн мэдрэмж, сэтгэгдлээ бусдынхтай харьцуулах, янз бүрийн аргаар илэрхийлэх;
Бүтээлчээр илэрхийлэх, дүгнэх	<ul style="list-style-type: none"> - Хөгжмийн бүтээлийг тайлбарлах, агуулга утга санааг зураг, график, хүснэгт, бүдүүвчээр илэрхийлэх; - Хэсэг тус бүр дээр сурагчдаар хөдөлгөөн, дуу хоолой эсвэл зэмсгээр илэрхийлэл хийлгэх; - “Энэ дүрийн зан төлөвийг өөр зохиолын дүртэй харьцуулаарай”, “Яагаад зохиолч ийм хэмнэл, эгшгийг хэрэглэсэн гэж бодож байна вэ?” зэрэг асуултад хариулах, хэлэлцэх; - Эргэцүүлэлдээ тулгуурлан үнэлэх, “Хэрэв чи зохиолч байсан бол төгсгөлийг хэрхэн өөрчлөх вэ?” зэргээр өөрсдөөр нь үргэлжлүүлэн хэмнэл, аялгуу зохиолгох, шинэ хэсэг нэмүүлэх;

Мөн судлагдахууны онцлогтой сонсголын ажиглалтын, сонсголын сорилын, харьцуулсан сонсолтын, хараа сонсгол хөдөлгөөнийг нэгтгэх, дүрд тоглох, зурган мэдээллийн, асуултаар хөтлөх, ялгаатай суралцахуйн аргыг зохиолд суурилсан арга зүйтэй хослуулан хэрэглэнэ.

Бага насны суралцагчдын үйлийн явцад тодорхой сурах арга барилыг эзэмшдэг онцлогийг харгалзан сонсголын ажиглалтын аргыг голлон ашиглана. Сонсголын ажиглалтын арга нь сурагчийн сонсох, ойлгох, ялгах, мэдрэх чадварыг

хөгжүүлэх ба тэдний хөгжмийн сонирхол, авьяас, чадвар харилцан адилгүй тул ялгаатай байдлыг харгалзан зохион байгуулна.Тухайлбал,

- Хөгжмийн хэмнэл, өнгө аяс, хурд, хүч, эгшиг аялгууны дуугаралт зэргийг сонсож ялгах, онцлогийг өөрийн үгээр тайлбарлаж, задлан шинжлэх;
- Өөрийн мэдрэмжээр хөгжмийг ойлгох, хариу үйлдэл үзүүлэх буюу төрсөн мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлэн дуулах, бүжиглэх, хөгжимдөх, зурах зэрэг үйлээр илэрхийлэх;
- Нэгдсэн том, жижиг бүлгүүд, ганцаарчилсан, холимог бүлэг зэргээр хичээлийн явцад ялгаатай хэлбэрийг хэрэглэх;

3.2. Сургалтын орчин

Хөгжмийн сургалтын орчин нь суралцагчдад дуулах, хөгжимдөх, бүжиглэх орон зайг олгосон, харилцан ярилцах, бие даан болон хамтаар гүйцэтгэх боломжийг дэмжсэн, хөгжмийг өдөр тутамдаа хэрэглэх нөхцөлийг бүрдүүлсэн байхыг чухалчилна. Тухайлбал; хөгжмийн бүтээлийг сонсоод хөдөлгөөнөөр илэрхийлэх, дүрд тоглох, хөгжим тоглох орчин, анги танхимыг бүрдүүлэх нь суралцагчийн идэвх оролцоо, урам зоригийг нэмэгдүүлж, хөгжмийн мэдлэгээ хэрэглэхэд нь дэмжлэг болно. Иймээс суралцагчийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, сонирхолд нийцсэн сургалтын олон арга хэлбэрээр зохион байгуулахад тохиромжтой, эерэг таатай уур амьсгал бүхий эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлнэ. Үүнд:

Эерэг таатай уур амьсгал бүхий харилцаа:

- Багш суралцагчдаа, суралцагч бие биедээ урам зориг өгдөг, хүндэтгэдэг, тууштай, тэвчээртэй байдлыг дэмждэг;
- Хөгжмийн үйл ажиллагааг сонирхож, хөгжилтэй тоглоом, хөгжимт хөдөлгөөнд идэвхтэй оролцдог;
- Суралцагчийн тууштай байдал, оролцоо, гүйцэтгэлийг дэмжиж, амжилтыг урамшуулдаг;
- Багш суралцагч, эцэг эхийн хамтын ажиллагааг дэмждэг;
- Ангийн найз нөхөдтэйгөө урлаг, соёлын үйл ажиллагаанд оролцохдоо эвтэй, нөхөрсгөөр хамтарч харилцдаг;
- Санаа бодлоо илэрхийлэхдээ нээлттэй, бусдын шүүмжлэлийг эергээр хүлээн авч алдаагаа засаж сайжруулдаг;

Эрүүл, аюулгүй, хүртээмжтэй анги танхим:

- Сонсох, дуулах, хөгжимдөх, бүжиглэх бүтээлч үйл ажиллагааг дэмжсэн, эрүүл ахуйн шаардлага хангасан зэмсэг, хэрэгсэл ашиглах;
- Суралцагч хөгжимт хөдөлгөөн хийх, дуулж, хөгжимдөж бие биетэйгээ харилцах боломжтой, уян хатан зохион байгуулалт (сандаг, ширээ, гэрэлтүүлэг, дуу чимээ намсгагч) бүхий анги танхимтай байх;
- Суралцагч бүрд хүрэлцэхүйц хүртээмжтэй хөгжмийн зэмсэг, хэрэглэгдэхүүнтэй байх;

- Сургалтын интерактив, дижитал хэрэглэгдэхүүн ашиглах боломжтой байх;

Ялгаатай байдлыг дэмжсэн, ялгаатай хэрэгцээг хангасан орчин:

- Суралцагчдын суралцах хэв маягийг (хараа, сонсгол, хөдөлгөөн) харгалзсан зураг, бүдүүвч, өнгө ялгаралттай материал, аудио, интерактив хичээл, практик туршилт, хөдөлгөөнт тоглоом ашиглах боломжтой байх;
- Хэл, соёлын ялгаатай суралцагчдад зориулсан сургалтын болон бусад толь бичигтэй байх;
- Суралцахуйн хоцрогдолтой болон илүү хурдтай суралцагчдад зориулсан ялгаатай даалгаврын сантай байх;

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

4.1. Үнэлгээний зорилго

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, төлөвшлийн давуу болон сул талыг илрүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг дэмжих, ахиц дэвшлийг урамшуулах, хүрсэн түвшнийг үнэлэхэд чиглэнэ.

Бага боловсролын эхлэл шатанд суралцагчийн үнэлгээ нь хөгжим сонсох, дуулах, хөгжимдөх, бүжиглэх, зохион найруулах чадварын ахиц, гүйцэтгэлийг илрүүлэх, суралцах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Бага боловсролын төгсгөл шатанд суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварын давуу болон сул талыг илрүүлэх, суралцахуйн үр дүнг үнэлж, дүгнэхэд чиглэнэ.

4.2. Үнэлгээний шалгуур

Хүрэх үр дүн	Шалгуур
Хөгжмийн хэлний үндсэн ухагдахууныг ойлгож хэрэглэдэг болно.	<ul style="list-style-type: none"> - Хөгжмийн үг хэллэг, тэмдэг, тэмдэглэгээг таньж, ойлгодог, зураглаж тайлбарладаг. - Хөгжмийн үг хэллэг, тэмдэг, тэмдэглэгээг ойлгож, хөгжимдөх, дуулах, бүжиглэх, зохион найруулахдаа бүтээлчээр хэрэглэдэг.
Хөгжим сонсох, дуулах, хөгжимдөх, бүжиглэх чадвартай болно.	<ul style="list-style-type: none"> - Хөгжмийн уран бүтээлийг сонсоод, төрсөн мэдрэмж санаагаа дуулж, бүжиглэж, хөгжимдөж илэрхийлдэг. - Өөрийн бүтээлээ бусадтай хуваалцдаг, гүйцэтгэж харуулдаг. - Хөгжимдөх, дуулах, бүжиглэхдээ зааврыг дагаж мөрддөг - Хөгжмийн хэлний хэрэглүүрийг ашиглан бишгүүр, пианика, хөгжмийн энгийн зэмсэгт ноотоор хөгжимддөг.
Хөгжмөөс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ эх хэлээрээ бүтээлчээр илэрхийлдэг болно.	<ul style="list-style-type: none"> - Хөгжмийн тэмдэг, тэмдэглэгээг ашиглан төрөл бүрийн хэрэгслээр дуу авианы зохиомж хийдэг. - Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрх, өнгө аясын өөрчлөлт, онцлогийг мэдэрч зурагладаг, дүрээр, үгээр, хөдөлгөөнөөр илэрхийлдэг. - Тодорхой сэдэв, дүрд тохирох хөгжмийн сонголт хийж, хөдөлгөөн хийж чаддаг.

	<ul style="list-style-type: none"> - Хөгжмийн бүтээлийг сонсоод төрсөн сэтгэгдэл, мэдрэмжээр хувилбар гаргахыг оролддог. - Хөгжмийн бүтээлийг сонсоод утга санааг баяжуулан дүрд хувирч жүжигчлэн тоглодог.
<p>Бие дааж болон хамтран суралцдаг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Өөрийн болон бусдын бүтээлтэй танилцаж, бусдыг анхааралтай сонсож, дэмжлэг үзүүлдэг. - Өөрийн болон бусдын бүтээлийг өөрчлөх санаа гаргаж, сайжруулдаг. - Санаа бодлоо нээлттэй хуваалцдаг, бусдын бүтээлийг хүндэлж байгаагаа илэрхийлдэг. - Дуулах, хөгжимдөх, бүжиглэхдээ бусадтай эвтэй найрсаг харилцдаг. - Бусдын ялгаатай байдалд хүндэтгэлтэй ханддаг, бусдад санаа тавьдаг, талархдаг. - Уран бүтээлийн талаарх хэлэлцүүлэг, үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог.

БИЕИЙН ТАМИР

НЭГ. ЗОРИЛГО

1.1. Зорилго

Суралцагчийн хөдөлгөөнт тоглоом, дасгалаар бие бялдраа хөгжүүлэх суурь чадамж, бүтээлчээр сэтгэх, харилцах, хамтрах, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх ерөнхий чадамжийг хөгжүүлнэ.

1.2. Хүрэх үр дүн, шатлал

Энэхүү хөтөлбөрийг судалснаар суралцагчид дараах ерөнхий үр дүнд хүрсэн байна.

- Биеийн тамирын үг, хэллэг, нэршлийг эх хэлээрээ ойлгож харилцдаг, дасгал хөдөлгөөний ач холбогдлыг танин мэдэх, энгийн дасгал хөдөлгөөнийг бие даан болон хамтаараа гүйцэтгэдэг болно.
- Эзэмшсэн чадвараа ашиглаж хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, идэвхтэй хөдөлгөөн, өөрт тохирсон дасгалаар тогтмол хичээллэдэг болно.
- Спортын төрлүүдийн энгийн техникээс суралцах, бүтээлчээр сэтгэж багаар хамтран тоглох, бусадтай хүндэтгэлтэй харилцдаг, дасгалын видео бичлэгийг ашиглах чадвартай болно.
- Тоглох, дасгал хөдөлгөөнийг гүйцэтгэхдээ дүрмийг баримтлан мөрддөг болно.

№	Хүрэх үр дүн	Шатлал	
		I-II анги	Төгсгөл шат (III-V анги)
1	Биеийн тамирын үг, хэллэг, нэршлийг эх хэлээрээ ойлгож харилцдаг, дасгал хөдөлгөөний ач холбогдлыг танин мэдэх, энгийн дасгал хөдөлгөөнийг бие даан болон хамтаараа гүйцэтгэдэг болно.	<ul style="list-style-type: none"> - Биеийн тамирын үг хэллэг, нэршлийг ойлгож, нэрлэдэг болно. - Дасгал хөдөлгөөний ач холбогдлыг ойлгодог болно. - Хөдөлгөөний үйлдлийг зааврын (техникийн) дагуу дуурайж ба дэмжлэгтэйгээр гүйцэтгэдэг болно. - Дасгалыг зохих хурд, хүч, далайцаар нь гүйцэтгэдэг болно. - Дасгалыг хосоор, багаар, хамтран гүйцэтгэдэг болно. -Бие бялдрын бэлтгэлжилтийн үзүүлэлтээ ахиулдаг болно. 	<ul style="list-style-type: none"> - Биеийн тамирын үг хэллэгээр ярилцах, нэршлийг бусдад тайлбарлан, хэрэглэдэг болно. - Дасгал, хөдөлгөөний ач холбогдлыг ойлгон, бусдад тайлбарладаг болно. -Хөдөлгөөний үйлдлийг зааврын (техникийн) дагуу дэмжлэгтэй ба бие даан гүйцэтгэдэг болно. - Дасгал хөдөлгөөнд тохирсон хурд, хүч, далайцаар нь, тодорхой хугацаанд тэсвэртэй гүйцэтгэдэг болно. - Хамтаараа дасгал хийхдээ өөрийн үүргийг ойлгон, үр дүнтэй хамтран ажиллах, шийдвэр гаргах чадвартай болно. - Бие бялдрын бэлтгэлжилтийн үзүүлэлтээ ахиулдаг болно.
2	Эзэмшсэн чадвараа ашиглаж хөдөлгөөний дутагдлаас	- Эзэмшсэн хөдөлгөөний чадвараа тоглоомд болон	- Өөрийн хэрэгцээнд тохирсон цогц дасгалуудыг өдөр бүр хийдэг болно.

	сэргийлэх, идэвхтэй хөдөлгөөн, дасгалаар тогтмол хичээллэдэг болно.	өдөр тутамдаа хэрэглэдэг болно. - Дасгал, тоглоомын өмнө ба дараах хувийн ариун цэврийг баримтлах энгийн үйлдлүүдийг гүйцэтгэдэг болно.	- Эрүүл ахуйн дэглэмийг бие даан баримтлахаас гадна, дасгалын үед аюулгүй байдлаа хангадаг болно.
3	Спортын төрлүүдийн энгийн техникээс суралцах, бүтээлчээр сэтгэж багаар хамтран тоглох, бусадтай хүндэтгэлтэй харилцдаг болно.	- Жижиг болон дунд зэргийн хэмжээтэй бөмбөгийг шиддэг, дамжуулдаг болно. - Дасгал, хөдөлгөөн, тоглоомын оновчтой арга, хувилбар сонгодог, 1-2 нэмэлт хөдөлгөөнөөр баяжуулан гүйцэтгэдэг болно. - Хосоороо болон хамтаараа дасгал, хөдөлгөөн гүйцэтгэхдээ бусад сурагчийн хөдөлгөөний чадварын ялгаатай байдлыг ойлгож хүндэтгэдэг болно. - Дасгал, тоглоомын явцад санал гаргах, эелдэг үг хэрэглэх, ялалт, ялагдлыг тайван хүлээж авах, сэтгэл хөдлөлөө эергээр илэрхийлэх чадвартай болно.	- Дасгалыг бие даан хийх, багаар, ангиараа хамтран оновчтой гүйцэтгэдэг болно. - Дасгал, тоглоомд тохирох арга, хувилбарыг сонгож, өөрсдийн санаачилсан 3-4 нэмэлт хөдөлгөөнөөр баяжуулан гүйцэтгэдэг, дасгал, тоглоомыг сайжруулах шинэ санаа, гаргах, бүтээлчээр сэтгэдэг болно. - Ойрын ба дундын зайд гүйх, гүйлтээс харайх, гүйлтээс жижиг бөмбөг шидэх: акробатикийн эвлүүлэг гүйцэтгэх: сагсан бөмбөгийг залах, дамжуулах, шидэх; волейболын бөмбөгийг тор давуулан дамжуулах; хөл бөмбөгийг өшиглөх, тогтоодог болно.
4	Тоглох, дасгал хөдөлгөөнийг гүйцэтгэхдээ дүрмийг баримтлан, мөрддөг болно.	- Хөдөлгөөнт болон хөгжөөнт (Хөгжилтэй буухиа, Чоно тарвага, Мэргэн буудагч, Цагаан тэмээцэх, Хол харайгч, Ууттай харайлт бусад.....) тоглоомын дүрмийн дагуу өөрийн үүргийг гүйцэтгэж, шударгаар өрсөлдөн тоглодог болно. - Энгийн дасгалын гүйцэтгэлд тавигдах шаардлагыг баримтлан мөрддөг болно.	- Багаараа тоглох тоглоомын дүрмийг баримтлан, шударгаар өрсөлдөн тоглодог болно. - Дасгалын техникийг гүйцэтгэх дүрмийг баримтлан хэрэгжүүлдэг болно.

ХОЁР. АГУУЛГА

2.1.Бага боловсролын эхлэл шатлал

Агуулгын ай 1. Хөдөлгөөн

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Алхах, гүйх	1.1а. Биеийн зөв галбираа хадгалан, янз бүрийн хувилбараар алхана.	2.1а. Алхааны хувилбаруудыг хослуулан, хурд ба чиглэлээ өөрчлөн алхана.
	1.1б. Биеийн байрлал, гар, хөлийн хөдөлгөөнийг зохистой хослуулан, 20 м хүртэлх зайд хурдтай гүйх; алхаа, гүйлтийг хослуулан 300 м зайг туулж, тэсвэрээ харуулна.	2.1б. Чиглэлээ өөрчлөх болон чигээрээ 25 м зайд хурдтай гүйх; алхаа, гүйлтийг хослуулан 400 м зайг туулж, тэсвэрээ харуулна.
Үсрэх, харайх	1.2а. Байрандаа болон шилжиж үсрэх, хол харайхдаа савах, түлхэх, буух хөдөлгөөнийг хослуулан гүйцэтгэнэ.	2.2а. Дээс, резин, тавцанд үсэрч тоглохдоо нэг ба хоёр хөлөөр түлхэх чадвараа ашиглана.
	1.2б. Байрнаас уртад болон жижиг саадыг даван харайж харуулна.	2.2б. Байрнаас уртад харайх чадвараа хөгжүүлэх, 4-5 алхам гүйлтээс жижиг саадыг даван харайж харуулна.
Өнхрөх, авирах, мөлхөх	1.3а. Эвхрэлт хөрвөлтийн дасгалыг бие даан гүйцэтгэнэ.	2.3а. Урагш, арагш өнхрөлтийг бие даан гүйцэтгэнэ.
	1.3б. Энгийн аргуудаар авирч, мөлхөнө.	2.3б. Авирах, мөлхөхийг хослуулан гүйцэтгэнэ.
Шидэх, дамжуулах	1.4а. Дунд зэргийн хэмжээтэй бөмбөгийг хоёр гараар барих, шидэх, өнхрүүлэх аргыг хэрэглэн, 1-2 м зайд дамжуулах, 3-4 м зайнаас байг онож харуулна.	2.4а. Дунд зэргийн хэмжээтэй бөмбөгийг алхалтаас шулуун ба шаланд ойлгон 2-3 м зайд оновчтой дамжуулах, 4-5 м зайнаас байг онож харуулна.
	1.4б. Том, жижиг бөмбөгийг байрнаасаа нэг ба хоёр гараар хол шидэж харуулна.	2.4б. Жижиг бөмбөгийг алхалтаас нэг гараар хол шидэж харуулна.

Агуулгын ай 2. Бие бялдрын хөгжил

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Бие бялдрын хөгжил,	1.5а. Өөрийн бие бялдрын хөгжил, бэлтгэлжилтийн түвшнийгээ ахиулна.	2.5а. Бие бялдрын хөгжил, бэлтгэлжилтийн түвшнийгээ бусдын тусламжтайгаар тогтоож, ахиц өөрчлөлтийг тооцно.

бэлтгэлжилт	1.5б. Гар, хөл, их биеийн үндсэн болон хослуулсан хөдөлгөөнийг ашиглан, өглөөний цогц дасгалыг бие даан гүйцэтгэнэ.	2.5б. Өглөөний болон хичээлийн завсарлагааны цогц дасгалыг үндсэн, завсрын, бусад хөдөлгөөнөөр баяжуулан, хэрэгсэлгүй ба бөмбөг, саваатай гүйцэтгэнэ.
	1.5в. Нэг ба хоёр эгнээ, цуваа жагсаалыг үүсгэж, тоглох, дасгал гүйцэтгэхдээ эгнээ, цуваагаар жагсаж харуулна.	2.5в. Баг, бүлгийн үйл ажиллагаанд оролцохдоо нэгээс гурван эгнээнд шилжинэ.
	1.5г. Өөрийн биеийн жингээр гүйцэтгэх болон тулалтын дасгалаар булчингийн хүчийг сунгалтын ба савалтын идэвхтэй дасгалаар уян хатны чадавхаа харуулна.	2.5г. Хоёр гараар дүүжигнэх болон өөрийн биеийн жин, 400-500 г хүндрүүлэгч ашигласан дасгалаар булчингийн хүчийг сунгалтын ба савалтын идэвхгүй дасгалаар уян хатны чадавхын өөрчлөлтөө тодорхойлно.
	1.5д. Биеийн тамирын хувцсаа өмсөх, хадгалахдаа эрүүл ахуйн шаардлагыг баримтлах. Дасгал, тоглоомын үеийн аюултай, аюулгүй нөхцөлийг ялгаж тайлбарлана.	2.5д. Өөрийн биеийн жинд тохируулан усыг зөв зохистой ууж хэвшинэ. Дасгал, тоглоомын үед багшийн зааварчилгаа, дүрмийг баримтална.
Үндэсний болон хөлөгт тоглоом	1.6а. Бог, бод малын шагайг ашиглаж, ойрхон зайнаас долоовор хуруугаар няслан тоглож сурснаа харуулна.	2.6а. Дунд, долоовор хуруугаар шагайг няслах аргыг ашиглан, багаар тоглож, тоглоомын дүрмийг хэрэгжүүлнэ.
	1.6б. Шагайг няслах үйлдлийг орон зай, хараа, сунгалтын, дасгалтай хослуулан гүйцэтгэнэ.	2.6б. Босоо, суугаа, хэвтээ зэрэг байрлалаас шагайг няслан, хөдөлгөөнийг эвслээ харуулна.
	1.6в. Хөлөг дээр хүүг өрөх, нүүх, идэх, даам гарах аргуудтай танилцаж, эдгээр дүрмийн дагуу тоглодог болно.	2.6в. Даамын онцлог дүрмийг ойлгох, 1-2 нүүдлийн бодлого бодож, ангийн хэмжээний даамын тэмцээнд оролцдог болно.

2.2.Бага боловсролын төгсгөл шатлал

Агуулгын ай 1. Хөдөлгөөн

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Алхах, гүйх	3.1а. Янз бүрийн дохиогоор, олон байрлалаас, чигээрээ ба чиглэлээ өөрчлөн гүйж харуулна.	4.1а. Тулж тонгойсон байдлаас гарч 40 м зайд зөв бөгөөд хурдтай; 10-15 м зайд	5.1а. Спорт алхааны техникийг дуурайн, 300 м зайг спорт алхаагаар туулна.

		чиглэл ба хурдаа огцом өөрчлөн гүйж харуулна.	
	3.1б. Босоо гараанаас 30 м зайд хурдтай гүйх; алхаа, гүйлтийг хослуулан 500 м зайг туулж, тэсвэрээ харуулна.	4.1б. Босоо гараанаас алхаа, гүйлтийг хослуулан 600 м зайг туулж тэсвэрээ хөгжүүлнэ.	5.1б. Тулж тонгойсон байдлаас гарч 50 м зайд хурдтай гүйх чадвараа харуулна. 5.1в. Босоо гараанаас 700-800 м зайд жигд хурдаар гүйж тэсвэрээ харуулна.
Үсрэх, харайх	3.2а. Өндөр саадыг давж харайхдаа гүйлтээс нэг хөлөөр түлхэх, нөгөө хөлөө савах чадвараа ашиглана.	4.2а. Нэг хөлийн түлхэлт, нөгөө хөлийн савалтаар өндөрт үсрэх; 8-10 м зайнаас гүйж, 50-60 см саадыг даван харайж харуулна.	5.2а. 9-10 м гүйлтээс нэг хөлөөр түлхэн, 60-70 см саадыг даван харайж харуулна.
	3.2б. Байрнаас уртад ба 8-10 м зайнаас гүйж нэг хөлөөр түлхэн, гүйлтээс уртад хол харайна.	4.2б. Байрнаас уртад ба 10-12 м гүйлтээс уртад хол харайх чадвараа хөгжүүлнэ.	5.2б. Байрнаас уртад ба 12-14 м гүйлтээс уртад хол харайх чадвараа хөгжүүлнэ.
Өнхрөх, авирах, мөлхөх	3.3а. Урагш, арагш ба үсрэлттэй өнхрөлтийг хослуулан гүйцэтгэнэ.	4.3а. Өнхрөлтийг хосоор болон багаар гүйцэтгэнэ.	5.3а. Акробатикийн эвлүүлэг гүйцэтгэж харуулна.
	3.3б. Гурван цэгийн зогсолт, далан дээр зогсолтыг бие даан гүйцэтгэнэ.	4.3б. Гар дээр зогсолт, цагариг эргэлтийг гүйцэтгэнэ.	5.3б. Багаараа овоолго бүтээж харуулна.
Шидэх, дамжуулах	3.4а. Янз бүрийн хэрэгслийг (бөмбөг, цагариг, саваа, тавганцар зэрэг) шидэж ба дамжуулж тоглохдоо тохирох аргыг сонгож, байг ононо.	4.4а. Сагс, волейбол, хөл бөмбөгөөр тоглохдоо дамжуулахад тохиромжтой аргыг сонгож, оновчтой дамжуулна.	5.4а. Сагсан бөмбөгийг залах, дамжуулах, шидэх; волейболын бөмбөгийг тор давуулан дамжуулах; хөл бөмбөгийг өшиглөх, тогтоох аргуудыг ашиглан багаараа тоглоно.
	3.4б. Гүйлтээс янз бүрийн хэрэгслийг хол шидэж харуулна.	4.4б. Гүйлтээс янз бүрийн хэрэгслийг хол шидэж хүчээ хөгжүүлнэ.	5.4б. Гүйлтээс жижиг бөмбөгийг хол шидэж хүчээ хөгжүүлнэ.

Агуулгын ай 2. Бие бялдрын хөгжил

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Бие бялдрын хөгжил, бэлтгэлжилт	3.5а. Бие бялдрын хөгжил, бэлтгэлжилтээ тогтоож, амжилтаа	4.5а. Бие бялдрын хөгжил, бэлтгэлжилтийн үзүүлэлтээ	5.5а. Өөрийн бие бялдрын хөгжил, бэлтгэлжилтийн үзүүлэлтээ харьцуулан,

	ахиулах цогц дасгалыг багшийн тусламжтай боловсруулан хэрэгжүүлнэ.	харьцуулан, өөрчлөлтийг тодорхойлж, түвшин ахиулах цогц дасгалыг багштай хамтран боловсруулж, хэрэгжүүлнэ.	өөрчлөлтийг тодорхойлж, үнэлнэ.
	3.5б. Биеийн галбир засах болон ерөнхий хөгжлийн дасгалыг богино дээс, саваа ашиглан гүйцэтгэнэ.	4.5б. Биеийн ерөнхий хөгжлийн цогц дасгалыг цацаг, алчууртай багаараа хөгжмийн аянд хийж гүйцэтгэнэ.	5.5б. Янз бүрийн хэрэгсэлтэй, хэрэгсэлгүй цогц дасгалыг нэмэлт хөдөлгөөнөөр баяжуулан, анги, багаараа хөгжмийн аянд хийж, үзүүлэх тоглолтод оролцоно.
	3.5в. Аливаа үйл ажиллагаанд оролцохдоо удирдагчийн командаар жагсаалтын хувиралтыг хамтран гүйцэтгэнэ.(нэгээс хоёр цуваанд жагсах, нэгээс гурван эгнээнд шилжих)	4.5в. Анги болон багаараа жагсаалын хувиралтыг шаардлагын дагуу гүйцэтгэж харуулна. (алхалт дундаа эргэх, цуваа жагсаалд мөр түрүүлж алхах)	5.5в. Биеийн тамирын хичээл, үзүүлэх тоглолтод оролцохдоо жагсаалыг янз бүрээр хувиргах чадвараа ашиглаж харуулна.
	3.5г. Янз бүрээр дүүжигнэх, тулах болон 700-800 г хүндрүүлэгчтэй дасгалыг гүйцэтгэхдээ аюулгүй байдлаа хангаж, булчингийн хүчээ; бие биедээ туслан, хосоороо гүйцэтгэх сунгалтын дасгалаар уян хатнаа хөгжүүлнэ.	4.5г. Нэг гараар дүүжигнэх, тулах болон хосоороо гүйцэтгэх дасгалаар булчингийн хүч, уян хатнаа хөгжүүлнэ.	5.5г. Тулалт, дүүжигнэлт болон хэрэгсэлгүй, 800-1000 г хүндрүүлэгчтэй дасгалыг хосоороо гүйцэтгэж булчингийн хүчээ, сунгалт, савалтын дасгалаар уян хатны чадавхаа харуулна.
	3.5д. Хөдөлгөөнгүй байрлалд тэнцвэрээ хадгалах дасгал, тоглоомоор тэнцвэрийн чадавхаа хөгжүүлнэ.	4.5д. Хөдөлгөөнтэй, хөдөлгөөнгүй байрлалд тэнцвэрээ хадгалах дасгал, тоглоомоор тэнцвэрийн чадавхаа хөгжүүлнэ.	5.5д. Хөдөлгөөнтэй, хөдөлгөөнгүй байрлалд тэнцвэрээ хадгалах чадвараа харуулна.
	3.5е. Дасгалаар хичээллэхдээ хоол хүнсийг зохистой хэрэглэх, өглөөний цайг тогтмол уухын	4.5е. Дасгалын үед үүсэж болзошгүй эрсдэл, хүндрэлийг ялган таньж, урьдчилан сэргийлнэ.	5.5е. Өөрийн бие бялдарт тохирсон дасгалыг өдрийн дэглэмдээ оруулж, хэрэгжүүлнэ. Хичээлийн бус цагаар

	ач холбогдлыг тайлбарлана.		дасгал хийх, тоглохдоо аюулгүй байдлаа хангана.
Үндэсний болон хөлөгт тоглоом	3.6а. Багаараа, янз бүрийн зайнаас шагай нясалж тоглохдоо шагайг эрхий хуруугаар татаж няслах болон бусад аргыг ашиглана.	4.6а. Шагай шүүрч тоглохдоо дүрмийг тайлбарлан, хэрэгжүүлнэ.	5.6а. Зайг хэмжих монгол хэмжигдэхүүнийг сантиметрт дүйцүүлэн хэрэглэж, шагай харвах, шүүрэх, няслах чадвараа харуулна.
	3.6б. Биеийн тэнцвэр, хөдөлгөөний эвсэл, уян чадавхаа хөгжүүлэхдээ шагайт дасгалыг ашиглана.	4.6б. Шагайт дасгалын хувилбараас сонгож, шагайт тоглоомыг баяжуулан зохиомжилж, хамтран гүйцэтгэнэ.	5.6б. Чөлөөт цагаараа найз нөхөд, гэр бүлийн хүрээнд шагайн тоглоомоор хамтран тоглож, шагайт дасгалыг баяжуулан гүйцэтгэж бие бялдраа хөгжүүлнэ.
	3.6в. Шатрын хөлөг, дүрстэй танилцаж, нүүдлийн үндсэн дүрмийг мэддэг болно.	4.6в. Шатар тоглохдоо тактикийн энгийн аргуудыг ашигладаг болно.	5.6в Шатрын 1-2 бодлогыг бодож, хосоороо болон бие даан тоглодог болно.

ГУРАВ. АРГА ЗҮЙ, ОРЧИН,

3.1. Арга зүй

Бага боловсролын биеийн тамирын сургалтын хөтөлбөрийг нь үндсэн хөдөлгөөний чадвар эзэмшүүлэх болон тоглоомд суурилсан арга зүйг хослуулан ашиглах байдлаар хэрэгжүүлнэ.

Үндсэн хөдөлгөөний чадвар эзэмшүүлэх арга зүй нь дараах алхмуудтай байна.

Алхам	Жишиг үйл ажиллагаа
Таних, ойлгох	<ul style="list-style-type: none"> - Хөдөлгөөнийг ажиглуулах, суралцагчийн тайлбарыг сонсох, асуух, ярилцах; - Дасгалыг бүрдүүлж буй хөдөлгөөний үйлдлүүдийг нэрлүүлэх, хөдөлгөөний холбоосыг тодруулж асуух; - Хөдөлгөөний үйлдлийг төсөөлөн бодуулах; - Төсөөлөн бодсон үйлдлийг нь удаавтар хөдөлгөөнөөр хийлгэх;
Гүйцэтгэх	<ul style="list-style-type: none"> - Хөдөлгөөний үйлдлийг зааврын (техникийн) дагуу дуурайлган давтуулах; - Бусдын дэмжлэгтэйгээр болон баримжаалах зүйлсийг ашиглан хөдөлгөөний үйлдлийг давтуулах; - Дасгалыг зохих хурд, хүч, далайцаар нь давтах; - Дасгалын алдааг хэлэх, ярилцах, засаж гүйцэтгэх;

	<ul style="list-style-type: none"> - Сайн гүйцэтгэлийг урамшуулах, бусдад жишээ болгон харуулах; - Суралцагчийн чадварт тохируулан, хөдөлгөөний үйлдлийг хөнгөвчилж ба бага зэрэг хүндрүүлж давтах; - Дасгалыг гүйцэтгэх дүрмийг баримтлан давтах
Хэрэглэх, үнэлэх	<ul style="list-style-type: none"> - Дасгалыг танил бус нөхцөлд (өөр байрлалд, бэлтгэх байдлыг өөрчлөн, хамтрагчаа сольж) гүйцэтгүүлэх; - Дасгалыг нэмэлт хөдөлгөөнөөр баяжуулан гүйцэтгүүлэх; - Дасгалыг өндөр эрчимтэй давтах; - Хэд хэдэн хөдөлгөөний үйлдлийг дэс дараалуулан гүйцэтгэх; - Аюулгүй байдлаа хангаж, дасгалыг багаар, ангиараа хамтран оновчтой гүйцэтгэх; - Дасгалын гүйцэтгэлийг үнэлэх, тогтоосон тоо, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг үнэлж дүгнэх;

Тоглоомд суурилсан арга зүй

Тоглоомд суурилсан арга зүй нь суралцах идэвх оролцоог нэмэгдүүлж, шүүн тунгаах, хамтран ажиллах, харилцах, бүтээлчээр сэтгэх ур чадваруудыг хөгжүүлэхэд чиглэдэг. Тоглоомд суурилсан арга зүй нь дараах алхамтай байна.

Алхам	Жишиг үйл ажиллагаа
Тоглоомын дүрэмтэй танилцах	<ul style="list-style-type: none"> - Тоглоомд сэдэлжүүлэх, тоглоомын зорилготой танилцах; - Тоглох дүрмийг ярилцах, асууж тодруулах; - Тоглоомын үйлдлийг гүйцэтгэхдээ аюулгүй байдлаа анхаарах, дүрмийг заавал баримтлахыг ярилцах; - Тоглоомыг хэрхэн дүгнэхээ тодруулж, ярилцах;
Тоглох, гүйцэтгэх	<ul style="list-style-type: none"> - Алхах, гүйх; үсэрч харайх; шидэх, дамжуулах; өнхрөх, мөлхөх үйлдэл бүхий тоглоом тоглох; - Булчингийн хүч, хөдөлгөөний хурд, эвсэл, тэсвэр, тэнцвэр, уян хатан зэрэг чадавхуудыг хөгжүүлэх тоглоом тоглох; - Тоглоомын дүрмийг өөрсдийн онцлогт тохируулан өөрчлөх, баг удирдах, баг бүрдүүлэх, мөн шүүгчийн үүргийг гүйцэтгэх зэрэг бие даасан үүргийг идэвхтэй гүйцэтгэх;
Тоглоомыг дүгнэх	<ul style="list-style-type: none"> - Тоглогчид ба багийн гүйцэтгэлд үнэлгээ өгөх; - Тоглоомд төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлж ярилцах; - Тоглоомын ялагчдад янз бүрийн хэлбэрээр баяр хүргэх, урамшуулах; - Тоглоомоос сурсан зүйл, ялагдал хожигдлын шалтгааныг дүгнэж ярилцах;

3.2. Сургалтын орчин

Сургалтын орчин нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад нөлөөлөх гол хүчин зүйл юм. Сурагчийн хэрэгцээ,

сонирхолд нийцсэн сургалтын арга хэлбэрт тохирсон, эерэг таатай уур амьсгал бүхий эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх нь чухал байна. Иймд дараах орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Эерэг таатай уур амьсгал бүхий харилцаа:

- Суралцагч айхгүйгээр, бусдаас ичихгүйгээр дасгал гүйцэтгэдэг;
- Сонирхолтой, хөгжилтэй тоглодог;
- Бусдад болон өөртөө урам зориг өгдөг;
- Амжилтыг нь урамшуулдаг;
- Тууштай, тэвчээртэй байдал, хамтын ажиллагааг дэмждэг;

Эрүүл, аюулгүй, хүртээмжтэй анги танхим:

- Биеийн тамирын заал, талбай нь сурагч бүтээлчээр ажиллах, оролцоог дэмжсэн, хүртээмжтэй, хөдөлгөөнд ээлтэй;
- I, II ангид биеийн тамирын хичээлийг зохион байгуулах жижиг талбайтай, зориулалтын хэрэглэгдэхүүн, зөөлөн, халтирдаггүй дэвсгэр бүхий заал танхимтай;
- Биеийн тамирын заал, талбайн гэрэлтүүлэг, шал, агааржуулалт, ариун цэвэр нь эрүүл ахуйн болон аюулгүй байдлын шаардлага хангадаг;

Ялгаатай хэрэгцээг харгалзсан орчин:

- Хөдөлгөөний чадварын болон бие бялдрын хөгжлийн ялгаатай байдалд тохирсон;
- Хувь хүний хэрэгцээг харгалзсан;
- Суралцагч бүрд тохирсон;
- Суралцагчийн онцлогийг хүндэтгэсэн, тэгш оролцоог хангасан, уян хатан зохион байгуулалттай байх;

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

4.1. Үнэлгээний зорилго

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, төлөвшлийн давуу болон сул талыг илрүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг дэмжих, ахиц дэвшлийг урамшуулах, хүрсэн түвшнийг үнэлэхэд чиглэнэ.

Бага боловсролын эхлэл шатанд суралцагчийн үнэлгээ нь дасгал хөдөлгөөн хийх, хамтран ажиллах, бүтээлчээр сэтгэх чадварын ахиц, гүйцэтгэлийг илрүүлэх, суралцах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Бага боловсролын төгсгөл шатанд суралцагчийн спортын төрлүүдийн энгийн техникийг гүйцэтгэх, харилцах, хамтрах, бүтээлчээр сэтгэх чадварын давуу болон сул талыг илрүүлэх, амжилт, үр дүнг үнэлж, дүгнэхэд чиглэнэ.

4.2. Үнэлгээний шалгуур

Хүрэх үр дүн	Шалгуур
<p>Биеийн тамирын үг, хэллэг, нэршлийг эх хэлээрээ ойлгож харилцдаг, дасгал хөдөлгөөний ач холбогдлыг танин мэдэх, энгийн дасгал хөдөлгөөнийг бие даан болон хамтаараа гүйцэтгэдэг болно.</p>	<p>Биеийн тамирын үг хэллэг, нэршлийг ойлгож, бусдад тайлбарлан хэрэглэдэг.</p> <p>Дасгал хөдөлгөөний ач холбогдлыг мэдэж, зааврын дагуу хөдөлгөөнийг дэмжлэгтэй болон бие даан, тохирсон хурд, хүч, далайцтайгаар гүйцэтгэдэг.</p> <p>Бие бялдрын бэлтгэлжилтийн үзүүлэлтээ ахиулдаг.</p> <p>Хамтран дасгал хийхдээ өөрийн үүргийг ойлгож, шийдвэр гарган, үр дүнтэй хамтран ажилладаг.</p>
<p>Эзэмшсэн чадвараа ашиглаж хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, идэвхтэй хөдөлгөөн, дасгалаар тогтмол хичээллэдэг болно.</p>	<p>Дасгал, тоглоомд оновчтой арга, хувилбарыг сонгон ашиглаж, хөдөлгөөнийг баяжуулан гүйцэтгэдэг.</p> <p>Өөрт тохирсон цогц дасгалуудыг өдөр бүр тогтмол гүйцэтгэж, эрүүл ахуйн дэглэмийг баримталдаг.</p> <p>Дасгал, хөдөлгөөн тоглоомын үеийн аюулгүй байдлын 3 ба түүнээс дээш дүрмийг мэдэж, хэрэгжүүлдэг.</p>
<p>Спортын төрлүүдийн энгийн техникээс суралцах, бүтээлчээр сэтгэж багаар хамтран тоглох, бусадтай хүндэтгэлтэй харилцдаг болно.</p>	<p>Дасгалыг бие даан болон багаар, ангиараа хамтран оновчтой гүйцэтгэдэг.</p> <p>Дасгал, хөдөлгөөн, тоглоомын хувилбар зохион хийж үзүүлдэг.</p> <p>Сагсан бөмбөг, волейбол, хөл бөмбөгийг хялбаршуулсан дүрмээр тоглохдоо сэтгэл хөдлөлөө зөргөөр илэрхийлдэг, бусдын үйлдлийг хүндэтгэдэг.</p>
<p>Тоглох, дасгал хөдөлгөөнийг гүйцэтгэхдээ дүрмийг баримтлан, мөрддөг болно.</p>	<p>Хөдөлгөөнт тоглоомын дүрмийг баримталдаг.</p> <p>Дасгал бүрийн гүйцэтгэлд тавигдах шаардлагыг биелүүлэхийг хичээдэг.</p>

ЭРҮҮЛ МЭНД

НЭГ: ЗОРИЛГО

1.1. Зорилго

Суралцагчийн эрүүл амьдралын дадал, хэвшлийг төлөвшүүлэх суурь чадамж болон бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч зүй зохистой харилцах, хамтрах, тунгаан бодох, бүтээлчээр сэтгэх ерөнхий чадамжийг хөгжүүлнэ.

1.2. Хүрэх үр дүн, шатлал

Энэхүү хөтөлбөрийг судалснаар суралцагчид дараах ерөнхий үр дүнд хүрсэн байна.

- Биеийн өсөлт хөгжилд хооллолт, нойр, дасгал хөдөлгөөн чухлыг мэддэг, тайлбарладаг болно.
- Өдөр тутамдаа эрүүл амьдралын дадал хэвшлийг бий болгоно.
- Өөрийн болон бусдын сэтгэл хөдлөлийг таньж, эергээр илэрхийлдэг, эх хэлээрээ бусадтай зүй зохистой харилцах чадварт суралцсан байна.
- Гэр, сургуулийн орчинд аюулгүй байдлаа хангаж, аливаа учирч болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадвартай болсон байна.

№	Хүрэх үр дүн	Шатлал	
		I-II анги	III-V анги
	Биеийн өсөлт хөгжилд хооллолт, нойр, дасгал хөдөлгөөн чухлыг мэддэг, тайлбарладаг болно.	- Өсөж том болоход бидэнд юу чухал болохыг мэддэг, өөрийн үгээр тайлбарладаг болно.	- Өдрийн дэглэм зохиож мөрддөг болсон байна. - Өсөлт хөгжилтэй холбоотой өөрийн бие махбод, сэтгэл санаанд гарах өөрчлөлтийг таньж, түүнд дасан зохицож өөр хоорондоо ярилцах чадвартай болно.
	Өдөр тутамдаа эрүүл амьдралын дадал хэвшлийг бий болгоно.	- Өглөөний цай, үдийн хоолны ач холбогдол болон эрүүл, эрүүл бус хүнс гэж юуг хэлэх талаар ойлгож, зохистой хэрэглэдэг болно. - Өдөр тутмын эрүүл ахуйн дэглэм (нүд, ам, гар, биеийн болон хувцасны) сахидаг болно.	- Хүнсний бүтээгдэхүүний шошго уншиж, зохистой хооллох аргад суралцана. - Шилжилтийн насны үеийн эрүүл ахуйн дэглэмийг сахидаг, түүний ач холбогдлыг тайлбарладаг болно.

	<p>Өөрийн болон бусдын сэтгэл хөдлөлийг таньж, эергээр илэрхийлдэг, эх хэлээрээ бусадтай зүй зохистой харилцах чадварт суралцсан байна.</p>	<ul style="list-style-type: none"> - Өөрийн хүсэл сонирхол, мэдрэмжээ илэрхийлдэг, өөрт итгэлтэй хэн нэгэнд өөрийгөө ойлгомжтой илэрхийлдэг болно. 	<ul style="list-style-type: none"> - Өөрийн болон бусдын хэрэгцээ, хүсэл сонирхол, мэдрэмжийн ялгаатай байдлыг мэддэг, бусдыг ойлгож сонсдог, туслах арга замыг эрэлхийлдэг болно.
	<p>Орчин тойрондоо дасан зохицож, аюул эрсдэлийг таньдаг, сэргийлдэг, авах арга хэмжээг мэддэг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Гэр ахуй, сургуулийн анги танхим, тоглоомын талбайд аюулгүй байдлаа хангадаг болно. - Замын тэмдэг, тэмдэглэгээг мэддэг, тээврийн хэрэгслээр аюулгүй зорчих дүрмийг мэддэг болсон байна. - Анхны тусламжийн энгийн аргуудаас үзүүлдэг болно. - Цахим хэрэглээний давуу, сул талыг мэддэг, хуваарь гаргаж хөтөлдөг болсон байна. 	<ul style="list-style-type: none"> - Хүрээлэн буй орчноо хайрлаж хамгаалдаг болсон байна. - Сургууль, нийтийн зам талбай, тээврийн хэрэгсэлд аюулгүй зорчих энгийн дүрмийг мэддэг, дагаж мөрддөг болно. - Анхны тусламжийн энгийн аргуудаас үзүүлдэг, тусламж авах арга замыг мэддэг болно. - Цахим мэдээллийг зохистой хэрэглэх аргад суралцсан байна.

ХОЁР. АГУУЛГА

2.1. Бага боловсролын эхлэл шатлал

Агуулгын ай 1: Хувийн эрүүл мэнд

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Өсөлт хөгжил	1.1а. Өсөж том болоход юу юу хэрэгтэй болохыг мэднэ.	2.1а. Өсөж том болоход хоол хүнс, дасгал хөдөлгөөн, нойр чухал болохыг мэдэж, өөрийн хооллолт, унтаж амрах, дасгал хийдэг цагийн тэмдэглэлтэй болсон байна.
	1.1б. Эрүүл өглөөний цайны ач холбогдлыг ойлгож, тогтмол уудаг болно.	2.1б. Үдийн хоолны ач холбогдол, эрүүл болон эрүүл бус хүнсний ялгааг тодорхойлж эрүүл хүнсийг сонгох чадвартай болно.
Эрүүл ахуй, ариун цэвэр	1.2а. Шүд угаах техникийн дагуу өөрөө бие даан угааж эхэлнэ.	2.2а. Шүдэнд ээлтэй хүнсийг сонгож чаддаг болсон байна.
	1.2б. Шүдний сойзыг сонгож сурсан байна.	2.2б. Шүд цэвэрлэгээний туслах хэрэгслийг (шүдний утас, завсрын сойз,

		хэл цэвэрлэгч) зориулалтын дагуу хэрэглэдэг болно.
	1.2в. Хувийн ариун цэврийн хэрэгсэлтэй (нүүр гарын болон биеийн алчуур, шүд угаах багц зэрэг) байж зөв хэрэглэдэг болно.	2.2в. Гараа тогтмол савандаж угаахын ач холбогдлыг тайлбарлаж чаддаг, өдөр тутамдаа хэрэгжүүлдэг байна.
	1.2г. Хувцасны үүрэг, зориулалтыг мэдэж, зөв тохируулан хувцасладаг, хиртэж бохирдсон үед сольдог байна.	
Эрсдэлээс сэргийлэх, аюулгүй байдал	1.3а. Гэр, сургуулийн орчинд тоглох үедээ учирч болох эрсдэлийг тооцоолон аюулгүй байдлаа бүрдүүлж чаддаг болно.	2.3а. Сургуулийн болон гадаа гудамж, тоглоомын талбай, завсарлагааны үеэр аюулгүй байдлын дүрмийг хэрэгжүүлдэг, шаардлагатай үед тусламж эрэх, хэнд, хаана хандахыг мэддэг болно.
	1.3б. Анхны тусламж: Хуруу зүсэгдэх, шалбарах үед авах арга хэмжээг мэдэх, шаардлагатай үед 103 дууддаг болно.	2.3б. Анхны тусламж: хэт халуун (нарших), хэт хүйтэн (хөлдөлт, осгох) үед авах арга хэмжээ (жин тавих, ус уух, шингэн нөхөх г.м.)-г мэддэг болсон байна.
	1.3в. Хувийн орон зайг (бие махбод, сэтгэл санаа) мэддэг болно.	2.3в. Цахим хэрэгслийн давуу ба сул талыг мэддэг, хуваарь гаргаж зохистой хэрэглэхийн ач холбогдлыг тайлбарлаж, мөрддөг болно.
		2.3г. Цахим орчин дахь хувийн орон зайн аюулгүй байдлыг ойлгож, хувийн мэдээллээ хамгаалах үндсэн арга замыг тайлбарлаж, хэрэгжүүлдэг болно.

Агуулгын ай 2. Нийгэмшиж аж төрөхүй

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Өөрийгөө илэрхийлэх	1.4.а. Өөрийгөө ойлгож, хайрлаж, хүндлэхийн ач холбогдлыг тайлбарлаж чаддаг болно.	2.4а. Хүсэл сонирхол, мэдрэмжээ ойлгодог, түүнийгээ зохистой илэрхийлдэг болно.
Гэр бүлийн харилцаа	1.5а. Гэр бүл нь олон янз байж болохыг ойлгож, бүх төрлийн гэр бүлд гишүүдийн хоорондын харилцаа, үүрэг хариуцлага чухал болохыг мэдэж авна.	2.5а. Гэр бүлийн гишүүдийн харилцаа, үүрэг хариуцлагыг ойлгон, эдгээр нь гэр бүлийн эрүүл мэндэд хэрхэн нөлөөлдгийг тайлбарлаж чадна.
Найз нөхөд, бүлгийн харилцаа	1.6а Найз гэж хэнийг хэлэх, найз нөхөд яагаад хэрэгтэй болохыг мэддэг болсон байна.	2.6а. Найз нөхөд, бүлэг, хамт олон байхын зорилгыг мэдэж, багийн гишүүн байхын утга учрыг тайлбарлаж чаддаг байна.

	1.6б. Хувь хүний ялгаатай байдал (тарган, туранхай, гарал үүсэл, арьсны өнгө)-ыг мэддэг, хүлээн зөвшөөрдөг, бусдыг гомдоохгүй байхад анхаардаг болсон байна.	2.6б. Өөрийн болон бусдын ялгаатай байдал, үзэл бодлыг хүлээн зөвшөөрдөг болсон байна.
--	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------

Агуулгын ай 3. Орчны эрүүл мэнд

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Гэр, сургуулийн орчин	1.7а. Гэр, сургуулийн орчны эрүүл ахуйн дүрмийг мэддэг болсон байна.	2.7а. Сургуульдаа ирж буцах зам, завсарлагааны цаг, тоглоомын талбайн эрүүл ахуйн дүрмийг мэддэг болсон байна.
Аюулгүй зорчих	1.8а. Ногоон гэрэл, цагаан шугамаар зорчдог болсон байна. 1.8б. Тээврийн хэрэгслээр зорчихдоо биеэ зөв авч явдаг болсон байна.	2.8а. Сургуульд ирж буцахдаа замын тэмдэг тэмдэглэгээг таньдаг, учирч болох эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалж сэргийлдэг болсон байна.

2.2. Бага боловсролын төгсгөл шатлал

Агуулгын ай 1: Хувийн эрүүл мэнд

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Өсөлт хөгжил	3.1а. Өдрийн дэглэм зохиож, түүнийг тогтмол мөрддөг болсон байна. (тогтмол цагт унтаж босох, өглөөний цай уух, дасгал хийх, тоглох цаг зэрэг)	4.1а. Шилжилтийн насны өөрчлөлттэй холбоотой биед гарч буй өөрчлөлт нь хэвийн зүйл болохыг мэдэж, айж ичихгүй, бусдыг шоолохгүй байхыг эрхэмлэнэ.	5.1а. Өөрийн эрүүл мэндэд анхаарах хувийн төлөвлөгөө гаргаж мөрддөг болсон байна. 5.1б. Шилжилтийн насны үед бие махбод, сэтгэл санаанд гарах өөрчлөлтөд дасан зохицож, бусадтай харилцан ярилцах чадвартай болно.
	3.1б. Хүнсний бүтээгдэхүүний шошго дээрх мэдээллийг уншиж, сонголт хийдэг болно.	4.1б. Эрүүл үдийн хоолны цэсийг төлөвлөж хэрэгжүүлэх чадвартай болно.	5.1в. Өөрийн өдөр тутмын хооллолтыг эрүүл байлгах зарчмуудыг тодорхойлж, эрүүл мэндэд ямар чухал болохыг тайлбарлаж чаддаг болно.
		4.1в. Хүмүүс бие махбод, сэтгэл санаа, мэдрэмж, сонирхлоор ялгаатай байдгийг мэдэж,	5.1г. Бэлгийн амьдралтай холбоотой олон янзын мэдрэмж, сэтгэл хөдлөл байдаг гэдгийг мэддэг болно.

		хүлээн зөвшөөрч хүндэтгэлтэй ханддаг болно.	
Эрүүл ахуй, ариун цэвэр	3.2а. Шүд унах болон гэмтэх үед үзүүлэх үйлдэл, урьдчилан сэргийлэх аргад суралцсан байна.	4.2а. Амны хөндий (шүд, буйл, салст)-н эрүүл ахуйг сахидаг болно.	5.2а. Шүд, эрүү нүүрний гажгаас сэргийлэх эрүүл дадал хэвшүүлнэ.
	3.2б. Нүд, чих, хамар, хоолойн эрүүл ахуйг сахидаг, үүсч болзошгүй өвчин эмгэгээс сэргийлдэг болно.	4.2б. Нүдний эрүүл ахуйг сахидаг, нүдний халдвар, бусад эмгэгээс сэргийлэх аргыг мэддэг болно.	5.2б. Гоо сайхны бүтээгдэхүүний давуу сул талыг тайлбарлаж, зөв сонгож хэрэглэдэг болно.
	3.2в. Биеийн ариун цэврийг сахиж усанд тогтмол орж, дотуур хувцасны эрүүл ахуйг сахидаг болно.	4.2в. Бэлгийн бойжилтын үед охид, хөвгүүдийн мөрдөх эрүүл ахуйн дэглэмийг мэддэг болсон болно.	5.2в. Бэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн дэглэмийг тогтмол сахидаг болно.
		4.2г. Хувцаслалт, хувцас арчилгаа, хувцасны эрүүл ахуйн шаардлагыг мэддэг болсон байна.	
Эрсдэлээс сэргийлэх, аюулгүй байдал		4.3а. Сургуульдаа ирэх буцах болон гудамж талбай, олон нийтийн газар аюулгүй зорчих, учирч болзошгүй аюул, эрсдэлээс сэргийлдэг болно.	5.3а. Аялал зугаалгын үеийн аюулгүй байдлыг сахих, хувийн бэлтгэлд юуг анхаарах талаар мэдэж, бэлтгэлтэй байна.
	3.3а. Анхны тусламж: Шаардлагатай үед дуудах тусламжийн утсыг мэднэ. (103, 102, 101, 108 зэрэг).	4.3б. Анхны тусламж: хөл гараа гэмтээх, хүнд хөнгөн хэлбэрийн шархыг ялгах, боолт хийх аргыг үзүүлж чаддаг болно.	
	3.3б. Хорт бодисын (тамхи, архи, эм, бодис) бие махбодод үзүүлэх нөлөөг ойлгож, өөрийгөө болон бусдыг эрсдэлээс сэргийлэх арга замыг тайлбарлаж чаддаг болно.	4.3в.Цахим донтолтоос сэргийлж, цахим хэрэгслийг зүй зохистой хэрэглэдэг болно.	5.3б. Хорт зуршлаас өөрийгөө болон бусдыг сэргийлдэг, бусдад шаардлага тавьдаг болсон байна.

	3.3в. Өөрийн хувийн орон зайг мэддэг болно.		5.3в. Таньдаг ба таньдаггүй хүнээс ирсэн таагүй үйлдлийг өөрийн итгэлтэй хүндээ шууд хэлдэг болно. 5.3г. Бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд (бэлгийн дарамт, хүчирхийлэл, жендэрт суурилсан хүчирхийлэл), түүнээс урьдчилан сэргийлэх арга замыг мэддэг болсон байна.
--	---------------------------------------------	--	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Агуулгын ай 2. Нийгэмшиж аж төрөхүй

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Өөрийгөө илэрхийлэх	3.4а. Өөрийн болон бусдын эерэг, сөрөг сэтгэл хөдлөлийг таньж мэддэг болно. 3.4б. Өөрийн хийх дуртай, дургүй зүйлсээ жагсаан бичиж, дургүй зүйлсээ гэр бүл, найз нөхдөдөө ойлгуулж чаддаг болно.	4.4а. Асуудал, бэрхшээл тулгарсан үед түүнийгээ эрүүл арга замаар шийдвэрлэхийг хичээдэг, өөрийн ойр дотно нь итгэлтэй хүнтэйгээ ярилцаж чаддаг болно.	5.4а. Өөрийн хүсэл мөрөөдлөө тодорхойлж, түүнд хүрэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхийг хичээдэг болно. 5.4б. Стрессийг хянаж удирдах аргуудыг ашиглаж, бусдаас тусламж авч чаддаг болно. 5.4в. Бясалгалаар анхаарлаа төвлөрүүлэх, сэтгэл хөдлөлөө хянах чадварт суралцсан байна.
Гэр бүлийн харилцаа	3.5а. Гэр бүлийн эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлж, гишүүдийн харилцаа, үүрэг хариуцлага нь эдгээр хүчин зүйлстэй хэрхэн уялдаж байгааг ойлгон, өөрийн үүрэг, оролцоог	4.5а. Гэр бүлийн эрүүл мэндтэй холбоотой асуудлуудыг илрүүлж, шийдвэрлэх арга замыг гэр бүлийнхэнтэйгээ хамтран боловсруулж, гэр бүлийн хүчирхийллийг таньж мэдэн, итгэж болох насанд хүрэгчдэд хандах, тусламж хайх арга замыг мэднэ.	5.5а. Гэр бүлийн эрүүл мэндийг дэмжих талаар бусдад мэдээлэл түгээх, эрүүл амьдралын хэв маягийг сурталчлах, гэр бүлийн хүчирхийллийн төрөл, шинж тэмдгүүдийг ойлгон, ийм нөхцөл байдалд хэрхэн тусламж хүсэх, бусдад дэмжлэг үзүүлэх талаар мэдлэгтэй болно.

	ухамсарлаж, хэрэгжүүлнэ.		
Найз нөхөд, бүлгийн харилцаа	3.6а. Өөрийн болон бусад найзынхаа зан чанаруудыг тодорхойлж чаддаг болсон байна.	4.6а. Өөрийнхөө онцлогийг хүлээн зөвшөөрч үнэлж чаддаг болсон байна.	5.6а. Өөрийн болон бусад хүмүүсийн зан чанар, ялгаатай байдлын талаар мэддэг болсон байна. 5.6б. Найз нөхөд, үе тэнгийнхнийхээ эрүүл харилцаа холбоог тодорхойлж, хөгжүүлэх чадвартай болсон байна.
	3.6б. Бэрхшээлтэй асуудлыг эерэг байдлаар илэрхийлдэг болно.	4.6б. Дээрэлхэл, гадуурхалтын эсрэг ямар арга хэмжээ авах, хэнд хандах талаар мэддэг болно (Сургуулийн ямар тушаалтанд хандах зэрэг)	5.6в. Эрүүл харилцааг хадгалах, сөрөг муу харилцааг өөрчлөхийг чармайдаг болно. 5.6г. Дээрэлхэл (цахим болон цахим бус)-ийг тодорхойлох, түүнд өртөхгүй байх, хариу арга хэмжээ авах үр дүнтэй арга замыг эрэлхийлдэг болно. 5.6д. Тохуурхах, нэр хоч өгөх (онлайн болон бодит байдалд), бусдыг дээрэлхэх, гадуурхалд өртсөн үед насанд хүрсэн итгэлтэй хүндээ хэлж мэдэгдэхийн ач холбогдлыг мэддэг болно.
	3.6в. Хүмүүс хэн нэгэнд сэтгэл татагдах, шохоорхох тохиолдол байдаг гэдгийг тайлбарлаж чаддаг болно.	4.6в. Гэр бүл болох, хамтран амьдрахын учир нь нэгнийгээ хайрлаж, хүндэлж, халамжилж, харилцан үүрэг хүлээхийг хэлдэг болохыг тайлбарлах чадвартай болно.	5.6е. Гэр бүлийн олон янз хэлбэр (ганц бие ээж аав, салсан, бэлэвсэн гэр бүл, хойд эцэг эх, холимог гэр бүл г.м.) байдаг бөгөөд аль ч тохиолдолд харилцан бие бие нь ээ хайрлаж, халамжилсаар байдаг гэдгийг мэднэ.

Агуулгын ай 3. Орчны эрүүл мэнд

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Гэр, сургуулийн орчин	3.7а. Гэртээ тав тухтай, эрүүл орчин бүрдүүлэхэд (гэрэлтүүлэг,	4.7а. Гудамж талбай, олон нийтийн газар зорчихдоо аюул эрсдэлийг тооцож сэргийлж сурсан, бусдад	5.7а. Аялал зугаалгын үеийн орчны эрүүл ахуйг анхаардаг (хог хаядаггүй, бие засах

	агааржуулалт, ариун цэвэр г.м.) өөрийн хувь нэмрийг оруулдаг болсон байна.	шаардлага тавьдаг болсон байна.	үеийн г.м.) болсон байна.
Аюулгүй зорчих		4.8а. Зам тээврийн осол гэмтлийн шалтгааныг тодорхойлж, аюулгүй байдлын дүрмийг мөрддөг болсон байна.	5.8а. Гудамж талбай, олон нийтийн газар тохиолдож болох аюул ослоос сэргийлж, аюулгүй зорчих замыг сонгож, унадаг дугуй, цахилгаан дугуйгаар зорчихдоо, өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангадаг болсон байна.

ГУРАВ. АРГА ЗҮЙ, СУРГАЛТЫН ОРЧИН

3.1. Арга зүй

Бага боловсролын эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг суралцагчийн өмнөх мэдлэгт тулгуурлан, тэдний идэвхтэй оролцоог дэмжин, бодит хэрэглэгдэхүүн, цахим контент, арр программууд ашиглан танхим, танхимын бус болон бие даах хэлбэрээр зохион байгуулна.

Танхимын сургалтаар суралцагчдад шинэ мэдээлэл өгөх, санал солилцох, харилцан ярилцах, хамтран бүтээх гэх мэтчилэн үйлийг хийх бөгөөд ирээдүйгээс эргэн төлөвлөх, багаар болон хосоор хамтран ажиллах, тоглоомын зэрэг идэвхтэй сургалтын аргыг ашиглана.

Ирээдүйгээс эргэн төлөвлөх (Backcasting) арга

Эхлээд хүүхдүүдээр өөрсдийнх нь хүссэн үр дүнг буюу ирээдүйн зорилтот төлөв байдлыг тодорхойлуулж, дараа нь түүнд хүрэхийн тулд одоо ямар алхмууд хийх шаардлагатайг тодорхойлох юм. Энэхүү арга нь уламжлалт “Ирээдүйг урьдчилан таамаглах” (Forecasting) аргаас ялгаатай. Уламжлалт арга нь одоогийн нөхцөл байдал, чиг хандлагад үндэслэн ирээдүйг төсөөлдөг бол ирээдүйгээс эргэн төлөвлөх арга нь эхлээд хүссэн ирээдүйгээ тодорхойлж, түүнд хүрэх замыг эргэн тооцоолдог. Ингэснээр урт хугацааны зорилго тавих боломжтой, өнөөгийн нөхцөл байдалд баригдахгүй, өөрөөр хэлбэл, одоогийн бодит байдалд хязгаарлагдахгүйгээр хүссэн ирээдүйгээ бүтээхэд тусална.

Дараах алхмын дагуу явагдана.

Алхам	Жишиг үйл ажиллагаа
1 дүгээр алхам: Ирээдүйн дүр төрхийг бүтээх	<ul style="list-style-type: none"> • “10 жилийн дараах Би” төсөөлөн бодуулах; • Хүүхдүүд өөрсдийн ирээдүйн эрүүл амьдралын дүр зургийг зурж, эсвэл бичиж илэрхийлнэ.

2 дугаар алхам: Ирээдүйн зорилгодоо хүрэх замыг тодорхойлох	<ul style="list-style-type: none"> • “Эрүүл, чийрэг байхын тулд одоо юу хийх ёстой вэ?” гэсэн асуултаар хөтлөн чиглүүлэх; • Гол хүчин зүйлс (хоол, дасгал, нойр, чийрэгжилт)-ийн талаар мэдээлэл өгөх; • Өдөр тутмын зөв дадлуудын ач холбогдлыг ойлгуулах.
3 дугаар алхам: Ирээдүйгээс одоо руу төлөвлөх	<ul style="list-style-type: none"> • Ирээдүйн зорилгод хүрэхийн тулд өдөр тутам ямар алхам хийх хэрэгтэйг тодорхойлох; • Хүүхдүүд өөрсдийн эрүүл амьдралын дадал хэвшлийн төлөвлөгөөг гаргах.
4 дүгээр алхам: Хэрэгжүүлэх, дадал болгох	<ul style="list-style-type: none"> • Хүүхэд бүр эрүүл амьдралын дадал хэвшлийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлж эхлэх; • Багш хяналт тавих, ахицыг үнэлэх.

Аргын үр дүн, давуу тал:

- Хүүхдүүд өөрсдийн эрүүл мэндийг ухамсарлаж, хариуцлагатай ханддаг болно.
- Бодитоор хэрэгжүүлж болох дадлуудыг төлөвлөж, амьдралдаа хэвшүүлнэ.
- Эрүүл мэндийн талаар зөв ойлголттой болж, идэвхтэй амьдралын хэв маяг төлөвшинэ.

Ингэснээр хүүхдүүд зөвхөн онолын мэдлэг аваад зогсохгүй, бодит амьдралдаа хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, эрүүл амьдралын хэв маягийг дадал болгох боломжтой.

Нэг ба хоёрдугаар ангийн шүдний эрүүл ахуйн хичээлийн 1.2а, 1.2б, 2.2а, 2.2б СҮА-г танхимаар орохдоо 1 ба 3 дугаар улиралд салгаж оруулахаар төлөвлөнө. Нэгдүгээр ангийн 1 дүгээр улиралд үзэж судалсан зүйлээ дадал болгосон эсэхийг 3 дугаар улиралд хянан баталгаажуулах, шинэ агуулгыг бага багаар нэмж судлуулах байдлаар төлөвлөсөн. Түүнчлэн нэгдүгээр ангийн 3 дугаар улиралд үзсэнийг хоёрдугаар ангийн намар хянах, үнэлэх, давтан сургах байдлаар үе шаттай оруулснаар хүүхдэд шүдээ угаах дадал хэвшил төлөвшинэ.

Танхимын бус сургалтаар хичээл дээр үзсэн шинэ мэдлэгийг бататгах, хэрэгжүүлэх, хэвшил болгох зорилгоор сургуулийн үдийн цай хөтөлбөр болон хичээлээс гадуурх бусад үйл ажиллагаа, аялал зэрэгтэй уялдуулан хэрэгжүүлнэ. Жишээ нь, үдийн цай хөтөлбөрөөр дамжуулан гараа угаах, шүдээ угаах дадлагыг тогтмол хийлгэнэ. Өдөр тутамдаа шүдээ угаах дадлага хийснээр өглөө оройд шүдээ тогтмол угаадаг дадалтай болно.

Мөн үе тэнгийн сургагчийг бэлтгэн тэднээр дамжуулан хичээл дээр үзсэн эрүүл дадал хэвшлийг бусдад таниулах, ойлгуулах, нөлөөлөх, үлгэр дуурайлал үзүүлэх зэрэг идэвхтэй үйл ажиллагааг зохион байгуулж болно.

Бие даах цагаар танхим болон танхимын бус цагаар хийсэн үйлийг өдөр тутмын амьдралдаа хийж хэвшүүлэх, хувийн төлөвлөгөөтэй болж ирээдүйн амьдралын

сайн сайхан, эрүүл чийрэг байдлыг бий болгоход нөлөөлөх чухал дадал, зан үйлийг хэвшүүлнэ. Тухайлбал, гэртээ ороод хувцсаа сольж өмсдөг, гараа угаадаг, шүдээ тогтмол зөв угаадаг, эрүүл хоолыг зохистой хэрэглэдэг, шаардлагатай тохиолдолд гэр бүлийнхээ гишүүдэд шаардлага тавьдаг, өөрийн дуртай дургүй зүйлээ хэлж илэрхийлдэг байх зэрэг.

Гэртээ өдөр тутамдаа хийсэн дадал хэвшлийг тэмдэглэх сурагчийн дэвтрийг хөтлүүлж болно. Сурагчийн дэвтэрт дараах зүйлсийг тусгана. Үүнд:

- Өндөр хэмжих хүснэгт
- Шүдний сойз солих хуваарь
- Шүдний эрүүл мэндийн байдал (цоорсон, ломбодсон, авхуулсан шүд тэмдэглэх хэсэгтэй)
- Өдөрт идсэн хоол хүнсний төрөл: Шинэ ногоо, уусан ус зэрэг
- 24 цагийн хоолны тэмдэглэл
- Долоо хоногийн тэмдэглэл: Унтах, босох цаг, өглөөний цай, дасгал хийсэн эсэх зэргийг тусгасан байна.

Танхимын сургалтыг тусгайлан бэлтгэгдсэн мэргэжлийн багш, эмч, сэтгэл зүйч, хоол зүйч, нийгмийн ажилтан, тээврийн цагдаагийн албаны ажилтан, эрүүл мэндийн чиглэлээр суралцаж буй ахлах дамжааны оюутан нар болон үе тэнгийн сургагч нартай хамтран зохион байгуулах боломжтой.

3.2. Сургалтын орчин

Сургалтын орчин нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад нөлөөлөх гол хүчин зүйл болдог. Сурагчийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн сургалтын арга хэлбэр, эерэг таатай уур амьсгал бүхий эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх шаардлагатай. Үүнд:

Эерэг таатай уур амьсгал бүхий Харилцаа:

- Сонирхолтой, хөгжилтэй тоглодог.
- Урам зориг өгдөг, тууштай, тэвчээртэй байдлыг дэмждэг.
- Амжилтыг нь урамшуулдаг.
- Хамтын ажиллагааг дэмждэг.
- Айдасгүй, нээлттэй байх.

Эрүүл аюулгүй, хүртээмжтэй анги танхим:

- Бүтээлчээр ажиллах, оролцоог дэмжих боломжтой.
- Суралцагч бүрд хүрэлцэхүйц хэмжээтэй сургалтын хэрэглэгдэхүүнтэй.
- Сурагчид хөдөлгөөнтэй бие биетэйгээ харилцах боломжтой. Уян хатан зохион байгуулалттай (ширээний зохион байгуулалт, гэрэлтүүлэг).
- Сургалтын техник хэрэгсэл ашиглах боломжтой.

Ялгаатай байдлыг дэмжсэн, ялгаатай хэрэгцээг хангасан орчин

- Сурагчдын суралцах хэв маягийг (хараа, сонсгол, хөдөлгөөний) харгалзсан зураг, бүдүүвч, өнгө ялгалттай материал, аудио хичээл, ярилцлага, практик туршилт, хөдөлгөөнтэй тоглоом ашиглах боломжтой,
- Хэл соёлын ялгаатай суралцагчдад зориулан сургалтын болон бусад толь бичигтэй,
- Суралцахуйн хоцрогдолтой болон илүү хурдтай суралцагчдад зориулсан ялгаатай даалгаврын сантай байх

Сургалтын хэрэглэгдэхүүний хувьд, эрүүл ахуйн дэглэм, шаардлага бичсэн бичил зөвлөмж, санамж бүхий зурагт үзүүлэн, бодит хэрэглэгдэхүүн, тараах материал; зохистой хооллолт, усны хэрэглээ, бие бялдын хөгжлийн өөрчлөлтийг тооцоолох ажлын хуудсыг суралцагчдын насны онцлогт тохируулан боловсруулж, ашиглана. Тухайлбал,

- Шүд угаах хэрэгсэл (толь, сойз), гар угаах аргачлал, угаалтуур бүхий орчныг бүрдүүлнэ.
- Багш нарт зориулсан гарын авлага, тарааж өгөх материал, хэрэгсэл зэргийг бэлтгэнэ.
- Бүлгийн хэлэлцүүлэг, хамтын ажиллагаа, бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтын самбар, ажлын хуудас, бичиж тэмдэглэх үзэг, уншиж судлах материал, холбогдох үзүүлэнг бэлтгэнэ
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн яам, Боловсролын яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын хүүхдийн сан зэрэг албан ёсны байгууллагаас гаргасан баталгаат эх сурвалж, цахим контент, арр зэргийг татаж бэлтгэсэн байна.

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

4.1 Үнэлгээний зорилго

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, төлөвшил (чадамж)-ийг илрүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг дэмжих, ахиц дэвшлийг урамшуулах, хүрсэн түвшнийг үнэлэхэд чиглэнэ.

Бага боловсролын эхлэл шатанд суралцагчийн үнэлгээ нь биеийн өсөлт хөгжил, өдөр тутмын хооллолт, дадал зуршил, бусадтай харилцах харилцаанд гарч буй ахиц, гүйцэтгэлийг илрүүлэх, суралцах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Бага боловсролын төгсгөл шатанд суралцагчийн хувийн эрүүл ахуй, дадал хэвшилд гарч буй ахиц дэвшлийг үнэлэх, бие даан болон багаар хамтран гүйцэтгэх, харилцах, бүтээлчээр сэтгэх чадварыг илрүүлж, гарсан амжилт, үр дүнг үнэлж дүгнэхэд чиглэнэ.

4.2 Үнэлгээний шалгуур

Хүрэх үр дүн	Шалгуур
<p>Биеийн өсөлт хөгжилд хооллолт, нойр, дасгал хөдөлгөөн чухлыг мэддэг, тайлбарладаг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Биеийн өсөлтийг дэмждэг зүйлсийг нэрлэдэг, тоочдог, учрыг өөрийн үгээр тайлбарладаг. - Өсөж том болоход бие махбод, сэтгэл санаанд гарах өөрчлөлтийг нэрлэдэг. - Өдөрт идсэн хоол хүнсний зүйлийг зургаар илэрхийлдэг. - Өдрийн тэмдэглэлийг хөтөлдөг (хэдэн цагт унтсан, хэдэн цагт сэрсэн г.м). - Бие махбод, сэтгэл санаанд гарах өөрчлөлтийг хэлдэг, ярилцаж чаддаг.
<p>Өдөр тутамдаа эрүүл амьдралын дадал хэвшлийг бий болгоно.</p>	<ul style="list-style-type: none"> - Өглөөний цайны ач холбогдлыг тайлбарладаг. - Шүд угаах багцыг тогтмол авч явдаг, угаадаг. - Шүд угаах дарааллыг зөв хийж үзүүлдэг. - Үдийн цайны үед гар болон шүдээ тогтмол угаадаг. - Хүнсний бүтээгдэхүүний шошго уншиж, тайлбарладаг. - Эрүүл хүнсийг сонгож хэрэглэдэг. - Эрүүл дадал хэвшлийн талаар тайлбарладаг. - Өөрийн өдөр тутмын зан үйлд эргэцүүлэл, дүгнэлт хийж чаддаг.
<p>Өөрийн болон бусдын сэтгэл хөдлөлийг таньж, эергээр илэрхийлдэг, эх хэлээрээ бусадтай зүй зохистой харилцах чадварт суралцсан байна.</p>	<ul style="list-style-type: none"> - Өөрийн сэтгэл хөдлөл, мэдрэмжээ зүй зохистой илэрхийлдэг. - Өөрийн хийх дуртай, дургүй зүйлсийн жагсаалтыг гаргадаг. - Эх хэлээрээ бусадтай зүй зохистой харилцдаг. - Харилцааны идэвхтэй аргыг хэрэглэж найз нөхөдтэйгөө өөртөө итгэлтэй харилцдаг. - Хүмүүсийн ялгаатай байдлыг мэддэг, нэрлэж чаддаг. - Бусадтай хүндэтгэлтэй харилцахын учрыг тайлбарладаг. - Найз нөхдийн хүрээг үүсгэж, түүнд үнэлгээ өгч чаддаг. - Гэр бүлийн гишүүдийн үүргийг жагсаан бичдэг, өөрийн хийдэг ажлыг нэрлэж бичдэг.
<p>Орчин тойрондоо дасан зохицож, аюул эрсдэлийг таньдаг, сэргийлдэг, авах арга хэмжээг мэддэг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Гэр, сургуулийн орчны аюул, эрсдэлтэй нөхцөл байдлыг тодорхойлдог, дүрслэн үзүүлдэг. - Гадаа тоглох үеийн аюулгүйн дүрмийг тоочдог. - Анхны тусламж үзүүлж сурахын ач холбогдлыг хэлдэг. - Бусдад шаардлага тавих нөхцөл байдлыг мэддэг. - “Ногоон гэрэл, цагаан шугам” баримтлахын ач холбогдлыг жишээ гарган тайлбарладаг. - Өөрт зориулсан аюулгүй байдлын дүрмийг зохиодог, хэрэгжүүлдэг, бусдад хэлж зөвлөдөг.

ТУВА ХЭЛ

НЭГ. ЗОРИЛГО

1.1. Зорилго

Суралцагчийн эх хэл, бичиг үсгийн суурь чадамж болон харилцах, хамтрах, бүтээлчээр сэтгэж илэрхийлэх, шүүн тунгаах, үндэсний болон дэлхийн өв соёлоос суралцах ерөнхий чадамжийг хөгжүүлнэ.

1.2. Хүрэх үр дүн, шатлал

Энэхүү хөтөлбөрийг судалснаар суралцагчид дараах ерөнхий үр дүнд хүрсэн байна.

- Хэл зүй, үгсийн сангийн суурь мэдлэг, чадвар эзэмшиж, хэрэглэдэг болно.
- Уншсанаа ойлгодог, ойлгосноо аман болон бичгийн хэлээр ойлгомжтой илэрхийлдэг, зөв найруулан бичдэг чадвартай болно.
- Уран зохиолын бус эхийг уншиж ойлгон, санаа бодлоо баримт нотолгоонд үндэслэн бүтээлчээр илэрхийлдэг болно.
- Аман зохиол, уран зохиол болон дэлхийн уран зохиолоос уншиж, үгийн сангаа баяжуулж, уламжлалт ёс заншлаас суралцаж, түүгээр бахархдаг, бусад үндэстний хэл, соёлыг танин мэдэж хүндэтгэдэг төлөвшил, чадвартай болно.

№	Хүрэх үр дүн	Шатлал	
		I-II анги	III-V анги
1	Хэл зүй, үгсийн сангийн суурь мэдлэг, чадвар эзэмшиж, хэрэглэдэг болно.	<ul style="list-style-type: none"> - Авиа, үсгийг зөв дуудаж, уншиж, зурлага, тигийн дагуу бичдэг, үгийн үндэс, залгаврыг ялгадаг болно. - Энгийн, асуух, анхааруулах өгүүлбэрийг ойлгож, хэрэглэдэг болно. - <i>Кым (хэн), чүү (юу), кандыг (ямар), каш (хэдэн), кайда (хаана), канчанган (яасан), канчап тур (яаж байна)</i> зэрэг асуултад хариулагдах үгийн утгыг таньж, ярьж, бичихдээ хэрэглэдэг болно. 	<ul style="list-style-type: none"> - Үг, өгүүлбэр, эхийн бүтцийг ойлгож, үгийн үндэс, язгуур, нөхцөл, дагаврыг ялгаж хэрэглэдэг болно. - Өгүүлбэрийн гишүүд болон бүтцийг ойлгож, хэрэглэдэг болно. - Жинхэнэ нэр, тэмдэг нэр, тооны нэр, төлөөний үг, үйл үгийг утгаар болон асуултаар таньж, зохион бичихдээ хэрэглэдэг болно.
2	Уншсанаа ойлгодог, ойлгосноо аман болон бичгийн хэлээр ойлгомжтой	<p><i>Сонсох:</i></p> <ul style="list-style-type: none"> - Яриа, заавар, асуулт, эхийг анхааралтай сонсож ойлгодог болно. 	<p><i>Сонсох:</i></p> <ul style="list-style-type: none"> - Эхийг сонсож ойлгодог, ойлгосноо ойлгомжтой илэрхийлдэг болно.

	<p>илэрхийлдэг, зөв найруулан бичдэг чадвартай болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Асуултад хариулж, хоорондоо ярилцдаг болно. <p><i>Ярих:</i></p> <ul style="list-style-type: none"> - Санаа бодол, сэтгэгдлээ энгийн, бүтэн өгүүлбэрээр ойлгомжтой илэрхийлдэг болно. - Дүрийн зан чанар, үг, үйлдлийг харьцуулж, сайн муу үйлийг ялгаж, учир шалтгааныг тайлбарладаг болно. <p><i>Унших:</i></p> <ul style="list-style-type: none"> - Зурган эх болон уран зохиолын эхийг уншиж ойлгодог болно. - Танил бус үгийн утгыг эхийн зураг, агуулга, ойр орчмын үг, өгүүлбэрийн утгаар таамаглаж хэлэлцдэг болно. <p><i>Бичих:</i></p> <ul style="list-style-type: none"> - Түлхүүр үг, зураг, заавар, загварын дагуу өгүүлбэр, эх зохиож бичдэг болно. - Сэдвийн хүрээнд санаа бодол, сэтгэгдлээ утгын уялдаа холбоотой, алдаагүй зохиож бичдэг болно. 	<ul style="list-style-type: none"> - Сэдвийн хүрээнд асуултад хариулж, шинэ санаа гаргаж, мэтгэлцдэг болно. <p><i>Ярих:</i></p> <ul style="list-style-type: none"> - Уншсан, сонссон эхийн талаар санаа бодол, сэтгэгдлээ илэрхийлэхдээ, эхээс жишээ татан ойлгомжтой илэрхийлдэг болно. - Эхийн утгыг эхлэл, гол, төгсгөл хэсэг тус бүрээр тодруулж, учир шалтгааныг тайлбарладаг болно. <p><i>Унших:</i></p> <ul style="list-style-type: none"> - Эхээс өөртөө чухал санагдсан хэсгийг олж, яагаад чухал гэж үзэж байгаагаа тайлбарладаг болно. - Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийн холбоо хамаарлыг ойлгож, үйл явдлын учир шалтгааныг тоочиж тайлбарладаг болно. <p><i>Бичих:</i></p> <ul style="list-style-type: none"> - Бичих зүйлээ сэдвийн хүрээнд төлөвлөж, эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй, ойлгомжтой, алдаагүй, зохиож бичдэг болно. - Эхийг түлхүүр үг, асуулт, зураг, хүснэгтэн мэдээлэл, баримт нотолгоо хэрэглэн дэлгэрүүлэн найруулж бичдэг болно.
3	<p>Уран зохиолын бус эхийг уншиж ойлгон, санаа бодлоо баримт нотолгоонд үндэслэн бүтээлчээр</p>	<ul style="list-style-type: none"> - Зурган эх болон мэндчилгээ, талархал, танилцуулгыг уншиж ойлгодог болно. - Уншсан эхээс сонирхолтой санагдсан хэсгийг янз бүрийн арга 	<ul style="list-style-type: none"> - Төрөл бүрийн эх уншиж гол санааг ойлгодог болно. - Ойлгосноо өөрийн санаа бодолтой харьцуулан баримт нотолгоонд үндэслэн тайлбарладаг болно.

	илэрхийлдэг болно.	хэлбэрээр илэрхийлж тайлбарладаг болно.	
4	Аман зохиол, уран зохиол болон дэлхийн уран зохиолоос уншиж, үгийн сангаа баяжуулж, уламжлалт ёс заншлаас суралцаж бахархдаг, бусад үндэстний хэл, соёлыг танин мэдэж, хүндэтгэдэг төлөвшил, чадвартай болно.	<ul style="list-style-type: none"> - Тува, Монгол аман зохиол, уран зохиол болон дэлхийн уран зохиолоос уншиж, үгийн сангаа баяжуулж, сурсан шинэ үгээ ярьж, бичихдээ хэрэглэдэг болно. - Тува, Монгол уламжлалт ёс заншил, соёлоос суралцаж, түүгээр бахархдаг, өвлөн уламжлах хандлагатай болно. 	<ul style="list-style-type: none"> - Аман болон уран зохиолын утга, хэл найруулгыг ойлгож, үгийн сангаа баяжуулж, аман болон бичгийн хэлэндээ хэрэглэдэг болно. - Уламжлалт ёс заншлыг харьцуулан суралцаж, хадгалан хамгаалдаг болно. - Бусад үндэстний хэл, соёлыг танин мэдэж, хүндэтгэдэг төлөвшил, чадвартай болно.

ХОЁР. АГУУЛГА

2.1. Бага боловсролын эхлэл шатлал

Агуулгын ай 1. Сонсох-ярих

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Мэдээллийг хүлээн авч ойлгох	1.1а. Яриа, зааврыг анхааралтай сонсож, хэлний авиаг ялгаж зөв дуудна.	2.1а. Яриа, заавар, асуултад анхаарлаа төвлөрүүлэн сонсож ойлгоно.
	1.1б. Үйл явдалтай зураг болон уншсан, сонссон эхийн хүрээнд асуулт асууж, ойлгосноо илэрхийлнэ.	2.1б. Үйл явдалтай зураг болон уншсан, сонссон эхийн үйл явдлаас асуулт асууж, ойлгосноо илэрхийлнэ.
Санаа бодлоо илэрхийлэх	1.1в. Үйл явдалтай зураг болон уншсан, сонссон эхийн үйл явдлыг хүүрнэн ярина.	2.1в. Эхээс сайн, муу үйлийг ялгаж тоочин ярина.
	1.1г. Сэдвийн хүрээнд тохирох үг, өгүүлбэрээр санаа бодлоо илэрхийлнэ.	2.1г. Сэдвийн хүрээнд санаа бодлоо бусдын ярьсантай холбон ойлгомжтой илэрхийлнэ.

Агуулгын ай 2. Унших

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Эхийг ойлгож унших	1.2а. Дармал, бичмэл үсгийг зөв таньж, зөв дуудаж, 1-2 үетэй үгийг шууд, 3 болон түүнээс дээш үетэй үгийг үелж уншина.	2.2а. Өгүүлбэр болон эхийг зөв, хурдан уншиж, уншсан зүйлээ тоочин ярина.
	1.2б. Өгүүлбэр болон эхийг ойлгож уншдаг болно.	2.2б. Эхийн үйл явдлыг төсөөлөн бодож таамаглана.
Ойлгосноо бүтээлчээр илэрхийлэх	1.2в. Ойлгосноо янз бүрийн аргаар илэрхийлнэ.	2.2в. Эхийн үйл явдал эхлээд, дараа нь, эцэст нь хэрхэн өрнөснийг ойлгож, ойлгосноо илэрхийлнэ.
	1.2г. Цээжилсэн шүлэг, зүйр цэцэн үг, оньсогыг тод, чанга дуугаар уншина.	2.2г. Цээжилсэн шүлэг, зүйр цэцэн үг, ертөнцийн гурав, оньсого, хэл зүгшрүүлэх үгийг өөртөө итгэлтэй тод, чанга дуугаар уншина.
Үгийн нөөцөө нэмэгдүүлэх	1.2д. Танил бус үгийн утгыг эхийн зураг, ойр орчмын үг, өгүүлбэрийн утгаар таамаглаж уншина.	2.2д. Танил бус үгийн утгыг эхийн зураг, агуулга, ойр орчмын үг, өгүүлбэрийн утгаар таамаглаж уншина.
	1.2е. Шинээр сурсан үгээ ярьж, бичихдээ хэрэглэнэ.	1.2е. Шинээр сурсан үгээ аман болон бичгийн хэлэндээ хэрэглэнэ.

Агуулгын ай 3. Бичих

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Зөв бичих	1.3а. Том, жижиг үсэг, үе, үг, өгүүлбэрийг дэвтэрт тигийн дагуу бичнэ.	2.3а. Өгүүлбэр, эхийг зохион найруулж бичихдээ зөв бичих дүрмийг баримтлан бичнэ: - “ь”-тэй үгийг зөв дуудаж, өгүүлбэр зохиохдоо алдаагүй бичнэ: <i>аьт, аьттыг, оьт, оьттуг.</i> - э (е) эгшиг үсэгтэй үгийг зөв уншиж, алдаагүй бичнэ.
	1.3б. Эгшиг, гийгүүлэгч үсэг, урт, богино эгшиг, тэмдэг үсгийг ялгаж танина.	2.3б. Оноосон нэрийг зөв бичнэ.
Зохиож бичих	1.3в. Үйл явдалтай зураг болон асуулт, загвар, хүснэгтийн дагуу 3-4 өгүүлбэртэй зохион бичлэг бичнэ.	2.3в. Бүтэц, зааврын дагуу эх зохиож бичнэ (богино эх, гэр бүлийн танилцуулга, мэндчилгээ, талархал, орчин тойронд болсон үйл явдал).
	1.3г. <i>Кым (хэн), чүү (юу), кандыг (ямар), каш (хэдэн), кайда</i>	2.3г. Ертөнцийн гурвын хэлбэрийг дуурайн зохиож бичнэ.

	(хаана), канчанган (яасан) гэсэн асуултад хариулагдах үгийг хэрэглэн өгүүлбэр зохиож бичнэ.	
--	---------------------------------------------------------------------------------------------	--

Агуулгын ай 4. Хэл зүйн болон үгийн сангийн хэрэглээ

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Хэл зүйн хэрэглээ	1.4а. Цэг, асуултын тэмдгийг зөв хэрэглэнэ.	2.4а. Өгүүлбэрт таслал, анхаарлын тэмдгийг зөв хэрэглэнэ.
	1.4б. Задгай, битүү үеийг ялган таньж, үгийг үелж, мөр шилжүүлж бичнэ.	2.4б. Жинхэнэ нэрийн ганц болон олон тооны залгаврыг зөв хэрэглэнэ.
	1.4в. Хүний болон газар усны нэрийг зөв бичнэ.	
Үгийн сангийн хэрэглээ	1.4г. <i>Кым (хэн), чүү (юу), кандыг (ямар), каш (хэдэн), кайда (хаана); канчанган (яасан)</i> гэсэн асуултад хариулагдах үгийг олж, ярьж, бичихдээ хэрэглэнэ.	2.4в. Жинхэнэ нэр, тэмдэг нэр (ойролцоо болон эсрэг утгатай үг)-ийг ялгаж, ярьж, бичихдээ зөв хэрэглэнэ.
	1.4д. Эсрэг утгатай үгийг ялгаж, өгүүлбэрт хэрэглэнэ.	2.4г. Төлөөний үг (<i>мен, сен, ол</i>)-ийг өгүүлбэрт зөв хэрэглэнэ.

2.2. Бага боловсролын төгсгөл шатлал

Агуулгын ай 1. Сонсох-ярих

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Мэдээллийг хүлээн авч ойлгох	3.1а. Эхийг сонсож, үйл явдлыг тайлбарлана.	4.1а. Эхийг сонсож, утгыг тайлбарлана.	5.1а. Эхийг сонсож, утгыг эхлэл, гол, төгсгөл хэсгээр тодруулж, онцлогийг тайлбарлана.
	3.1б. Эхийн утгыг ойлгосноо эхлэл, гол, төгсгөл хэсгээр илэрхийлнэ.	4.1б. Хүлээн авсан мэдээллээс ойлгосноо илэрхийлнэ.	5.1б. Эхийн үйл явдлын учир шалтгааныг тодруулах асуулт асууж, ярина.
Санаа бодлоо илэрхийлэх	3.1в. Эхийн үйл явдлаас сайн, муу үйлийг ялгаж тайлбарлана.	4.1в. Эхийн дүрүүдийн үг, үйлдлийг	5.1в. Ярилцахдаа бусдыг хүлээцтэй

		харьцуулж тайлбарлана.	сонсож, санаа бодлоо харьцуулж дүгнэнэ.
	3.1г. Сэдвийн хүрээнд санаа бодлоо илэрхийлж, бусдын санаа бодлыг харьцуулж дүгнэнэ.	4.1г. Бусдыг хүндэтгэн сонсож, санаа бодлоо төлөвлөн илэрхийлнэ.	5.1г. Зураг, загвар, бүдүүвч, хүснэгтэн мэдээлэл, жишээ баримтад үндэслэн санаа бодлоо илэрхийлнэ.

Агуулгын ай 2. Унших

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Эхийг ойлгож унших	3.2а. Эхийг зөв түгдрэлгүй уншиж, утгыг ойлгож, ойлгосноо тоочиж, тайлбарлана.	4.2а. Эхийн утгыг ойлгож, зөв, хурдан уншиж, уншсан зүйлээ тоочиж, тайлбарлаж, харьцуулна.	5.2а. Эхийн утгыг ойлгож, зөв, хурдан уншиж, уншсан зүйлээ тоочиж, тайлбарлаж, харьцуулж, дүгнэнэ.
	3.2б. Гол дүрийн зан чанар, үг, үйл хөдлөлийн онцлогийг илрүүлж, дүрд хувирч уншина.	4.2б. Шүлгийн толгой, сүүл, холбоц, давталт нь утга, хэмнэлийг хэрхэн бүтээж буйг тодорхойлж уншина.	5.2б. Эхээс сургамжит хэсгийг ойлгож, үйл явдлыг дарааллаар нь тоочин ярина.
Ойлгосноо бүтээлчээр илэрхийлэх	3.2в. Эхийн эхлэл хэсгээс үндэслэн цаашид гол хэсгийн үйл явдлыг хэрхэн өрнөхийг таамаглаж, таамагласнаа илэрхийлнэ.	4.2в. Эхийн эхлэл, гол хэсгийн үйл явдал дээр үндэслэн төгсгөлийг ургуулан боддог, бодсоноо илэрхийлдэг болно.	5.2в. Эхийн далд утгыг асуултын дагуу тодруулж, ойлгосноо бүтээлчээр илэрхийлнэ.
	3.2г. Эхийн гол үйл явдал <i>кажан (хэзээ), каяа (хаана), чүге (яагаад)</i> ямар дүрүүдийн хооронд өрнөснийг илэрхийлнэ.	4.2г. Дүрүүдийн үг, үйлдэл, сайн муу үйлийг харьцуулж, харьцуулснаа илэрхийлнэ.	5.2г. Уран зохиолын бус эхийн гол утгыг тодруулж, ойлгосноо бүтээлчээр илэрхийлнэ.
Үгийн нөөцөө нэмэгдүүлэх	3.2д. Танил бус үгийн утгыг эхийн зураг, агуулга, ойр орчмын үг, өгүүлбэрийн утгаар таамаглаж уншина.	4.2д. Танил бус үгийн утгыг толь бичгээс судалж мэднэ.	5.2д. Танил бус үгийн утгыг толь бичиг болон бусад эх сурвалжаас судалж мэднэ.
	3.2е. Шинээр сурсан үгээ зохиож бичихдээ хэрэглэнэ.	4.2е. Шинээр сурсан үгээ эх зохиож бичихдээ хэрэглэнэ.	5.2е. Шинээр сурсан үгээ эх найруулан бичихдээ хэрэглэнэ.

Агуулгын ай 3. Бичих

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Зөв бичих	3.3а. Уншсан эхийн талаарх сэтгэгдлээ бичнэ.	4.3а. Бичих зүйлээ төлөвлөж бичдэг болно.	5.3а. Жишээ баримт, зураг, хүснэгтэн мэдээлэл хэрэглэн утгын уялдаа холбоотой, алдаагүй бичнэ.
	3.3б. Бүтэц, загвар, заавар, асуултын дагуу бичнэ.	4.3б. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг тодруулж бичнэ.	5.3б. Үйл явдлын учир шалтгааныг илрүүлж бичнэ.
Зохиож бичих	3.3в. Хүндэтгэлийн үг хэрэглэн бүтцийн дагуу урилга бичнэ.	4.3в. Ертөнцийн гурав, шүлгийн хэлбэрийг дуурайн зохиож бичнэ.	5.3в. Үлгэрийн гол (<i>кол</i>), төгсгөл (<i>түцнел</i>) хэсгийг үргэлжлүүлэн зохиож бичнэ.
	3.3г. Богино эх (харилцан яриа)-ийг түлхүүр үг, асуулт, нэг язгууртай үг, ойролцоо болон эсрэг утгатай үг хэрэглэн дэлгэрүүлж бичнэ.	4.3г. Эх (харилцан яриа)-ийг зүйр цэцэн үг, хэлц үг хэрэглэн дэлгэрүүлж бичнэ.	5.3г. Эх (харилцан яриа)-ийг түлхүүр үг, асуулт, зураг, хүснэгт дэх мэдээлэл, баримт нотолгоог хэрэглэн дэлгэрүүлэн зохиож бичнэ.

Агуулгын ай 4. Хэл зүйн болон үгийн сангийн хэрэглээ

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Хэл зүйн хэрэглээ	3.4а. Тийн ялгал болон шинэ үг бүтээдэг <i>-лыг, -ныг, -тыг, -дыг, -сак, -кы</i> залгаврыг зөв залгаж бичнэ.	4.4а. Өгүүлбэр, эх зохиож бичихдээ холбох үг (<i>болгааш, биле, ынчалза-даа, харын, а, ынчаарга</i>)-ийг зөв хэрэглэнэ.	5.4а. Нөхцөл (<i>өскертилге кожумаа</i>), дагавар (<i>чогаадылга кожумаа</i>)-ыг ялгаж, зөв хэрэглэнэ.
	3.4б. Хоёр үгнээс бүтсэн оноосон нэр (<i>Хой-Баштыг, Балыктыг-Хөл, Сарыг-Уруг, Көк-оол, Чечен-кыс, Бат-Эрдэнэ</i>), тэмдэг нэр (<i>ак-</i>	4.4б. а. Биеийн төлөөний үг (<i>мен, сен, ол, бис, силер, олар</i>)-ийг тийн ялгалаар зөв хувиргаж зөв бичнэ.	

	<i>көк, хүрөң-кызыл)-ийг зөв бичнэ.</i>	б. Тооны нэрийг зөв бичиж, хэрэглэнэ.	
	3.4в. Гийгүүлэгч <i>с, т, к, ш, л</i> үсгээр төгссөн үгэнд эгшгээр эхэлсэн залгавар залгаж зөв бичнэ: <i>дус-дузу, диш-дизи, тып-тывар.</i>	4.4в. Өгүүлбэр, эх зохиож бичихдээ үйл үгийн өнгөрсөн, одоо, ирээдүй цагт байгаа үйл үгийг зөв хэрэглэнэ.	
Үгийн сангийн хэрэглээ	3.4г. Үгийн нөөцөө нэмэгдүүлнэ: нэг язгууртай үг, ойролцоо утгатай үг, эсрэг утгатай үгийг ярьж, бичихдээ утга ялгаж хэрэглэнэ.	4.4г. Үгийн нөөцөө нэмэгдүүлнэ: тува хэлэнд орж ирсэн монгол болон харь үгийг ялгаж, ярьж, бичихдээ зөв хэрэглэнэ.	5.4б. Үгийн нөөцөө нэмэгдүүлнэ: хэлц үг, зүйр цэцэн үгийг тогтоож, зохиож бичихдээ хэрэглэнэ.
			5.4в. Нутгийн аялгууны онцлогтой үгийг зөв хэрэглэнэ: <i>эже (кырган-ача), калбы (бүрү).</i>

ГУРАВ. АРГА ЗҮЙ, ОРЧИН

3.1. Арга зүй

Зохиолд суурилсан арга зүй

“Суралцагчид мэдлэгийг өөрсдөө бүтээдэг” гэсэн үндсэн санаа бүхий конструктивизмын онолд тулгуурлан бага боловсролын түвшинд хэлний хичээлд зохиолд суурилсан арга зүйг хэрэгжүүлэх нь илүү тохиромжтой.

Зохиолд суурилсан сургалтын арга зүй нь сурагчдын хэл, сэтгэхүй, нийгмийн болон ёс суртахууны хөгжлийг дэмжих зорилгоор уран зохиолын эхийг сургалтын гол хэрэглэгдэхүүн болгон ашиглаж, оролцоог чухалчилсан суралцахуй төвтэй үйл ажиллагаагаар хэрэгжинэ.

Энэхүү арга зүйг хэрэгжүүлснээр суралцагчид зохиол унших аргачлалд суралцах, зохиол унших дүр сонирхолтой болох, тухайн зохиолд тулгуурласан ярилцлага, мэтгэлцээн нь суралцагчдын харилцан ойлголцлыг нэмэгдүүлэхээс гадна дараах үр дүнд хүрнэ. Тухайлбал,

- Унших сэдвийн хүрээнд танин мэдэхүйн мэдлэг, ойлголтоо өргөжүүлж, үгийн нөөцөө нэмэгдүүлэхэд болон чадварлаг, өөртөө итгэлтэй, шүүмжлэлтэй уншигч, зохиогч болоход тусална.
- Эхийг уншиж, уншсанаа ойлгож, бодит амьдралтай холбож, шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх, шүүн тунгаах, бүтээлчээр сэтгэх чадамжийг хөгжүүлнэ.
- Эхээс сайн, муу үйлийг ялгаж, дүрүүдийн эерэг зан чанараас суралцах боломжийг олгоно.

Зохиол нь Тува, Монгол үлгэр, оньсого, зүйр цэцэн үгс зэрэг аман зохиолын төрөл болон уламжлалт ёс заншил бүхий уран зохиол, уран зохиолын бус эх байна. Түүнчлэн эх зохиол нь дараах нийтлэг агуулгыг хамарсан байна. Үүнд: 1. тува, монгол уламжлалт ёс заншил (ахмадыг хүндэтгэх, бусдад туслах, эв найртай байх, муу үйл хийхгүй, хулгай хийхгүй, худал хэлэхгүй байх зэрэг), 2. эх оронч сэтгэлгээ (эх орон, түүний түүх, соёл, уламжлал, зан үйл, газарзүйн онцлог, байгалийн баялгаар бахархах, үндэстэн, угсаатны хэл, соёл, зан заншлаас харилцан суралцах, хүндлэн дээдлэх зэрэг) 3. тогтвортой хөгжлийн боловсрол (ус, цахилгааныг хэмнэх, цэцэг, мод тарих, арчлах, хамгаалах зэрэг), 4. эдийн засаг, санхүүгийн боловсрол (хичээлийн хэрэглэл, хувцас, хоол хүнс зэрэг аливаа эд зүйлийг ариг гамтай хэрэглэх зэрэг).

Зохиолд суурилсан сургалтын арга зүйгээр сурагчид унших чадвараа хөгжүүлэхээс гадна эх хэл дээр буюу тува хэл дээр тулгуурлан монгол хэлийг илүү чанартай сурахад анхаарна.

Зохиолд суурилсан арга зүйг дараах алхмыг баримтлан хэрэгжүүлнэ.

Алхам	Жишиг үйл ажиллагаа
Бэлтгэх, унших	<p><i>Бэлтгэх:</i></p> <ul style="list-style-type: none"> - Суралцагчдын өмнөх мэдлэгийг сэргээх; - Зохиолын нэр, зохиолч, сэдвийг танилцуулах - Ямар зохиол уншихыг зохиолын агуулгыг харуулсан зураг болон сэдвээр нь ургуулан бодож “Юуны тухай эх байж болох” талаар таамаглах, ярилцах, харилцан яриа өрнүүлэх; - Өмнө уншсан сэдэвтэйгээ холбох; <p><i>Унших:</i></p> <ul style="list-style-type: none"> - Унших арга хэлбэрээ сонгох (суралцагч эхийг бие дааж унших, хамтарч унших, чимээгүй унших, багш унших, багшийг дагаж унших, бусдыг сонсож ойлгоход зориулж чанга дуугаар унших, эхийг хэсэг хэсгээр эсвэл бүтнээр нь унших, эхийн агуулгыг илүү сайн ойлгохын тулд дахин унших, сонсох); - Зохиолын эхлэл хэсгийг уншаад үйл явдал цаашид хэрхэн өрнөхийг таамаглах
Үгийн нөөц нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none"> - Танил бус үгийг тэмдэглэх - Танил бус үгтэй ажиллах, үг хэллэг, өгүүлбэрийн утга тайлбарлах, тухайн үгийн ойр орчмын үг, өгүүлбэрээс утгыг нь таамаглах, тайлбар толь бичгээс үгийн утга судлах; - Төрөл бүрийн үгэн тоглоом тоглох; - Тухайн үгийн утгыг илэрхийлэх өгүүлбэр зохиох; - Үгийн утгыг илэрхийлэх өгүүлбэрийг тохирох зураг, тайлбартай нь зөв харгалзуулах, холбох зэрэг дасгал даалгавар гүйцэтгэх;

Уншиж ойлгох	<p><i>Шинжлэх:</i></p> <ul style="list-style-type: none"> - Зохиолын эхлэл, гол, төгсгөл хэсгийг тодруулах; - Эхлэл, гол, төгсгөл хэсэгт үйл явдал хэрхэн өрнөснийг тайлбарлах; - Дүрүүдийн зан чанар, үйл хөдлөлийг ярилцаж, сайн, муу үйлийг ялгаж, тухайн зохиол болон өөр зохиол, өөр дүртэй харьцуулах; <p><i>Бүтээх:</i></p> <ul style="list-style-type: none"> - “Хэрэв чи энэ дүрийн оронд байсан бол яах байсан бэ?” зэрэг асуулт асууж, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх аргаар багийн хэлэлцүүлэг хийх; - Дүрд тоглох, сонгосон дүрээс өөр дүрд хувирч тоглох; <p><i>Бичих:</i></p> <ul style="list-style-type: none"> - Уншсан зохиолын тухай сэтгэгдлээ бичих; - Эерэг, сөрөг дүр болон сайн, муу үйлийг ялгаж бичих; - Зохиолын гол болон төгсгөл хэсгийг өөр хувилбараар зохиож бичих; - Зохиосон эхээ бусдад уншиж, саналын дагуу сайжруулж бичих; - Зохиолын дүр болон үйл явдлыг өөр зохиолтой харьцуулж, дүгнэж бичих; - Зохиож бичихдээ ойролцоо утгатай үг, эсрэг утгатай үг, зүйр цэцэн үг, хэлц үг болон үгийн баялгаа ашиглан дэлгэрүүлж бичих; <p><i>Уншсанаа хэрэглээ болгох:</i></p> <ul style="list-style-type: none"> - Асуултын дагуу ярилцах, асуултын зөв хариултыг олж сонгох, агуулгыг зураг бүдүүвчээр харуулах, эхийн агуулгыг харуулсан зураг, өгүүлбэрийг зөв дараалалд оруулах, дугаарлах, уншсан зүйлтэйгээ ижил төсөөтэй өөр мэдээлэл хайх, эхийн утга санааг амьдралтайгаа холбон бодох, санал бодлоо илэрхийлэх; - Зохиолоос сургамжит хэсгийг болон өөртөө чухал гэсэн хэсгийг олж, яагаад сургамжтай, чухал гэж үзэж байгаагаа тайлбарлах, хоорондоо хэлэлцэх
Эргэцүүлэл хийх	<ul style="list-style-type: none"> - Өөрийн бүтээл, оролцоог эргэцүүлэн дүгнэх; - “Би юу сурсан бэ?”, “Юу хамгийн сонирхолтой байсан бэ?”, “Би дараа нь юуг сайжруулах вэ?” зэрэг асуултаар үнэлгээний ярилцлага хийх; - Сэтгэгдэл хуваалцах, тайлбарлах;

3.2. Сургалтын орчин

Сургалтын орчин нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад нөлөөлөх гол хүчин зүйл болохын зэрэгцээ суралцагчийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн сургалтын арга хэлбэрт тохирсон, эерэг

таатай уур амьсгал бүхий эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлнэ. Тухайлбал, суралцагчид бие биеэ сонсдог, харилцан суралцдаг, санаа бодлоо солилцдог, мэтгэлцдэг, чөлөөтэй харилцдаг орчин бүрдүүлсэн байхыг чухалчилна. Үүнд:

Эерэг таатай уур амьсгал бүхий харилцаа:

- Багш суралцагчдаа, суралцагч бие биедээ урам зориг өгдөг, харилцан хүндэтгэдэг, тууштай, тэвчээртэй байдлыг дэмждэг;
- Эхийг сонирхож уншдаг, сонсдог, сэдвийн хүрээнд дүрд хувирч хөгжилтэй тоглодог;
- Суралцагчийн идэвх, оролцоо, ахиц, амжилтыг нь урамшуулдаг;
- Багш, суралцагч, эцэг эхийн хамтын ажиллагааг дэмждэг;
- Ангийн болон сургуулийн аливаа үйл ажиллагаанд найз нөхөдтэйгөө эвтэй, нөхөрсгөөр хамтарч, харилцдаг;
- Санаа бодлоо нээлттэй илэрхийлдэг, бусдын шүүмжлэлийг эергээр хүлээн авч алдаагаа засаж сайжруулдаг;

Эрүүл, аюулгүй, хүртээмжтэй анги танхим:

- Суралцагч эх хэлээ сонирхон судлах тал бүрийн боломжийг хангасан лингафоны кабинеттай
- Бүтээлчээр ажиллах, суралцагч бүрийн оролцоог дэмжих боломжтой;
- Суралцагч бүрд хүрэлцэхүйц хэмжээтэй унших эх, зураг, дасгал даалгавар бүхий бүтээлч үйл ажиллагааг дэмжсэн, эрүүл ахуйн шаардлага хангасан сургалтын хэрэглэгдэхүүнтэй;
- Суралцагчид хөдөлгөөнтэй, бие биетэйгээ харилцах боломжтой, уян хатан зохион байгуулалттай (ширээний зохион байгуулалт, гэрэлтүүлэг);
- Сургалтын интерактив, дижитал хэрэглэгдэхүүн ашиглах боломжтой;

Ялгаатай байдлыг дэмжсэн, ялгаатай хэрэгцээг хангасан орчин:

- Суралцагчдын суралцах хэв маягийг (хараа, сонсгол, хөдөлгөөний) харгалзсан зураг, бүдүүвч, өнгө ялгасан материал, аудио хичээл, ярилцлага, практик туршилт, хөдөлгөөнт тоглоом ашиглах боломжтой;
- Хэл, соёлын ялгаатай суралцагчдад зориулсан сургалтын болон бусад толь бичигтэй;
- Суралцахуйн хоцрогдолтой болон илүү хурдтай суралцагчдад зориулсан ялгаатай даалгаврын сантай;

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

4.1. Үнэлгээний зорилго

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, төлөвшлийн давуу болон сул талыг илрүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг дэмжих, ахиц дэвшлийг урамшуулах, хүрсэн түвшнийг тодорхойлохын тулд өдөр тутмын сургалт, үйл ажиллагааны явцад ажиглаж, баримт нотолгоонд үндэслэн үнэлэхэд чиглэнэ.

Бага боловсролын эхлэл шатанд суралцагчийн үнэлгээ нь сонсох, сонссоноо ойлгох, унших, уншсанаа ойлгох, ойлгосноо аман болон бичгийн хэлээр илэрхийлэх чадварын ахиц, гүйцэтгэлийг илрүүлэх, суралцах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Бага боловсролын төгсгөл шатанд суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварын давуу болон сул талыг илрүүлэх, суралцахуйн үр дүнг үнэлж, дүгнэхэд чиглэнэ.

4.2. Үнэлгээний шалгуур

Хүрэх үр дүн	Шалгуур
Хэл зүй, үгсийн сангийн суурь мэдлэг, чадвар эзэмшиж, хэрэглэдэг болно.	<ul style="list-style-type: none">- Авиа, үсгийг зөв дуудаж, уншиж, зурлага, тигийн дагуу бичдэг.- Үг, өгүүлбэр, эхийн бүтцийг ойлгож, үгийн үндэс, язгуур, нөхцөл, дагаврыг ялгаж хэрэглэдэг.- Энгийн, асуух, анхааруулах өгүүлбэр болон өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүн гишүүн, хураангуй, дэлгэрэнгүй өгүүлбэрийг ойлгож, хэрэглэдэг.- Жинхэнэ нэр, тэмдэг нэр, тооны нэр, төлөөний үг, үйл үгийг утгаар болон асуултаар таньж, зохион бичихдээ хэрэглэдэг.
Уншсанаа ойлгодог, ойлгосноо аман болон бичгийн хэлээр ойлгомжтой илэрхийлдэг, зөв найруулан бичдэг чадвартай болно.	<p><i>Сонсох:</i></p> <ul style="list-style-type: none">- Яриа, заавар, асуулт, эхийг анхааралтай сонсож, ойлгосноо илэрхийлдэг.- Сэдвийн хүрээнд асуултад хариулж, шинэ санаа гаргаж хоорондоо ярилцдаг, мэтгэлцдэг. <p><i>Ярих:</i></p> <ul style="list-style-type: none">- Уншсан, сонссон эхийн талаар санаа бодол, сэтгэгдлээ илэрхийлэхдээ эхээс жишээ татан энгийн, бүтэн өгүүлбэрээр ойлгомжтой илэрхийлдэг.- Дүрийн зан чанар, үг, үйлдлийг харьцуулж, сайн муу үйлийг ялгаж, учир шалтгааныг тайлбарладаг.- Эхийн утгыг эхлэл, гол, төгсгөл хэсэг тус бүрээр тодруулж, учир шалтгааныг тайлбарладаг. <p><i>Унших:</i></p> <ul style="list-style-type: none">- Зурган эх болон уран зохиолын эхийг уншиж ойлгодог.

	<ul style="list-style-type: none"> - Танил бус үгийн утгыг эхийн зураг, агуулга, ойр орчмын үг, өгүүлбэрийн утгаар таамаглаж хэлдэг. - Эхээс өөртөө чухал санагдсан хэсгийг олж, яагаад чухал гэж үзэж байгаагаа тайлбарладаг. - Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийн холбоо хамаарлыг ойлгож, үйл явдлын учир шалтгааныг тоочиж тайлбарладаг. <p><i>Бичих:</i></p> <ul style="list-style-type: none"> - Түлхүүр үг, зураг, заавар, загварын дагуу өгүүлбэр, эх зохиож бичдэг. - Сэдвийн хүрээнд санаа бодол, сэтгэгдлээ утгын уялдаа холбоотой, алдаагүй зохиож бичдэг. - Бичих зүйлээ төлөвлөж, эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй, ойлгомжтой зохиож бичдэг. - Эхийг хүснэгтэн мэдээлэл, баримт нотолгоо хэрэглэн дэлгэрүүлэн найруулж бичдэг.
<p>Уран зохиолын бус эхийг уншиж ойлгон, санаа бодлоо баримт нотолгоонд үндэслэн бүтээлчээр илэрхийлдэг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Төрөл бүрийн эх уншиж гол санааг ойлгодог. - Уншсан эхээс ойлгосноо өөрийн санаа бодолтой харьцуулан баримт нотолгоонд үндэслэн тайлбарладаг.
<p>Аман зохиол, уран зохиол болон дэлхийн уран зохиолоос уншиж, үгийн сангаа баяжуулж, уламжлалт ёс заншлаас суралцаж бахархдаг, бусад үндэстний хэл, соёлоос суралцдаг чадвартай болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Тува, Монгол аман зохиол, уран зохиол болон дэлхийн уран зохиолоос уншиж, утга, хэл найруулгыг ойлгодог, санаа бодлоо нээлттэй хуваалцдаг. - Үгийн сангаа баяжуулж, сурсан шинэ үгээ аман болон бичгийн хэлэндээ хэрэглэдэг, өөрийн болон бусдын зохиосон эхийг өөрчлөх санаа гаргаж, сайжруулдаг. - Тува, Монгол уламжлалт ёс заншил, соёлоос суралцаж, түүгээр бахархаж байгаагаа илэрхийлдэг. - Бусад үндэстний хэл, соёлд хүндэтгэлтэй ханддаг, бусадтай эвтэй найрсаг харилцдаг.

КАЗАХ ХЭЛ

НЭГ. ЗОРИЛГО

1.1. Зорилго:

Казах хэлний сургалтын хөтөлбөрөөр суралцагчийн сонсох, ярих, унших, бичих суурь чадамж, харилцах, хамтран ажиллах, шүүн тунгаах, бүтээлчээр сэтгэх ерөнхий чадамжийг хөгжүүлнэ.

1.2. Хүрэх үр дүн, шатлал

Судлагдахууны хөтөлбөрийг хэрэгжүүлснээр суралцагч дараах үр дүнд хүрсэн байна.

- Үгийн нөөцөө нэмэгдүүлж, зөв ярих, зөв бичих дүрмийг хэрэглэдэг болно.
- Сонссон, уншсан мэдээллийг ойлгож, өөртөө хэрэгтэй мэдээллийг сонгож чаддаг болно.
- Санал бодол, сэтгэгдлээ бүтээлчээр илэрхийлдэг болно.
- Эх хэлээ сурахын ач холбогдлыг ойлгон, хэл соёлын ялгаатай байдлыг хүндэтгэж, бие даан болон хамтран суралцах чадвар, төлөвшилтэй болно.

№	Хүрэх үр дүн	Шатлал	
		I-II анги	III-V анги
1	Үгийн нөөцөө нэмэгдүүлж, зөв ярих, зөв бичих дүрмийг хэрэглэдэг болно.	<ul style="list-style-type: none"> - Таних тэмдэг, цэг тэмдгийг таньж, утгыг ойлгодог болно. - Хэлний анхан шатны ойлголтуудын талаар мэдээлэлтэй болж, ялгадаг болно. - Авиа, үгийг зөв дуудаж, зөв бичгийн дүрмийн дагуу бичдэг болно. - Танил бус үгийн утгыг ойлгож, үгийн нөөцийг нэмэгдүүлдэг болно. - Ном унших дуртай болно. 	<ul style="list-style-type: none"> - Нэр томъёо, таних тэмдэг, бүдүүвч, хүснэгт, графикийн утгыг ойлгодог болно. - Хэлний нэгжүүдийн үүргийг ойлгож, зөв хэрэглэдэг болно. - Зөв бичих дүрмийн дагуу бичдэг болно. - Үгийн нөөцийг нэмэгдүүлж, бүтээлчээр хэрэглэдэг болно. - Номыг бүтээлчээр уншдаг болно.
2	Сонссон, уншсан мэдээллийг ойлгож, өөртөө хэрэгтэй мэдээллийг	<ul style="list-style-type: none"> - Аман ярианы гол санааг ойлгодог болно. - Зургийг уншиж, утгыг ойлгодог болно. 	<ul style="list-style-type: none"> - Эх сурвалжаас шаардлагатай мэдээллийг олж, сонгож чаддаг болно. - Сонгосон мэдээллийг бүтээлчээр хэрэглэдэг болно.

	сонгож чаддаг болно.	<ul style="list-style-type: none"> - Үг, холбоо үг, өгүүлбэрийг зөв уншиж, утгыг ойлгодог болно. - Үг хэллэгийн хэрэглээг ойлгодог болно. 	<ul style="list-style-type: none"> - Мэдээллийг ойлгох, шинжлэх, нэгтгэх, харьцуулах, ангилах, дүгнэх чадвартай болно. - Үнэн, зөв мэдээллийг олохыг хичээж, шударга ёсыг дадал болгоно.
3	Санал бодол, сэтгэгдлээ бүтээлчээр илэрхийлдэг болно.	<ul style="list-style-type: none"> - Туршлага, сэтгэгдэл, санал бодлоо бүтээлчээр илэрхийлдэг болно. - Сэтгэгдэл, санал бодлоо илэрхийлэхдээ нэр томъёо, үг, хэллэгийг оновчтой хэрэглэдэг болно. - Сэдвийн дагуу асуулт асууж, асуултад бүтэн өгүүлбэрээр хариулдаг болно. - Амаар, бичгээр зохиож чаддаг болно. 	<ul style="list-style-type: none"> - Эхийн агуулгыг бусад хичээл, өдөр тутмын амьдралтай холбон, бүтээлчээр илэрхийлдэг болно. - Сэдвийн хүрээнд санал бодлоо илэрхийлэхдээ сонсогчдын анхаарлыг татдаг болно. - Биеийн хөдөлгөөн, гарын дохио, нүүрний хувирал болон дууны өнгийг тохируулан ярьдаг болно. - Эх сурвалж, мэдээлэлд үндэслэн ярьж, бичдэг болно. - Уран зохиолын бүтээл зохиодог болно. - Загварын дагуу эх зохиодог болно. - Бичгийн ажлын арга барилыг эзэмшдэг болно.
4	Эх хэлээ сурахын ач холбогдлыг ойлгон, хэл соёлын ялгаатай байдлыг хүндэтгэж, бие даан болон хамтран суралцах чадвар, төлөвшилтэй болно.	<ul style="list-style-type: none"> - Эх хэл, эх орон, төрсөн нутгийн талаар ойлголттой болно. - Бусдыг анхааралтай сонсдог болно. - Багаар ажиллаж сурдаг болно. - Санал бодлоо бусадтай хуваалцдаг болно. - Асуулт тавьж, хариулдаг болно. 	<ul style="list-style-type: none"> - Эх орон, эх хэл, ёс заншлын талаар ойлголттой болно. - Эх хэл болон төрийн хэлээ сурахын ач холбогдлыг ойлгодог болно. - Эх хэлний яруу сайхныг мэдэрч, бахархдаг болно. - Мэдээллийг идэвхтэй (харилцан ярилцаж) сонсдог болно. - Баг дотор өөрийн үүрэг хариуцлагаа ойлгодог болно. - Найз нарын ялгаатай байдлыг ойлгож, хүлээцтэй ханддаг болно. - Эрдэм номын ач тусыг ойлгож, сурах эрмэлзэлтэй болно.

ХОЁР. АГУУЛГА

2.1. Бага боловсролын эхлэл шатлал

Агуулгын ай 1. Сонсох-ярих

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Уран зохиолын бус эхийн агуулгыг ойлгох, тайлбарлах	1.1а. Багшийн яриа, асуулт, зааврыг анхааралтай сонсоно.	2.1а. Багш, ангийнхны яриаг анхааралтай сонсож, ойлгоогүй зүйлээ асууна.
	1.1б. Асуулт асууж, асуултад бүтэн өгүүлбэрээр хариулна.	2.1б. Юмс үзэгдлийн шинж чанарыг илэрхийлсэн үг хэрэглэн хариулна.
	1.1в. Зургийн дагуу өгүүлбэр зохиож ярина.	
Уран зохиолын эхийн агуулгыг ойлгох, тайлбарлах	1.1г. Сонсох эхийн агуулгыг зураг ашиглан таамаглана.	2.1в. Түлхүүр үг, цуврал зураг ашиглан дүрүүдийг нэрлэж, агуулгыг таамаглана.
	1.1д. Үйл явдлын өрнөлөөр дүрийн үйл хөдлөлийг тайлбарлана.	2.1г. Дүрийн үг, яриаг дуурайн хэлнэ.
	1.1е. Шүлэг, оньсого, зүйр цэцэн үгийг олны өмнө цээжээр хэлнэ.	1.2д. Сэдэвтэй холбоотой өгүүлбэр, эх зохионо. 2.1е. Шүлэг, оньсого, зүйр цэцэн үгийн утгыг ойлгож, цээжээр уран тод уншина.
Аман ярианы гол санааг ойлгох	1.1ж. Мэндлэх, өөрийгөө танилцуулах (өөрийн болон эцэг, эхийн нэр, анги, насыг хэлэх зэрэг) үед харилцагчийн яриаг анхааралтай сонсоно.	2.1ж. Талархал илэрхийлэх, хүсэлт гаргах, баяр хүргэх, уучлал гуйх, зөвшөөрөл авах утга бүхий яриаг ойлгож, түлхүүр үгсийг зөв хэрэглэнэ.
Сэдвийн хүрээнд санал бодлоо илэрхийлэх	1.1з. Богино дүрс бичлэг дэх үг, дүрс, агуулгын талаар өөрийн бодлоо (таалагдсан, таалагдаагүй) илэрхийлнэ.	2.1з. Дуу, дүрс бичлэгийн агуулгатай холбоотой өөрийн бодлоо (таалагдсан, таалагдаагүй, шалтгаан нь...) илэрхийлнэ.
	1.1и. Хөдөлгөөн, дохио зангаар сонсогчийн анхаарлыг татна.	2.1и. Үг, ярианы өнгө, үйл хөдөлгөөн, дохио зангаар сонсогчийн анхаарлыг татна.

Агуулгын ай 2. Унших

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Эх сурвалжаас хэрэгтэй мэдээллээ олох	1.2а. Тэмдэг, даалгавар, дасгалын зааврыг ойлгоно.	2.2а. Зурагтай богино эхээс багшийн дэмжлэгтэйгээр хэрэгтэй мэдээллийг олно.
	1.2б. Багшийн дэмжлэгээр зураг болон эхийн агуулгын талаар асуулт асууж, хариулна.	2.2б. Эхийн агуулгыг тодруулах зорилго бүхий асуулт (хэн? юу? ямар? хэд?) асууж, хариулна.
Уран зохиолын эхийн агуулга, гол санааг ойлгох	1.2в. Үг, өгүүлбэр, эхийг зөв, ойлгож уншина.	2.2в. Үлгэр, богино өгүүллэг, шүлэг, зүйр цэцэн үг, хэл зүгшрүүлэх үгийг зөв, хурдан, ойлгож, уран тод уншина.
	1.2г. Багшийн дэмжлэгээр эхэд хэн, юуны тухай өгүүлснийг тодорхойлно.	2.2г. Эхийн дүрүүдийг нэрлэж, сэдэв, гол санааг тодорхойлно.
Уран зохиолын бус эхийн гол санааг тодорхойлох	1.2д. Мэндчилгээ, танилцуулга гэх мэт загвар эхийн түлхүүр үгсийг таньж, утгыг ойлгоно.	2.2д. Мэндчилгээ, талархал бүхий эхийн гол санааг тодорхойлж, бүтэц, хэсгүүдэд хуваана.
Эхийн төрөл, бүтцийг тодорхойлох	1.2е. Үг, өгүүлбэр, эхийн бүтцийг (үгийн үеийн тоо, өгүүлбэр дэх үгийн тоо, эх дэх өгүүлбэрийн тоо) зураглалын дагуу ойлгоно.	2.2е. Багшийн дэмжлэгээр эхийн төрлийг (хүүрнэл, дүрслэл) болон бүтцийг (эхлээд? дараа нь? төгсгөлд нь?) тодорхойлно.

Агуулгын ай 3. Бичих

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Эх сурвалж, мэдээлэлд тулгуурлан бичгийн ажил гүйцэтгэх	1.3а. Үг, зураг ашиглан үг, өгүүлбэр зохиож бичнэ.	2.3а. Эх дэх танил бус үгсийг тодорхойлно.
		2.3б. Зураг, түлхүүр үг ашиглан өгүүлбэр, эх зохионо.
Уран зохиолын эх зохиож бичих	1.3б. Үйл явдал бүхий зураг ашиглан өгүүлбэр, эх зохиож бичнэ.	2.3в. Зураг, түлхүүр үг, асуулт ашиглан багшийн тусламжаар эх зохионо.
		2.3г. Шүлгийн холбоц (толгой, сүүл холбоц)-ыг олно.
Загварын дагуу эх зохиох	1.3в. Түлхүүр үгсийг ашиглан мэндчилгээ, танилцуулгатай	2.3д. Загварын дагуу талархлын захидал, баярын мэндчилгээ, дэвтрийн хаяг, байршлын мэдээлэл бичнэ.

	холбоотой өгүүлбэр, эх зохионо.	2.3е. Зураг, сэдвийн дагуу харилцан яриа зохиож бичнэ.
Зохион бичих арга барилаас суралцах	1.3г. Багшийн дэмжлэгээр зургийн дагуу эх зохиож бичнэ.	2.3ж. Багшийн дэмжлэгээр үйл явдал бүхий зураг, бодит үзүүлэн ашиглан хүүрнэл, дүрслэл бүхий эх зохиож бичнэ.

Агуулгын ай 4. Хэл зүйн дүрэм болон үгийн сангийн хэрэглээ

Дэд ай	Суралцахуйн үр дүн	
	I анги	II анги
Зөв дуудах, зөв бичих	1.4а. Авиа, үсгийг танина.	2.4а. У, и, й, ё, я, ю үсгийг зөв уншиж, зөв бичих дүрмийн дагуу хэрэглэнэ.
	1.4б. Эгшиг, гийгүүлэгч авиа, ь, ь тэмдгүүдийг ялгана.	2.4б. Эр, эм эгшгийг, мөн эр, эм эгшиг орсон үсгийг ялгана.
	1.4в. Том, жижиг, дармал болон бичмэл үсгийг хэрэглэнэ.	2.4в. Үгийг үеэр тасалж, мөр шилжүүлж бичнэ.
	1.4г. Цагаан толгойн дарааллыг мэднэ.	
Үгийн нөөцийг нэмэгдүүлэх	1.4д. Багшийн дэмжлэгээр үгийн утгыг ойлгоно.	2.4г. Багшийн дэмжлэгээр үгийн утгыг (ижил утгатай, эсрэг утгатай) ялгана.
Үгсийн аймаг ба бүтцийг таних	1.4е. Хүний нэр болон өгүүлбэрийг том үсгээр эхэлж бичнэ.	2.4д. Олон тооны нөхцөлийг зөв хэрэглэнэ.
	1.4ж. Хэн?, юу? хэд? ямар? гэсэн асуултад хариулна.	2.4е. Хэн?, юу?, хэд?, хэдэн?, ямар?, аль?, яасан?, юу хийсэн? зэрэг асуултад хариулах үгсийг таньж ялгана.
Өгүүлбэр, эхийн төрлийг ялгах	1.4з. Өгүүлбэрийг том үсгээр эхэлж, төгсгөлд нь цэг эсвэл асуултын тэмдэг тавина.	2.4ж. Өгүүлбэрийн төрлийг (хүүрнэх, асуух, анхааруулах) ялгана.
		2.4з. Цэг, асуулт, анхаарлын тэмдгийг зөв хэрэглэнэ.

2.2. Бага боловсролын төгсгөл шатлал

Агуулгын ай 1. Сонсох-ярих

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Уран зохиолын бус эхийн	3.1а. Бусдын ярьсан, уншсаныг анхааралтай сонсоно.	4.1а. Бусдын ярьсан, уншсаныг хүлээцтэй сонсоно.	5.1а. Мэдээллийг идэвхтэй (харилцан ярилцаж) сонсоно.

агуулгыг ойлгох, тайлбарлах	3.1б. Ойлгоогүй үгээ тэмдэглэж, утгыг асууна.	4.1б. Түлхүүр үгсийг тогтоож авна.	5.1б. Диаграмм, хүснэгт, бүдүүвчээр өөрийн санааг нотолгоотой илэрхийлнэ.
	3.1в. Түлхүүр үгсийг ашиглан асуултад хариулна.	4.1в. Түлхүүр үгсийг ашиглан нээлттэй асуултад хариулна.	5.1в. Сэдвийн хүрээнд асуулт асууна.
	3.1г. Түлхүүр үгсийг ашиглан эхийн агуулгыг ярина.	4.1г. Түлхүүр үгсийг ашиглан эхийн агуулгыг дарааллаар ярина.	5.1г. Эхийн агуулгыг төлөвлөгөөний дагуу ярина.
Уран зохиолын эхийн агуулгыг ойлгох, тайлбарлах	3.1д. Гарчиг, түлхүүр үгэнд үндэслэн эхийн агуулгыг таамаглана.	4.1д. Гарчиг болон дүрс бичлэгийн хэсгээр эхийн агуулгыг таамаглана.	5.1д. Гарчиг, эхлэл, төгсгөл хэсгээр агуулгыг таамаглана.
	3.1е. Эхийн дүрийн үг, үйлдлийг дуурайн дүрээр тоглоно.	4.1е. Эхийн гол санаа (сургамж), эхээс төрсөн сэтгэгдэлд тулгуурлан ярина.	5.1е. Хэлц үгсийг оролцуулан өөрт таалагдсан хэсгийн агуулгыг урнаар ярина.
	3.1ж. Шүлэг, зүйр цэцэн үг, оньсогын утгыг ойлгож, уран уншина.	4.1ж. Шүлэг, зүйр цэцэн үг, оньсогын утгыг ойлгож, зааврын дагуу уран уншина.	5.1ж. Сургаал үг, ардын дуу, ерөөл, магтаал, харилцаа дууны утга, онцлогийг тайлбарлаж, зааврын дагуу уран уншина, дуулна.
	3.1з. Оньсогыг хэрхэн тааснаа тайлбарлана.	4.1з. Оньсого, логик асуултыг хэрхэн тааснаа тайлбарлана.	
Аман ярианы гол санааг ойлгох	3.1и. Өдрийн дэглэм, санал асуулга, захиа, зар сурталчилгааны гол санааг ойлгоно.	4.1и. Зар сурталчилгаа, урилга, уриалгын гол санааг ойлгоно.	5.1з. Намтар, өдрийн тэмдэглэлийн гол санааг ойлгоно.
	3.1к. Харилцан ярилцахдаа үг, хөдөлгөөн, дохио зангаар санаагаа илэрхийлж, ярианы соёлыг баримтална.	4.1к. Үг, дохио, хөдөлгөөн, харцаар санаагаа илэрхийлнэ.	5.1и. Ганцаарчилсан яриа зохиохдоо өөрийн ахиц, амжилт, баяр, сэтгэгдлээ баримттай илэрхийлнэ.
Сэдвийн хүрээнд санал бодлоо илэрхийлэх	3.1л. Дуу, дүрс бичлэгийн агуулгад үндэслэн санаагаа илэрхийлнэ.	4.1л. Дуу, дүрс бичлэг, ТВ нэвтрүүлгийн агуулгад үндэслэн санал бодлоо илэрхийлнэ.	5.1к. Бусдын бодлыг сонсож, өөрийн байр сууриа баримтаар илэрхийлнэ.

	3.1м. Сонсогчийн анхаарлыг татах зураглал, уран яруу дүрслэл бүхий үг хэллэг хэрэглэнэ.	4.1м. Уран дүрслэлтэй үг (зүйрлэл, тодорхойлолт, харьцуулалт) хэрэглэнэ.	5.1л. Зүйрлэл, адилтгал, дүрслэл зэрэг утга зохиолын хэрэгслүүдийг ашиглан уран ярина.
--	-----------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------

Агуулгын ай 2. Унших

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Эх сурвалжаас хэрэгтэй мэдээллээ олох	3.2а. Багшийн дэмжлэгээр толь бичиг, лавлах, нэвтэрхий толиос шаардлагатай мэдээллийг цуглуулж, ангилна.	4.2а. Толь бичиг, хэвлэл, лавлах, нэвтэрхий толиос мэдээлэл хайх аргыг (гүйлгэж харах, тэмдэглэх) мэднэ.	5.2а. Шаардлагатай мэдээллийг олохын тулд толь бичиг, нэвтэрхий толь, интернэт, газрын зураг зэрэг олон төрлийн эх сурвалж ашиглаж сурна.
	3.2б. Мэдээллээс өөртөө таалагдсан, шаардлагатай хэсгийг олж, тэмдэглэнэ.	4.2б. Мэдээллийг загвар хүснэгтэд оруулна.	5.2б. Мэдээлэлд дүн шинжилгээ хийж, бүдүүвч хэлбэрээр илэрхийлнэ.
Уран зохиолын эхийн агуулгыг ойлгох	3.2в. Эхийн агуулгыг тодруулах асуулт (хэн? юу? ямар? хаана? хэд? яасан?) зохиож, тодорхой хариулна.	4.2в. Эхийн агуулгыг нарийвчлан ойлгох асуулт (ямар? хаана? хэзээ?) зохиож, асуултад гүйцэд хариулна.	5.2в. Эхийн агуулгыг үнэлэх, шийдвэр гаргахад чиглэсэн асуулт (яагаад? юунд?) зохиож, баримттай хариулна.
	3.2г. Үлгэр, домог, өгүүлэл, шүлэг, зүйр цэцэн үг, хэл зүгшрүүлэх үг, оньсогыг ойлгож, уран (аялга, өнгө аяс) уншина.	4.2г. Хэл зүгшрүүлэх үг, түргэн хэллэгийг унших зааврын дагуу уран тод уншина.	5.2г. Гарчиг, сэдэв, эхийн агуулгын уялдааг тодорхойлно.
	3.2д. Багшийн дэмжлэгээр эхийн гол санаа (ёс суртахуун, сургамж)-г тодорхойлно.	4.2д. Эхийн үйл явдал, гол санааг тодорхойлно.	5.2д. Эхийн гол санаа, далд утгыг (магтаал, ерөөл, бэлгэдэл, элэглэл, ёжлол зэрэг) тодорхойлно.

	3.2е. Зохиолын баатруудын үг, яриаг дүрээр уншина.	4.2е. Дүрийг тодорхойлж, харьцуулж, онцолсон хэсгийг сонгон уншина.	5.2е. Дүрийн үйл, яриа, ялгаатай үзэл бодлыг өөрийн үзэл бодолтой харьцуулан, дүгнэлт, үнэлгээ өгнө.
Уран зохиолын бус эхийн гол санааг тодорхойлох	3.2ж. Өдрийн дэглэм, санал асуулга, захиа, зарлал зэрэг загвар эхийн гол санааг тодорхойлно.	4.2ж. Зар сурталчилгаа, уриалга, урилга зэрэг загвар эхийн гол санааг тодорхойлно.	5.2ж. Намтар, өдрийн тэмдэглэл зэрэг загвар эхийн гол санааг тодорхойлж, бүтцээр ангилна.
	3.2з. Өдрийн дэглэм, санал асуулга, захиа, зарлалын эхийг бүтцээр ангилна.	4.2з. Зар сурталчилгаа, уриалга, урилга зэргийг бүтцээр ангилна.	5.2з. Намтар, өдрийн тэмдэглэлийн эхийг бүтцээр ангилж, цогцолборын уялдааг харуулна.
Эхийн төрөл, бүтцийг тодорхойлох	3.2и. Багшийн дэмжлэгээр асуулт (юу хийсэн? ямар?) тавьж, хүүрнэх, дүрслэх эхийн ижил, ялгаатай талыг тодорхойлно.	4.2и. Асуулт (юу хийсэн? ямар? яагаад?) тавьж, ижил сэдэвт эхийн нийтлэг ба ялгаатай талыг олно.	5.2и. Асуулт (юу хийсэн? ямар? яагаад?) ашиглан эхийн төрлийг тодорхойлно.
	3.2к. Багшийн дэмжлэгээр хүүрнэх, дүрслэх эхийн бүтэц (эхлэл, гол хэсэг, төгсгөл)-ийг тодорхойлно.	4.2к. Ижил сэдэвтэй эхийн бүтцийг тодорхойлж, цогцолбор бүрд нэр өгнө.	5.2к. Эхийн бүтцийг тодорхойлж, цогцолборын утгын уялдааг тодорхойлно.

Агуулгын ай 3. Бичих

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Эх сурвалж, мэдээлэлд тулгуурлан бичгийн	3.3а. Уншсан, сонссон эх, дуу, дүрс бичлэгээс түлхүүр үгсийг тэмдэглэж авна.	4.3а. Уншсан, сонссон эх, дуу, дүрс бичлэгийн агуулгыг зураглал, хүснэгт, бүдүүвч, график хэлбэрээр бичнэ.	5.3а. Уншсан, сонссон эх, дуу, дүрс бичлэгээс зүйр цэцэн үг, хэлц үгсийг тэмдэглэж бичнэ.

ажил гүйцэтгэх	3.3б. Эхийн мэдээллийг нэгтгэн хүснэгт, бүдүүвч дээр тэмдэглэнэ.	4.3б. Зураг, тэмдэг, бүдүүвчийг ашиглан эх зохионо.	5.3б. Эх, дуу, дүрс бичлэгийн агуулга, гол санааг төлөвлөгөө, баримт (диаграмм, хүснэгт, бүдүүвч)-д тулгуурлан бичнэ.
Уран зохиолын эх зохиож бичих	3.3в. Түлхүүр үгсийг ашиглан дүрийн зан чанарыг тодорхойлж бичнэ.	4.3в. Багшийн дэмжлэгээр дүрийн зан байдлыг харьцуулан бичнэ.	5.3в. Төлөвлөгөөний дагуу зохион бичлэг бичнэ.
	3.3г. Үлгэр, өгүүллэгийн эхлэл, гол хэсгийг гүйцээж бичнэ.	4.3г. Зургийн дагуу шинэ дүр, үзэгдэл нэмж, зохиолын төгсгөлийг өөрчилнө.	5.3г. Үлгэр, өгүүллэгийн гол санааг зүйр үг, мэргэн үгээр дүгнэж бичнэ.
	3.3д. Шүлгийн мөр, үгийг зөв байршуулан бадаг бүтээнэ.	4.3д. Загварын дагуу дөрвөн мөрт, оньсого зохионо.	5.3д. Үлгэр, шүлгийг дуурайж бяцхан зохиол бичнэ. 5.3е. Оньсого, зүйр цэцэн үг, түргэн хэллэг зохиож бичнэ.
Загварын дагуу эх зохиох	3.3е. Түлхүүр үг, өгүүлбэр, зураг ашиглан өдрийн дэглэм, санал асуулга, зарлал, зохиолын баатарт захидал бичнэ.	4.3е. Загварын дагуу зар сурталчилгаа, урилга, уриалга бичиж, постер хийнэ.	5.3ж. Өдрийн тэмдэглэл, намтар бичихдээ өөрийн амжилт, баяр баясал, сэтгэгдлээ тусгана.
		4.3ж. Багшийн дэмжлэгээр бүдүүвч, зураг ашиглан захидал, урилга, хүсэлт зэргийг компьютер дээр шивж бичнэ.	5.3з. Өдрийн тэмдэглэл, намтар бичихдээ зураг оруулж, компьютер дээр шивж бичнэ.
Зохион бичих арга барилаас сурах	3.3ж. Багшийн дэмжлэгээр эхийн эхлэл эсвэл төгсгөлийг гүйцээн бичнэ.	4.3з. Бүдүүвч, төлөвлөгөө ашиглан санаагаа өрнүүлэн бичнэ.	5.3и. Эхийн гол санааг зүйр үг, мэргэн үг, жишээ эшлэлээр дүгнэж бичнэ.
	3.3з. Багшийн дэмжлэгээр зурагт үзүүлэн, түлхүүр үг, үйл явдлын зураг ашиглан хүүрнэх, дүрслэх эх зохиож бичнэ.	4.3и. Ижил, эсрэг, салаа утгатай үгсийг ашиглан, юмс үзэгдлийн талаар хүүрнэн бичнэ.	5.3к. Холбох үгс (учир нь, хэрэв, тэгвэл, тиймээс зэрэг)-ийг ашиглан хүүрнэх, дүрслэх, эргэцүүлсэн эх зохиож бичнэ.

Агуулгын ай 4. Хэл зүйн дүрэм болон үгийн сангийн хэрэглээ

Дэд ай	Суралцахуйн үр дүн		
	III анги	IV анги	V анги
Зөв дуудах, зөв бичих	3.4а. У-ү-ө, и-й, б-п, д-т, қ-ғ, к-г, л-р, н-ң үсгийг зөв хэрэглэнэ.	4.4а. Харь үгэнд ордог үсгийг (э, в, ф, ц, ч, щ, х, һ) зөв дуудаж, зөв бичгийн дүрмээр бичнэ.	5.4а. Үгэнд залгавар залгахдаа эгшиг зохицох ёс болон үеийн зохицлыг харгалзана.
		4.4б. Харь үгсийн утгыг ойлгоно.	
Үгийн нөөцийг нэмэгдүүлэх	3.4б. Багшийн дэмжлэгээр үгийн утгыг (ижил утгатай, эсрэг утгатай, адил дуудлагатай, олон утгатай) ялган бичнэ.	4.4в. Нийлмэл үгсийг (хоршоо, товчилсон, холбоо) ялгаж, зөв бичгийн дүрмийн дагуу бичнэ.	5.4б. Хэлц үг болон олон утгатай үгийн утгыг ойлгож, зөв хэрэглэнэ.
Үгсийн аймаг ба бүтцийг таних	3.4в. Нэр үг, тэмдэг нэр, тооны нэр, үйл үгийг асуултаар ялгана.	4.4г. Тооны нэрийг (тоо ширхэг, дэс дугаар, энгийн, нийлмэл) зөв бичгийн дүрмээр бичнэ.	5.4в. Орон байр, цаг хугацаа заасан үгийг утгаар нь ялгаж, үйл үгтэй хамт хэрэглэнэ.
	3.4г. Оноосон нэрийг ялгана.	4.4д. Үйл үгийг өнгөрсөн, одоо, ирээдүй цагт хэрэглэнэ.	5.4г. Холбох үгсийг (жөне, себебі, мен, пен) хэрэглэнэ.
	3.4д. Хамаатуулах нөхцөлийг хэрэглэнэ.	4.4е. Баймжийн залгаврыг хэрэглэнэ.	5.4д. Нэр үг, төлөөний үгийг тийн ялгалаар хувиргана.
	3.4е. Энгийн болон нийлмэл нэр үг, тэмдэг нэр, тооны нэр, үйл үгийг таньж мэднэ.	4.4ж. Үндсэн болон үүсмэл нэр үг, тэмдэг нэр, үйл үгийг ялгана.	5.4е. Чимэх үгийг танина, хэрэглэнэ.
	3.4ж. Үгийн үндэс ба залгаврыг багшийн дэмжлэгээр ялгана.	4.4з. Дагавар, нөхцөлийн онцлог, тэмдэглэгээг танина.	5.4ж. Үгийг бүтцээр задална.
		4.4и. Язгуур дээр залгавар залгаж, үүсмэл үг бүтээнэ.	5.4з. Нэр үг, үйл үг үүсгэдэг залгаврыг ялгана.
4.4к. Нэг язгууртай үгсийн утгыг ойлгоно.			

Өгүүлбэр, эхийн төрлийг ялгах	3.4з. Өгүүлбэрийн утгын төрлийг ялгаж, цэг тэмдэг (цэг, асуулт, анхаарлын тэмдэг) зөв тавина.	4.4л. Өгүүлбэрийн бүтцийн төрөл (энгийн болон нийлмэл өгүүлбэр) ялгаж, цэг тэмдгийг (таслал) зөв тавина.	5.4и. Өгүүлбэрийн гол гишүүдийн асуулт, үүргийг мэднэ.
	3.4и. Өгүүлбэрийн нэг төрлийг нөгөөд шилжүүлнэ (жишээ нь: асуух өгүүлбэрийг хүүрнэх болгож хувиргах).	4.4м. Харилцан ярианы цэг тэмдгийг хэрэглэнэ.	5.4к. Өгүүлбэрийн зэрэгцсэн гишүүдийг ялгана, таслал тавина.

ГУРАВ. АРГА ЗҮЙ, ОРЧИН

3.1. Арга зүй

Эх хэлний судлагдахууны хөтөлбөрийн суралцахуйн онол нь конструктив (Constructivist Theory) болон когнитив онол (Cognitive Theory)-д суурилдаг. Конструктив онолоор суралцагч мэдлэгийг өөрийн туршлага, орчинтой харилцан үйлчлэлээр бүтээдэг, багш нь чиглүүлэгч, дэмжигчийн үүргийг гүйцэтгэдэг бол когнитив онолоор суралцахуйн үйл нь мэдээллийг хүлээн авах, боловсруулах, хадгалах, сэргээн санахтай холбоотой танин мэдэхүйн үйл явц болохоор суралцагч өөрийн бүтээсэн мэдлэг, туршлагаа боловсруулах, хадгалах, хэрэглэх чадвартай болно. Мөн суралцах хэв маяг, сэтгэл хөдлөлийн байдал, сонирхол, зорилго зэрэг хувь хүний хүчин зүйлс суралцах үйлд нөлөөлдөг тул хувь хүний хэрэгцээ, сонирхолд нийцсэн сургалтыг зохион байгуулахыг харгалзаж үзэх нь чухал байдаг.

Конструктив онолыг хэлний хичээлд, ялангуяа зохиол дээр ажиллахад хэрэгжүүлэх нь сурагчдын сэтгэлгээ, ойлголт, бүтээлч чадварыг хөгжүүлэхэд маш үр дүнтэй байдаг. Энэхүү онолын дагуу сурагчид зохиолын утга агуулга, дүр, сэдэв, хэлбэрийг өөрсдийн туршлага, мэдлэг дээр тулгуурлан тайлбарладаг. Үүнийг сургалтад асуудалд суурилсан уншлага, хэлэлцүүлэг, мэтгэлцээн, дүрд тоглох, бүтээлчээр бичих, холбоо үүсгэх, суралцагчдын сонирхлыг өдөөх, хамтран суралцах төсөл, дасгал, даалгавар зэрэг үйл ажиллагаагаар хэрэгжүүлнэ. Жишээ нь:

Асуудалд суурилсан уншлагын арга:

- Зохиолын гол асуудлыг тодорхойлж, өөрийн байр суурь, шийдлийг гаргах;
- “Энэ зохиолын баатар яагаад ийм шийдвэр гаргасан бэ?” зэрэг асуултаар хэлэлцүүлэг өрнүүлэх.

Хэлэлцүүлэг, мэтгэлцээн:

- Зохиолын сэдвээр багт хуваагдан өөр өөр байр суурь илэрхийлж, мэтгэлцэх. Энэ нь олон өнцгөөс сэтгэх, логик тайлбарлах чадварыг хөгжүүлнэ.

Дүрд тоглох:

- Зохиолын дүрийн сэтгэлзүй, үйл хөдлөлийг тайлбарлаж, дүрээр тоглох. Энэ нь дүрийн дотоод зөрчил, сэтгэл хөдлөлийг ойлгоход тусална.

Бүтээлчээр бичих:

- Зохиолын үргэлжлэлийг бичих, өөр өнцгөөс бичих, өөр төгсгөл зохиох. Энэ нь сурагчид зохиолын бүтэц, хэлбэр, утгыг гүнзгий ойлгож, өөрийнхөөрөө илэрхийлэхэд дэмжлэг болно.

Холбоо үүсгэх арга:

- Зохиолын үйл явдал, дүрийг өөрийн амьдралтай, эсвэл нийгмийн нөхцөл байдалтай холбож тайлбарлах. Жишээ нь: “Тус зохиолын үйл явдал өнөөгийн нийгэмд хэрхэн хамааралтай вэ?”, “Хэрвээ та ийм нөхцөлд орвол яах вэ?” зэрэг.

Хамтран суралцах төсөл:

- Суралцагчид зохиолын сэдвээр судалгаа хийж, постер, видео, эсвэл танилцуулга бэлдэж танилцуулах. Энэ нь хэлний чадвар, бүтээлч байдал, хамтын ажиллагааг дэмжинэ.

Сургалтын орчинд хэрэгжүүлэх арга барил:

- *Нээлттэй асуулт тавих:* Суралцагчдыг бодож, эргэцүүлж, өөрсдийн хариултыг бүтээхэд чиглүүлнэ.
- *Кейс судалгаа ашиглах:* Бодит нөхцөл байдалд тулгуурласан сургалт нь мэдлэгийн хэрэглээг нэмэгдүүлдэг.
- *Технологи ашиглах:* Онлайн платформ, STEM портал зэрэг нь конструктив онолыг дэмждэг.
- *Багшийн чиглүүлэгч үүрэг:* Багш нь мэдлэгийг шууд дамжуулагч бус, суралцах үйл явцыг чиглүүлэгч, дэмжигч байх ёстой.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эх (зохиол)-д суурилсан арга зүйг үндсэн арга зүй болгон хэрэглэнэ. Энэ нь хэлний суурь чадварууд (сонсох-ярих, унших, бичих, хэл зүйн хэрэглээ, үгийн нөөцийг нэмэгдүүлэх) болон суралцагчдын сэтгэлгээ, хэл яриа, уран дүрслэл, уран бүтээлч чадварыг хөгжүүлэхэд чиглэнэ.

Зохиолд суурилсан арга зүй нь голчлон:

- Суралцахуйн сэтгэлзүйн үндсийг тавьж, хүүхдийн сэтгэлгээ, хэл яриа, нийгмийн харилцааг хөгжүүлэхэд зохиолын үүргийг онцолдог.
- Суралцагчид бодит амьдралтай холбож, сургамж, үнэт зүйлсийг ойлгож, бүтээлчээр сэтгэж сурдаг.
- Хэлэлцүүлэг, дүрд тоглох, зохиолын үргэлжлэлийг бичих зэрэг нь хүүхдийн оролцоог нэмэгдүүлдэг.

Энэхүү арга зүйг дараах алхмаар хэрэгжүүлж болно.

Алхам	Жишиг үйл ажиллагаа
Асуулт асуух, таамаглал дэвшүүлэх	<ul style="list-style-type: none"> - Зохиолын нэр, зохиолч, сэдвийг танилцуулах; - “Энэ зохиолд юуны тухай ярих бол?”, “Ямар дүр гарах бол? Тэр юу хийх бол?” зэрэг асуултаар таамаглал дэвшүүлэх; - Зохиолын эхлэл хэсгийг уншаад, үргэлжлэлийг таамаглах.
Төлөвлөх, унших үйл явцыг чиглүүлэх	<ul style="list-style-type: none"> - Зохиолын бүтэц, гол дүр, үйл явдлын өрнөлд анхаарах, чиглэл өгөх; - “Дүрийн зан чанарыг хэрхэн илэрхийлсэн байна вэ?”, “Зохиолч ямар уран дүрслэл ашигласан вэ?” зэрэг асуултаар унших төлөвлөгөө гаргах.
Унших, өгөгдөл цуглуулж, задлан шинжлэх	<ul style="list-style-type: none"> - Зохиолыг хэсэгчлэн унших; - Гол санаа, дүр, уран дүрслэл, хэл найруулгын онцлогийг тэмдэглэх; - Үйл явдлыг хүснэгт, зураглал, хураангуйгаар илэрхийлэх; - “Яагаад ийм үйл явдал болсон бэ?”, “Дүрийн үйлдэл зөв байсан уу?” зэрэг асуултаар задлан шинжлэх.
Дүгнэлт гаргах, нягтлах	<ul style="list-style-type: none"> - Зохиолын гол санаа, сургамжийг тодорхойлж, өөрийн ойлголтыг нэгтгэх; - “Зохиолын санаа танд ямар нөлөө үзүүлэв?”, “Та энэ зохиолын төгсгөлийг өөрөөр төсөөлж чадах уу?” зэрэг асуултаар эргэцүүлэл хийх.
Үр дүнг танилцуулах	<ul style="list-style-type: none"> - Зохиолын тухай санал бодлоо бусадтай хуваалцах, тайлбарлах; - Эх зохиож бичих; - Дүрийн тухай тайлбар бичих; - Зохиолын сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулах.

Эх (зохиол)-д суурилсан арга зүй нь уран зохиолын болон уран зохиолын бус эхийг үндсэн хэрэглэгдэхүүн болгон түүнд үндэслэн унших, бичих, ярих, сонсох чадварыг зэрэгцүүлэн тэнцвэртэй хөгжүүлдгээрээ онцлогтой. Бага ангид үлгэр, өгүүллэг, бодит амьдралын түүхээр дамжуулан сурагчдын хүмүүжил, сэтгэлгээ зэрэгт эергээр нөлөөлж, сурагч бүр санаа бодлоо хуваалцан ярилцах эерэг нээлттэй сургалтын орчныг дэмждэг.

Мөн суралцагчдын нас, сэтгэхүйн онцлог (I-II анги)-т тохируулж тоглоом дээр суурилсан сургалтын аргыг хослуулан нээлттэйгээр хэрэглэж болно.

Тоглоомын арга зүйн үндсэн чиглэл нь:

- *Интерактив хичээл*: Суралцагчид багт хуваагдан, асуулт хариулт, дүрд тоглох, таавар таах зэргээр хичээлд идэвхтэй оролцоно.

- *Төсөлд суурилсан сургалт:* Суралцагчид бүлгээр ажиллан, тодорхой сэдвээр бүтээл хийж, танилцуулах замаар мэдлэгээ бататгана.
- *Задлаг нийлэг арга зүй:* Суралцагчид сэдвийн хэсгүүдийг тус тусдаа судалж, дараа нь бүлгээрээ нэгдэж, бүх сэдвийг бүрэн ойлгоно.
- *Асуултад суурилсан сургалт:* Багш асуулт тавьж, суралцагчид өөрсдөө хариулт хайж, хэлэлцүүлэг өрнүүлнэ.

Суралцахуйн онол нь тодорхой арга зүйгээр хэрэгжинэ. Арга зүйн өдөр тутмын сургалтын үйл ажиллагаагаар олон удаа давтагдсаны үр дүнд дадал болно.

3.2. Сургалтын орчин

Сургалтын орчин нь судлагдахууны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад нөлөөлөх гол хүчин зүйл болно. Суралцагчийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн сургалтын арга хэлбэр, эерэг таатай уур амьсгал бүхий эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх шаардлагатай. Үүнд:

1. Эерэг таатай уур амьсгал бүхий харилцаа:

- Багш, суралцагчид өөртөө болон бусдын урам зориг өгдөг, тууштай, тэвчээртэй байдлыг дэмждэг.
- Хосоор, багаар, бүлгээр сонирхолтой, хөгжилтэй, тоглож хамтардаг.
- Өөрийн болон бусдын гаргасан амжилтыг урамшуулдаг.
- Хамтран ажиллаж үр дүнг хуваалцдаг.
- Өөрийгөө болон бусдыг айдасгүй, нээлттэй байхыг дэмждэг.
- Суралцагчийн ахиц, гүйцэтгэл бүрийг ажиглаж амжилтыг чи өмнөхөөсөө илүү сайн хийж чадлаа, энэ сэдвийг маш сайн ойлгожээ, бие даан ажиллаж чадсан нь үнэхээр бахархмаар байна зэрэг үгсээр урамшуулах.
- Суралцагчийн хариулт нь буруу байсан ч хариултыг шууд үгүйсгэхээс зайлсхийх, тухайн хариултад хүрэх болсон учир шалтгааныг олох, зөв хариултад дөхөх оновчтой арга замыг эрэлхийлж, алдаа гаргах, нээлттэй харилцдаг орчныг бүрдүүлэх.

2. Эрүүл, аюулгүй, хүртээмжтэй анги танхим:

- Суралцагчийн эх хэлээ сонирхон судлах бүх боломжийг хангасан лингафоны кабинеттай.

Анги танхимд суралцагчийн ном унших сонирхлыг өдөөх, бүтээлч үйл ажиллагаа, идэвхтэй оролцоог дэмжих номын булантай.

- Багаараа хамтран ажиллах, бүтээлч, тэгш оролцоог дэмжих суралцагч бүрд хүрэлцэхүйц сургалтын хэрэглэгдэхүүнтэй.
- Суралцагчид бие биетэйгээ харилцах, саналаа хуваалцах, хамтран суралцах боломжтой, уян хатан зохион байгуулалттай (орон зай, ширээний зохион байгуулалт, гэрэлтүүлэг) сургалтын танхимтай.
- Сургалтын техник хэрэгсэл, интерактив, цахим хэрэглэгдэхүүн ашиглах боломжтой.

Ялгаатай хэрэгцээг харгалзсан орчин:

- Суралцагчдын суралцах хэв маягийг (хараа, сонсгол, хөдөлгөөн) харгалзсан зураг, бүдүүвч, өнгө ялгалттай материал, аудио хичээл, ярилцлага, практик туршилт, хөдөлгөөнтэй тоглоом ашиглах боломжтой;
- Хос хэлний сургалтыг дэмжих тайлбар, зурагт толь бичигтэй;
- Суралцахуйн хоцрогдолтой болон илүү хурдтай сурагчдад зориулсан ялгаатай даалгаврын сантай;

Сургалтын хэрэглэгдэхүүн нь суралцагчдын сонсох-ярих, унших, бичих, хэл зүйн хэрэглээний чадварыг хөгжүүлэх, агуулгын айд нийцсэн, анги бүрийн суралцахуйн үр дүнг эзэмшихэд чиглэсэн байна. Үүнд:

- Хэлний лингафон кабинет;
- Агуулгын айн хүрээнд хамаарах мэдээлэл бүхий унших эх;
- Агуулгын айн хүрээнд хамаарах хэвлэмэл зурагт хуудас, зурагт ном;
- Агуулгын айн хүрээнд хамаарах холбогдох бүдүүвч зураг, зураглал, газрын зураг;
- Агуулгын айн хүрээнд хамаарах ном, дуу болон дүрс бичлэг, цахим платформ зэрэг олон төрлийн хэрэглэгдэхүүнээс сонгож, бүтээж хэрэглэх боломжтой.

Суралцагчид багшийн дэмжлэгтэйгээр мэдээлэл цуглуулах, тэдгээрийг ангилах замаар хэрэглэгдэхүүний санг бий болгож ашиглана.

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

4.1. Үнэлгээний зорилго

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, төлөвшлийн давуу болон сул талыг илрүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг дэмжих, ахиц дэвшлийг урамшуулах, хүрсэн түвшнийг үнэлэхэд чиглэнэ.

Суралцагч бага боловсролын эхлэл шатлалд хэлний анхан шатны нэр томъёо, тодорхойлолт, ухагдахуун, үг хэллэгийг ялган таньдаг, уншиж, бичиж чаддаг, сонсож, уншиж ойлгосноо энгийн үгээр тайлбарладаг, бусдад хүндэтгэлтэй хандаж, анхааралтай сонсдог, ярилцдаг, багийн ажилд идэвхтэй оролцож, бусдад тусалдаг, орчиндоо ээлтэй зан үйлийг эрхэмлэдэг болсон байна.

Бага боловсролын төгсгөл шатлалд суралцагч эх хэлээ сонирхон судлах, эхийг ойлгож унших, гол санааг тодорхойлох, эхэд дүн шинжилгээ хийх, өөрийн санал бодол, сэтгэгдлийг амаар, бичгээр бүтээлчээр илэрхийлэх, зохиох, зөв бичих дүрмийг мөрдөх, хэлний нэгжүүдийн үүргийг ойлгох, бие даан болон хамтран суралцах, багийн ажилд хариуцлагатай, идэвхтэй оролцох, бусдын ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах зэрэг үнэлгээний шалгуурыг хангасан байна.

Багш суралцагчийн сурах үйл ажиллагаанд ахиц, амжилт гаргахад дэмжлэг

үзүүлэх, цаашдын суралцах үйл явцыг тодорхой чиглэсэн зөвлөгөө, санал, хариу мэдээлэл өгч, хичээл, сургалтад явцын болон үр дүнгийн үнэлгээг хэрэглэнэ.

4.2. Үнэлгээний шалгуур

Хүрэх үр дүн	Шалгуур
<p>Үгийн нөөцөө нэмэгдүүлж, зөв ярих, зөв бичих дүрмийг хэрэглэдэг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Нэр томьёо, таних тэмдэг, бүдүүвч, хүснэгт, графикийн утгыг ойлгодог. - Хэлний нэгжүүдийн үүргийг ойлгож, зөв хэрэглэдэг. - Авиа, үгийг зөв дуудаж, зөв бичгийн дүрмийн дагуу бичдэг. - Өгүүлбэр, эхийг уншиж, утгыг ойлгодог. - Үгийн нөөцийг нэмэгдүүлж, бүтээлчээр хэрэглэдэг.
<p>Сонссон, уншсан мэдээллийг ойлгож, өөртөө хэрэгтэй мэдээллийг сонгож чаддаг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Аман ярианы гол санааг ойлгодог. - Зураг, үг, өгүүлбэр, эхийг уншиж, утгыг ойлгодог. - Эх сурвалжаас шаардлагатай мэдээллийг олж, сонгож чаддаг. - Сонгосон мэдээллийг бүтээлчээр хэрэглэдэг. - Мэдээллийг ойлгож, шинжилж, нэгтгэж, харьцуулж, ангилж, дүгнэж чаддаг.
<p>Санал бодол, сэтгэгдлээ бүтээлчээр илэрхийлдэг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Туршлага, сэтгэгдэл, санал бодлоо бусад хичээл, өдөр тутмын амьдралтай холбон, нэр томьёо, үг, хэллэгийг оновчтой хэрэглэж, бүтээлчээр илэрхийлдэг. - Амаар, бичгээр бүтээлчээр зохиож чаддаг. - Биеийн хөдөлгөөн, гарын дохио, нүүрний хувирал болон дууны өнгийг тохируулан ярьж, сонсогчдын анхаарлыг татдаг. - Эх сурвалж, мэдээлэлд үндэслэн ярьж, бичдэг. - Зөв бичих дүрмийн дагуу бичдэг. - Бичгийн ажлын арга барилыг эзэмшдэг.
<p>Эх хэлээ сурахын ач холбогдлыг ойлгон, хэл соёлын ялгаатай байдлыг хүндэтгэж, бие даан болон хамтран суралцах чадвар, төлөвшилтэй болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Эх орон, эх хэл, ёс заншлын талаар ойлголттой болж, бахархдаг. - Эх хэл болон төрийн хэлээ сурахын ач холбогдлыг ойлгож, сонирхон суралцдаг. - Хэл, соёлын ялгаатай байдалд хүндэтгэлтэй ханддаг. - Эрдэм номын ач тусыг ойлгож, бие дааж сурахыг эрмэлздэг. - Ном унших дуртай болдог. - Бусдыг анхааралтай сонсож, санал бодлоо хуваалцдаг. - Баг дотор идэвхтэй, хариуцлагатай ажиллаж, эв зөийг эрхэмлэдэг.

НИЙГЭМ АХУЙН БАРИМЖАА

НЭГ. УДИРТГАЛ

1.1. ҮНДЭСЛЭЛ

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон насанд хүрэгчдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, үнэлэхдээ “Өвчний олон улсын ангилал (ICD-10)-ыг үндэслэж байсан. Орчин үед тэгш хамруулан сургах боловсролд анагаах ухааны загвараас нийгмийн загварт суурилсан боловсролын үйлчилгээ үзүүлэх зорилгоор “Үйл хөдлөл, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал” ҮАОУА (ICF гэж товчилно)-аар суралцагчийг үнэлж, тэдний чадвар, нийгмийн оролцоог дэмжиж байгаа болон хязгаарлаж буй гадаад, дотоод орчны хүчин зүйлийг тодорхойлох хэрэгцээ, шаардлага үүссэн.

Ялгаатай хэрэгцээтэй (хөгжлийн бэрхшээлтэй) суралцагчийг боловсролд тэгш хамруулан сургахад хүүхдийн өдөр тутмын амьдралд тохиолддог сурч хөгжихөд нь үүсдэг саад, бэрхшээлийг багасгаж, боломжит дээд түвшинд нь хөгжүүлэх, үе тэнгийнхээ найз нөхдийн дунд үр дүнтэй суралцахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Нийгэм ахуйн баримжаа судлагдахууны хөтөлбөрийг шинээр боловсруулсан болно.

1.2. ЗОРИЛГО

Суралцагч нь гэр бүл, сургууль, нийгмийн танил орчинд амьдрах, биеийн болон сэтгэл зүйн суурь чадамж, түүнчлэн суралцахууд суралцах, бүтээлчээр сэтгэх, харилцах, хамтрах ерөнхий чадамжийг эзэмшинэ.

1.3. ХҮРЭХ ҮР ДҮН

Энэхүү хөтөлбөрийг судалснаар суралцагчид дараах ерөнхий үр дүнд хүрсэн байна.

- Өөртөө үйлчлэх, эрүүл аюулгүй амьдрах дадал, хэвшилтэй болно.
- Харилцааны арга барилыг эзэмшиж, бусдад өөрийгөө илэрхийлэх, ойлгуулах чадвартай болно.
- Нийгмийн танил орчинд аюулгүй байдлаа ханган оролцох, аюул ослоос урьдчилан сэргийлэх, түүнээс хамгаалах, хамтран суралцах чадвар, дадалтай болно.

ҮАОУА (ICF)-ийн үнэлгээнд суурилан тухайн суралцагчийн хөгжлийн бодит чадварыг тодорхойлно. Ингэснээр хөгжүүлэх хэрэгцээтэй байгаа чадварыг суралцахуын үр дүнгээс сонгож, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хэрэгжүүлнэ.

Хүрэх үр дүн	Бага боловсрол
Өөртөө үйлчлэх, эрүүл аюулгүй амьдрах дадал, хэвшилтэй болно.	<ul style="list-style-type: none">- Хувийн ариун цэврийг сахиж, эрүүл ахуйн дэглэм, хэм хэмжээг баримталдаг болно.- Хувцаслах, хувийн эд зүйлсээ ялган таних, сонгох, хэрэглэх, арчлах мэдлэг чадвартай болно.

	<ul style="list-style-type: none"> - Хоол, хүнсний төрлийг мэдэх, эрүүл хоол, хүнсийг ялгаж сонгох, хоол бэлтгэж, хооллох үед эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны дүрмийг мөрддөг болно. - Амьдрах орон байрны нэр, төрөл, гэрийн эд хогшлоо нэрлэх, зориулалтыг тайлбарлаж, өөрт ногдсон гэрийн ажлаа хийхдээ аюулгүй ажиллагааны дүрмийг мөрддөг болно.
Харилцааны арга барилыг эзэмшиж, бусдад өөрийгөө илэрхийлэх, ойлгуулах чадвартай болно.	<ul style="list-style-type: none"> - Гэр бүлийн орчинд харилцахдаа ажиглах, сонсох, ойлгох, харилцан ярилцах, өөрийн хүсэлт, санаа, бодлоо илэрхийлэх харилцааны арга (дохионы хэл, брайл тэмдэглэгээ, харилцааны аппликейшн, туслах хэрэгсэл)-ыг ашиглан харилцдаг болно. - Анги, сургууль, нийгмийн танил орчинд мэндлэх, талархах, санаа бодлоо илэрхийлэх, харилцан ярилцах, бусдаас тусламж хүсэх, тусламж үзүүлэх, тогтоосон дэгийн дагуу харилцаанд оролцдог болно.
Нийгмийн танил орчинд аюулгүй байдлаа ханган оролцох, аюул ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах чадвар, дадалтай болно.	<ul style="list-style-type: none"> - Тээврийн хэрэгслийг нэрлэх, төрлийг ангилах, зориулалтыг мэдэж үйлчлүүлдэг, замын хөдөлгөөний дүрмийг дагаж мөрддөг болно. - Дэлгүүрийн төрөл, зориулалтыг мэдэх, мөнгөн дэвсгэртийг таньж, ялгаж, худалдан авалт хийдэг, үйлчилгээний газраар үйлчлүүлэх дэгийг мөрддөг болно. - Гэр, сургууль, нийгмийн танил орчинд аюулгүй байдлыг хангаж (галын аюул, цахилгааны осол, түлэгдэх зэрэг) урьдчилан сэргийлдэг, өөрийгөө хамгаалах аргыг мэдэж, зааврыг дагаж мөрддөг болно.

ХОЁР. АГУУЛГА

Нийгэм ахуйн баримжаа судлагдахууны сургалтын хөтөлбөрийн агуулгыг “Өөртөө үйлчлэх”, “Нийгмийн танил орчны харилцаа”, “Нийгмийн танил орчны үйлчилгээ” гэсэн 3 ай, 11 дэд айн хүрээнд боловсруулж, суралцахуйн үр дүнг тодорхойлсон.

Агуулгын ай 1. Өөртөө үйлчлэх

Дэд ай	Суралцахуйн үр дүн
Хувийн ариун цэвэр	<p>1.1а. Өдөр тутмын амьдралдаа хувийн ариун цэврийг сахих үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлж хэвшинэ.</p> <p>1.1б. Бие засах үйлээ хянаж, зохицуулдаг болно.</p> <p>1.1в. Эрүүл ахуйн дэглэм, хэм хэмжээг баримталдаг болно.</p> <p>1.1г. “Хувийн ариун цэвэр, эрүүл мэнд” дэд айн хүрээний үгийн утгыг ойлгож, өгүүлбэр, эх зохиож хэрэглэдэг болно.</p>
Хувцас, гутал	1.2а. Хувцас, гутлыг ялган таних, сонгох, хэрэглэх мэдлэг, чадвартай болно.

	<p>1.2б. Хувцас, гутлаа зөв сонгож өмсөхийн ач холбогдлыг ойлгож, тайлбарладаг, цэвэр, зөв хувцасладаг болно.</p> <p>1.2в. “Хувцас, гутал” дэд айн хүрээний үгийн утгыг ойлгож, өгүүлбэр, эх зохиож хэрэглэдэг болно.</p>
Хоол хүнс	<p>1.3а. Хоол, хүнсний талаар болон хооллох үед ашиглах хоолны хэрэгсэл, хооллох дарааллыг мэдэх, эрүүл хоол, хүнсийг ялгаж, сонгон хэрэглэдэг болно.</p> <p>1.3б. Өөртөө болон гэр бүлийн гишүүддээ зууш, хоол бэлтгэхэд шаардлагатай хоолны материалыг сонгох, орцыг мэдэж, өглөө, өдөр, оройн зууш, хоолыг бэлтгэдэг болно.</p> <p>1.3в. Хооллох болон зууш, хоол бэлтгэх үеийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж хэвшинэ.</p> <p>1.3г. “Хоол, хүнс” дэд айн хүрээний үгийн утгыг ойлгож, өгүүлбэр, эх зохиож хэрэглэдэг болно.</p>
Орон байр	<p>1.4а. Амьдрах орон байрын нэр, төрөл, гэрийн эд хогшлоо нэрлэх, зориулалтыг тайлбарлаж, хүнд гэр орон ямар хэрэгтэй болохыг мэдэж, ойлгодог болно.</p> <p>1.4б. Гэр орны цэвэрлэгээ, өөрт ногдсон гэрийн ажлаа хийх дэс дарааллыг сонгох, тайлбарлах, цэвэрлэгээний бодисыг ялгаж таних, сонгох, хэрэглэх аргыг эзэмшиж, өөрийгөө эергээр үнэлдэг болно.</p> <p>1.4в. Гэр орны ажил хийх явцад аюулгүй ажиллагааны дүрмийг мөрддөг болно.</p> <p>1.4г. “Орон байр” дэд айн хүрээний үгийн утгыг ойлгож, өгүүлбэр, эх зохиож хэрэглэдэг болно.</p>

Агуулгын ай 2. Нийгмийн танил орчны харилцаа

Дэд ай	Суралцахуйн үр дүн
Би	<p>2.1а. Өөрийгөө танилцуулж, өөрийнхөө сонирхдог зүйлийг тайлбарлаж, илэрхийлдэг болно.</p> <p>2.1б. Өөрт ногдсон үүрэг, даалгаврыг ялгаж таних, сонгох, үйл ажиллагааг төлөвлөж, шийдвэр гаргадаг болно.</p> <p>2.1в. Бусдыг хүндэтгэж харилцдаг болно.</p> <p>2.1г. “Би” дэд айн хүрээний үгийн утгыг ойлгож, өгүүлбэр, эх зохиож хэрэглэдэг болно.</p>
Миний гэр бүл	<p>2.2а. Гэр бүлийн гишүүдээ танилцуулдаг, гэр бүлийн гишүүдийнхээ ажил мэргэжлийг тайлбарлаж, илэрхийлдэг болно.</p> <p>2.2б. Гэрийн эд хогшлын зориулалт, ач холбогдлыг ялгаж таньж, ангилдаг, план зураг зурах үйл ажиллагааг төлөвлөж, гүйцэтгэдэг болно.</p>

	<p>2.2в. Гэр бүлийн хүрээнд тэмдэглэдэг баяр, тэмдэглэлт өдрүүдийн учир шалтгаан, ач холбогдлыг тайлбарлаж, илэрхийлдэг болно.</p> <p>2.1г. “Миний гэр бүл” дэд айн хүрээний үгийн утгыг ойлгож, өгүүлбэр, эх зохиож хэрэглэдэг болно.</p>
Манай анги	<p>2.3а. Ангийн багш, суралцагчидтай мэндчилж, талархал илэрхийлдэг болно.</p> <p>2.3б. Ангийн эд зүйлийн зориулалтыг тайлбарлаж, байршлын план зураг зурж, тайлбарладаг болно.</p> <p>2.3в. Ангийн дэг мөрддөг болно.</p> <p>2.3г. “Манай анги” дэд айн хүрээний үгийн утгыг ойлгож, өгүүлбэр, эх зохиож хэрэглэдэг болно.</p>
Манай сургууль	<p>2.4а. Сургуулийн орчинд мэндлэх, талархах, хүсэлт, санаа, бодлоо илэрхийлдэг болно.</p> <p>2.4б. Сургуулийн байршил, гадаад, дотоод орчныг дүгнэж, тайлбарладаг, үйл ажиллагаанд оролцох шийдвэр гаргадаг болно.</p> <p>2.4в. Бусдын бодол, санааг анхаарч сонсох, өөрийн бодол, санаагаа илэрхийлж харилцдаг болно.</p> <p>2.4г. Бусадтай харилцахдаа тогтоосон дэгийн дагуу харилцаанд оролцдог болно.</p> <p>2.4д. Сургуулийн дэг мөрддөг болно.</p> <p>2.4е. “Манай сургууль” дэд айн хүрээний үгийн утгыг ойлгож, өгүүлбэр, эх зохиож хэрэглэдэг болно.</p>

Агуулгын ай 3. Нийгмийн танил орчны үйлчилгээ

Дэд ай	Суралцахуйн үр дүн
Тээвэр	<p>3.1а. Тээврийн хэрэгслийг нэрлэх, төрлийг ангилах, зориулалтыг ойлгож, тайлбарладаг болно.</p> <p>3.1б. Замын хөдөлгөөний дүрмийг биелүүлж, замын хөдөлгөөний явган зорчигчийн зорчих хөдөлгөөнийг зөвшөөрсөн тэмдэг, тэмдэглэгээг таньж, ялгах чадвартай болно.</p> <p>3.1в. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийг баримталж зорчдог болно.</p> <p>3.1г. “Тээвэр” дэд айн хүрээний үгийн утгыг ойлгож, өгүүлбэр, эх зохиож хэрэглэдэг болно.</p>
Дэлгүүр	<p>3.2а. Дэлгүүрийн төрөл, зориулалтыг мэдэх, ялгах, тайлбарлах, худалдан авалт хийх шийдвэр гаргадаг болно.</p> <p>3.2б. Мөнгөн дэвсгэртийг таних, ялгах, худалдан авалт хийхэд ашигладаг болно.</p>

	<p>3.2в. Дэлгүүрээр үйлчлүүлэх дэгийг мөрддөг болно.</p> <p>3.2г. “Дэлгүүр” дэд айн хүрээний үгийн утгыг ойлгож, өгүүлбэр, эх зохиож хэрэглэдэг болно.</p>
Эмнэлэг, эмийн сан	<p>3.3а. Эмнэлгийн байгууллага, эмийн сангийн тухай таамаглах, тайлбарлах, ямар үед эмнэлэг, эмийн сангаар үйлчлүүлэх хэрэгтэйг ойлгож, үйлчлүүлдэг болно.</p> <p>3.3б. Эмнэлгийн тусламж авч, эмийг ялгаж таних, зааврын дагуу ууж, зохистой хэрэглэдэг болно.</p> <p>3.3в. Эмнэлгийн тусламж авахдаа үйлчлүүлэх дэгийг мөрддөг болно.</p> <p>3.3г. “Эмнэлэг, эмийн сан” дэд айн хүрээний үгийн утгыг ойлгож, өгүүлбэр, эх зохиож хэрэглэдэг болно.</p>

ГУРАВ. АРГА ЗҮЙ, ОРЧИН

3.1. Арга зүй

Нийгэм ахуйн баримжаа сургалт нь суралцагчийн өөртөө үйлчлэх, өөрийгөө илэрхийлэх, бусадтай харилцах, нийгмийн танил орчны үйлчилгээнд тэгш, хүртээмжтэй оролцоход шаардлагатай мэдээллийг шууд хүлээн авагч бус, өөрийн амьдралын өмнө хуримтлуулсан мэдлэг, туршлагадаа суурилан шинэ мэдлэгээ өөрөө бий болгодог гэж үздэг суралцахуйн конструктивизмын онолд тулгуурлана.

Нийгэм ахуйн баримжааны сургалтаар ҮАОУА (ICF)-ийн үнэлгээнд суурилан тухайн суралцагчийн хөгжлийн бодит чадвар, хэрэгцээг тодорхойлж, хүүхдэд хөгжүүлэх хэрэгцээтэй байгаа чадварыг суралцахуйн үр дүнгээс сонгож, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хэрэгжүүлнэ. Тиймээс нийгэм ахуйн баримжааны сургалтад идэвхтэй сургалтын арга зүйгээс суралцагчийн ямар чадварыг хөгжүүлэх хэрэгцээтэй байгааг харгалзан судлагдахууны онцлогтой сурагч төвтэй, бодит амьдралд суурилсан сургалтын аргыг чухалчилж (харилцах, багийн ажиллагааг дэмжих, шинэ мэдлэгийг өөрөө олж авах боломж олгох, хамтран суралцах, асуудалд суурилсан сургалт, дижитал технологид суурилсан арга, суралцагчийн өөрөө удирдах сургалт, дүрд тоглох, кейс судалгаа, загварчлал хийх арга, пиктограмм, яриа, харилцан яриа, үзүүлэн таниулах, ялгаатай дасгалын арга, багаар ажиллах арга зэрэг) сонгож, хослуулан хэрэглэж болох юм.

Сургалтад тоглоомын аргыг хэрэгжүүлж тухайн суралцахуйн үр дүнд хүрэхэд суралцагчид эзэмших мэдлэг, чадвар, төлөвшлийг хэрхэн олгохыг багш урьдчилан тооцоолж, хүүхэд бүрийн хувийн онцлог, бодит чадвар, хэрэгцээ, сонирхлыг харгалзан амьдралд нь хэрэгцээтэй, тэдний хөгжилд ахиц дэмжлэг үзүүлэхэд анхаарна. Тоглоомын аргыг сургалтад хэрэгжүүлэхэд дараах нөхцөлийг харгалзах нь тохиромжтой болно.

- Тоглоомын сэдэв нь тухайн суралцахуйн үр дүнд хүрэх зорилготой нийцтэй байх;
- Суралцагч бүрийн сонирхол, гэр орон, орчин тойрны бодит амьдралд нь хэрэгцээтэй, тэдний хөгжилд ахиц авчрах тоглоомын төрлийг сонгох

(танин мэдэхүйн тоглоом, хөдөлгөөнт тоглоом, дүрд тоглох, багийн уралдаант тоглоом зэрэг);

- Тоглоомын зорилго, тоглох дүрэм, агуулга, үг хэллэг, шаардагдах орчин нөхцөл нь суралцагчийн нас, хөгжлийн онцлог, хэрэгцээнд тохирсон байх;
- Тоглоомд суралцагчийн оролцоог тэгш, жигд оролцуулах;
- Тоглох явцад суралцагчийн ярих чадвар, үгийн нөөцийг нэмэгдүүлэх, танин мэдэхүйн үйлийг хөгжүүлэх, учир шалтгааныг илрүүлэх, асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий асуулт, даалгавар, хэрэглэгдэхүүнийг урьдчилан боловсруулсан байх;
- Суралцагчийн бие дааж танин мэдэх, суралцах үйлийг урамшуулан сайшаах;

“Дэлгүүр”, “Эмнэлэг, эмийн сан”, “Тээвэр” дэд айн хүрээнд суралцагчид нийгмийн үйлчилгээнд оролцохдоо ажиглах, бэрхшээлийг даван туулах, аюулгүй оролцох чадварыг хөгжүүлэхэд анхаарна. Тоглоом-аяллын үед ялгаатай хэрэгцээтэй (хөгжлийн бэрхшээлтэй) суралцагчид юуг ажиглах, ойлгох, мэдэх ёстой гэдгийг багш урьдчилан тайлбарласан байна. Ялгаатай хэрэгцээтэй (хөгжлийн бэрхшээлтэй) суралцагчид багшийн зүгээс олон удаагийн заавар, зааварчилгааг өгч, дэмжлэг үзүүлж ажиллана.

Ялгаатай хэрэгцээтэй (хөгжлийн бэрхшээлтэй) суралцагчид өөртөө үйлчлэх чадварыг хөгжүүлэх, бие биедээ туслах, бусдыг хүндлэх, сайхан сэтгэлтэй болоход эерэг сайн нөлөө үзүүлнэ. Тоглоомын явцад ялгаатай хэрэгцээтэй (хөгжлийн бэрхшээлтэй) суралцагч нийгмийн орчинд цаг баримтлах, дэг мөрдөх, үйлчилгээний газар соёлтой, дэгийн дагуу үйлчлүүлэх, замын хөдөлгөөнд аюулгүй байдлыг хангаж оролцох, тээврийн хэрэгслийг сонгож, үйлчлүүлэх талаар мэдлэг, ойлголттой болж, амьдралдаа хэрэгжүүлдэг болоход суралцана. Жишээлбэл, “Хоол, хүнс” дэд айн хүрээнд хэн нэгэн хоол хийх үедээ ширээгээ бохирдуулсан бол түүнд яаж туслах вэ?, Нийгмийн үйлчилгээ айн хүрээнд олон нийтийн газар орилох, хүнтэй буруу харилцах, хэн нэгнийг гомдоосон бол чи юу гэж зөвлөх вэ? зэрэг амьдралд тохиолддог асуудалд хэрхэн шийдвэр гаргах хувилбарыг тоглоомын хэлбэрээр илэрхийлнэ. Багшийн өгсөн үүргийг ойлгож, зааврын дагуу үйлдлийг хийж гүйцэтгэнэ. Багш “Уучлалт гуйгаарай” гэхэд суралцагч багшаас, ээжээсээ, найзаасаа уучлалт гуйхад хэрэглэж болох үг хэллэгийг хэрэглэж хэвшинэ. Жишээлбэл: “Ээждээ хайраа илэрхийлээрэй”, “Ээждээ туслаарай”, “Найздаа тусламж үзүүлээрэй” зэргээр үргэлжлүүлэн тоглож болно.

Нийгэм ахуйн баримжаа судлагдахууны хөтөлбөрийг бага боловсролд суралцаж буй ялгаатай хэрэгцээтэй (хөгжлийн бэрхшээлтэй) суралцагчид ганцаарчилсан болон бүлгийн сургалтаар хэрэгжүүлнэ. Сургалтыг ЯАОУА (ICF)-ийн үнэлгээнд суурилан суралцагчийн бодит байдлын судалгаанд үндэслэн, эцэг эх, асран хамгаалагчтай зөвшилцөж, саналыг харгалзан зохион байгуулна.

3.2. Сургалтын орчин

Сургалтын орчин нь судлагдахууны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад нөлөөлөх гол хүчин зүйл юм.

Суралцагчийн сурах арга барилын ялгаатай байдал, хэрэгцээ, сонирхолд нийцсэн хүүхдийн оролцоог идэвхжүүлсэн, туршиж үзэх, хийж бүтээх явцдаа суралцах боломж олгосон орчин байна. Иймд дараах орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Эерэг таатай уур амьсгал бүхий харилцаа:

- Багш-сурагч, сурагч-сурагч бие биеэ сонсдог, хүндэтгэдэг, урам зориг өгдөг;
- Бодит орчинд ойр, практик хэрэглээтэй байх, суралцахуйн үр дүнд хүрэхэд дэмжлэг үзүүлэхүйц орчныг бүрдүүлэх (жишээ нь: хувийн ариун цэврийн болон хувцасны булан, гэр орны эд хогшил, гэрийн ажил, хуанли, огноо, цаг хугацаа харуулсан үзүүлэн таниулах материал, анги, сургуулийн макет, тээврийн хэрэгсэл, замын хөдөлгөөн, үйлчилгээний газрууд дэлгүүр, эмнэлэг, эмийн сан зэргийг харуулсан булан, макет байх);
- Сургалтын хэрэглэгдэхүүний талаарх тэмдэг, тэмдэглэгээ нь ойлгомжтой, энгийн байх (хүүхдийн нас, сурах арга барилын онцлогийг харгалзсан зурагт самбар, тэмдэг, тэмдэглэгээ, өнгө, тэмдэгтэй байх, “Хаалга”, “Гар угаах газар”, “Дэлгүүрийн булан”, “Хувцас солих хэсэг” зэрэг байршлыг тэмдэглэсэн тэмдэг, тэмдэглэгээ, самбарууд;
- Бие даан хийж сурах боломжийг бүрдүүлсэн байх (ажиглах, оролцох, туршиж үзэх, бие дааж гүйцэтгэх зориулалттай тавилга, бага хэмжээний гал тогооны хэрэгсэл, хувцас угаах, эвхэх, индүүдэх хэрэгсэл, мөнгөний багц үзүүлэн, хүнсний бүтээгдэхүүн, эмнэлэг, эмийн сангийн холбогдолтой хэрэглэгдэхүүн, харилцан ярианы аудио, видео бичлэг зэрэг);
- Харилцах, хамтран ажиллах боломжтой; сурагч алдаанаасаа суралцах, санал, хүсэлтээ чөлөөтэй илэрхийлдэг;
- Багш туслагч, зөвлөгч, чиглүүлэгч байж, сурагчийг өөртөө үйлчлэх, эрүүл ахуйн зөв дадал, хэвшилтэй, өөрийгөө илэрхийлэх, бусадтай харилцах ур чадвартай, нийгмийн танил орчны үйлчилгээнд оролцох чадвартай болоход дэмжлэг болдог;
- Суралцагчийн тууштай байдал, идэвхтэй оролцоог дэмжиж, амжилтыг урамшуулдаг;

Эрүүл, аюулгүй, хүртээмжтэй анги танхим:

- Суралцагчийн сэтгэл санаа, бие махбодын эрүүл мэндийг дэмжсэн;
- Суралцагчийн хөдөлгөөн хийх, бие биетэйгээ харилцах боломжтой, уян хатан зохион байгуулалттай;
- Суралцагчийн өөрөө хийх, бусдаас дэмжлэг авах, бүтээлч үйл ажиллагааг дэмжсэн, хүртээмжтэй орон зай, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан, нэмэлт тохируулга хийсэн орчин байх;
- Сургалтын интерактив, дижитал хэрэглэгдэхүүн ашиглах боломжтой;

Ялгаатай хэрэгцээг харгалзсан орчин:

- Суралцагчийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрсөн, түүнийг хүндэтгэсэн;

- Суралцагчийн суралцах хэв шинж, ялгаатай хэрэгцээнд тохирсон төрөл бүрийн сургалтын материал, хэрэгслийг бэлтгэх, ашиглах боломжтой;
- Дохионы хэлний орчуулга, толь бичиг, аудио, видео хэрэглэгдэхүүн, брайл хэрэглэгдэхүүн, зурагт, үгт карт, сонголттой, хувилбартай дасгал, даалгаврын сантай;

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

4.1. Үнэлгээний зорилго

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, төлөвшлийн давуу болон сул талыг илрүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг дэмжих, ахиц, амжилтыг урамшуулах, хүрсэн түвшнийг үнэлэхэд чиглэнэ.

Үнэлгээ нь тухайн суралцагчийн хөгжлийн бодит чадварыг тодорхойлж, тасралтгүй хөгжлийг дэмжихүйц үйл байна.

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж буй суралцагчийг үнэлэх чиглэлийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан журмыг баримтална.

4.2. Үнэлгээний зорилт

Хүрэх үр дүн	Шалгуур
Өөртөө үйлчлэх, эрүүл аюулгүй амьдрах дадал, хэвшилтэй болно.	<ul style="list-style-type: none"> - Гараа тогтмол угааж, гар угаах аргачлалыг мэдэж, хэрэглэдэг. - Амны хөндийн ариун цэврийг сахидаг (шүд, хэлээ угаах, хоолойгоо зайлах). - Усанд орж, биеэ угааж, арчиж, хатааж, арчилдаг. - Хувцас, гутлаа таньж, сонгож өмсдөг, тайлж, эвхдэг, өлгүүрт өлгөдөг, цаг агаар, улирлын байдалд тохируулан хувцасладаг. - Хооллох хэрэгцээгээ ойлгож, илэрхийлдэг. Бусдад саад болохгүйгээр хооллодог. - Хоол, хүнсний зүйл (талх, мах, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ), тэдгээрийн төрөл зүйл, хүний эрүүл мэндэд гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг ойлгож мэддэг. - Гал тогооны хэрэгслийг нэрлэж, хэрэглэж, цэвэрлэдэг. - Гал тогооны хэрэгслийг хэрэглэх үеийн аюулгүй ажиллагааны дүрмийг мөрддөг. - Монгол гэр, байшин, орон сууцны төрөл, онцлог, зориулалт, гэрийн тавилга, эд хогшлыг нэрлэж, ялгаж, зориулалтаар нь ашиглаж чаддаг. - Гэр ахуйн цахилгаан хэрэгслийг аюулгүй ашиглах талаар мэдэж, мөрддөг. - Өөртөө үйлчлэх, эрүүл аюулгүй амьдрах дадал хэвшлийн хүрээний үгийн утгыг ойлгож, өгүүлбэр, эх зохиож хэрэглэдэг, өөрийн санаа, бодлоо илэрхийлдэг.
Харилцааны арга барилыг эзэмшиж, бусдад өөрийгөө илэрхийлэх,	<ul style="list-style-type: none"> - Гэр бүл, анги, сургуулийн танил орчинд өөрийн овог нэр, нас, хамт амьдардаг гэр бүлийн гишүүдийг танилцуулж, амьдардаг гэрийнхээ хаяг, байршлыг мэддэг, хаана байдгийг тайлбарлаж чаддаг.

<p>ойлгуулах чадвартай болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Өдөр тутмын ажлаа эрэмбэлдэг, өдрийн дэглэмээ төлөвлөж, өөрт ногдсон үүрэг даалгавраа ойлгож, танилцуулж илэрхийлдэг. - Өөрийн дуртай тоглоом, спорт, үзэх дуртай кино, өөрт тохиолдсон хөгжилтэй болон бусад зүйлийн талаар ярьж, тайлбарлаж чаддаг. - Гэр бүл, сургуулийн орчинд өөрийнхөө хийж чаддаг эсвэл хийх дуртай ажлаа олон янзаар хийх арга замыг сонгож, шийдвэрлэдэг. - Анги, сургууль дээр зохион байгуулагдаж байгаа үйл ажиллагаанд оролцон, найз нөхөд, багш нартаа өөрийн санаа бодлоо ойлгуулж, хүсэлт тавьж, шийдвэрлүүлдэг - Өөрийгөө илэрхийлэх, ойлгуулах үг хэллэгийн утгыг ойлгож, бусдад ойлгомжтой байдлаар илэрхийлдэг. - Харилцааны арга барил эзэмшиж, өөрийгөө бусдад ойлгуулж, илэрхийлдэг,
<p>Нийгмийн танил орчинд аюулгүй байдлаа ханган оролцох, аюул ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, хамтран суралцах чадвар, дадалтай болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Тээврийн хэрэгслийг нэрлэх, ангилах, зориулалтыг тайлбарлаж, бусдын дэмжлэгтэй болон бие даан тээврийн хэрэгслээр зорчдог, сургуулийн автобус, нийтийн тээврийн автобус, такси, тээврийн хэрэгслээр зорчихдоо өөрийгөө илэрхийлж чаддаг, замын хөдөлгөөний тэмдэг, тэмдэглэгээг таньж, ялгаж, аюулгүй зорчих дүрмийг баримталж зорчдог. - Дэлгүүрийн төрөл, зориулалтыг мэдэж, тайлбарлах, өөрт хэрэгтэй зүйлээ мөнгөн дэвсгэртийг хэрэглэн худалдан авалт хийж чаддаг. - Дэлгүүрээр үйлчлүүлэх дэгийг мөрддөг. - Эмнэлэг, эмийн сангийн зориулалт, ямар үед үйлчлүүлэх хэрэгтэйг ойлгож, мэддэг, эмнэлгийн тусламж авахдаа өөрийн талаар мэдээлэл өгч, тайлбарлаж, илэрхийлж чаддаг. - Эмийн зохистой хэрэглээг мэддэг, зааврын дагуу ууж, хэрэглэдэг. - Нийгмийн танил орчны үйлчилгээ айн хүрээний үг хэллэгийг ашиглаж, өөрийн санаа, бодлоо илэрхийлдэг.

ҮАОУА (ICF)-ийн үнэлгээнд суурилан тухайн суралцагчийн хөгжлийн бодит чадварыг тодорхойлно. Ингэснээр хөгжүүлэх хэрэгцээтэй байгаа чадварыг суралцахуйн үр дүнгээс сонгож, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хэрэгжүүлж, дэвшүүлсэн зорилгодоо хүрч буй эсэхийг ахицаар үнэлнэ.

-оОо-